МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ**

# ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМАНД ХАМААРАХ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН
## /2025 ОНЫ ЭЦЭС/

**УЛААНБААТАР**
**2026 ОН**

# ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМАНД ХАМААРАХ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН /2025 ОНЫ ЭЦЭС/

## НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд хамаарах хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд 2025 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх, дүгнэх, зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2025 оны сүүлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээг хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Байгууллагын үйл ажиллагааг үнэлэх журам”, 2025 оны 183 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журам”-ыг тус тус удирдлага болгов.

Арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн түвшинг үнэлэн тогтоохдоо дээрх журмын 6.1-д заасан “Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тооцох аргачлал”-ыг удирдлага болгон үр дүн, нотлох баримтад тулгуурлах зарчмыг баримталлаа.

## ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд хамаарах Монгол Улсын 14 хуулийн 28 заалт, Улсын Их хурлын 22 тогтоолын 32 заалт, Улсын Их хурлын Байнгын хорооны 15 тогтоолын 42 заалт, Ерөнхийлөгчийн 8 зарлигийн 9 заалт, Засгийн газрын 73 тогтоолын 103 заалт, Засгийн газрын хуралдааны 78 тэмдэглэлийн 138 заалт, Засгийн газрын 10 албан даалгаврын 65 заалт, Ерөнхий сайдын 4 захирамжийн 4 заалт, Үндэсний аюулгүй байдлын 1 зөвлөмжийн 1 заалт нийт 225 захиргааны актын 447 заалт бүхий хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт байгаагаас 2026 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах үр дүн гарлаа. Үүнд:

1. Хэрэгжсэн буюу 100%-335 заалт;
2. Ахиц гарсан буюу 50%-25 заалт;
3. Тодорхой үр дүнд хүрсэн буюу 50%-25 заалт;
4. Удаашралтай эрчимжүүлэх шаардлагатай буюу 50%-18 заалт;
5. Зохион байгуулалтаас шалтгаалж биелээгүй буюу 0%-13 заалт;
6. Санхүү хөрөнгө оруулалтаас шалтгаалж биелээгүй 0%-9 заалт;
7. Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй буюу Х.Б тэмдэглэгээтэй -5 заалт;
8. Хэрэгжих боломжгүй тэмдэглэгээтэй 17 заалт байна. Үүнд:
    a) Хэрэгжүүлэх хугацаа тодорхойгүй-3 заалт;
    b) Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй-10 заалт;
    c) Хэрэгжүүлэх зардал, санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй-2 заалт;
    d) Хийгдэх үйл ажиллагаа, зорилго тодорхойгүй-1 заалт;
    e) Хэмжигдэхүйц биш-1 заалт тус тус байна.

Хэрэгжилтийн дундаж: 87 хувьтай үнэлгээ хийгдлээ.

Нийт хяналтад авсан 447 заалтын 67 хувь нь Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг байх бөгөөд 10 хувь нь УИХ-ын тогтоол үлдэх 23 хувь нь бусад шийдвэрүүдээс бүрдсэн байна. Түүнчлэн хяналтад авсан нийт 447 заалтын 331 заалт нь Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, тогтоол, албан даалгаваар өгөгдсөн үүргүүд байх бөгөөд үлдэх 116 заалт нь бусад шийдвэрүүдтэй холбоотой заалтууд туссан байна.

Хяналтад авсан шийдвэрүүдийг дор зургаар илэрхийлэв.

***Зураг1. Хяналтад авсан шийдвэрүүд тоогоор илэрхийлэв.***




***Зураг2. Хяналтад авсан заалтууд тоогоор илэрхийлэв.***



Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 2026 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар нийт 447 заалтад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах байдалтай байна. Үүнд:

***Зураг3. Хяналтад авсан заалтын үнэлгээ хийсэн байдал.***




Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнгээс харахад нийт шийдвэрийн 72 хувь нь хэрэгжсэн буюу 100 хувьтай, ахиц гарсан болон тодорхой үр дүнд хүрсэн 10 хувьтай үнэлгээ хийгдэж үлдэх 18 хувь нь бусад үнэлгээнд хамрагдсан байна. Түүнчлэн дээрх 447 заалтаас хасуулах санал тусгасан нийт 42 заалт байгааг онцлох нь зүйтэй байна.

Хяналт-шинжилгээ, үлнэлгээг хийхэд амжилттай хэрэгжсэн заалтуудыг онцлон харуулбал Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны салбарын эрх зүйн орчинг бүрдүүлэх ажлууд амжилттай хэрэгжсээр байна. Өөрөөр хэлбэл Цахим шилжилтийг дэмжсэн 4 багц хуулийн хэрэгжилтийг хангуулан ажиллах хүрээнд хууль тогтоомжоор эрх олгогдсон нийт 43 хэм хэмжээний акт /дүрэм, журам, стандарт/-ыг шинээр болон шинэчлэн боловсруулах ажлыг гүйцэтгэж байгаагаас тайлант хугацаанд Нийтийн мэдээллий ил тод байдлыг хангах тухай хуулийн хүрээнд 21 акт батлахаас батлуулсан 17, Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хүрээнд 11 акт батлахаас батлуулсан 11, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хүрээнд 4 акт батлахаас батлуулсан 2, Цахим гарын үсгийн тухай хуулийн хүрээнд 7 акт батлахаас батлуулсан 4 актын хэрэгжилтийг хангуулан ажиллаж, үлдсэн 9 актын төслийг боловсруулах ажлыг зохион байгуулж байна. 2024-2025 онд батлуулсан захиргааны хэм хэмжээний актуудаас дурдвал:

- ✓ Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан бүрдүүлэх, түүнийг зарцуулах журам
- ✓ Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх, зарцуулах журам

- ✓ Кибер аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хариу арга хэмжээ авах нийтлэг журам
- ✓ Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам, аргачлал
- ✓ Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх этгээдийг бүртгэх, аудит хийх журам
- ✓ Цахим хэлбэрээр боловсруулалт хийх технологийг ашиглан мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглах үйл ажиллагаанд үнэлгээ хийх журам
- ✓ Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам
- ✓ Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах нөхцөл, бүртгүүлэх журам
- ✓ Цахим технологийн шинжилгээ хийх журам
- ✓ Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх үндэсний зөвлөл, түүний бүрэлдэхүүн, ажиллах журам
- ✓ Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн ажиллах журам
- ✓ Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам гэх мэт олон захиргааны хэм хэмжээний актыг баталж эрх зүйн орчныг бүрдүүлж ажилласан сайн үзүүлэлттэй байна.

Мөн түүнчлэн Цахим хөгжил, инновац харилцаа холбооны салбарын бодлогын амжилттай хэрэгжиж буйг илтгэх хэд хэдэн томоохон арга хэмжээнүүд байна. Үүнээс онцлон дурдвал:

Засгийн газрын 2025 оны 84 дүгээр тогтоолоор өгсөн үүрэг буюу “Иргэддээ ойр, нээлттэй засаглалыг хөгжүүлэх, төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зорилтын хүрээнд Засгийн газрын бодлого, шийдвэрийг төлөвлөх, боловсруулах үйл явцад иргэдийн саналыг авах, нийгэмд тулгамдаж буй асуудлаар цахим хэлэлцүүлэг явуулах цахим системийг нэвтрүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар нарт үүрэг болгосугай” гэсэн заалтын биелэлтэд салбарын зүгээс амжилттай хэрэгжүүлсэн байна.

“Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” болон “Иргэдийн санал, санаачилгын цахим системийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын төслүүдэд 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 01/2020 дугаар албан бичгээр санал хүргүүлсэн. "Засгийн газрын бүрэн эрхийн хүрээнд хамаарах нийтийн ашиг сонирхлыг хөндсөн дараах асуудлаар гаргасан иргэн, хуулийн этгээдийн саналыг Монгол Улсын 18 насанд хүрсэн 50 мянган иргэн дэмжсэн бол хуралдаанаар хэлэлцүүлнэ.” гэж Засгийн газрын хуралдааны журамд өөрчлөлт орсны дагуу иргэдийн санал, санаачилгыг хүлээн авах Засгийн газрын цахим систем (d-gov.mn)-ийг хөгжүүлж, 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр ашиглалтад оруулсан” гэжээ.

Мөн 2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай Засгийн газрын 2023 оны 49 дүгээр тогтоолын хэрэгжилт хангалттай буюу "Авлигатай тэмцэх “Шүгэл ажиллагаа”-ны хүрээнд Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн “Нэгдье” аяны зурагт хуудаст байгууллагын логог байрлуулан аянд нэгдэж буйгаа илэрхийлэн байгууллагын цахим хуудас болон олон нийтийн сүлжээн дэх хуудаснууд, харьяа байгууллага болох Үндэсний дата төв УТҮГ, И-Монгол академи УТҮГ, Радио, телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын олон нийтийн сүлжээн дэх цахим хуудаст “Үгүй гэж хэлээд өөрчилье” видео шторкийг байрлуулсан.

Тус яамны болон харьяа байгууллагын нийтийн албан тушаалтнуудад авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, төсвийн хөрөнгийг захиран зарцуулахтай холбоотой гарч буй эрсдэл, төсвийг зориулалтын дагуу зарцуулах, гэрээний гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах, албан тушаалтанд хуулиар хүлээлгэсэн хориглолт, хязгаарлалтыг мөрдөх талаар албан хаагчдын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд сургалт авах хүсэлтийг 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 03/903 дугаар албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, 2024 оны 05 дугаар сарын

14-ний өдөр цахим хэлбэрээр зохион байгуулсан сургалтад яамны болон харьяа улсын төсөвт үйлдвэрийн газрын 60 гаруй албан хаагчдыг хамруулсан.

Аймгийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийн хяналт шалгалтын газар, Харилцаа холбооны зохицуулах хороо, Зэвсэгт хүчний жанжин штабын Мэдээлэл, харилцаа холбооны хяналтын 31 улсын (ахлах) байцаагчдад 2025 оны 04 дүгээр сарын 23-25-ны өдөр нийслэлийн Прокурорын газар, Авлигатай тэмцэх газар болон бусад байгууллага, сургагч багш нар хөтөлбөрийн дагуу хяналт шалгалтын арга хэлбэрийг илүү боловсронгуй болгох, хяналт шалгалтаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад учруулж буй бэрхшээл, хүндрэлийг хөнгөвчлөх, хяналт шалгалтын давхардлыг арилгах, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулах, аливаа аюул, эрсдэл, авлига ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх, хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг сайжруулан иргэд, аж ахуйн нэгжүүдийн талархлыг хүлээсэн шинэчлэлт, өөрчлөлтийг хийж ажиллахыг улсын (ахлах) байцаагчдад чиглэл өгч ажилласан байна.

Мөн Иргэнд e-mongolia, e-business, ХУРДАН цэг, ХУРДАН киоск, lavlagaa.e-mongolia.mn, мобайл аппликейшн гэсэн 6 үндсэн сувгаар хүн, хуулийн этгээдэд үзүүлж, чирэгдлийг багасгаж, хүнд суртлыг бууруулан ажиллаж байна. Үүнд:

1.Төрийн байгууллагаас цахим хэлбэрээр үзүүлж болох 785 үйлчилгээ (лавлагаа тодорхойлолт 106, нэг шатлалт үйлчилгээ буюу үйлчилгээний хүсэлтийг хандсан цэгээс нь нэмэлт шат, дамжлагагүй шийдвэрлэн хариу өгөх боломжтой үйлчилгээ 144, олон шатлалт үйлчилгээ буюу нийтийн мэдээллийн системээр дамжуулан үйлчилгээний хүсэлтийг хүлээн авч эрх бүхий байгууллагад шилжүүлж, шийдвэрлүүлэх 535)-нээс 43 байгууллагын 451 үйлчилгээг төрийн үйлчилгээний цэг, киоск машинаар хүн, хуулийн этгээдэд үзүүлж байна.

2025 онд Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын нийслэл дэх 144, орон нутаг дахь 405, хилийн чанад дахь дипломат төлөөлөгчийн газар дахь 31 улсын 47 буюу нийт 596 төрийн үйлчилгээний хурдан цэгээр дамжуулан төрийн 43 байгууллагын 451 үйлчилгээг 1,581,079 удаа амжилттай үзүүлээд байна.

2.Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (www.e-mongolia.mn)-д 2021 онд 59 байгууллагын 606, 2022 онд 69 байгууллагын 897, 2023 онд 86 байгууллагын 1170, 2024 онд 87 байгууллагын 1263, 2025 онд 88 байгууллагын 1268 болгон нэмэгдүүлэн үйлчилгээг хүргэсэн. Тус системд бүртгэлтэй 2,091,011 иргэнд 92 сая удаа амжилттай үзүүлээд байна.

3.Бизнес эрхлэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хуулийн этгээдэд зориулсан платформ И-Бизнес (e-business)-ийг 2023 оны 07 дугаар сард 800 үйлчилгээтэйгээр хэрэглээнд нэвтрүүлсэн. 2025 онд хуулийн этгээдтэй холбоотой нийт 88 төрийн байгууллагын 953 үйлчилгээг нэгтгэж, иргэд 339,342 удаа үйлчилгээ авсан байна.

Түүнчлэн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээлэл хариуцагч байгууллага байнга ил тод, нээлттэй байлгах 67 төрлийн мэдээллийг нээлттэй байршуулсан эсэх талаарх “Шилэн индекс”-ийн тайланг тус яамны харьяа Засгийн газрын агентлаг-Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар хүлээн авч, үнэлгээ хийж байна.

Тус нээлттэй мэдээллийн "shilen.gov.mn" 2.0 системд 2025 оны 3 дугаар улирлын байдлаар хандах эрхийг мэдээлэл хариуцагч 4,583 үүсгэн сургалтад 10511 албан хаагчийг хамруулаад байна. Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсээр дамжуулан шаардлагатай мэргэжил, арга зүйн зөвлөгөөг тогтмол өгч ажиллаж байна гэжээ.

Мөн “Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 233 дугаар тогтоолын 1-д Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдээс олгох зөвшөөрлийг цахим хэлбэрээр шийдвэрлэх харилцааг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт, тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох шийдвэр гаргах үйл ажиллагааг 2023 оны 08

дугаар сарын 01-ний өдөрт багтаан цахим хэлбэрт шилжүүлж, төрийн үйлчилгээний нэгдсэн системд холбох арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв (Т.Батбилэг), И-Монгол академи (Б.Мягмарнаран)-д тус тус даалгасан байх ба биелэлтийг дараах байдлаар тайлагнасан байна. Үүнд:

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын А/27 дугаар тушаалаар Ажлын дэд хэсгийн хурлын шийдвэрийн дагуу Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх зорилгоор төрөөс аж ахуйн нэгжтэй харилцах бүхий л үйл ажиллагааг "Төрийн үйлчилгээний нэгдсэн систем “e-Business”-д нэгтгэх ажлын хүрээнд ажиллах төлөвлөгөө болон Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн "Ажил хариуцуулах тухай" тушаалыг А/135 дугаар тушаал, 10 дугаар сарын 16-ны өдрийн 01/2379 албан бичгээр холбогдох байгууллагуудад, 10 дугаар сарын 22-ны өдрийн 02/2412 албан бичгээр харьяа байгууллагуудад тус тус хүргүүлсэн. Холбогдох байгууллагууд нь төлөвлөгөөний дагуу арга хэмжээг хэрэгжүүлж байна:

Зөвшөөрлийн нэгдсэн сангаас зөвшөөрлийн хүсэлт гаргасан байгууллага, олгосон байгууллага, шийдвэрлэлтийн төлөв зэрэг мэдээллийг Төрд байгаа миний мэдээлэл цэс-Зөвшөөрлийн мэдээлэл- цэсээр e-Mongolia системд хөгжүүлэн 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр хэрэглээнд нэвтрүүлсэн.

Зөвшөөрлийн нэгдсэн санд нэвтрүүлсэн зөвшөөрлүүдийг e-business системд “Oauth” системээр дамжуулан нэвтрэлтийг дамжуулан зөвшөөрөл авах боломжийг бүрдүүлэн ажилласан.

2025 оны жилийн эцсийн байдлаар e-business платформд 832 үйлчилгээ нэвтэрсэн. Зөвшөөрлийн тухай хуульд заасан 254 тусгай зөвшөөрлөөс e-business платформд 44 цахимжиж, 134 линкээр холбогдож, 76 цахим хэлбэрт шилжээгүй, харин 124 энгийн зөвшөөрлөөс 23 цахимжиж, 43 линкээр холбогдож, 58 цахим хэлбэрт шилжээгүй гэж тайлагнасан байна.

Мөн Монгол Улсын Засгийн газрын “Их өгөгдлийн (big data) сан” үүсгэх тухай 2023 оны 403 дугаар тогтоолын хэрэгжилт амжилттай буюу “Хязгаарлалттай мэдээллийг тодорхойлох боломжгүй болгох арга хэрэгсэл бүхий хэрэгсэл (tool) хөгжүүлэх ажлын хүрээнд өгөгдлийг 5 төрөл (Hashed keys, Masking, Obfuscataion, Generalization, Perturbation)-өөр тодорхойлох боломжгүй болгон хувиргах хэрэгслийг хөгжүүлж, тус хэрэгслийг Үндэсний статистикийн хороо, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт суурилуулан амжилттай туршсан.

Мөн их өгөгдлийн сан үүсгэх дэд бүтцийг бэлдэх ажлын хүрээнд Үндэсний дата төв УТҮГ нь 500GB санах ой бүхий нөөцийг үүсгэсэн. И-Монгол академи УТҮГ-ын төлөөлөлтэй хамтран Үндэсний статистикийн хороо, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Мэдээллийн технологийн төвд 2025 оны 05 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд ажиллаж, өгөгдлийг хувиргах, нууцлан дамжуулах явцад гарсан эх кодын алдааг засварлах, турших ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгох хэрэгсэл, хувиргасан өгөгдлийг ХУР системээр дамжуулах сервисийг ашиглан Үндэсний статистикийн хороо (өрхийн мэдээлэл - 1,000,313 мөр өгөгдөл, иргэний - 3,531,278 мөр өгөгдөл), Нийгмийн даатгал (даатгуулагч иргэний - 18,142,864 мөр өгөгдөл) -ын мэдээллийг Үндэсний дата төв УТҮГ-т байрлах өгөгдлийн санд байршуулсан. Цуглуулсан өгөгдлүүдийг нэгтгэн боловсруулалт хийх виртуал орчинг үүсгэсэн” гэж тайлагнасан байна.

Мөн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай” 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн зөвлөмжийн хэрэгжилт хангалттай буюу дараах байдлаар тайлагнасан байна. Тодруулбал Зөвлөмжийн 1.12-т Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг ил болон далд хэлбэрээр сурталчилсан хэвлэл мэдээллийн байгууллагын тусгай зөвшөөрлийг цуцлах, цахим сайт, хаягуудыг хориглох, ийм төрлийн сэдэвтэй гэмт хэрэг үйлдэхийг өөгшүүлэн сурталчилсан, үйлдэх аргыг нарийвчлан харуулсан бүх төрлийн кино, нэвтрүүлэг, нийтлэл болон бусад уран бүтээлийг олон нийтэд

хүргэхгүй байх арга хэмжээг тухай бүр авах тухай заасан ба биелэлтийг доорх байдлаар ирүүлсэн байх тул 100 хувиар үнэлгээ хийгдлээ. Үүнд:

"Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчсөн утга агуулгатай контентыг нийтэлсэн тул ОӨГ, ЦЕГ, ШӨХТГ, ТЕГ зэрэг эрх бүхий байгууллагын шийдвэр, дүгнэлтээр 2025 онд нийт 512 вебсайтыг зөрчилтэй домэйн нэрийн жагсаалт (black-list.mn)-д оруулж Монгол Улсын нутаг дэвсгэрээс хандах хандалтыг хязгаарлах технологийн арга хэмжээ авч ажилласан.

2025 онд эрх бүхий байгууллагаас мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг сурталчилсан гэх агуулга бүхий контентыг устгуулах хүсэлт ирээгүй.

Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ нь интернэтийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудтай мэдээлэл солилцох гэрээг байгуулж, IP хаяг эзэмшигчийг тогтоож чаддаг болсноор халдлага, зөрчилд өртсөн иргэн, хуулийн этгээдийг олж, халдлага зөрчилд хариу үзүүлэх заавар зөвлөмжийг хүргүүлэх, уялдуулан зохицуулах үйл ажиллагааг цаг алдалгүй хийж байна. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх Үндэсний хорооны 2025 оны хурлуудад оролцож, хариуцсан чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна" гэжээ.

Энэ мэтчилэн 100 хувиар үнэлгээ хийгдсэн олон заалтуудаас Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны салбарын бодлого үр дүнтэй хэрэгжсэн талаар үзэх боломжтой байна.

Гэсэн хэдий ч Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 14.2-т Энэ хуулийн 14.1.3-т заасан зохицуулалтын сэндбокс орчныг бий болгох, үйл ажиллагаа явуулах журмыг Засгийн газар батална гэсэн заалтын хэрэгжилт амжилтгүй буюу Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6-д заасны дагуу дэвшилтэт технологийн сэндбокс орчны талаарх гадаад улс орны туршлагыг судалж, "Хиймэл оюун, их өгөгдөл, блокчэйн, сансрын үйлдвэрлэлийн дэвшилтэт технологид суурилсан сэндбоксын журам"-ын төслийг эхний байдлаар боловсруулсан гэж тайлагнасан байх тул зохион байгуулалтаас шалтгаал тухайн заалт бүрэн биелээгүй байна гэж үзэж 0 хувиар үнэлгээ хийлээ.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2023 оны "Түлхүүр үг батлах тухай" 433 дугаар тогтоолын 4-т "Түлхүүр үгийг 2024 оноос хэрэглэж эхлэхтэй холбогдуулан бэлтгэл ажлыг 2023 онд багтаан хангаж, бэлтгэл ажилд шаардагдах зардлыг батлагдсан төсвийн хүрээнд шийдвэрлэж ажиллахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Соёлын сайд Ч.Номин, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт үүрэг болгосугай" гэсэн заалтын биелэлт амжилтгүй буюу "түлхүүр үгийг 2025 оноос хэрэглэж эхлэхтэй холбогдуулан шаардагдах зардлыг батлагдсан төсвийн хүрээнд шийдвэрлэн ажиллаж байна" гэж тайлагнажээ.

Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны 44 дүгээр тэмдэглэлээр өгсөн үүрэг буюу Хяналт, удирдлагын нэгдсэн цахим систем (shilenkhyanalt.gov.mn)-ийн шинэчлэлийг хийж, системийн хэвийн ажиллагааг хангаж ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүд даалгасан заалт хэрэгжилт хангалтгүй буюу дараах байдлаар тайлагнасан байна. Үүнд:

"Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргын 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/12 дугаар тушаалаар Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны ажлын албаны даргаар ахлуулсан ажлын хэсэг ажилласан болно. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнээр Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны Ажлын албаны Үндсэн үйл ажиллагааны хэлтсийн дарга, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ, мониторингийн газрын ахлах референт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын салбарын бодлого зохицуулалтын газрын шинжээч, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны салбарын хяналтын газрын эрсдэлийн удирдлага хариуцсан ахлах мэргэжилтэн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны бодлого төлөвлөлт, судалгааны хэлтсийн мэргэжилтэн, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Тамгын газрын ахлах шинжээчийн бүрдэлдэхүүнтэй 2 удаагийн хурлаар Хяналт, удирдлагын нэгдсэн цахим системийн хэвийн, аюулгүй ажиллагааг

хангах зорилгоор системийн шинэчлэл хийхэд шаардлагатай ажлын даалгавар боловсруулж тус ажлын тендер зарлагдахад бэлэн болсон. Засгийн газар бүх шатанд төсвийн хэмнэлтийн горимыг сахин, үр ашиггүй зардлыг танах, төрийн чиг үүргийн давхардлыг арилгаж, орон тоог үе шаттай цөөлөх зорилтын хүрээнд Засгийн газрын хуралдаанаар 29 хороо зөвлөлийг татан буулгах Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 22 дугаар тогтоолоор Хяналт, үнэлгээний үндэсний хороо татан буугдснаар Хяналт, удирдлагын нэгдсэн цахим систем http://shilenkhyanalt.gov.mn/-ийг шинэчлэх ажил зогссон болно" гэжээ.

Энэ мэтчилэн хангалттай, хангалтгүй хэрэгжилттэй олон заалтуудад хяналт-шинжилгээ үнэлгээг хийх явцад олон бэрхшээл тулгарлаа. Тодруулбал Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим систем гацах, заалтын биелэлтийг нэгтгэн оруулах ажиллагаа удаашрах, зарим заалтын хэрэгжилтийн хугацаа бүрэн дууссан, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон, зарим заалтыг хасуулах санал илгээсэн боловч дахин нээгдсэн, хяналт хийх явцад заалтын тоо нэмэгдсэн гэх мэт. Мөн яам болон харьяалах асуудлын хүрээний байгууллагуудад хамаарахгүй олон заалтууд байлаа. Иймд заалт бүрийн агуулга, хэрэгжилтэд Засгийн газрын 2025 оны 183 дугаар тогтоолын холбогдох үнэлгээний аргачлалыг ашиглан үнэлгээг хийлээ.

Үнэлгээг хийх явцад Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 183 дугаар тогтоолын үнэлгээний аргачлалыг хэрхэн ашиглах сургалтыг зохион байгуулаагүй байсныг дурдах нь зүйтэй байна.

## ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЯВЦАД ГАРСАН ДҮГНЭЛТ

Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнгээс харахад Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд хамаарах хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт дунджаар 87 хувьтай үнэлэгдэж, нийт заалтын дийлэнх нь бүрэн хэрэгжсэн нь салбарын бодлого, үйл ажиллагаа зорилтот түвшинд үр дүнтэй хэрэгжиж байгааг илтгэж байна. Ялангуяа цахим шилжилтийг дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэх хүрээнд батлагдсан захиргааны хэм хэмжээний актууд, төрийн үйлчилгээний цахимжилт, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх цахим системүүд, e-Mongolia, e-Business, ХУРДАН цэгийн үйл ажиллагаа бодит үр өгөөж өгч, иргэд, аж ахуйн нэгжийн цаг хугацаа, зардлыг хэмнэх, төрийн үйлчилгээний ил тод, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэхэд бодит ахиц гаргасан байна.

Гэсэн хэдий ч зарим заалтын хэрэгжилт зохион байгуулалт, санхүүжилт, чиг үүргийн тодорхой бус байдал, системийн шинэчлэл удааширсан зэрэг шалтгаанаар хангалтгүй, эсхүл биелээгүй хэвээр үлдсэн нь анхаарал татаж байна. Тухайлбал, зохицуулалтын сэндбокс орчны журам батлах, "Түлхүүр үг"-ийн хэрэглээг хугацаанд нь нэвтрүүлэх, Хяналт, удирдлагын нэгдсэн цахим системийн шинэчлэл зэрэг ажлууд бодлогын түвшинд чухал ач холбогдолтой боловч бодит хэрэгжилт удааширч, зарим нь зогссон байдалтай байна.

Үүнд байгууллагын зохион байгуулалтын өөрчлөлт, төсвийн хязгаарлалт, чиг үүргийн тодорхой бус байдал, хариуцах байгууллага тодорхойгүй байх зэрэг хүчин зүйлс нөлөөлсөн байна.

Мөн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх явцад цахим системийн доголдол, заалтын давхардал, хугацаа нь дууссан эсхүл ач холбогдолгүй болсон заалтууд хадгалагдсан, байгууллагын чиг үүрэгт хамаарахгүй заалтууд орсон зэрэг хүндрэлүүд илэрсэн нь үнэлгээний чанар, үр ашигт сөргөөр нөлөөлж байна. Үүнээс гадна 2025 оны 183 дугаар тогтоолоор батлагдсан үнэлгээний аргачлалыг хэрэгжүүлэх талаар нэгдсэн сургалт, арга зүйн дэмжлэг хангалтгүй байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Иймд цаашид хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах, хяналт-шинжилгээ, үнэлгээний чанар, бодитой байдлыг дээшлүүлэхэд эрх зүйн зохицуулалт, цахим систем, хүний нөөцийн чадавхыг цогцоор нь сайжруулах зайлшгүй

шаардлага байгааг онцлон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмжийг дараах байдлаар өгч байна.

## ДӨРӨВ. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ / ЗӨВЛӨМЖ /

1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн заалтын чанарыг сайжруулах
   - Хэрэгжүүлэх хугацаа, хариуцагч байгууллага, санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй, хэмжигдэхүйц бус заалтыг цаашид батлахгүй байх зарчмыг мөрдүүлэх.
   - Ач холбогдолгүй болсон, бодит хэрэгжилт боломжгүй заалтыг тогтмол шүүн хасах саналыг тухай бүр өгч хэвших.
2. Хэрэгжилт удаашралтай буюу хангалтгүй хэрэгжсэн заалтыг эрчимжүүлж ажиллахад анхаарах / Санхүүжилтээс шалтгаалж саатсан заалтуудыг дунд хугацааны төсвийн төлөвлөлттэй уялдуулах/
3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг гаргахдаа харьяа байгууллагуудын нэмэлт мэдээллийг авч тусгаж хэвших;
4. Тайланг 2000 тэмдэгтээс хэтрүүлэхгүй, зөв бичгийн алдаагүй, тодорхой, ойлгомжтой, товчилсон үггүй, эцсийн байдлаар хянагдсан тайланг заасан хугацаанд тайлагнаж хэвших;
5. Тайлан нэгтгэлийг хариуцаж буй албан хаагч удирдлагаар баталгаажуулсан эцсийн тайланг өгч хэвших;
6. Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн заалтаар өгөгдсөн үүрэг дагуу хэрэгжилтийн агуулгыг баримттайгаар тайлагнаж хэвших;
7. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас өгсөн зөвлөмжийг тухай бүр ERP системийн байгууллагын файл цэснээс авч танилцаж байх;
6. Хэрэгжээгүй үнэлгээтэй биелэлтийг хэрхэн ахиулах болон тайлагнах талаар бодлогын түвшинд төлөвлөж, Төрийн захиргааны удирдлагын газрын холбогдох албан хаагч, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын албан хаагчдаас төлөвлөлт, тайлагналтай холбоотой арга зүйн зөвлөгөө, дэмжлэг авч ажиллах;

Жич: Яамны газар, хэлтсийн дарга нар дээрх зөвлөмжүүдийг хүлээн авч, нэгжийн албан хаагчиддаа танилцуулах, танилцуулсан хугацаанаас хойш холбогдох арга хэмжээг авч ажиллах үүрэгтэй бөгөөд зөвлөмжийг хэрэгжүүлж байгаа эсэхэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас төлөвлөгөөт бус хяналт шалгалтын ажлыг хийх болохыг үүгээр мэдэгдэж байна.

-оОо-

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт
Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам
2025 оны жилийн эцэс

| Шийдвэрийн д/д | Заалтын д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтын явц | Өөрийн үнэлгээ | Хяналтаас хасах саналтай эсэх | Хяналтаас хасах санал |
|---|---|---|---|---|---|---|---|
| МУ-ын хууль | | | | | | | |
| 1 | 1 | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2019-06-06 Дугаар 2020.01.01 | 32.3.. Энэ хуулийн 32.2-т заасан хойшлуулшгүй мэдээллийг үнэ төлбөргүй яаралтай нийтэлж, нэвтрүүлэх журмыг хууль зүйн болон харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална. | Хэвлэл мэдээллийн хэрэгслийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх агуулга бүхий нийтлэл, мэдээлэл бэлтгэн нэвтрүүлэх, түүний нийт мэдээлэлд эзлэх хувь хэмжээг тогтоох тухай журам" болон "Хэвлэл мэдээллийн байгууллага гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоохтой холбогдсон хойшлуулшгүй мэдээллийг нийтэлж, нэвтрүүлэх журам"-ын төсөлд 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01/50 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд санал хүргүүлж, тус яамнаас хамаарах ажлыг хийж гүйцэтгэсэн болно. Өөрөөр хэлбэл Хууль зүйн яамнаас тус журмын төслийг боловсруулсан бөгөөд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам өөрт хамаарах ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн болно.<br><br>Хавсралт : 1 файл | Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50% | Үгүй | |
| | 2 | | 32.5.. Энэ хуулийн 32.4-т заасан агуулга бүхий нийтлэл, мэдээллийг тухайн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлж, нийтэлж байгаа нийт мэдээлэлд эзлэх хувь, заавал нэвтрүүлбэл зохих нийтлэл, мэдээллийн доод хэмжээг хууль зүйн болон харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална. | Хэвлэл мэдээллийн хэрэгслийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх агуулга бүхий нийтлэл, мэдээлэл бэлтгэн нэвтрүүлэх, түүний нийт мэдээлэлд эзлэх хувь хэмжээг тогтоох тухай журам" болон "Хэвлэл мэдээллийн байгууллага гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоохтой холбогдсон хойшлуулшгүй мэдээллийг нийтэлж, нэвтрүүлэх журам"-ын төсөлд 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01/50 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд санал хүргүүлж, тус яамнаас хамаарах ажлыг хийж гүйцэтгэсэн болно. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас тухайн журмын төслийг боловсруулсан бөгөөд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам өөрт хамаарах ажлыг бүрэн хэрэгжүүлсэн болно.<br><br>Хавсралт : 1 файл | Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50% | Үгүй | |
| 2 | 3 | Засгийн газрын тусгай сангийн тухай /Шинэчилсэн найруулга/ 2019-11-13 Дугаар 2020.01.01 | 9.7. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх, зарцуулах журмыг Засгийн газар батална. | Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9.7, Харилцаа холбооны тухай хуулийн 5.1.3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 354 дүгээр тогтоолоор "Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх, зарцуулах журам"-ыг баталсан. линк: https://legalinfo.mn/mn/detail?lawId=16960002809751 | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 3 | 4 | Өргөн нэвтрүүлгийн тухай 2019-12-12 Дугаар 2023_10 | 29.1.3. өргөн нэвтрүүлгийн сүлжээгээр дамжуулах гамшгийн болон онцгой байдлын талаар урьдчилан сэргийлэх үеийн мэдээ, мэдээлэл дамжуулах журам боловсруулж, батлах; | "Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/01 дүгээр тушаалаар ""Өргөн нэвтрүүлгийн сүлжээгээр гамшиг болон аюулын дохио, сэрэмжлүүлгийг дамжуулах журам""-ыг баталсан.<br>"<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 5 | | 29.1.4. өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан бүрдүүлэх, түүнийг зарцуулах журмыг эрх бүхий байгууллагуудтай хамтран боловсруулах; | "Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 364 дугаар тогтоолоор ""Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх, зарцуулах журам""-ыг баталсан.<br>https://legalinfo.mn/mn/detail?lawId=16960002809751 | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 6 | | 18.2. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, зах зээлийн хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх журмыг Зохицуулах хороо батална. | Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 73 дугаар тогтоолоор баталсан. https://legalinfo.mn/mn/detail?lawId=16389972057261&type=3 | Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50% | Үгүй | |
| | 7 | | 28.3. Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан бүрдүүлэх, түүнийг зарцуулах журмыг батална. | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 364 дүгээр тогтоолоор "Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн дүрэм", "Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан бүрдүүлэх, сангийн хөрөнгийг зарцуулах журам"-ыг баталсан. https://legalinfo.mn/mn/detail?lawId=16960414867061 | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 8 | | 30.1. Харилцаа холбооны зохицуулах хорооны бүрэн эрх:30.1.7.өргөн нэвтрүүлгийн үйлчилгээтэй холбогдсон дараах дүрэм, журмыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих; 30.1,7.а.хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалахад чиглэсэн радио, телевизийн хөтөлбөрийн дүрэм; 30.1.7.б.өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн журам; 30.1.7.в.олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багцын зохицуулалтын журам; | Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 62 дугаар тогтоолоор Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалахад чиглэсэн радио, телевизийн хөтөлбөрийн дүрмээр баталсан. https://legalinfo.mn/mn/detail?lawId=16381537306261 Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны 88 дугаар тогтоолоор "Радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага"-ыг баталсан. https://legalinfo.mn/mn/detail?lawId=16123495457411 Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 02 дугаар тогтоолоор "Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага"-ыг баталсан. https://legalinfo.mn/mn/detail?lawId=16147364164751 Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны 62 дугаар тогтоолоор олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багцын зохицуулалтын журам баталсан. //legalinfo.mn/mn/detail?lawId=15710 | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 4 | 9 | Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай<br>2019-12-20<br>Дугаар 2019.12.20. | 47.9.. Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журмыг цагдаагийн төв байгууллага болон Харилцаа холбооны зохицуулах хорооны саналыг үндэслэн Сонгуулийн Ерөнхий хороо хамтран баталж, мөрдүүлнэ. | Сонгуулын ерөнхий хорооны 2024 оны 14 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар "Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам"-ыг баталж, цахим орчин ашиглан ээлжит, ээлжит бус, нөхөн сонгуулийн сурталчилгаа явуулахтай холбогдсон харилцааг зохицуулж байна. https://legalinfo.mn/mn/detail?lawId=17089716019011 | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 5 | 10 | Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай<br>2020-05-15<br>Дугаар 2020-05-15 | 8.4. Эрүүл мэндийн цахим бүртгэл, мэдээллийн сангийн өгөгдөл солилцох, хадгалах, хамгаалах, баяжуулах, ашиглах журмыг Засгийн газар батална. | Эрүүл мэндийн тухай хуулийн энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар "8.4.Эрүүл мэндийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, аюулгүй байдлыг хангах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулж Засгийн газар батална." гэж заасны дагуу журмын төслийг Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Эрүүл мэндийн яамтай хамтран боловсруулж, Засгийн газрын 2024 оны 3 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанд хэлэлцүүлэн Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн "Журам батлах тухай" 100 дугаар тогтоолоор батлагдсан. https://legalinfo.mn/mn/detail?lawId=17089589971371 | Хэрэгжсэн - 100% | Тийм | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай. |
| | 11 | | 8.10.. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамжид тавигдах шаардлагыг тогтоох, үнэлгээ хийх, шаардлагад нийцсэн программ хангамжийг мэдээлэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална. | Эрүүл мэндийн тухай хуулийн 8.4, 8.10 дахь хэсэгт заасан журмыг Засгийн газрын 2024 оны 100 дугаар тогтоол, ЭМС, ЦХИХХС-ын хамтарсан 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/130, А/58 дугаар тушаалаар батлуулан 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдөр захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн.<br>Цахим хуудаст хандах: https://legalinfo.mn/mn/detail?lawId=17431252533582 | Хэрэгжсэн - 100% | Тийм | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай. |
| | 12 | | 7.1. Кибер аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хариу арга хэмжээ авах нийтлэг журмыг Засгийн газар батална. | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 224 дүгээр тогтоолоор "Кибер аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хариу арга хэмжээ авах нийтлэг журам"-ыг баталсан. Цахим хуудаст хандах: https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759862474271 | Хэрэгжсэн - 100% | Тийм | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай. |
| | 13 | | 8.3. Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам, аргачлалыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тагнуулын байгууллагатай хамтран батална. | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Тагнуулын ерөнхий газрын даргын хамтарсан 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/30, А/148 дугаар хамтарсан тушаалаар "Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам, аргачлал"-ыг баталж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн. https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141973551921 | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 14 | Кибер аюулгүй байдлын тухай | 9.5.. Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх этгээдийг бүртгэх, аудит хийх журмыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална. | Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх этгээдийг бүртгэх, аудит хийх журмыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/74 дүгээр тушаалаар баталсан.<br><br>Хавсралт : 2 файл | Хэрэгжсэн - 100% | Тийм | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | 15 | 2021-12-17<br>Дугаар 2021-12-17 | 11.3. Зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг Засгийн газар батална | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 38 дугаар тогтоолоор “Засгийн газрын үндэсний хороо, комисс, үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 350 дугаар тогтоолын 34 дүгээр хавсралт болгож “Кибер аюулгүй байдлын зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг нэмж баталсан. Зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд даргадах бөгөөд дэд даргаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Тагнуулын Ерөнхий Газрын дарга ажиллах ба гишүүнд Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга, Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд дарга, Зэвсэгт хүчний Жанжин штабын нэгдүгээр орлогч дарга, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх "Үндэсний төв", "Нийтийн төв", "Зэвсэгт хүчний төв"-ийн дарга нар болон Үндэсний дата төв УТҮГ-ын захирал, Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн захирал, Нарийн бичгийн даргаар Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга ажиллахаар бүрэлдэхүүн батлагдсан. “Кибер аюулгүй байдлын зөвлөлийн дүрэм”-ийг Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 42 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан.<br>https://legalinfo.mn/mn/detail?lawId=16758282553111 | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 7 | 16 | Цахим гарын үсгийн тухай<br>2021-12-17<br>Дугаар 2021.12.17 | 9.5. Цагийн бүртгэл хөтлөх, аюулгүй байдлыг хангахад тавигдах шаардлагыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална. | Цагийн бүртгэл хөтлөх, аюулгүй байдлыг хангахад тавигдах шаардлага"-ыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/74 дүгээр тушаалаар баталсан.<br><br>Хавсралт : 1 файл | Зохион байгуулалтаас - 0% | Үгүй | |
| | 17 | | 16.8. Төрийн албан хаагчид гэрчилгээ олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг зохицуулах журмыг Төрийн албаны зөвлөлийн саналыг харгалзан цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална. | Төрийн албан хаагчид тоон гарын үсгийн гэрчилгээ олгох, түүнийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журмыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/28 дугаар тушаалаар баталсан. https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530835387261 | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 8 | 18 | Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай<br>2021-12-17<br>Дугаар 2022.05.01 | 23.3. Энэ хуулийн 23.1-д заасан үнэлгээ хийх аргачлал, журмыг Хүний эрхийн Үндэсний Комиссын саналыг үндэслэн цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална. | "Цахим хэлбэрээр боловсруулалт хийх технологийг ашиглан мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглах үйл ажиллагаанд үнэлгээ хийх журам"-ыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн А/81 дүгээр тушаалаар баталсан. Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгэгдсэн. https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760452393121 | Хэрэгжсэн - 100% | Тийм | Бүрэн хэрэгжсэн |
| | 19 | | 8.19. Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журмыг Засгийн газар батална. | Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журмыг Засгийн газрын 2022 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 352 дугаар тогтоолоор батлуулсан.<br>Цахим хуудаст хандах: https://legalinfo.mn/mn/detail?lawId=16531445101831 | Хэрэгжсэн - 100% | Тийм | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай. |
| | 20 | | 27.9. Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах нөхцөл, бүртгүүлэх журмыг Засгийн газар батална. | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нийцүүлэн “Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах нөхцөл, бүртгэл хөтлөхтэй холбоотой харилцааг зохицуулсан журам”-ыг Засгийн газрын 2024 оны 02 дгаар сарын 28-ны өдрийн 77 дугаар тогтоолоор батлуулсан.<br>Цахим хуудаст хандах: https://legalinfo.mn/mn/detail?lawId=17089588437961 | Хэрэгжсэн - 100% | Тийм | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | 21 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай<br>2021-12-17<br>Дугаар 2022.05.01 | 28.1. Нийтийн мэдээллийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөлтийг Засгийн газар батална. | Дэлхийн ДНБ-ний 80%, ОУ-ын худалдааны 75%, Дэлхийн хүн амын гуравны хоёр (2/3), Дэлхийн газар нутгийн 60%-ийг эзэлдэг G7, G20-д багтдаг Европын холбооны гишүүн 40-өөд улсын мөрддөг баримт бичиг болох:<br>•Европын харилцан уялдааны тогтолцооны архитектур<br>•Европын харилцан уялдааны тогтолцоо<br>•Европын харилцан уялдааны тогтолцооны лавлагаа<br>•Европын цахим эрх ба зарчим<br>•Европын харилцан уялдааны архитектурыг хөгжүүлэх үйл ажиллагаа<br>•Эстони Улсын X-Road системийн тухай<br>•Европын дижитал 10 жилийн хөтөлбөр(The European Digital decade program 2030)<br>• Олон Улсын эдийн засаг, хөгжлийн агентлагаас гаргасан Цахи засаглалын бодлогын хүрээ зэрэг баримт бичгүүдийг судалсан.<br>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан үндсэн систем, дэмжих систем, мэдээлэл хариуцагчийн систем болон мэдээллийн сүлжээ, нийтийн мэдээллийн сангийн хэрэглээ, түүний ашиглалтын өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлж, Нийтийн мэдээллийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөлтийн зураглалыг гаргаж, нэгдсэн зөвлөмж, заавар боловсруулах зорилготой тендерийн ажлын даалгавар, тендерийн баримт бичгийг тус тус боловсруулж, уг тендерийг 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зарласан боловч, оролцогч орж ирээгүй. Тиймээс Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/319 дүгээр тушаалаар ажлын хэсэг байгуулж, журмын төслийг боловсруулж байна.<br><br>Хавсралт : 1 файл | Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50% | Үгүй | |
| 9 | 22 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай<br>2021-12-17<br>Дугаар 2022.05.01 | 28.3. Нийтийн мэдээллийн дэд бүтцийн төлөвлөлтийн нийтлэг журмыг Засгийн газар батална. | Дэлхийн ДНБ-ний 80%, ОУ-ын худалдааны 75%, Дэлхийн хүн амын гуравны хоёр (2/3), Дэлхийн газар нутгийн 60%-ийг эзэлдэг G7, G20-д багтдаг Европын холбооны гишүүн 40-өөд улсын мөрддөг баримт бичиг болох:<br>•Европын харилцан уялдааны тогтолцооны архитектур<br>•Европын харилцан уялдааны тогтолцоо<br>•Европын харилцан уялдааны тогтолцооны лавлагаа<br>•Европын цахим эрх ба зарчим<br>•Европын харилцан уялдааны архитектурыг хөгжүүлэх үйл ажиллагаа<br>•Эстони Улсын X-Road системийн тухай<br>•Европын дижитал 10 жилийн хөтөлбөр(The European Digital decade program 2030)<br>• Олон Улсын эдийн засаг, хөгжлийн агентлагаас гаргасан Цахи засаглалын бодлогын хүрээ зэрэг баримт бичгүүдийг судалсан.<br>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан үндсэн систем, дэмжих систем, мэдээлэл хариуцагчийн систем болон мэдээллийн сүлжээ, нийтийн мэдээллийн сангийн хэрэглээ, түүний ашиглалтын өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлж, Нийтийн мэдээллийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөлтийн зураглалыг гаргаж, нэгдсэн зөвлөмж, заавар боловсруулах зорилготой тендерийн ажлын даалгавар, тендерийн баримт бичгийг тус тус боловсруулж, уг тендерийг 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зарласан боловч, оролцогч орж ирээгүй. Тиймээс Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/319 дүгээр тушаалаар ажлын хэсэг байгуулж, журмын төслийг боловсруулж байна.<br><br>Хавсралт : 1 файл | Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 10 | 23 | Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай<br>2021-12-24<br>Дугаар 2021-12-24 | 33.5.. Мэдээллийн сангийн бүрдэл, уг санг бүрдүүлэх, нууцлал, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдал, байгууллага хооронд мэдээлэл солилцохтой холбоотой журмыг Засгийн газар тогтооно. | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29.1-д заасны дагуу зөвлөмж, дүгнэлт гаргуулах хүсэлт ирүүлээгүй. | Зохион байгуулалтаас - 0% | Үгүй | |
| 11 | 24 | Шүүх шинжилгээний тухай<br>2022-12-23<br>Дугаар 2022.12.23 | 36.4. Цахим технологийн шинжилгээ хийх журмыг хууль зүйн болон цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална. | Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын хамтарсан 2023 оны 09 дүгээр сарын 13-ний өдрийн А/315, А/91 дүгээр тушаалаар "Цахим технологийн шинжилгээ хийх журам" батлагдсан.<br>Цахим хуудаст хандах: https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760360582021 | Хэрэгжсэн - 100% | Тийм | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай. |
| 12 | 25 | Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай /Шинэчилсэн найруулга/<br>2024-06-05<br>Дугаар 2024.06.05 | 14.2.. Энэ хуулийн 14.1.3-т заасан зохицуулалтын сэндбокс орчны бий болгох, үйл ажиллагаа явуулах журмыг Засгийн газар батална. | Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6-д заасны дагуу дэвшилтэт технологийн сэндбокс орчны талаарх гадаад улс орны туршлагыг судалж, “Хиймэл оюун, их өгөгдөл, блокчэйн, сансрын үйлдвэрлэлийн дэвшилтэт технологид суурилсан сэндбоксын журам”-ын төслийг эхний байдлаар боловсруулсан. | Зохион байгуулалтаас - 0% | Үгүй | |
| 13 | 26 | Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих<br>2024-06-05<br>Дугаар 2024.06.05 | 11.7.. Зөвлөлийн бүрэлдэхүүн, түүний ажиллах журам болон виртуал бүсийн ажиллах журмыг Засгийн газар батална. | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 97 дугаар тогтоолоор “Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх үндэсний зөвлөл, түүний бүрэлдэхүүн, ажиллах журам”-ыг баталсан.<br>“Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн ажиллах журам”-ын төслийг Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх Үндэсний зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн хуралд танилцуулан хэлэлцүүлсэн бөгөөд хурлын шийдвэрээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр тогтсон.<br>Дээрх шийдвэрийн дагуу Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн 98 дугаар тогтоолоор "Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн ажиллах журам"-ыг баталсан.<br><br>https://legalinfo.mn/mn/detail?lawId=17434151754902"<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Тийм | Бүрэн хэрэгжсэн тул хасах саналтай |
| | 27 | | 13.4.. Энэ хуулийн 13.2, 13.3-т заасан татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар батална. | Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 13.4-т заасны дагуу “Виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд үзүүлэх татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх журам”-ыг Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 98-р тогтоолоор батлуулсан.<br><br>Хавсралт : 2 файл | Хэрэгжсэн - 100% | Тийм | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай. |
| 14 | 28 | Хүүхэд хамгааллын тухай<br>2025-01-17<br>Дугаар 2024.01.17. | 25.11.. Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журмыг цахим хөгжил, харилцаа холбооны, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална. | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд нарын хамтарсан 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/53, А/95, А/76 дугаар тушаалаар "Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам"-ыг баталсан.<br>https://legalinfo.mn/mn/detail?lawId=17430823278592 | Хэрэгжсэн - 100% | Тийм | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай. |
| УИХ-ын тогтоол | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 15 | 29 | Улсын бүртгэлийн багц хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай<br>2018-06-21<br>Дугаар 2018 №54 | 1.2/. Төрийн мэдээлэл солилцох, түүний аюулгүй байдлыг хангах, өгөгдөл хамгаалах, цахим засгийг бэхжүүлэхтэй холбогдсон эрх зүйн орчныг боловсронгуй болгохтой холбоотой арга хэмжээг судалж танилцуулах; | Төрийн мэдээлэл солилцох, түүний аюулгүй байдлыг хангах, хүний хувийн мэдээллийг хамгаалах, цахим засаглалыг хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэхээр Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, УИХ-ын 2021 оны 12 тогтоолоор баталсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-д заасны дагуу "Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль", "Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль", "Кибер аюулгүй байдлын тухай хууль", "Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын тухай хууль"-н төслүүдийг боловсруулан Засгийн газрын 2021 оны 3 сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 2021 оны 5 сарын 19-ний өдөр УИХ-д өргөн барьсан.УИХ-ын даргын 2021 оны 7-р сарын 06-ны өдрийн 54 дүгээр захирамжаар Хуулийн төслийг Байнгийн хорооны болон чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий, УИХ-ын гишүүн Н.Учралаар ахлуулсан ажлын хэсгийг байгуулан холбогдох байнгийн хороодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажилласан. "Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль", "Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль", "Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын тухай хууль"-н төслийг УИХ-ын 2021 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн "Кибер аюулгүй байдлын тухай хуулийн төсөл"-ийг УИХ-ын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар эцсийн хэлэлцүүлгийг тус тус хийж 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдөр шинэчилсэн найруулгаар батлагдсан байна. Хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | Хэрэгжсэн - 100% | Тийм | хэрэгжсэн. |
| 16 | 30 | Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай<br>2020-04-29<br>Дугаар 2020 №32 | 2.9/. Төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх; | Төрийн 1,150 байгууллагаас үзүүлж байгаа 6,080 үйлчилгээ (давхардсан тоогоор)-ээс 4,405 үйлчилгээ нь цахим хэлбэрт шилжсэн бөгөөд үүнээс 1,268 үйлчилгээ (давхардаагүй тоогоор)-г Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-Mongolia.mn)-д холбож, төрийн үйлчилгээний e-Mongolia.mn портал, операторын систем, киоск машин, мобайл аппликейшн, хуулийн этгээдэд зориулсан e-business.mn платформ, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын lavlagaa.e-mongolia.mn гэсэн 6 сувгаар дамжуулан иргэн, хуулийн этгээдэд хүргэж байна. Мэдээлэл хариуцагч байгууллага нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.10 дахь хэсэгт заасан "Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам"-д заасны дагуу үндсэн болон дэмжих системд холбогдон Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia.mn)-ээр дамжуулан үйлчилгээгээ хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үзүүлж байна.<br>Төрийн болон салбарын үйлчилгээг бүрэн цахим хэлбэрт шилжүүлэх, цахим гарын үсэг, цахим архив, цахим маягтыг нэвтрүүлснээр цаас, тээвэр, шуудангийн хэрэглээг бууруулав. Төрийн үйлчилгээний нэгдсэн системд 2025 онд 1,064 хэрэглэгч шинээр нэмэгдсэнээр нийт бүртгэлтэй хэрэглэгчийн тоо 2,087,342 хүрч, нийт 88 байгууллагын 1268 үйлчилгээг 94 сая удаа үзүүлсэн байна. Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр үзүүлсэн нийт үйлчилгээ нь 1,902,352,347,902 төгрөгийн шууд бус зардлыг хэмнэсэн. Үүнээс 2025 онд 612,478,720,913 төгрөгийн хэмнэлт хийсэн байна.<br>Албан бичиг солилцооны дундын систем DocX-ээр дамжуулан 2025 онд 3,040 байгууллага тус системтэй холболт хийж, 354,888 бичиг илгээж, 402,724 албан бичиг хүлээн аваад байна.<br>Монгол Улсын хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 1,945,161 буюу Монпасс СА ХХК 95554, Ньюкомпасс ХХК 49,985, Тридум 46,445, Үндэсний дата төв 14,293, Ви Эс Эм 138, Улсын бүртгэлийн ерөнхий газар 1,738,746 иргэнд тоон гарын үсэг олгосон байна.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 17 | 31 | “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай 2020-05-13 Дугаар 2020 №52 | 3.1/. Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т үүрэг болгосугай: 1/Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үндэсний, салбарын, салбар хоорондын болон бүс нутаг, аймаг, нийслэлийн түвшний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгаж, шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсвийн болон санхүүжилтийн бусад эх үүсвэрээс төлөвлөн үе шаттайгаар хэрэгжүүлэх; | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны чиг үүрэгт хамаарах "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тухай бүр тайлагнаж байна. Мөн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт туссан зорилт, арга хэмжээний биелэлтийг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Эдийн засаг хөгжлийн яам гэх мэт байгууллагуудад тус тус албан бичгээр тайлагнаж байна. Түүнчлэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны А/05 дугаар тушаалаар сайдын эрхлэх асуудлын хүрээний 2024-2028 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг баталсан. Стратеги болон бусад богино, дунд хугацааны бодлогын баримт бичигт урт хугацааны бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээг тусгасан болно. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 18 | 32 | Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2021-12-17 Дугаар 2021 №99 | 1. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд шаардагдах техник, тоног төхөөрөмж, хүний нөөц болон бусад холбогдох зардлыг 2023 оноос эхлэн жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлэх, шаардлагатай бусад дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай. | Тус заалт нь Санхүүгийн зохицуулах хорооны чиг үүрэгт хамааралтай бөгөөд тус яамнаас Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/171 дүгээр тушаалын дагуу байгуулагдсан Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үнэлгээ хийх дэд ажлын хэсэг (Модуль 11)-т ажиллаж, “Цахим “хар зах” руу нэвтрэх (dark web)” бүлгийг судлах дэд статистикууд болох Dark web ашиглан террористууд виртуал хөрөнгөөр галт зэвсэг худалдан авах эрсдэлийн судалгааг хийж гүйцэтгэн дэмжлэгг үзүүлсэн. | Хэрэгжсэн - 100% | Тийм | Үндсэн чиг үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хариуцах тул хасуулах саналтай. |
| 19 | 33 | Монгол хүний удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах, хүн амын өсөлтийг дэмжих талаар авах арга хэмжээний тухай 2022-01-14 Дугаар 2022 №1 | 1.2/. Монгол хүний удмын санг цус ойртолт, удамшлын өвчлөлөөс сэргийлэх зорилгоор "Угийн бичиг"-ийг айл өрх бүрд шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хөтлүүлэн хэвшүүлэх ажлыг орон даяар 2024 онд багтаан хэрэгжүүлэх, шаардлагатай бол холбогдох судалгаанд тулгуурлан ургийн овгийн нэршлийг шинэчлэх арга хэмжээг зохион байгуулах; | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам нь udam.mn, ugiinbichig.mn, ugiinbichig.com зэрэг системүүдийг судалж, Удам.мн системийг хариуцан ажилладаг “Старсофт” ХХК-тай "ҮНДСЭН СИСТЕМ (ХУР)-ИЙГ АШИГЛАН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ"-г байгуулан ажиллаж байна. Ингэснээр үндсэн системээр мэдээлэл солилцох боломж бүрдсэн. Эртний соёл уламжлалаа өнөө үед сэргээхдээ мэдээллийн технологи ашиглан хөтлөх нь илүү оновчтой шийдэл юм. Старсофт компанийн залуус УДАМ төслийг санаачлан 2013 онд гар утсанд УГИЙН БИЧИГ хөтлөх апп хэлбэрээр зохиосон энэхүү систем нь УДАМ нэртэй болж, вэб програм бүтээгдэн хөгжиж байна. УДАМ төсөл нь мэдээллийн технологи ашиглан олуулаа нэг овгийн хүмүүс хамтдаа угийн бичгээ хөтөлж, удмын түүхээ бүтээх боломжийг нийт Монголчууддаа олгож байна. Мөн тэд Үндэсний архивын ерөнхий газартай хамтран 1933 он ба түүнээс өмнөх хүн амын тооллогын мэдээллийг цахимжуулж олон нийт ашиглах боломжийг бий болгосон.Монгол улсын бүх аймаг сумаас уг гаралтай 71,000+ овог УДАМ сүлжээнд үүсээд байна. https://www.udam.mn | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 20 | 34 | МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ<br>2022-11-11<br>Дугаар 2022 №72 | 1.2. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого", 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний бэлтгэл ажил, зураг төсөв болон техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлыг 2023 онд шуурхай зохион байгуулах; | Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын багцын 2024 оны төсвийн төсөл боловсруулахдаа "Шинэ сэргэлтийн бодлого", 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний бэлтгэл ажлыг төлөвлөн Ухаалаг засаг 2 төслөөс шийдвэрлэх боломжтой эсэх судалгаа хийж, Сангийн яаманд 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 01/1254 дугаартай албан бичгээр төсвийн төсөөллийг бэлтгэн хүргүүлсэн. ''Цахим үндэстэн'' болох арга хэмжээг эрчимжүүлж, нийтийн мэдээллийн дэд бүтцийг боловсронгуй болгож, цаасан суурьтай үйл ажиллагааг багасган цахим харилцаанд шилжиж, нийтийн мэдээллийн системээс олж авах, солилцох боломжтой мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй байх нөхцөлийг хангаж, цахимаар үзүүлэх төрийн үйлчилгээний хүртээмж, тоог нэмэгдүүлж, иргэнийг цахим гарын үсгээр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх 1 арга хэмжээ бодлогод туссан бөгөөд биелэлт 100% хэрэгжиж байна. E-mongolia.mn-д нэвтэрсэн төрийн үйлчилгээний мэдээллийг үзэх бүрэн боломжтой. www.e-mongolia.mn | Хэрэгжсэн - 100% | Тийм | хэрэгжилтийг тооцох хугацаа дууссан. Мөн хэрэгжилт бүрэн биелэгдсэн. |
| | 35 | | 1.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийнх нь эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулах; | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас алслагдсан багуудад харилцаа холбооны сүлжээний дэд бүтэц байгуулахад шаардлагатай нэг маягийн зураг төсөл, төсвийг төслийн ашиглагч байгууллага болон зураг төсвийн тусгай зөвшөөрөлтэй компанитай хамтран боловсруулж, уг зураг төсөл, төсөвт Барилгын хөгжлийн төвөөр магадлал хийлгүүлэхээр хүргүүлсэн. | Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50% | Үгүй | |
| 21 | 36 | ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ<br>2023-01-12<br>Дугаар 2023 №06 | 1.3. уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааг цахимжуулж, үндэсний мэдээллийн технологийн компаниудын хөгжүүлсэн систем, программ хангамжийг биржийн үйл ажиллагаанд ашиглах боломжтой эсэхийг судалж, холбогдох арга хэмжээ авах. | Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааг цахимжуулж, үндэсний мэдээллийн технологийн компаниудын хөгжүүлсэн системийг ашиглах талаар Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29.1-д заасны дагуу зөвлөмж, дүгнэлт гаргуулах хүсэлт ирүүлээгүй. | Хэрэгжүүлэх хугацаа тодорхойгүй | Үгүй | |
| 22 | 37 | ОРХОНЫ ХӨНДИЙД "ШИНЭ ХАРХОРУМ" ХОТ БАЙГУУЛАХ ТУХАЙ<br>2023-01-12<br>Дугаар 2023 №07 | 2.2. "Шинэ Хархорум" хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, зам, тээвэр, эрчим хүч, инженерийн дэд бүтцийн хангамжийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулах; | Шинэ Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалтын ажлын хүрээнд хийгдэх эхний ээлжийн арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, төлөвлөгөөг гаргаж 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/438 дугаар албан бичгээр, мөн танилцуулгыг 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 01/780 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Шинэ Хархорум хотын эхний ээлжийн мэдээлэл, харилцаа холбооны худаг, сувагчлал, шилэн кабелийн ажлын зураг, төсөв боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам яамны төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч болон Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 2024/02 дугаар бүхий ажлын даалгаврыг баталсан. Шинэ Хархорум хотын эхний ээлжийн мэдээлэл, харилцаа холбооны худаг, сувагчлал, шилэн кабелийн ажлын зураг, төсөв боловсруулах ажлын өртөгт саналаа Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 03/385 албан бичгээр Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яаманд хүргүүлсэн. Шинэ хар хорум бүтээн байгуулалтын үндэсний хорооны 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд саналаа 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр Шинэ хар хорум хотын захиргаанд хүргүүлсэн. 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдөр нээлттэй тендер шалгаруулалтыг Төрийн худалдан авах ажиллагааны газраас зарласан боловч шаардлага хангасан тендер ирүүлээгүй тул тендер шалгаруулалт амжилтгүй болсон. 2025 оны төсвийн тухай хуулийн тодортголоор төсөвт өртөг татагдсан. | Санхүү, хөрөнгө оруулалтаас - 0% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 23 | 38 | АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ<br>2023-06-30<br>Дугаар 2023_59 | 3. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагааг улсын болон аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар ханган хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Авлигатай тэмцэх газар /З.Дашдаваа/-т тус тус үүрэг болгосугай. | Цахим хөгжил, харилцаа холбооны яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагааг хангах, хэрэгжилтийг зохион байгуулж байна. Авлигатай тэмцэх газраас Харилцаа холбооны сүлжээний дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилттэй холбоотой тодруулга авах хүсэлтийн дагуу холбогдох албан тушаалтнуудыг оролцуулан 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр уулзалт зохион байгуулсан. Уг уулзалтын хүрээнд яригдсан асуудалтай холбогдуулан нэмэлт мэдээлэл бэлтгэж, byambadorj@jaac.mn цахим шуудангаар хүргүүлсэн. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024 оны А/29 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан “Харилцаа холбооны сүлжээний дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Авлигатай тэмцэх газрын холбогдох албан тушаалтнуудтай уулзалт зохион байгуулж, Яаралтай тусламжийн зориулалттай тусгай дугаар болон Төлбөргүй үйлчилгээний зориулалттай тусгай дугаарлалт (Toll free)-ын ялгаа, зааг болон Олон Улсын Цахилгаан Холбооны Байгууллагаас гаргасан зөвлөмж /ITU-T E.161.1/-ийн талаар мэдээлэл өгч, санал солилцов. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 24 | 39 | МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ<br>2023-11-10<br>Дугаар 2023_93 | 1.10. төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, ашиглалтад хүлээн авах, өмчид хүлээн авах үйл ажиллагаанд ногоон байгууламжийн стандарт болон тусгай хэрэгцээт иргэдийн хэрэгцээнд нийцсэн стандартыг чанд мөрдөж хэрэгжүүлэх, зохион байгуулах; | Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд зааснаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ төсөл (УТ2506700069), Сэлгэн ажиллах дата төвийн нөөцийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/ төсөл (УТ2506700014), Хил хамгаалах ерөнхий газарт хэрэгжүүлэх “BPF-24mn” дрон бүтээх, турших, үйлдвэрлэж албанд нэвтрүүлэх (УТ2506700099) 3 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны газарт зохион байгуулсан.<br>Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтад Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцад батлагдсан “Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны салбарын тоног төхөөрөмж /улсын хэмжээнд/” төслийн хүрээнд нийт 6,863,400,000 төгрөгийн өртөг бүхий 22 нэр төрлийн тоног төхөөрөмж (галт хана, сүлжээний төхөөрөмж болон Dell VxRail VP-760 загварын 20 ширхэг сервер)-ийг 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр хүлээн авч, Үндэсний дата төв УТҮГ-т хүлээлгэн өгсөн. Бусад ажлуудын хувьд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсөв татагдсан бөгөөд барилга байгууламж биш, тоног төхөөрөмж тул ногоон байгууламжийн стандарт болон тусгай хэрэгцээт иргэдийн хэрэгцээнд нийцсэн стандартыг чанд мөрдөж хэрэгжүүлэх, зохион байгуулах шаардлагын талаар тайлагнах боломжгүй байна. | Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй | Үгүй | |
| 24 | 40 | | 1.2. Кибер аюулгүй байдлын тухай хуульд заасан онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй болон холбогдох бусад байгууллагад мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо, чанарын менежментийн тогтолцоо, бизнесийн тасралтгүй байдлын менежментийн тогтолцоо, хүний хувийн мэдээллийг хамгаалах менежментийн тогтолцооны олон улсын стандартыг нэвтрүүлэх, кибер аюулгүй байдлын мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх хүрээнд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын кибер аюулгүй байдлын менежментийн тогтолцоог сайжруулах хүрээнд Их Британийн Засгийн газартай хамтран Монгол Улсын Үндэсний кибер эрсдэлийг тодорхойлох судалгааг 2025 оны 09-12 дугаар сарын хооронд хэрэгжүүлсэн. Үндэсний кибер эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийг бууруулах арга хэмжээнүүдийг төлөвлөх зорилго бүхий судалгааг 2025 оны 10 дугаар сарын 27-31-ний өдрүүдэд зохион байгуулсан. Энэхүү судалгаанд онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй 25 байгууллага хамрагдаж, байгууллага бүрээр кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний тайлан боловсруулж, зөвлөмжийг гаргаж байна. Цаашид энэхүү аргачлалаар онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын кибер эрсдэлийг тодорхойлох, түүнийг удирдах арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлэх боломжтой. Мөн төслийн хүрээнд Их Британийн кибер аюулгүй байдлын экспертүүд Монгол Улсад биечлэн ирж, Үндэсний кибер эрсдэлийг тодорхойлох арга аргачлал, тайлан, зөвлөмж боловсруулах талаар сургалт хийсэн. Мөн кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх зөвшөөрөл бүхий байгууллагуудад, кибер халдлага, зөрчилтэй тэмцэх төвүүдийн эрсдэлийн үнэлгээ хийх, тайлан хүлээн авах чиг үүргийг хариуцсан албан хаагчдад нийт 2 удаагийн сургалт хийж, мэдээлэл солилцсон.<br>https://mddic.gov.mn/mn/2025/10/22776/ | Тодорхой үр дүнд хүрсэн - 50% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 25 | 41 | Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2024-01-12 Дугаар 2024_05 | 1.3. үндэсний цахим шилжилтийг эрчимжүүлж, нийгэм, эдийн засгийн бүх салбарт мэдээллийн технологийн инновац, их өгөгдлийн шинжилгээ, хиймэл оюун ухаан ашиглах боломжийг нээх үүднээс төрд байгаа гааль, татвар, санхүүгийн болон бусад мэдээллийг хуульд заасан журмын дагуу мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгосны үндсэн дээр нээлттэй өгөгдөл болгох, нээлттэй өгөгдлийг хиймэл оюун ухааны тусламжтай болон бусад хэлбэрээр боловсруулж ашиглах, эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг зохион байгуулах, төрийн байгууллагын суурь болон төрөлжсөн мэдээллийн санд нэгдсэн үзлэг, шалгалтыг 2024 онд багтаан хийж давхардал, зөрчлийг арилгах арга хэмжээг авах; | Мэдээллийн нэгдсэн цахим сан үүсээгүй. | Зохион байгуулалтаас - 0% | Үгүй | |
| | 42 | | 1.5. цахим шилжилтийн суурь дэд бүтэц болох харилцаа холбооны дэд бүтцийн давхардсан хөрөнгө оруулалтыг багасгах, дэд бүтцийн ашиглалтыг нэмэгдүүлж, иргэдийг хөдөлгөөнт интернэтээр тасралтгүй, найдвартай, хүртээмжтэйгээр хангах зорилгоор дотоодын роуминг, дэд бүтэц хуваалцах болон бусад олон улсын туршлага, арга, хэлбэрийг судалж, төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх; | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар харилцаа холбооны дэд бүтцийн барилга байгууламж байгуулах ажлыг, 100 хувь төрийн өмчит компаниар интернэтийн дамжуулах урсгал, түүний ашиглалт, үйлчилгээг хариуцуулж, хувийн хэвшил болох үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчдээр алслагдсан багт баригдсан дэд бүтцэд үүрэн холбооны бааз станц суурилуулах, иргэдийг үүрэн холбоо болон интернэтийн үйлчилгээгээр хангах зэрэг ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг хангаан ажиллаж байна. | Ахиц гарсан - 50% | Үгүй | |
| | 43 | | 2.. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан бодлого, хууль тогтоомжийг иргэд, олон нийтэд тайлбарлан таниулах, иргэдээс санал авах ажлыг хэрэгжүүлэх хүрээнд дараах арга хэмжээг авч, хамтран зохион байгуулах, холбогдох зардлыг шийдвэрлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай: | 1.Монгол Улсын Засгийн газраас санаачлан боловсруулсан төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, хүн, хуулийн этгээдийн төрийн байгууллагаас авах үйлчилгээг цахимжуулах, цахим баримт бичгийг хүлээн зөвшөөрөх, төр өөрт байгаа мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор нийт 109 хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан. Хууль тогтоомжийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэгт “Засгийн газар, холбогдох төрийн захиргааны төв байгууллага хууль тогтоомжийг өөрийн бүрэн эрх, чиг үүргийн дагуу харьяалах салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулна.” гэж заасны дагуу дээр дурдсан хуулиудад орсон нэмэлт, өөрчлөлтийг танилцуулах, хуулийн хэрэгжилтийг зохион байгуулахтай холбогдуулан хууль зүй, эрүүл мэнд, банк, санхүүгийн салбарт “Шилэн төр, төрийн хурдан үйлчилгээ” сэдэвт уулзалт, зөвлөгөөнийг 2024 оны 03 дугаар сарын 14, 26-ны өдөр боловсролын салбарын 500, эрүүл мэндийн салбарын 400 орчим албан хаагчийг хамруулан зохион байгуулж, арга хэмжээний үеэр Цахим хөгжил, харилцаа холбооны сайд “Шилэн төр, төрийн хурдан үйлчилгээ” сэдэвт илтгэл тавьсан.<br>2."Засгийн газрын бүрэн эрхийн хүрээнд хамаарах нийтийн ашиг сонирхлыг хөндсөн дараах асуудлаар гаргасан иргэн, хуулийн этгээдийн саналыг Монгол Улсын 18 насанд хүрсэн 50 мянган иргэн дэмжсэн бол хуралдаанаар хэлэлцүүлнэ.” гэж Засгийн газрын хуралдааны журамд өөрчлөлт орсны дагуу иргэдийн санал, санаачилгыг хүлээн авах Засгийн газрын цахим систем (d-gov.mn)-ийг хөгжүүлж, 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр ашиглалтад оруулсан.<br>Цахим хуудаст хандах: https://www.d-gov.mn/ | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 26 | 44 | Засгийн газарт чиглэл өгөх тухай<br>2024-01-17<br>Дугаар 2024_11 | 3.. Энэ тогтоолын 2 дахь заалтад заасан дүн шинжилгээ хийхэд шаардлагатай мэдээллээр хангаж, туслалцаа үзүүлж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай. | Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9.2, 22.9.10, 22.9.11-т заасан харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын үйл ажиллагааг нийгмийн хариуцлагын хүрээнд дэмжих зорилгоор элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт, харилцан хамааралгүй бусад этгээдээс олгосон санхүүгийн дэмжлэг, хандивын зардлыг гаргасан ахуйн нэгж, байгууллагад хуульд заасан татварын хөнгөлөлт олгоход тавигдах шаардлагын төслийг боловсруулан Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн А/79 дүгээр тушаалаар батлуулсныг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 7258 дугаарт бүртгэсэн.<br><br>Хавсралт : 1 файл | Ахиц гарсан - 50% | Үгүй | |
| 27 | 45 | Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээний хэрэгжилтийн талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2024-03-29<br>Дугаар 2024_24 | 2.б. Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээний хэрэгжилтийг хариуцах төрийн байгууллага хоорондын уялдаа холбоо, мэдээлэл дамжуулах, солилцох мэдээллийн нэгдсэн цахим санг бий болгох; | Мэдээллийн нэгдсэн цахим сан үүсээгүй. | Зохион байгуулалтаас - 0% | Үгүй | |
| 28 | 46 | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай<br>2024-04-18<br>Дугаар 2024_27 | 2. 2.Хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагаа, арга хэмжээг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7, 6.8, 6.9 дэх хэсэгт заасны дагуу үндсэн чиглэл, хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Ёс зүйн хороо, Засгийн газрын, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо, бүх шатны томилох эрх бүхий албан тушаалтанд тус тус даалгасугай. | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны бүтэц зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан “Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн”-ийг Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/126 дугаар тушаалаар шинэчлэн баталсан. Ёс зүйн дэд хорооноос 2024 оны 11 дүгээр сарыг "Төрийн албан хаагчийн ёс зүйн" сар болгон зарлаж, 7 хоног бүрийн Пүрэв гаригт Ёс зүйн талаарх 4 удаагийн сургалтад тус яам болон харьяа байгууллагын албан хаагчдыг хамруулсан. Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор баталсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ыг нийт албан хаагчдад танилцуулж, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны цахим хуудаст байршуулсан. Монгол Улсын ёс зүйн хороо Удирдлагын академиас хамтран зохион байгуулсан Ёс зүйн сургагч багш бэлтгэх анхан шатны 32 багц цагийн хөтөлбөрт Ёс зүйн дэд хорооны 2 гишүүн 2025 оны 05 дугаар сарын 21-23, 27-ны өдрүүдэд хамрагдаж, Удирдлагын академийн захирлын 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/285 дугаар тушаалаар үнэмлэхтэй төгссөн.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 29 | 47 | Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2024-05-02 Дугаар 2024_37 | 7.д. д/Монгол Улсын цахим хөгжлийн бодлогод хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралын чанар, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх шинэ технологийг нэвтрүүлэх, хөгжүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэхэд чиглэсэн судалгаа, хөрөнгө оруулалтын арга хэмжээг тусган хэрэгжүүлэх. | Харааны бэрхшээлтэй иргэнд мэдээлэл технологийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2024 оны 3, 5-р саруудад сургалт зохион байгуулж, нийт 2 удаагийн 120 цагийн сургалтад 10 харааны бэрхшээлтэй иргэнийг чадавхжуулж, гэрчилгээ олгосон. Мөн хүртээмжтэй технологийг 6 агуулгыг шинэчлэн сайжруулж, сургалтын контентыг боловсруулж, 11 удаагийн сургалтад 335 иргэнийг хамруулсан байна. E-Mongolia системд 49996 хөгжлийн бэрхшээлтэй иргэний карт үүссэн байна. Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар 2024 онд “Бүх нийтийн цахим ур чадвар бүтцийн хүрээн”-нд заасан үйл ажиллагааны хүрээнд “Цахимд зөв байя” 3 дугаар шатны аян зохион байгуулж, аянд 21 аймаг, 9 дүүргийн төрийн албан хаагч, аж ахуйн нэгж, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, оюутан, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид нийт 20000 гаруй иргэд хамрагдсан байна. ЦХИХХСайдын 2025.05.22-ны өдрийн А/83 дугаар тушаалаар салбарын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хангахад чиглэсэн хууль, тогтоомж, төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын орон тооны бус дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Төрийн нарийн бичгийн даргаар тушаалаар 2025.05.23-ны өдөр Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, харилцаа холбоо, мэдээлэл, технологийн салбарын орон тооны бус дэд зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан. Төрийн нарийн бичгийн даргын 2025.06.06-ны өдрийн 02/1377 дугаар албан бичгээр харьяа, салбар газруудад хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 4 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 30 | 48 | Ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох, төлбөр, татвар ногдуулах, хураахтай холбоотой үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2024-06-05 Дугаар 2024_62 | 1.5. 5/хамгаалалтын бүс тогтоосон түүх, соёлын дурсгалт газар, гол, мөрний урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газар, усны сан бүхий газар, улсын тусгай хамгаалалттай газар нь ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайтай давхацсан асуудлыг судалж, төрийн байгууллагын мэдээлэл зөрүүтэй байгаад дүгнэлт хийж, мэдээллийн сан хоорондын уялдааг хангах, газрын нэгдмэл сангийн удирдлагын цахим системтэй холбох арга хэмжээг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан зохион байгуулах; | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас санал ирүүлээгүй байна. | Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй | Үгүй | |
| 31 | 49 | Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2024-06-05 Дугаар 2024_74 | 1.2. 2/хотын Зөвлөл, Захирагчийн сонгуулийг цахимаар явуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудлыг судалж, танилцуулах. | Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 07 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах нэгдсэн төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх ажлын хүрээнд ашиглах технологийн шийдэлтэй танилцаж, 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 03/370 дугаар албан бичгээр Сонгуулийн ерөнхий хороонд хариу хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 50 | | 2.3. 3/Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон жил бүрийн улсын төсөвт тусган хэрэгжүүлэх; | Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-т заасны дагуу Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны Төсвийн хүрээний мэдэгдлийг 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 01/740 дугаартай албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 32 | 51 | Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай<br>2024-08-27<br>Дугаар 2024_21 | 2.4. 4/Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнахдаа энэ тогтоолын 2 дугаар хавсралтад заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх; | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөлд тусгах саналаа 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 01/1522 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн. 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан арга хэмжээний биелэлтийг Хяналт хэрэгжүүлэх газарт 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 03/1400 дугаарт албан бичгээр, 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан арга хэмжээний биелэлт, биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цахим систем (unelgee.gov.mn)-д 2024 оны жилийн эцсийн тайлагнасан. Мөн 2025 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 01/1564, жилийн эцсийн ХШҮ-ний тайланг 2025 оны 12 дугаар сарын 25-ны өрийн 01/2954 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 2 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 33 | 52 | Засгийн газарт чиглэл өгөх тухай<br>2024-12-12<br>Дугаар 2024_52 | 4.1. 1/төрийн байгууллагуудад ашиглаж байгаа мэдээллийн систем, программ хангамж, тоног төхөөрөмжийн ашиглалтын өнөөгийн байдал болон кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, мэдээллийн аюулгүй байдалд аудит хийж тайланг 2025 оны нэгдүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах | Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-т Кибер аюулгүй байдлыг хангах зардлын ангиллыг шинээр нэмж тусгах талаарх саналыг Сангийн яаманд 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 01/724, 2025 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 01/518 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Мөн 2025 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр Сангийн яамны холбогдох газрын даргатай уулзалт хийсэн. Зардлын эдийн засгийн ангилалд нэмэлт өөрчлөлт оруулах нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй бүх төрлийн хуулийн этгээдийн санхүүгийн мэдээллийн систем, сүлжээнд өөрчлөлт оруулах томоохон ажил тул одоогоор шууд өөрчлөлт оруулах боломжгүй боловч 2025 оны III улиралд “Зардлын эдийн засгийн ангилал”-д мэдээллийн технологи, кибер аюулгүй байдал гэсэн ангиллыг нэмэх талаар Сангийн яамтай тохиролцсон. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Шадар сайдын ажлын алба, Тагнуулын ерөнхий газар, Төрийн худалдан авах ажиллагааны газар, Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төв, Үндэсний дата төвийг хамарсан Ажлын хэсгийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны А/37 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна. Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 5,671 байгууллагын 17% буюу 939 байгууллагад 49,017 компьютер ашиглаж байгаагийн 88.5% нь, мөн 2,261 сервер ашиглаж байгаагийн 79% нь тус тус Майкрософтын корпорацын бүтээгдэхүүнийг сонгон ашиглаж байна. Түүнчлэн төсвийн 68 байгууллагаас сүүлийн 2 жилийн хугацаанд (2022-2024) Майкрософтын 6 төрлийн 138,164 ширхэг лицензийг нийт 5.5 тэрбум төгрөгөөр худалдан авсан байна. Майкрософт корпорац Монгол Улсын Засгийн газрын хэрэгцээ, шаардлагад нийцсэн шийдэл санал болгохоор урьдчилсан байдлаар хүлээн зөвшөөрч, цаашид талууд нууцлалын гэрээ байгуулах, Монгол Улсын Засгийн газраас албан ёсны хүсэлт илгээх шаардлагатай байгааг мэдэгдсэн. Хэрэгжилтийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 01/1195 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 3 файл | Ахиц гарсан - 50% | Үгүй | |
| 34 | 53 | Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай<br>2025-05-30<br>Дугаар 2025_49 | 2. 2.Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай. | Ухаалаг засаг 2 төслийн хүрээнд Төрийн цахим үйлчилгээний үр ашиг, хэрэглээг сайжруулах, дижитал ур чадварыг дээшлүүлэх, дижитал технологид суурилсан ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор 2025 онд үндсэн 3 зорилтын хүрээнд 18 төслийн гэрээг байгуулан хэрэгжүүлж, 8 төсөл худалдан авах ажиллагааны шатанд, 12 төслийн ажлын даалгаварыг боловсруулан ажиллаж байна. Төсөл хэрэгжүүлэгч байгууллагаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, төслийн үр шим хүртэгч байгууллага Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Авлигатай тэмцэх газартай хамтран төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна. | Ахиц гарсан - 50% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 35 | 54 | Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2025-06-27 Дугаар 2025 №61 | 4.. 4.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хуульд нийцүүлэн хийж, үнэлгээг эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд тогтмол байршуулах ажлыг зохион байгуулахыг Монгол Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороод, Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/, Монгол Улсын Их Хурлын Тамгын газар /Б.Баасандорж/, Монгол Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга нарт тус тус даалгасугай. | 2024 онд Радио долгионы тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийлгэсэн. Үнэлгээний тайлангаар гарсан дүгнэлтийн хүрээнд 2026 онд өөрчлөлт оруулахаар төлөвлөөд байна.<br><br>Хавсралт : 2 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 55 | | 1.3.а/. "3/Хүний эрх ба цахим технологийн талаар:<br><br>а/цахим технологийн хүний эрхийн нөлөөллийг тооцох аргачлалыг олон улсын стандартад нийцүүлэн боловсруулах, уг аргачлалаар төрийн үйлчилгээ, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн, эсхүл нэвтрүүлэхээр төлөвлөж байгаа цахим технологид үнэлгээ хийх зохицуулалтыг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд тусгах;" | Цахим технологийн хүний эрхийн нөлөөллийг тооцох ажлын хүрээнд Монгол Улсын Хүний эрхийн комисс, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам хамтран Австрали Улсын Засгийн газрын дэмжлэгтэйгээр зохион байгуулсан Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй төрийн цахимжилтын үндсэн платформ болох “И-Монгол академи” УТҮГ-ын цахимжилтын системд иргэний улсын бүртгэлээс хүний хувийн мэдээллийг дамжуулах, боловсруулах, ашиглах ажиллагаа нь хүний эрхийн зарчимд нийцэж байгаа эсэхэд хөндлөнгийн судалгааны ажлыг 2025 оны 9, 10 дугаар сард хийж дууссан. Судалгаагаар “И-Монгол академи” УТҮГ-аас төрийн үйлчилгээг цахимжуулж байгаа системд цахим хэлбэрээр боловсруулалт хийх технологийг ашиглан мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглах үйл ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээ хийсэн. Тус судалгааны ажлын тайлан болон хөндлөнгийн экспертийн үнэлгээг 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яаманд зохион байгуулж, мэргэжлийн салбарын байгууллагуудаар хэлэлцүүлсэн. Цахим технологид үнэлгээ хийх зохицуулалтыг хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд тусгах ажлын судалж байгаа бөгөөд хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн өнөөгийн хэрэгжилт, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага байгаа эсэхэд холбогдох мэргэжлийн чиг үүрэг бүхий байгууллагуудтай хамтран ажиллаж байна. | Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50% | Үгүй | |
| | 56 | | 1.3.г/. г/нийтийн болон хувийн орон зайд байрших дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн систем, хүнийг тагнах, мөрдөн мөшгих боломжтой бүх төрлийн цахим төхөөрөмжөөс хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх чөлөө, хүний хувийн мэдээллийг хамгаалах зохицуулалтыг холбогдох хуульд нарийвчлан тусгах; | Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 7 дугаар бүлэгт дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн систем хэсгийг бүхэлд нь зохицуулах харилцааг тусгаж өгсөн бөгөөд хүний халдашгүй чөлөөтэй байх, эрх чөлөө, хүний хувийн мэдээллийг хамгаалах, зохицуулалтыг тус хуулийн 27 дугаар зүйлийн 27.4-т хориглох үйл ажиллагааг зааж өгсөн. Цахим техник, технологи хурдацтай хөгжиж буй өнөө үед Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хэрэгжилт ямар байгаа болон хуулиас гадуур хүнийг тагнах, мөрдөн мөшгих боломжтой бүх төрлийн цахим төхөөрөмжийг хэрэглэх хэрэглээ Монгол Улсад ямар байгаа хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нарийвчлан тусгах хэрэгцээ шаардлага байгаа эсэхийг тодорхойлох хуулийн хэрэгжилтэд нөлөөллийн үнэлгээ хийлгэх ажлыг тус яамны 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган ажиллаж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 36 | 57 | Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2024 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай<br>2025-07-08<br>Дугаар 2025 №77 | 1.3.д/. д/хиймэл оюуны хөгжүүлэлт, ашиглалттай холбоотойгоор хүн төвтэй байх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх, мэдээлэл, өгөгдлийн боловсруулалт ил тод байх, хариуцлагатай байх гэсэн зарчмуудыг уг илтгэлд тайлбарласан агуулгаар "Үндэсний хиймэл оюуны стратеги"-д тусгаж, улмаар Монгол Улсад хөгжүүлэх, ашиглахыг хориглох хиймэл оюуны төрлийг тодорхойлох; | Цахим хөгжил инновац харилцаа холбооны сайдын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/42 тушаалаар "Их өгөгдөл, хиймэл оюун стратеги хэлэлцүүлэх анхдугаар чуулга"-ны хэлэлцүүлэгт оролцсон олон улсын судлаачид, хувийн хэвшлийн төлөөлөл, мэргэжлийн холбоо, төрийн байгууллагуудаас санал авч, "Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратеги"-ийг Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанд танилцуулж, 18 дугаар тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын дагуу Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратегид тусгагдсан зорилт, арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгасан.<br>Тус "Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратеги"-ийн төслийн 3.1.2-т "Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд тулгуурлан ёс зүйтэй, хариуцлагатай хиймэл оюуны тогтолцоог бүрдүүлнэ.", 4.1.1.-д "Хүний эрх, ёс зүйн зарчим, аюулгүй байдлыг хангасан, хүн төвт хөгжилд чиглэсэн байх", 4.1.2-т "Хэнийг ч орхигдуулахгүй байх", 5.2.1-д "Хүний эрх, ёс зүйн зарчим, аюулгүй байдлыг эрхэмлэсэн Үндэсний хиймэл оюуныг хөгжүүлэх хууль, эрх зүйн орчныг бий болгоно.", 5.2.4-т "Хүний эрх, ёс зүйн зарчимд нийцсэн, хиймэл оюуны талаарх мэдлэг, ойлголтыг олон нийтэд таниулж, соён гэгээрүүлнэ." гэж тусгасан. Мөн тус стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.1.2-т "Хиймэл оюуны салбар хоорондын уялдааг зохицуулах, хиймэл оюуны системийг үнэлэх, алгоритмыг бүртгэх, баримтжуулах, бүртгэлийг олон нийтэд ил тод мэдээллэнэ." гэж тусгасан.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 58 | | 1.3.ё/. ё/ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, алслагдсан орон нутгийн болон орлого багатай өрх, монгол хэлээр харилцах боломжгүй хүмүүсийн цахим технологийн хүртээмжийг нэмэгдүүлэх, тэдгээрийн ялгаатай байдлыг харгалзан хэрэгцээнд нь нийцүүлэн хэрэглээний үр чадвар олгох сургалтын хөтөлбөр, хэрэглэгдэхүүн боловсруулах, үр дүнтэй сургах, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний шинжлэх ухааны дэвшлийн үр шимийг хүртэх эрхийг хангах асуудлыг тусгасан цахим хуваагдлыг арилгах бодлогыг тодорхойлж, батлах, хэрэгжүүлэх; | Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газраас 2025 онд өрх толгойлсон эцэг, эх, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан зэрэг зорилтот бүлгийн нийгмийн оролцоог хангах, хиймэл оюуны хэрэглээ, орчин үеийн дэвшилтэт технологийг ашиглан орлогоо нэмэгдүүлэх арга зүйн мэдлэг, ойлголт, ур чадварт сургах зорилтын хүрээнд иргэн 4643, ахмад настан 1989, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 572, алслагдсан бүс нутагт ажиллаж, амьдарч байгаа малчин өрх, иргэдэд харилцаа холбоо (утасгүй интернэт, старлинк, сансрын холбоо), мэдээллийн технологийг ашиглан төрийн цахим үйлчилгээг хөдөлгөөнт төхөөрөмжөөр авах мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэх зорилтын хүрээнд 1260 малчин тус тус сургалт зохион байгуулсан. Мэдээлэл, технологийн үндэсний парк ТӨААТҮ-аас 2025 онд "Сошиал маркетинг", "Reel богино бичлэг хийх", "Аюулгүй цахим хэрэглээ" сэдэвт сургалтад 24 хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамрагдсан.<br>Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний шинжлэх ухааны дэвшлийн үр шимийг хүртэх эрхийг хангах асуудлыг тусгасан цахим хуваагдлыг арилгах бодлогыг баримталж байна.<br><br>Хавсралт : 3 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 59 | | 1.4.а/. "4/Цахим орчинд үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийллээс хамгаалах талаар:<br><br>а/цахим технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчийн онцлог байдал, үйлдлийн арга, хэлбэр, цаашид бий болох хор уршиг, хохирлын талаар нарийвчлан судалж, энэ төрлийн хүчирхийлэлтэй үр дүнтэй тэмцэхэд шаардлагатай зохицуулалтыг Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон холбогдох бусад хуульд тусгах боломжийг судлах;" | Монгол Улсад жендэрийн эрх тэгш байдлыг хангах төрийн тогтолцоо үүсэж хөгжсөний түүхт 30 жилийн ойг тохиолдуулан Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяныг 2025.11.25-12.10-ны хооронд тэмдэглэн өнгөрүүлсэн.Энэ аяныг дэлхийн 180 гаруй улс жил бүр тэмдэглэдэг. Энэ жил “Технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэхэд нэгдье” уриатайгаар өсвөр насныхан, залуучуудын цахим орчин дахь аюулгүй байдалд голлон анхаарч, технологийг аюулгүй, ёс зүйтэй ашиглахыг дэмжин ажилласан. Энэ хүрээнд төлөвлөгөө батлаж, харьяа, салбар байгууллагуудад хүргүүлэн цахим хуудаст нээлттэй мэдээлж, ХНХЯ, НҮБ-ын хүн амын сангийн дэмжлэгтэйгээр 2025.12.02-ны өдөр зохион байгуулагдсан “Технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийлэл” өндөр түвшний бодлогын хэлэлцүүлэгт СБТГ-ын дарга Ц.Борхүү фаниалистаар оролцсон. Монголын эмэгтэйчүүдийн холбооноос 2025.10.11-ний өдөр Олон Улсын охидын эрхийн хамгаалах өдөрт “Дэлгэцийн цаанаас үйлдэгдэж буй аюул атганд тань байна” бэлгийн хүчирхийлэл, залилангаас ангид байлгах зорилготой өсвөр үеийнхэнд зориулсан “Нандин” чуулганыг Төрийн ордонд зохион байгуулсан. Тус чуулганд Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ-аас илтгэл тавьж оролцсон. | Зохион байгуулалтаас - 0% | Үгүй | |
| | 60 | | 1.4.е/. в/цахим технологи ашиглан цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэргийг мөрдөн шалгах, цахим нотлох баримтыг илрүүлэх, бэхжүүлэх, үнэлэх аргачлал боловсруулж, кибер халдлагатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудын алба хаагчдад зориулсан сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах, хүний нөөцийн болон санхүүгийн чадавхыг нэмэгдүүлэх, бэхжүүлэх, энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх; | Кибер аюулгүй байдлын хүний нөөцийг хөгжүүлэх төслийн хүрээнд 2024 онд Цагдаагийн академи болон ДХИС-ын 6 багшийг кибер аюулгүй байдлын чадавхжуулах сургалтад хамруулсан. Үндэсний кибер эрсдэлийг тодорхойлох судалгааны хүрээнд 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн кибер эрсдэлийг тодорхойлох, түүнийг удирдах талаар сургалтад ЦЕГ-ын 2 албан хаагчийг хамруулсан. Мөн "Онц чухал мэдээллийн аюулгүй байдлын удирдлага, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлэх төлөвлөгөө"-ний бэлтгэл судалгаанд ЦЕГ-ын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газрын албан хаагчдыг хамруулж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| УИХ-ын байнгын хорооны тогтоол | | | | | | | | |
| | 61 | | 3.1. Өндөр технологи болон гарааны бизнесийг дэмжиж өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэх, инновацийн бүтээгдэхүүнийг дотоод, гадаадын зах зээлд гаргах, нөхцөл боломжийг хангах чиглэлээр: Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийг инновацийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцуулах, дэмжлэг үзүүлэх, хамтын хөрөнгө оруулалтын санг байгуулах, үйл ажиллагааг эхлүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх. | Инновац, өндөр технологи, гарааны бизнесийн өсөлтийг дэмжих зорилгоор хөрөнгө оруулалтын сан байгуулах боломжийг судалж, бодлого боловсруулагчид, хөрөнгө оруулагчид, гарааны бизнесүүдэд чиглэсэн экосистемийн хөгжлийн замын зураглалыг боловсруулах зорилгоор тус яамнаас “Инновац, өндөр технологи, гарааны бизнесийг дэмжих хөрөнгө оруулалтын санг байгуулах судалгаа хийх, экосистемийн замын зураглал боловсруулах” судалгаа хийсэн. Судалгаагаар Хамтын хөрөнгө оруулалтын сан байгуулах, Монгол Улсын онцлог, хэрэгцээ шаардлагад нийцэх хувилбаруудыг гаргасан. Тухайлбал, Matching fund буюу төр, хувийн хэвшлийн хамтарсан санхүүжилтийн загвар, Сангуудын сан (Fund of fund) байгуулах зэрэг боломжит хувилбаруудыг судалж, тэдгээрийн давуу, сул тал, хэрэгжих боломжийг шинжилсэн. Энэхүү судалгааны үр дүнд үндэслэн боломжит санхүүжилтийн загварыг хөгжүүлэх зөвлөмж гаргасан. Мөн Япон Улсын Хамтын ажиллагааны байгууллага (JICA)-тай хамтран Startup Ecosystem судалгаа хийсэн бөгөөд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл боловсруулсан. https://docs.google.com/presentation/d/1Cddy81L6pZ7k9Dntut7NysAsknFXiOJA/edit?slide=id.p7#slide=id.p7<br><br>Хавсралт : 1 файл | Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 37 | 62 | Инновацийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2017-02-16 Дугаар 2017.02.16 №18 ИЦББХ | 3.2/. Инновацийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийн хэрэгжилтийг хангах, эрдэм шинжилгээний байгууллага, аж ахуйн нэгжийн хэрэгжүүлж буй инновацийн төсөл, бүтээгдэхүүнийг дэмжих зохицуулалт хийх | “Инновацын төслийг улсын төсвөөс санхүүжүүлэх, инновацын үйл ажиллагаанд оролцогчид грант олгох журам”-ыг Засгийн газрын 2025 оны 05 дүгээр сарын 07-ны өдрийн 224 дүгээр тогтоолоор батлуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 224 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Инновацын үйл ажиллагаанд оролцогчид грант олгох журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1-т заасны дагуу инновацын үйл ажиллагаанд оролцогчид грант олгох сонгон шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамжийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 06 дугаар сарын 06 өдрийн А/88 дугаар тушаалаар баталж, сонгон шалгаруулалтыг 06 дугаар сарын 18-ны өдөр зарлаж, 2 үе шаттай зохион байгуулсан. Сонгон шалгаруулалтад нийт 55 инновацын шийдэл бүхий төсөл оролцсоноос 8 төсөл нь тэргүүлэх чиглэлд нийцээгүй, 1 төсөл жилийн борлуулалтын орлогын үзүүлэлтээс хэтэрч, нийт 49 төсөл сонгон шалгаруулалтад оролцсон. Эцсийн сонгон шалгаруулалтаар удирдамжид заасны дагуу хамгийн өндөр оноо авсан 14 оролцогчийг шилдгээр шалгаруулан ЦХИХХ-ны сайдын 2025 оны А/120 дугаар, Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/242 дугаар тушаалын дагуу инновацын грант олгох төслүүдтэй гэрээ байгуулан тус бүр 20 сая төгрөгийн грант олгосон.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 63 | | 3.4/. Инновацийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.8 дахь заалтын хэрэгжилтийг хангах, дотоодод үйлдвэрлэж буй инновацийн бүтээгдэхүүнийг борлуулахад төрөөс дэмжлэг үзүүлэх, худалдан авалтаар дэмжих; | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 224 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Инновацын үйл ажиллагаанд оролцогчид грант олгох журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1-т заасны дагуу инновацын үйл ажиллагаанд оролцогчид грант олгох сонгон шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамжийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 06 дугаар сарын 06 өдрийн А/88 дугаар тушаалаар баталж, сонгон шалгаруулалтыг 06 дугаар сарын 18-ны өдөр зарлаж, 2 үе шаттай зохион байгуулсан. Сонгон шалгаруулалтад нийт 55 инновацын шийдэл бүхий төсөл оролцсоноос 8 төсөл нь тэргүүлэх чиглэлд нийцээгүй, 1 төсөл жилийн борлуулалтын орлогын үзүүлэлтээс хэтэрч, нийт 49 төсөл сонгон шалгаруулалтад оролцсон. Эцсийн сонгон шалгаруулалтаар удирдамжид заасны дагуу хамгийн өндөр оноо авсан 14 оролцогчийг шилдгээр шалгаруулан ЦХИХХ-ны сайдын 2025 оны А/120 дугаар, Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/242 дугаар тушаалын дагуу инновацын грант олгох төслүүдтэй гэрээ байгуулан тус бүр 20 сая төгрөгийн грант олгосон.<br><br>Хавсралт : 3 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 64 | | 3.5/. Инновацийн дэд бүтцийг сайжруулах, бэхжүүлэхэд төрөөс санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх, технологи дамжуулах төв, технологийн инкубатор байгуулж, технологи бойжуулах, туршин нэвтрүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх | Бүс нутгийн шинжлэх ухаан, технологи, инновацын хамтын ажиллагааг дэмжигч тэргүүлэгч байгууллага болох Азийн Шинжлэх Ухааны Паркуудын Холбоо (АШУПХ) ны 27-р их хурлыг “Бүсийн хөгжилд оруулах Шинжлэх ухаан Технологийн Паркуудын хүлээх үүрэг, үзүүлэх нөлөө” сэдвийн хүрээнд 2024 оны 08 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд Улаанбаатар хотод амжилттай зохион байгуулсан ба хуралд гадныг 10 орны 63 төлөөлөгч, Монгол Улсын 250 орчим оролцогч оролцсон. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу "Бүс орон нутагт өндөр технологи, инновацыг нэвтрүүлнэ" гэсэн зорилтын хүрээнд “Мэдээллийн технологийн төрөлжсөн хаб/хамтын оффис байгуулах ТЭЗҮ, зураг төсөл гүйцэтгэх” ажлыг хийж байна. Тус ажлын хүрээнд бүс орон нутгийг үнэлэх судалгааны ажлын эхлэлийн тайланг хүлээлгэн өгсөн. Судалгаанд үндэслэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн А/80 дугаар тушаалаар уг ХАБ-уудыг байгуулах бүсийн байршлыг тогтоосон. Тогтоогдсон Хэнтий, Орхон, Архангай, Дархан-Уул, Ховд, Өмнөговь аймгийн Засаг дарга нартай хамтран ажиллаж, хаб байгуулах нөхцөл шаардлага, эскиз зургийг боловсруулан Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. Дундын тайланг хүлээн авах ажил хийгдэж байна. | Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 65 | | 3.6/. Судалгаа боловсруулалтын ажлын үр дүнг засгийн эргэлтэд оруулах, үйлдвэрлэлийн технологийг сайжруулах зорилго бүхий технологийн бирж бий болгон ажиллуулах | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 97 дугаар тогтоолоор Мэдээллийн технологийн үйлдвэрлэл дэвшилтэт технологийн үндэсний зөвлөлийг байгуулсан. Уг үндэсний зөвлөлийн анхдугаар хуралдаан 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр хуралдаж хуралдааны дэг, Үйлдвэрлэлийн технологийг сайжруулах, зорилго бүхий технологийн бирж бий болгон ажлуулахын хүрээнд Шинжлэх ухааны академитай хамтран Монгол Улсын эрдэмтэн, зохион бүтээгч, инженерүүдийн бүтээсэн оюуны өмчөөр хамгаалагдсан эцсийн бүтээгдэхүүнийг эдийн засгийн эргэлтэд оруулах үүднээс Технологи инновацийн дэлгүүрийг 2021 онд байгуулсан. Уг дэлгүүрээр өдгөө 230 нэр төрлийн бүтээгдэхүүн худалдаалж байгаа бөгөөд 2025 оны хувьд нийт 132 нэр төрлийн 3263 ширхэг бараа зарж 42,777,000 төгрөгийн борлуулалт хийсэн байна. Үүнээс эрдэмтэн судлаагч, зохион бүтээгч нарт 32,082,720 төгрөгийн олголт хийсэн байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 66 | | 3.7/. Инновацийн тухай хуулийг дагалдаж гарсан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуульд өөрчлөлт оруулах . тухай, Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай нэмэлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.хуульд | Инновацын тухай хууль, түүнийг дагаж гарсан хуулиудын хэрэгжилтийг хангах, гарааны компани болон программ хангамжийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг төрөөс татварын бодлогоор дэмжих ажлын хүрээнд гарааны компаниар бүртгэгдсэн гарааны компаниуд хуулийн дагуу 2024 онд 268 сая төгрөгийн НӨАТ, 136 сая төгрөгийн ААНОХТ, 2025 онд 158 сая төгрөгийн НӨАТ, 55 сая төгрөгийн ААНОХТ, нийт 600 гаруй сая төгрөгийн татварын хөнгөлөлт эдэлсэн байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 67 | | 5. Төр, шинжлэх ухаан, бизнесийн байгууллагын түншлэл, хамтын ажиллагааг бэхжүүлж, төрийн бодлого, шийдвэрийн төсөл боловсруулахад холбогдох эрдэм шинжилгээний байгууллагын санал, дүгнэлт, зөвлөмжийг харгалзаж байх | "Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх үндэсний зөвлөлийн анхдугаар хуралдааныг 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулж, хуралдаанаар "Үндэсний зөвлөлийн хуралдааны дэг", "Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх, виртуал бүсийн үйл ажиллагааны журам", "Мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгчдэд үзүүлэх татварын болон татварын бус дэмжлэгийг зохицуулах журам"-ын төслийг тус тус боловсруулах ажлын хэсгийг төрийн болон хувийн хэвшлийн мэргэжилтэн, эрдэмтэн, судлаач нарын бүрэлдэхүүнтэй байгуулсан. 2025 онд Монгол Улс анх удаа мэдээллийн технологийн татварын таатай орчин бүхий виртуал бүс байгуулагдаж үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэж, хөгжүүлж буй бүтээгдэхүүн үйлчилгээний зардлыг төрөөс хуваалцаж грант олгох, зээлийн үйл ажиллагаанд батлан даалт гаргах, санхүүжүүлэх мөн судалгаа хөгжүүлэлтийн зардлын 70 хүртэлх хувьтай тэнцэх нэг удаагийн дэмжлэг үзүүлэх, шагнаж урамшуулах зэрэг татварын бус дэмжлэг үзүүлэх боломжоо бий болсон. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 38 | 68 | Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай<br>2018-12-20<br>Дугаар 2018 №24 НББСШУБХ | 1.10/. Хэвлэл мэдээлэл, цахим орчин дахь хүүхдийн хөгжил, хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөөтэй зураг, кино, дүрс бичлэг болон мэдээ, мэдээлэл, контентыг хянах, хаах зохицуулалтыг хууль, эрх зүй, технологийн түвшинд боловсронгуй болгож, хууль зөрчсөн этгээдэд оногдуулах хариуцлагыг чангатгах; | Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.8, 27 дугаар зүйлийн 27.1.1, 30 дугаар зүйлийн 30.1.7 дахь заалтууд болон Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.6, 8.2.7, 13 дугаар зүйлийн 13.2.1 дэх заалтууд, 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсгүүдэд тус тус хүүхдийн эсрэг гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, хүүхдэд зохисгүй агуулгыг хаах, хязгаарлах, сэтгэц болон эрүүл мэндэд хортой бодисыг сурталчлахгүй байх тухай нарийвчлан заасан. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн нэгдсэн чуулганаар Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга, хамт өргөн мэдүүлсэн 14 хуулийг хэлэлцэн баталсан. Дээрх хуулийг 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна. Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 25 дугаар зүйлд хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчин дахь хүүхэд хамгааллын талаар зохицуулалтыг хуульчилсан. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25.11-д “Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журмыг цахим хөгжил, харилцаа холбооны, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.” гэж заасны дагуу Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд нарын "Журам батлах тухай" 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/53/А/95/А/76 дугаар тушаалаар баталж, Захиргааны ерөнхий хуулийн дагуу захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр 7204 дугаараар бүртгүүлсэн. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 39 | 69 | Экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр Засгийн газар, Монголбанканд чиглэл өгөх тухай<br>2019-04-09<br>Дугаар 2019 №04 ЭЗБХ | 1.4. олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай, мэдлэг, инноваци шингэсэн хөдөө аж ахуй, мэдээллийн технологи, аялал жуулчлал болон бусад салбарыг хувийн хэвшилд тулгуурлан хөгжүүлэх бодлого, стратегийг танилцуулах; | Их өгөгдөл, хиймэл оюуны өнөөгийн нөхцөл байдал болон дэлхийн цаашдын чиг хандлагын талаар судалж, 2025 оны 01 дүгээр сарын 17-оос 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хооронд төр, хувийн хэвшлийн байгууллага, банк, финтек, шинжлэх ухааны салбарын эрдэмтэн, судлаачид, үүрэн холбооны оператор болон их, дээд сургуулийн нийт 500 орчим төлөөлөлтэй 6 удаагийн уулзалтуудыг зохион байгуулж, гарсан санал, зөвлөмжийг нэгтгэн, дүн шинжилгээ хийсний дүнд "Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратеги"-ийн төслийг боловсруулсан.<br>Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратегийн төслийг хэлэлцүүлэх анхдугаар чуулганыг 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулсан. Уг чуулганд гадаадын болон дотоодын илтгэгч, панелист, төр, хувийн хэвшлийн 1000 орчим төлөөлөл оролцож, их өгөгдөл, хиймэл оюуны чиглэлийн өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцсэн.<br>Мөн их өгөгдөл, хиймэл оюуны өнөөгийн нөхцөл байдал болон дэлхийн цаашдын чиг хандлагын талаар судалж, Монгол Улсын хэмжээнд хиймэл оюуныг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудлын талаар судалж стратегийн төслийг боловсруулахад шаардлагатай суурь судалгааг хийсэн.<br>Дээрх суурь судалгаанд үндэслэн “Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратеги”-ийг төслийг 4 зорилтын хүрээнд 66 арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулан, Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанд танилцуулж, 18 дугаар тэмдэглэлийн дагуу уг стратегид тусгагдсан зорилт, арга хэмжээг Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн “Шинжлэх ухаан, технологи, хиймэл оюун” бодлогын чиглэлийн хүрээнд тусгасан. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 70 | Чиглэл өгөх тухай | 1.3/. Төрийн байгууллагуудын мэдээллийн системийн уялдаа холбоо, нэгдмэл байдлыг хангах суурь үзэл баримтлалыг хувийн хэвшил, иргэний байгууллагын оролцоотойгоор боловсруулж батлах, түүнд үндэслэн цахим шилжилтийг хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөг баталж шаардагдах төсвийг 2020-2022 оны улсын төсөвт тусгаж хэрэгжүүлэх; | 1.Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг ЦХИХХ-ны сайдын 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 05 дугаар тушаалаар баталсан.<br>2.Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх үндэсний зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 03 дугаар тогтоолоор “Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх стратеги” төлөвлөгөөг баталсан. Шаардагдах төсвийг тухайн жилийн төсөвт тусган хэрэгжүүлэн ажиллаж байна.<br><br>Хавсралт : 2 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 40 | 71 | Чиглэл өгөх тухай<br>2019-06-05<br>Дугаар 2019 №05 "Цахим бодлогын түр хороо" | 1.11/. Цахим орчин дахь хууль бус контентын хандалтыг хязгаарлах, худал мэдээ, хуурамч хэрэглэгчийн бүртгэлийг устгах, хариуцлага тооцох тогтолцоог бий болгох, холбогдох байгууллагын чиг үүрэг, оролцоог оновчтой зохион байгуулах, үйл ажиллагааг хэрэгжүүлэх журмыг боловсруулах, батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих, цахим орчны сөрөг үр дагавраас сэргийлэх, зохистой хэрэглээг дэмжсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх; | Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25.11-д “Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журмыг цахим хөгжил, харилцаа холбооны, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.” гэж заасны дагуу Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Харилцаа холбооны зохицуулах хороотой журмын төслийг хамтран боловсруулж, 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд нарын "Журам батлах тухай" А/53/А/95/А/76 дугаар тушаалаар баталж, Захиргааны ерөнхий хуулийн дагуу захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр 7204 дугаараар бүртгүүлсэн.<br>https://legalinfo.mn/mn/detail?lawId=17430823278592 | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 41 | 72 | Чиглэл өгөх тухай<br>2022-04-20<br>Дугаар 2022.04.20 №08 ТББХ | 1.1. Олон нийтийн радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох | Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 06 дугаар тогтоолын 2.4/-телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох талаар тооцоо судалгааг үндэслэлтэй боловсруулан Засгийн газарт хүргүүлж шийдвэрлүүлэхийг Монгол Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлд үүрэг болгосон. Тус тогтоолыг хавсаргав. Тус яамны чиг үүрэгт хамааралгүй болно.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй | Тийм | Чиг үүрэгт хамааралгүй тул хяналтаас хасуулах саналтай |
| | 73 | | Нэг.2/. 2/мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарын хүний нөөцийн хөгжил, тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хомсдолоос сэргийлэх зорилгоор дунд хугацааны стратеги боловсруулж хэрэгжүүлэх;<br>(Нэг.Цахим шилжилтийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор дараах арга хэмжээг аач хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т даалгасугай:) | 1.Боловсрол, соёл шинжлэх ухааны сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын "Мэдээлэл харилцаа, холбооны мэргэжилтэй хүний нөөцийг бэлтгэх чиглэлээр хамтран ажиллах тухай" 2022 оны А/440, А/70 дугаар хамтарсан тушаалаар 2025 он хүртэлх ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, төлөвлөгөөний хугацаа дуусаж байгаатай холбогдуулан биелэлтийг дүгнэж байна.<br>2.Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “Хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэл батлах тухай” 115 дугаар тогтоолоор тэргүүлэх мэргэжлийн чиглэлд “Мэдээллийн технологи”, “Программ хангамжийн инженерчлэл”, “Электроникийн инженерчлэл”, “Үйлдвэрлэлийн автоматжуулалт”, “Ухаалаг технологи” тусгасан.<br>3.Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны “Мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, индекс шинэчлэн батлах тухай” А/146 дугаар тушаалаар “Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, индекс“-ийг баталсан. Тус индексээр Мэдээлэл харилцаа холбооны мэргэжилтэн бэлтгэх чиглэлээр 21 индексийг батлан дээд боловсролын салбарт мэргэжилтэн бэлтгэж, хөдөлмөрийн зах зээлд боловсон хүчний хэрэгцээг хангаж байна.<br><br>Хавсралт : 3 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 74 | | Нэг.3/. олон улсад ашигладаг цахим төлбөрийн системийг Монгол Улсад ашиглах боломжийг бүрдүүлэх;<br>(Нэг.Цахим шилжилтийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор дараах арга хэмжээг аач хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т даалгасугай:) | Монгол Улсад 2024 оны 12 дугаар сард Apple Pay үйлчилгээг нэвтрүүлэн хэрэглэгчдэд хүргэсэн. 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр Google Pay төлбөрийн системийг нэвтрүүлснээр Android болон Wear OS төхөөрөмж хэрэглэгчид төлбөр тооцоогоо хялбар, түргэн шуурхай гүйцэтгэх боломж бүрдсэн. Google Pay нь төлбөрийн мэдээллийг шифрлэж, биометрийн (хурууны хээ, нүүрний танилт) баталгаажуулалтыг ашиглан хэрэглэгчийн мэдээллийн мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалдаг, дэлхийн 100 гаруй оронд идэвхтэй хэрэглэгддэг төлбөрийн шийдэл юм.<br>Цахим хуудаст хандах: https://www.mongolbank.mn/mn/r/11003 | Хэрэгжсэн - 100% | Тийм | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 42 | 75 | Чиглэл өгөх тухай<br>2022-10-24<br>Дугаар 2022 №01 ИЦББХ | Нэг.6/. үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцийг сайжруулан олон улсын итгэмжлэгдсэн жагсаалтад оруулах;<br>(Нэг.Цахим шилжилтийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор дараах арга хэмжээг аач хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т даалгасугай:) | Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчлэх ажлыг Дэлхийн Банкны “Ухаалаг засаг-2” төслийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр ажлын даалгавар болон тендерийн баримт бичгийг боловсруулж, төслийн нэгжид хүргүүлсэн. Тендер шалгаруулалт хүлээгдэж байна. | Санхүү, хөрөнгө оруулалтаас - 0% | Үгүй | |
| | 76 | | Нэг.7/. ерөнхий боловсролын сургалтад тоон бичиг үсгийн чадавхыг дээшлүүлэх талаар агуулгыг тусгах, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв болон их, дээд сургуулиудад мэдээллийн технологи, программ хангамж, мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн сүлжээ, хиймэл оюун ухаан, өгөгдлийн шинжлэх ухаан зэрэг мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг өргөжүүлэх;<br>(Нэг.Цахим шилжилтийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор дараах арга хэмжээг аач хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т даалгасугай:) | 1.Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх төлөвлөгөөг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Соёлын сайдын хамтарсан 2022 оны 7 дугаар сарын 25–ны өдрийн А/260, А/391, А/1461, А/260 тушаалаар баталсан. Ерөнхий боловсролын сургуульд ахлах ангийн сонгон судлах хичээлийг хэрэгцээ сонирхолд нь үндэслэн танхимаар судлах боломж бүрдээгүй сурагчдад цахимаар зохион байгуулах боломжийг бүрдүүлж, 2022 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Монголын анхны цахим сургууль “Medle” орон даяар нээлтээ хийсэн. /2022 онд 10,407 суралцагч/ Цахим шилжилтийг эрчимжүүлэх, иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх, мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх зорилгоор бүх нийтийн цахим ур чадвар олгох V аяны хүрээнд үндэсний хэмжээнд 21 аймагт 105 удаа, 112 суманд 560 удаагийн сургалтад 2025 онд нийт 53256 иргэнийг хамруулсан.<br>2.Хүүхдүүдэд техник сэтгэлгээ, бүтээлч байдал, асуудал шийдвэрлэх чадварыг төлөвшүүлэх Код+Инженер сургалт, Өсвөрийн сансрын инженер сургалт, ШИМТ воркшоп, нийт 4 удаагийн арга хэмжээнд 48 суралцагч хамрагдсан. "Миний кодын эхлэл" хакатон тэмцээнийг 02 дугаар сарын 20, 21-ний өдрүүдэд Өмнөговь аймгийн II сургуульд 30 хүүхэд, 11 дүгээр сарын 19, 20-ний өдрүүдэд Чингэлтэй дүүргийн ерөнхий боловсролын 14 сургуулийн 9-11 дүгээр ангийн 27 сурагч хамрагдсан. “DEV HACKATHON 2025” арга хэмжээ, Хакатон тэмцээнд 6 их дээд сургуулийн 94 оюутан, залуус; D-TECH YOUTH 2025 хөтөлбөрийн хүрээнд "Ур чадварын ялгааг арилгах нь" 55 оролцогч хамруулж, нийт 4 удаа 201 оролцогч хамруулсан. ХБИ-ийн цахим ур чадварыг сайжруулах зорилгоор "Аюулгүй цахим хэрэглээ" сургалтад 19, Хөгжлийн шийдэл ТББ-тай хамтран “Сошиал маркетинг” сургалтад 4 суралцагч хамруулав. "Reel хэрхэн хийх вэ" сургалтад 4 суралцагч, "Хүртээмжтэй вэб сайт 2025" сургалтыг 4 удаа зохион байгуулж, 64 суралцагч хамруулав. Сургалтаар Web Content Accessibility Guidelines (WCAG) стандартыг Монгол Улсад нутагшуулах талаар мэдлэг олгох сургалтад 122 суралцагч хамруулсан. | Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50% | Үгүй | |
| | 77 | | Нэг.8/. радио өргөн нэвтрүүлгийн дамжуулах сүлжээг тоон технологид шилжүүлэх, шаардлагатай судалгааг хийх, ач холбогдлыг тайлбарлан таниулах, санхүүжилтийг шийдвэрлэх;<br>(Нэг.Цахим шилжилтийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор дараах арга хэмжээг аач хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т даалгасугай:) | Засгийн газрын 2010 оны 275 дугаар тогтоолоор “Радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 5.6.1-т “тоон радио, телевизийн үйлчилгээг дамжуулахтай холбогдсон бэлтгэл ажлыг хангах, газрын тоон сүлжээг зохион байгуулах” гэж, заасны дагуу “Хонхорын их хүчний радио төв станцын радио өргөн нэвтрүүлгийн дамжуулах сүлжээг тоон технологид шилжүүлэх” төслийн санхүүжилтийн танилцуулгыг боловсруулан 2026 оны төсөвт суулгахаар Сангийн яаманд хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 1 файл | Санхүү, хөрөнгө оруулалтаас - 0% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 78 | | Нэг.9/. нийгмийн мэдээллийн сүлжээ, цахим хуудас, өргөн нэвтрүүлгийн радио, телевизээр дамжуулан бүх нийтийн тоон бичиг үсгийн чадавхыг дээшлүүлэх, соёлтой хэрэглээг төлөвшүүлэх талаар ойлголт мэдлэг, мэдээлэл өгөх арга хэмжээг зохион байгуулах; (Нэг.Цахим шилжилтийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор дараах арга хэмжээг аач хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т даалгасугай:) | Цахим хөгжил, харилцаа холбооны яамны харьяа "И-Монгол академи" УТҮГ-аас "Цахим ур чадварын аян"-ыг нийслэл 9 дүүрэгт 2024 оны 4 дүгээр сарын 01-ээс 7 дугаар сарын 10-ны хооронд зохион байгуулсан.Тус аяны хүрээнд 2024 оны 04 дүгээр сарын 09 өдрөөс эхлэн дараах сургалт арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд: 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 01/1037 дугаар албан бичиг ирсэн. Дээрх албан бичгийн дагуу тус газрын 20 албан хаагчдад Цахим засаглал; Тоон гарын үсэг түүний хэрэглээ; Хүртээмжтэй технологи- WCAG сэдвээр сургалт зохион байгуулсан. 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Сүхбаатар дүүргийн 11, 12, 13, 14, 15-р хорооны 64 иргэдэд Цахим иргэн; Ухаалаг утасны хэрэглээ; E-Mongolia систем танилцуулга, ашиглалт сэдвээр сургалт зохион байгуулсан. 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Сүхбаатар дүүргийн 16, 17, 18, 19, 20-р хорооны 51 иргэдэд Цахим иргэн; Ухаалаг утасны хэрэглээ; E-Mongolia систем танилцуулга, ашиглалт сэдвээр сургалт зохион байгуулсан. 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдөр ЧД-ийн 128 төрийн албан хаагчид "Цахим иргэн; Мэдээллийн аюулгүй байдал сэдвээр сургалт зохион байгуулсан.. 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдөр НБГ-тай хамтран 31 багшид "Цахим иргэн; Мэдээллийн аюулгүй байдал сэдвээр сургалт зохион байгуулсан.05 дугаар сарын 06-ны өдөр "Цахим иргэн" гэж хэн болох, цахим орчны зохистой хэрэглээ, цахим орчинд үйлдэгдэж буй цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, халдлагын төрлүүд, мэдээллийн аюулгүй байдлын зөвлөмж, гар утасны хэрэглээ зэрэг сэдвээр Теди төвд, 05 дугаар сарын 17-нд 18-25 насны оюутан, залууст зориулсан Digital youth арга хэмжээг "ЧИНГИС ХААНЫ ҮНДЭСНИЙ МУЗЕЙ"-д тус тус зохион байгуулсан. https://www.facebook.com/emongolia.academy<br><br>Хавсралт : 2 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 43 | 79 | Чиглэл өгөх тухай<br>2023-03-28<br>Дугаар 2023№05 НББХ | 1.2.2/. цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдийн нэр төр, алдар хүндэд халдах, гутаан доромжлох, залилах, хүчирхийлэлд уриалах, садар самуун явдлыг сурталчлах зэрэг гэмт хэрэг, зөрчлийн үйлдлүүдийг таслан зогсоох, хууль бус үйл ажиллагаатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг нэн яаралтай авах; | Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25.11-д “Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журмыг цахим хөгжил, харилцаа холбооны, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.” гэж заасны дагуу Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Харилцаа холбооны зохицуулах хороотой журмын төслийг хамтран боловсруулж, 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд нарын "Журам батлах тухай" А/53/А/95/А/76 дугаар тушаалаар баталсан. Тус журмын 2 дугаар зүйлд Цахим орчинд контент, бүтээл, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгаа байршуулахад 2.2.1-д "хүүхдийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон агуулга орсон эсэх", 2.2.2-д "хүүхдийн зураг, дуу, дуу-дүрсний бичлэг агуулсан контент, мэдээ, мэдээлэл, бүтээлийг олон нийтэд түгээхэд хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөл авсан эсэх", 2.2.3-;д "хүүхдийн эрүүл мэнд, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц хүүхдийн эсрэг гэмт хэргийн үйлдэл болон гэмт хэргийн үйлдлийг нарийвчлан харуулсан, эсхүл сурталчилсан эсэх" гэсэн заалтуудыг тусгасан.<br>https://legalinfo.mn/mn/detail?lawId=17430823278592 | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 80 | | 1.2.3/. Боловсрол, шинжлэх ухааны яамнаас Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз, Харилцаа холбооны зохицуулах хороо зэрэг холбогдох байгууллагуудтай 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр байгуулсан хүүхдийг сэрүүн байх цагаар хүмүүжил төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэх тодорхой төрлийн контентыг хязгаарлахтай холбоотой харилцан ойлголцлын санамж бичгийн хэрэгжилтийг хангах, үр дүнг тайлагнах; | Өргөн нэвтрүүлгийн орчинд хүүхэд залуусын сэтгэхүйд сөргөөр нөлөөлөх, хүчирхийлэл, садар самууныг сурталчлах, гэмт хэргийн үйлдлийг нарийвчлан зааварчилсан контентоос урьдчилан сэргийлэх зорилгоор IPTV, интернэтийн үйлчилгээнд эцэг эхийн хяналтын тохиргооны функцыг нэвтрүүлсэн. Энэ үйлчилгээ нь хүүхдийн профайлаараа зөвхөн зөвшөөрөгдсөн суваг, кино контентыг үзэх боломжтой болсон. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч болон тус үйлчилгээг эрхлэх хүсэлт гаргасан этгээдэд “Өргөн нэвтрүүлэгт насны ангилал тогтоох, таних тэмдэг ашиглах шаардлага 6587:2016 стандарт”-ыг мөрдүүлж, телевизээр нэвтрүүлж байгаа +18 контентод Харилцаа холбооны зохицуулах хорооноос байнгын хяналт мониторинг хийж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 81 | | 3а/. Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээ, өмч хөрөнгийн бүртгэл, хэрэгжилт, үр дүнд тавих хяналтыг сайжруулах, хэрэгжиж дууссан төслүүдийн хүрээнд үүссэн өмч, хөрөнгийн бүртгэлийг судлах, зээлийн эргэн төлөлтийн байдал, шинээр авахаар төлөвлөж буй зээлүүдийн эрэлт хэрэгцээг үнэлж, дүн шинжилгээ хийх, үр дүн муутай, хэрэгжилт удаашралтай төслүүд болон шинээр авахаар төлөвлөж буй шаардлагагүй гэж үзсэн зээлийг зогсоох, цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг салбар бүрээр гаргах, танилцуулах; | Цахим хөгжил, харилцаа холбооны яам нь салбарын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд хэрэгжилтийн тайлан, хөрөнгийн шилжилт, үр өгөөжийн үнэлгээний дүнг нэгтгэн ажиллаж байна. Тухайлбал, “Ухаалаг засаг-2”, “Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцийн шинэчлэл”, "Харилцаа холбооны салбарын хүртээмж, чанар, хяналтыг сайжруулах төсөл" зэрэг төслийн хүрээнд хийгдсэн хөрөнгө оруулалтаар бий болсон дэд бүтэц, техник тоног төхөөрөмж, системүүдийн өмчийн бүртгэл, шилжилт, хариуцах байгууллагын тодорхойлолт, ашиглалтын байдалд судалгаа хийх, тайлагнах, дүн шинжилгээ хийх ажлууд хийгдэж байна. Мөн 2025 оноос эхлэн шинээр санал болгож буй төсөл, зээлийн хэрэгцээнд дүн шинжилгээ хийж, давхардсан, үр өгөөж багатай, хэрэгжилт удаашралтай төслүүдийг цэгцлэх, нэн шаардлагатай төслүүдийг оновчтой хэлбэрээр хэрэгжүүлэх чиглэлд анхаарч, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Зээлийн эргэн төлөлтийн хуваарь, эрсдэлийн үнэлгээг Сангийн яамтай хамтран хянан өөрийн салбарын хүрээнд хэрэгжүүлж буй төслүүдийн эдийн засаг, нийгмийн үр өгөөж, техник технологийн давуу тал, тогтвортой хөгжлийн үзүүлэлтэд үзүүлэх нөлөөллийг үндэслэн дүгнэлт гаргаж, тайлагнах ажлыг зохион байгуулж байна. Цаашид хэрэгжилтийн үр дүн сайтай, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд суурь нөлөө үзүүлж буй төслүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, харин давхардсан, шаардлагагүй төслийг зогсоох санал боловсруулж, ЗГХЭГ болон Сангийн яаманд танилцуулан ажиллана. “Цахим засаглал ба цахим шилжилт” төсөл 2025 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар хэрэгжиж дууссан. | Ахиц гарсан - 50% | Үгүй | |
| | 82 | | 4а/. төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой байгууллагуудын биет болон биет бус хөрөнгийг бүртгэх, хянах тогтолцоог сайжруулж, өмчийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн цахим систем бий болгох, нэгдсэн мэдээлэл, дүнг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодод жил бүр танилцуулахтай холбоотой зохицуулалтыг хууль тогтоомжид оруулах санал бэлтгэх, танилцуулах; | Мэдээллийн системийн хөгжүүлэлт, мэдээллийн уялдаа холбоо, дата дэд бүтэц, мэдээллийн аюулгүй байдлыг хариуцдаг байгууллага болохын хувьд холбогдох төрийн байгууллагуудтай хамтран өмчийн нэгдсэн бүртгэлийн системийг төлөвлөн техникийн шаардлага, шийдлийн зураглал, уялдааг боловсруулж байна. Цахим хөгжил, харилцаа холбооны яам, төсөвт болон төрийн өмчит харьяа байгууллагууд хөрөнгийн бүртгэл, хөдөлгөөнийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн дагуу бүртгэж, тайлагнаж, Сайдын багцад нэгтгүүлж мөн ТӨБЗГ-н https://burtgel.pcsp.gov.mn/ өмчийн бүртгэл, мэдээллийн цахим системд дэлгэрэнгүй тайлагнаж, жил бүр үнэлгээ хийлгэж, дараа оны Өмч эзэмших гэрээ байгуулж холбогдох хууль, журмын дагуу тайлагнаж, ил тод мэдээллэн ажиллаж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 44 | 83 | Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай<br>2023-04-25<br>Дугаар 2023№05 ТБХ | 4б/. төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн бүтэц, орон тоо, зардлын зохистой байдлыг бий болгох, үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын ил тод байдлыг хангах хүрээнд биржээр дамжуулан борлуулж, ашигт ажиллагааны түвшинг нэмэгдүүлэх, татварын дараах ашгийг хуваарилах, олон нийтийн оролцоог хангасан сайн засаглалтай болгох, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал, удирдлагын багийн сонгон шалгаруулалтыг нээлттэй, ил тод болгох, тэдний эрх үүрэг, хүлээх хариуцлагыг холбогдох хууль тогтоомжид нарийвчлан зохицуулах санал бэлтгэх, танилцуулах. | Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн бүтэц, орон тоо, зардал нь одоогоор ялгаатай, салбар бүрт харилцан адилгүй байгаа тул зардлын үр ашиг, бүтээмжид суурилсан бүтэц бий болгох бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах, тухайн байгууллагуудын зардлын мэдээлэл, гүйцэтгэл, тайлагналын ил тод байдлыг нэмэгдүүлэх хэрэгцээ байгааг анхаарч ажиллаж байна. | Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй | Үгүй | |
| | 84 | | 6г/. төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтын бүх үе шатанд мэргэжлийн судлаачид, мэргэжлийн төрийн бус болон судалгааны байгууллагуудтай хамтран ажиллах. | Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн үе шатанд Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль тогтоомж холбогдох дүрэм, журмын дагуу мөрдөж ажиллаж байна. Батлагдсан төсвийн хүрээнд, төлөвлөгөөт арга хэмжээний Худалдан авах ажиллагааны тендерийн үнэлгээний хороонд 2024 онд мэргэжлийн Мэдлэгийн хотхон ТББ, Аудит боловсролын төв ТББ, Худалдан авах ажиллагааны хөтөч ТББ, 2025 онд Сэтгэл зүй судалгаа мэдээллийн төв, Худ.ярмаг гишүүдийн үйлчилдэг ТББ, Ниймийн хөгжлийн ертөнц ТББ-ын төлөөлөлтэй хамтран ажилласан. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 85 | | 5а/. аймгуудын өрсөлдөх чадварын индексийг тогтоох аргачлалыг боловсруулан баталж, мөрдүүлэх, жил бүр Засгийн газраас Засаг дарга нартай байгуулдаг үр дүнгийн гэрээнд индексийг тусган, биелэлтийг хянах; | 1.Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/14 дүгээр тушаалаар байгуулагдсан "Ухаалаг аймаг, сум, хотын жишиг баримт бичиг, шалгуур үзүүлэлтийн төсөл боловсруулах" чиг үүрэг бүхий ажлын хэсгийн хүрээнд аймгийн цахим шилжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг 6 индекс бүхий 66 төрлийн үзүүлэлттэйгээр боловсруулан "Цахим аймаг бодлогын зөвлөмж"-д тусгасан ба холбогдох албан хаагчид 21 аймагт ажиллан уг зөвлөмжийг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүй, бодлогын дэмжлэг үзүүлэн ажилласан.<br>2.Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Засаг дарга нартай 2025 онд хамтран ажиллах гэрээ байгуулан цахим шилжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийн дагуу аймагт хэрэгжүүлсэн арга хэмжээний үнэлгээ хийж, тайланг 2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр аймаг, нийслэлийн Засаг даргад цахимаар танилцуулсан. Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн системд аймгийн хэрэгжилтүүдийг оруулах ажиллагаа явагдаж байна.<br><br>Хавсралт : 2 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 86 | | 1.2. Монгол Улсын Засгийн газар хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэн шийдвэр гаргахдаа төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжид заасан зарчим, нийтлэг хэм хэмжээ, шаардлагад нийцүүлж байх; | Ёс зүйн дэд хороонд 2023 онд 1 гомдол ирснийг хэлэлцэн зөвлөмж гарган Төрийн нарийн бичгийн даргад 2024 оны 1 дүгээр сарын 05-ны өдөр танилцуулсан. Мөн Ёс зүйн дэд хорооны 2023 оны тайланг Төрийн албаны зөвлөлд 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 03/181 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. 2025 онд Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 1 албан хаагчтай холбоотой гомдолд дүгнэлт гаргасан. Тус яамнаас аливаа шийдвэрийг төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжид заасан зарчим, нийтлэг хэм хэмжээ, шаардлагад нийцүүлэн гаргаж байна.<br><br>Хавсралт : 2 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 45 | 87 | Засгийн газарт чиглэл өгөх тухай<br>2023-11-01<br>Дугаар 2023_10 ЁЗСХБХ | 1.6. Нийгэмд ёс суртахууны эерэг чиг хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр ерөнхий боловсролын болон их, дээд сургууль, шинжлэх ухаан, соёл, урлаг, хэвлэл мэдээллийн байгууллага, төрийн бус байгууллагад дэмжлэг үзүүлэх, хамтарч ажиллах; | 1.Цахим шилжилтийг эрчимжүүлэх, иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх, мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх зорилгоор бүх нийтийн цахим ур чадвар олгох V аяны хүрээнд үндэсний хэмжээнд 21 аймагт 105 удаа, 112 суманд 560 удаагийн сургалтад 48248 иргэнийг хамруулсан. 2.Бүх нийтийн харилцаа холбоо, мэдээллийн суурь мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилгоор иргэдэд цахим ур чадвар олгох суурь сургалтыг 2025 онд 63 удаагийн давтамжтай нийт 5008 иргэнийг хамруулсан байна.<br>2.Мэдээллийн технологийн улсын олимпиад (Улсын программчлалын 33 дугаар олимпиад)-ыг 2025 оны 04 дүгээр сарын 25-27-ны өдөр Монгол Улсын Боловсролын их сургуульд зохион байгуулсан. Уг олимпиадад нийт 7 сургуулийн 11 багийн 33 оюутан оролцон 2 өдрийн турш 6 бодлогыг шийдвэрлэх программ бичиж өрсөлдөж, онооны эрэмбээр алтан медаль 1, мөнгөн медаль 2, хүрэл медаль 3, шагналт тусгай байр 2, шагналт байр 3-г шалгаруулсан. Хиймэл оюуны Улсын олимпиадыг хоёр үе шаттайгаар зохион байгуулсан бөгөөд нэгдүгээр шатыг 2025 оны 05 дугаар сарын 02-14-ний хооронд цахимаар, хоёрдугаар шатыг 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр танхимаар тус тус явуулсан. Уг олимпиадад нийслэл, орон нутгаас нийт 272 сурагч бүртгүүлэн оролцсоноос нэгдүгээр шатанд 91, хоёрдугаар шатанд 50 сурагч тус тус хамрагдсан. Хоёрдугаар шатнаас шалгарсан 8 сурагч Хиймэл оюуны олон улсын II олимпиадад Монгол Улсаа төлөөлөн оролцохоор тодорсон. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, нийслэлийн Бизнес хөгжил, инновацийн газар, И-Монголиа академи УТҮГ, Инфо сек плас ХХК-тай хамтран 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдөр Баянхошуу Бизнес инкубатор, сургалт үйлдвэрлэлийн төвд "Өсвөр үеийнхэнд зориулсан цахим аюулгүй байдлын воркшоп" зохион байгуулсан ба Сонгинохайрхан дүүргийн ахлах ангийн 40 сурагчид хамрагдсан. Мэдээлэл технологийн чиглэлээр III-IV түвшинд суралцаж буй 60 оюутныг харьяа болон салбар байгууллагуудад мэргэжлийн чиглэлээр дадлага хийлгэсэн. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 88 | | 1.7. Цахим орчинд ёс суртахууны үнэт зүйлсийг эрхэмлэх хүрээнд нийгмийн ёс суртахууныг дээшлүүлэх, ёс зүйгүй харилцаа, хандлагыг өөрчлөх, олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, хуулийн этгээдтэй хамтран ажиллах эрх зүйн орчныг бий болгох; | Монгол Улсын Их Хурлын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн нэгдсэн чуулганаар Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга, хамт өргөн мэдүүлсэн 14 хуулийг хэлэлцэн баталсан. Дээрх хуулийг 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна. Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 25 дугаар зүйлд хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчин дахь хүүхэд хамгааллын талаар зохицуулалтыг хуульчилсан. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд нарын "Журам батлах тухай" 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/53/А/95/А/76 дугаар тушаалаар баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус журмын 2 дугаар зүйлд Цахим орчинд контент, бүтээл, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгаа байршуулахад 2.2.1-д "хүүхдийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон агуулга орсон эсэх", 2.2.2-д "хүүхдийн зураг, дуу, дуу-дүрсний бичлэг агуулсан контент, мэдээ, мэдээлэл, бүтээлийг олон нийтэд түгээхэд хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөл авсан эсэх", 2.2.3-д "хүүхдийн эрүүл мэнд, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц хүүхдийн эсрэг гэмт хэргийн үйлдэл болон гэмт хэргийн үйлдлийг нарийвчан харуулсан, эсхүл сурталчилсан эсэх" гэсэн заалтуудыг тусгасан. Өргөн нэвтрүүлгийн орчинд хүүхэд залуусын сэтгэхүйд сөргөөр нөлөөлөх, хүчирхийлэл, садар самууныг сурталчлах, гэмт хэргийн үйлдлийг нарийвчлан зааварчилсан контентоос урьдчилан сэргийлэх зорилгоор IPTV, интернэтийн үйлчилгээнд эцэг эхийн хяналтын тохиргооны функцыг нэвтрүүлсэн. Энэ үйлчилгээ нь хүүхдийн профайлаараа зөвхөн зөвшөөрөгдсөн суваг, кино контентыг үзэх боломжтой болсон.<br>https://legalinfo.mn/mn/detail?lawId=17430823278592 | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 46 | 89 | Тогтоолын хэрэгжилтийг хангуулах талаар авах арга хэмжээний тухай 2024-11-06 Дугаар 2024_06 ЕЗДБХ | 1.1. Байнгын хорооны 2023 оны 10 дугаар тогтоолын 1 дэх заалтын 1, 3, 6. 7. 8. 9 дэх дэд заалтад заасан арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж, нийгмийн болон монгол хүний ёс суртахууны түвшин, чиг хандлагыг тодорхойлох суурь судалгаа хийж, судалгаанд суурилсан бодлого боловсруулах; | ЦХИХХЯамны бүтэц зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан “Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн”-ийг Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/126 дугаар тушаалаар шинэчлэн батлуулсан. Ёс зүйн хорооноос 11 дүгээр сарыг "Төрийн албан хаагчийн ёс зүйн" сар болгон зарлаж 7 хоног бүрийн Пүрэв гаригт Ёс зүйн талаарх 5 удаагийн сургалтад яамны болон харьяа байгууллагын албан хаагчдыг хамруулж ажилласан. Тогтоолд туссан тус яамтай хамаарах заалтын хэрэгжилтийг 2024 оны 04 дүгээр сарын 10-ны 03/756 дугаар албан бичгээр ЗГХХ-т хүргүүлсэн. Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг албан хаагчдад танилцуулсан. Хөтөлбөрт тусгагдсаны дагуу Тус яаманд шинээр томилогдсон албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон бусад тогтоол, шийдвэрийн талаарх мэдээллийг цахим хаягаар хүргүүлж ажилласан. Төрийн албаны зөвлөлөөс 11 дүгээр сард зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүй ба эрүүл мэнд, “Төрийн албан хаагчийн ёс зүй” (гомдол, мэдээлэл, зөрчлийг шийдвэрлэх), “Төрийн албан хаагчийн ёс зүй” (Дижитал ёс зүй), “Төрийн албан хаагчийн ёс зүй” (Ёс зүй ба бодлого, үйл ажиллагаа) сэдвээр 7:4:10 сургалтад яамны албан хаагчдыг хамруулсан.<br>Тус яамны Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөөнд ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг бууруулах, нөлөөллийн ажил, ёс зүй сахилга хариуцлагаар үлгэрлэсэн соёлыг төлөвшүүлэх чиглэлийг тусган хэрэгжүүлсэн.<br><br>Хавсралт : 2 файл | Тодорхой үр дүнд хүрсэн - 50% | Үгүй | |
| | 90 | | 1.2. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр” (2024-2030)-ийн хэрэгжилтийг нэгдсэн зохицуулалтаар хангаж, жил бүр тайлагнах; | Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг албан хаагчдад танилцуулсан. Хөтөлбөрт тусгагдсаны дагуу Тус яаманд шинээр томилогдсон албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон бусад тогтоол, шийдвэрийн талаарх мэдээллийг цахим хаягаар хүргүүлж ажилласан. Төрийн албаны зөвлөлөөс 11 дүгээр сард зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүй ба эрүүл мэнд, “Төрийн албан хаагчийн ёс зүй” (гомдол, мэдээлэл, зөрчлийг шийдвэрлэх), “Төрийн албан хаагчийн ёс зүй” (Дижитал ёс зүй), “Төрийн албан хаагчийн ёс зүй” (Ёс зүй ба бодлого, үйл ажиллагаа) сэдвээр 7:4:10 сургалтад яамны албан хаагчдыг хамруулсан. Яамны албан хаагчдын ёс зүйн талаар мэдлэг, мэдээллийг өргөжүүлэх зорилгоор Ёс зүйн хороо, Төрийн албаны зөвлөл “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвээр 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулсан. ЦХИХХЯамны бүтэц зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан “Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн”-ийг Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/126 дугаар тушаалаар шинэчлэн батлуулсан. Ёс зүйн хорооноос 11 дүгээр сарыг "Төрийн албан хаагчийн ёс зүйн" сар болгон зарлаж 7 хоног бүрийн Пүрэв гаригт Ёс зүйн талаарх 5 удаагийн сургалтад яамны болон харьяа байгууллагын албан хаагчдыг хамруулж ажилласан. Тогтоолд туссан тус яамтай хамаарах заалтын хэрэгжилтийг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт 2024 оны 04 дүгээр сарын 10-ны 03/756 дугаар албан бичгээр хүргүүлсэн. 2025 оны жилийн эцсийн тайланг хүргүүлэхээр бэлтгэж байна.<br><br>Хавсралт : 2 файл | Ахиц гарсан - 50% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 91 | | 1.3 . төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг идэвхжүүлж, төрийн албан хаагчдыг чадавхжуулах, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг таниулах сургалтыг зохион байгуулж, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өргөжүүлж, үр дүнг тайлагнаж ажиллах. | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль батлагдсантай холбогдуулан тус яамны дэргэдэх Төрийн албан хаагчийн Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/126 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан бөгөөд уг хорооны гишүүн Э.Насанбат, Г.Батбилэг нар ажлаас чөлөөлөгдсөнтэй холбогдуулан Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын 2.8-д заасны дагуу дэд хорооны 2 гишүүнийг нөхөн сонгох арга хэмжээг 2025 оны 03 сард зохион байгуулж, нөхөн томилогдсон гишүүдийг Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/77 дугаар тушаалаар баталгаажуулсан. Тус яамны Ёс зүйн дэд хороо нь 6 гишүүнтэй ажиллаж байгаа бөгөөд 2 гишүүнийг Монгол Улсын ёс зүйн хороо Удирдлагын академиас хамтран зохион байгуулсан Ёс зүйн сургагч багш бэлтгэх сургалтад хамруулж эрх аваад байна. Ес зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасны дагуу ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллаж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, хүнд суртал, шударга бус байдалтай тууштай тэмцэх, таслан зогсоох, албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглахгүй байх чиглэлээр 3 удаагийн сургалтыг зохион байгуулсан.<br>Тус яам нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийн 2025 оны жилийн эцсийн тайланг Монгол Улсын Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолоор баталсан “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”, “Тайлангийн маягт”-ын дагуу харьяа байгууллага (Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, Радио Телевизийн Үндэсний Сүлжээ УТҮГ, Үндэсний дата төв УТҮГ, И Монгол Академи УТҮГ, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ)-аас 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 02/2976 дугаартай албан бичгээр тайланг хүлээн авч, нэгтгэн хүргүүлэхээр боловсруулж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 92 | | 1.1. Улсын төсвийн сар, улирал, жилийн гүйцэтгэлийн нэгдсэн мэдээллийг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсвийн орлого, хөрөнгийн зардал, урсгал зардал, тусгай сангууд, концессоор хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ, гадаадын зээл тусламж зэрэг загварын дагуу нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар цахим орчинд байршуулж, зардлын задаргааг одоогоор хөгжүүлээд байгаа цахим талбаруудтай холбон харах боломжийг бүрдүүлэх;(Энэ тогтоолын биелэлтийг Монгол Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах) | Төсвийн орлого, урсгал ба хөрөнгийн зардал, тусгай сан, концессын арга хэмжээ, гадаадын зээл, тусламжийн гүйцэтгэлийг багтаасан мэдээллийг цахим орчинд байршуулах ажиллаж байна. Мэдээллийг tusuv.mn, shiledans.gov.mn, shilen.gov.mn, odamis.mof.gov.mn зэрэг цахим платформ дээр байршуулж, иргэд, байгууллагууд нийтлэг хандах боломжийг бүрдүүлсэн. “Улсын төсвийн гүйцэтгэлийн тайлангийн систем”-ийг Сангийн яамтай хамтран зардлын задаргааг үзүүлж болох байдлаар холболт хийх техникийн нөхцлийг бүрдүүлсэн. “Цахим төсөв” дэд системээр дамжуулан төсвийн зарцуулалтыг орлого, зардлын төрлөөр харуулдаг загварчлалын хөгжүүлэлт хийгдэж байна. Төсвийн гүйцэтгэлийн мэдээллийг CSV, XLS, JSON хэлбэрээр татаж авах боломжтой болгож, өгөгдлийг боловсруулан ашиглах нөхцөлийг сайжруулсан. | Ахиц гарсан - 50% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 47 | 93 | Засгийн газарт чиглэл өгөх тухай<br>2025-01-14<br>Дугаар 2025_01 ИЦББХ | 1.2 . Төсвийн тухай хуулийн 28Т2.4, 291.3 заалтуудын хэрэгжилтийг хангуулан Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”, Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаал “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам”-ын хэрэгжилтийг хангах, цахим орчинд байршуулж буй төсвийн талаарх мэдээллийг эдгээр журмуудын хавсралтад тусгасан загварт хууль тогтоомжийн хүрээнд нийцүүлэх, мэдээллийг тогтоосон хугацаанд нь нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар оруулах.(Энэ тогтоолын биелэлтийг Монгол Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах) | “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д заасан загварын дагуу төсвийн хөрөнгө оруулалтын мэдээллийг нийцүүлэн цахим платформуудад оруулж байна. Төсөл, арга хэмжээ бүрийг тус журмын хавсралтын загварын дагуу төрөл, ангилал, хэрэгжилтийн үе шат, санхүүжилтийн дүн зэрэг үзүүлэлтүүдээр ангилан оруулж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 48 | 94 | Засгийн газарт чиглэл өгөх тухай<br>2025-01-14<br>Дугаар 2025_02 ИББХ | 1.1. Улсын нэгдсэн төсвийн ангилалд Мэдээллийн технологийн арга хэмжээ, кибер аюулгүй байдлын ангиллын зардлыг шинээр нэмж тус бүрд программ хангамж, техник хангамжаар ялган бүртгэх нөхцөл бүрдүүлэх;(Энэ тогтоолын биелэлтийг Монгол Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах) | Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-т Кибер аюулгүй байдлыг хангах зардлын ангиллыг шинээр нэмж тусгах талаар саналыг Сангийн яаманд 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 01/724, 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01/518 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Мөн 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр Сангийн яамны холбогдох албан хаагчидтай уулзалт хийсэн. “Зардлын эдийн засгийн ангилал”-д мэдээллийн технологи, кибер аюулгүй байдал гэсэн ангиллыг нэмсэн.<br><br>Хавсралт : 4 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 95 | | 1.2. Нийтийн мэдээллийн ил, тод байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангуулж, цахим хөгжил, инновац, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвлөмж, дүгнэлт гарсны дараа холбогдох төсөл хөтөлбөрт зориулсан санхүүжилт олгох. | ЦХИХХС-ын 2022 оны А/18 дугаар тушаалаар “Нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө зөвлөмж, дүгнэлт гаргах журам"-ыг баталсан. Дүгнэлт зөвлөмж гаргуулах тухай 2024 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн 01/923 дугаартай албан бичгийг Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны нийт 48 байгууллагад хүргүүлсэн. Зөвлөмж, дүгнэлт гаргах ажлын хэсгийг ЦХИХХС-ын 2025 оны А/55 дугаар тушаалаар шинэчилсэн. Тус яамнаас 2025 оны жилийн эцсийн байдлаар мэдээлэл хариуцагч байгууллагын 40 системд дүгнэлт зөвлөмж гаргаж өгсөн байна.<br>Мөн ЦХИХХС-ын 2022 оны А/18 дугаар тушаалаар “Нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө зөвлөмж, дүгнэлт гаргах журам"-ыг шинэчлэн 2025 оны А/164 дүгээр тушаалаар баталсан. Захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлд бүртгүүлэх бичгийг 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 01/2856 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 2 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 49 | 96 | Засгийн газарт чиглэл өгөх тухай<br>2025-01-14<br>Дугаар 2025№02 ЭЗБХ | 1.1/. Монгол Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаанаар сонссон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын мэдээллийг хэлэлцээд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай. 1/Улсын нэгдсэн төсвийн ангилалд мэдээллийн технологийн арга хэмжээ, кибер аюулгүй байдлын ангиллын зардлыг шинээр нэмж тус бүрд программ хангамж, техник хангамжаар ялган бүртгэх нөхцөл бүрдүүлэх | Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-т Кибер аюулгүй байдлыг хангах зардлын ангиллыг шинээр нэмж тусгах талаар саналыг Сангийн яаманд 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 01/724, 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01/518 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Мөн 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр Сангийн яамны холбогдох газрын даргатай уулзалт хийсэн. “Зардлын эдийн засгийн ангилал”-д мэдээллийн технологи, кибер аюулгүй байдал гэсэн ангиллыг нэмсэн.<br><br>Хавсралт : 4 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 97 | | 1.2/. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангуулж, цахим хөгжил, инновац, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвлөмж, дүгнэлт гарсны дараа холбогдох төсөл хөтөлбөрт зориулан санхүүжилт олгох | ЦХИХХС-ын 2022 оны А/18 дугаар тушаалаар “Нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө зөвлөмж, дүгнэлт гаргах журам"-ыг баталсан. Дүгнэлт зөвлөмж гаргуулах тухай 2024 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн 01/923 дугаартай албан бичгийг Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны нийт 48 байгууллагад хүргүүлсэн. Зөвлөмж, дүгнэлт гаргах ажлын хэсгийг ЦХИХХС-ын 2025 оны А/55 дугаар тушаалаар шинэчилсэн. Тус яамнаас 2025 оны жилийн эцсийн байдлаар мэдээлэл хариуцагч байгууллагын 40 системд дүгнэлт зөвлөмж гаргаж өгсөн байна.<br>Мөн ЦХИХХС-ын 2022 оны А/18 дугаар тушаалаар “Нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө зөвлөмж, дүгнэлт гаргах журам"-ыг шинэчлэн 2025 оны А/164 дүгээр тушаалаар батлуулсан. Захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлд бүртгүүлэх бичгийг 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 01/2856 тоот албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 2 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 98 | | 2. Энэ тогтоолыг биелэлтийг Монгол Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хороонд УИХ-ын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т үүрэг болгосугай. | ЦХИХХС-ын 2022 оны А/18 дугаар тушаалаар “Нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө зөвлөмж, дүгнэлт гаргах журам"-ыг баталсан. Дүгнэлт зөвлөмж гаргуулах тухай 2024 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн 01/923 дугаартай албан бичгийг Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны нийт 48 байгууллагад хүргүүлсэн. Зөвлөмж, дүгнэлт гаргах ажлын хэсгийг ЦХИХХС-ын 2025 оны А/55 дугаар тушаалаар шинэчилсэн. Тус яамнаас 2025 оны жилийн эцсийн байдлаар мэдээлэл хариуцагч байгууллагын 40 системд дүгнэлт зөвлөмж гаргаж өгсөн байна.<br>Мөн ЦХИХХС-ын 2022 оны А/18 дугаар тушаалаар “Нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө зөвлөмж, дүгнэлт гаргах журам"-ыг шинэчлэн 2025 оны А/164 дүгээр тушаалаар батлуулсан. Захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлд бүртгүүлэх бичгийг 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 01/2856 тоот албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 2 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 50 | 99 | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2025-06-10<br>Дугаар 2025_04 ЁЗДБХ | 1.1.1. 1/Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлыг төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын жил бүрийн төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг хангаж үр дүнд хяналт тавьж ажиллах; | Тус яам нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийн 2025 оны жилийн эцсийн тайланг Монгол Улсын Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолоор баталсан "Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт", "Тайлангийн маягт"-ын дагуу харьяа байгууллага (Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, Радио Телевизийн Үндэсний Сүлжээ УТҮГ, Үндэсний дата төв УТҮГ, И Монгол Академи УТҮГ, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ)-аас 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 02/2976 дугаартай албан бичгээр тайланг хүлээн авч, нэгтгэн хүргүүлэхээр боловсруулж байна.<br><br>Хавсралт : 2 файл | Тодорхой үр дүнд хүрсэн - 50% | Үгүй | |
| | 100 | | 1.1.3. 3/Монгол Улсын ЁС зүйн хорооны гишүүдийн, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх ЁС зүйн дэд хороодын гишүүдийн хараат бус, бие даасан зарчмаар ажиллах нөхцөл, баталгааг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хангах зохицуулалт хийх. | Тус яамны дэргэдэх Төрийн албан хаагчийн Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/126 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан бөгөөд уг хорооны гишүүн Э.Насанбат, Г.Батбилэг нар ажлаас чөлөөлөгдсөнтэй холбогдуулан Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын 2.8-д заасны дагуу дэд хорооны 2 гишүүнийг нөхөн сонгох арга хэмжээг 2025 оны 03 сард зохион байгуулж, нөхөн томилогдсон гишүүдийг Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/77 дугаар тушаалаар баталгаажуулсан. Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, И Монгол академи УТҮГ, Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ, Үндэсний дата төв УТҮГ-ын дэргэдэх Ёс зүйн дэд хороо үйл ажиллагаа явуулж байна.<br>Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэн яамны 2025 оны төсөвт Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг тусган олгосон. Ёс зүйн дэд хороодын гишүүдийн хараат бус, бие даасан зарчмаар ажиллах нөхцөл, баталгааг хөдөлмөрийн дотоод журамд тусгасан. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 101 | | 1.3.1. 1/Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, тухайн байгууллагын ЁС зүйн дэд хорооны гишүүдэд олгох урамшууллын асуудлыг шийдвэрлэх, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэн үр дүнг тооцож ажиллах. | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны бүтэц зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан "Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн"-ийг Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/126 дугаар тушаалаар шинэчлэн баталсан. Тус яамны дэргэдэх Төрийн албан хаагчийн Ёс зүйн дэд хорооны гишүүн Э.Насанбат, Г.Батбилэг нар ажлаас чөлөөлөгдсөнтэй холбогдуулан Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын 2.8-д заасны дагуу дэд хорооны 2 гишүүнийг нөхөн сонгох арга хэмжээг зохион байгуулалж, нөхөн томилогдсон гишүүдийг Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/77 дугаар тушаалаар баталгаажуулсан. Яамны ёс зүйн дэд хороо нь 2025 оны эхний хагас жилд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн: 1. 2025 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төсөл боловсруулсан; 2. Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн баталсан тушаал болон Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор баталсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны цахим хуудаст байршуулсан; 3. Засгийн газрын тохируулагч агентлаг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын албан хаагчаас мөн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны нарийн бичигт гаргасан гомдлыг хянан үзэж, Зөвлөлийн 3 удаагийн хурлыг зохион байгуулж, тайлбар, мэдээлэл цуглуулан, зөвлөмж боловсруулсан; 4. Монгол Улсын ёс зүйн хороо Удирдлагын академиас хамтран зохион байгуулсан "Ёс зүйн сургагч багш бэлтгэх" анхан шатны 32 багц цагийн хөтөлбөрт Ёс зүйн дэд хорооны 2 гишүүн 2025 оны 5 сарын 21-23, 27-ны өдрүүдэд хамрагдаж, Удирдлагын академийн захирлын 2025 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн А/285 тоот тушаалаар баталсан үнэмлэх гардаж авсан. Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/173 дугаар тушаалаар Ёс зүйн хорооны гишүүдэд 2024 онд 5,940,000 төгрөг, Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн даргад 2025 онд 1,188,000 төгрөгийг олгосон.<br><br>Хавсралт нийт : 2 Файл : 1 Зураг : 1 | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 51 | 102 | Засгийн газарт чиглэл өгөх тухай<br>2025-06-24<br>Дугаар 2025№15 ЭЗБХ | 1.1. Монгол Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2024 оны 08 дугаар тогтоолоор байгуулагдсан Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилт, үйлдвэрлэл, технологийн паркуудын үйл ажиллагаатай танилцах, санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн явц, түүнчлэн "Үйлдвэрлэл технологийн пахкийн хэлэлцүүлэг"-ээс гарсан санал, зөвлөмжид үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Г.Занданшатар)-т чиглэл болгосугай: 1. Үйлдвэрлэл, технологийн паркад бодлогын дэмжлэг үзүүлэх чиглэлээр: 1/Монгол Улсад үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх стратеги төлөвлөлт, нэгдсэн бодлогын баримт бичиг боловсруулах; | Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх үндэсний зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 03 дугаар тогтоолоор “Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх стратеги” төлөвлөгөөг баталсан.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| Ерөнхийлөгчийн зарлиг | | | | | | | |
| | 103 | Монгол бичгийн хэрэглээг<br>нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх | 1.. Монгол бичгийн цахим кодыг хэрэглэх үндэсний стандартыг холбогдох мэргэжилтнүүдийн саналыг тусган шуурхай боловсруулж, хуульд заасны дагуу батлуулах, цаашид хөгжүүлэн тогтвортой байдлыг хангаж, цахим орчинд үндэсний хэрэглээг нэмэгдүүлэх талаар бодлого, төлөвлөгөө гарган ажиллахыг Мэдээлэл, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон Монгол хэлний тухай хуулиар үүрэг хүлээсэн эрх бүхий судалгааны байгууллагад; Үндэсний стандартыг боловсруулах ажилд хяналт тавьж, боловсруулсан стандартыг судалж батлах, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, монгол бичгийн цахим кодчиллыг олон улсын стандартад үндэсний стандартыг хэлэлцүүлэх, батлуулах ажлыг зохион байгуулахыг Стандартчилал, тохирлын үнэлгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон Монгол Улсын Шадар сайдад чиглэл болгосугай. | Цахим хөгжил, харилцаа холбооны сайд "Монгол хэл, бичгийн асуудал шийдэл" Үндэсний чуулган-2024-д оролцсон ба Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам үндэсний монгол бичгийн хэрэглээг дэмжихэд чиглэсэн стандарт, монгол бичгийн технологийн бэлэн байдлыг бүрдүүлэх чиглэлээр ажиллаж байна. Энэ хүрээнд цахим системийн гарын байрлалын болон бусад стандартуудыг холбогдох байгууллагуудтай хамтран батлуулж, монгол бичгийн цахим кодыг боловсронгуй болгох чиглэлээр гадаад, дотоодын байгууллагууд, эрдэмтэн судлаачидтай хамтран ажилласан. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 52 | 104 | нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай<br>2018-05-23<br>Дугаар 2018_46 | 3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай. | 1.Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны албан хаагчдын өрөө тасалгаа, хурлын заалны хаягийг монгол бичгээр хаягжуулсан.<br>2.Цахим хөгжил, харилцаа холбооны сайд "Монгол хэл, бичгийн асуудал шийдэл" Үндэсний чуулган-2024-д оролцсон ба "Цахим хөгжил, харилцаа холбооны яам үндэсний монгол бичгийн хэрэглээг дэмжихэд чиглэсэн стандарт, монгол бичгийн технологийн бэлэн байдлыг бүрдүүлэх чиглэлээр ажиллаж байна. Тус яамны 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд “Кирилл болон үндэсний бичгийн хооронд харилцан хөрвүүлэг хийх, зөв бичих дүрмийн алдаа хянах программ нэвтрүүлэх”-ээр туссан. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2025.04.17-ны өдрийн ХЭГ/1043 дугаар "Хуулийн хэрэгжилтийг хангах тухай" албан бичгийн хавсралтаар Тагнуулын ерөнхий газрын 2025.04.01-ны өдрийн ТЕГ01/128 дугаар "Мэдээлэл хүргүүлэх тухай" албан бичгийг ирүүлсэн бөгөөд уг албан бичигт Хэлний бодлогын үндэсний зөвлөлөөс баталгаажуулсан "Дуаллайн" ХХК-ийн "Алдаа шалгагч, бичиг хөрүүлэгч" программыг Засгийн газрын 2023 оны 224 дүгээр тогтоолоор баталсан "Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журам"-д заасан аюулгүй байдлын шаардлагыг хангахгүй, тус системийг төрийн үйл ажиллагаанд нэвтрүүлэн ашиглахад аюулгүй байдлын хувьд эрсдэлтэй тухай ирүүлсэн. "Дуаллайн" ХХК-ийн хөгжүүлсэн тус системд Тагнуулын ерөнхий газраас эрсдэлгүй тухай зөвлөмж ирүүлсэн тохиолдолд ЦХИХХЯ хэрэглээнд нэвтрүүлэхээр хүлээгдэж байна.<br>3.“Төрийн албаны зөвлөлийн цахим систем”-д байгаа төрийн бүх шатны байгууллагын албан хаагчдад үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлох судалгааны асуулгын холбоосыг цахим орчинд хүргэсэн бөгөөд судалгаанд хамрагдаж, Төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулах эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтийн талаар цахим сургалтад хамрагдсан. Тус яам албан хэрэг хөтлөлтийг үндэсний бичгээр хөтөлж хэвшиж байна. Архивын 2025 оны улсын үзлэгээр тус яамны архив, албан хэрэг хөтлөлт 91,8 хувийн үнэлгээгээр үнэлэгдсэн.<br><br>Хавсралт нийт : 3 Файл : 2 Зураг : 1 | Ахиц гарсан - 50% | Үгүй | |
| 53 | 105 | Засгийн газарт чиглэл өгөх тухай<br>2019-04-09<br>Дугаар 2019_60 | 7. Хүүхдийг цахим орчны халдлагаас хамгаалах тодорхой арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, үр дүнг үнэлж, хэрэгжилтийг сайжруулах, энэ чиглэлээр хуулийн төсөл боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх.<br><br>Тайлбар: 2022 оны хагас жилийн тайланд хийсэн ХШҮ-ний дагуу энэхүү заалтыг ирүүлэхдээ дараах зүйлийг анхаарна уу: Тодорхой төлөвлөгөө гаргасан эсэх, хэрэгжилт үр дүнг үнэлж, сайжруулах арга хэмжээ авсан эсэх, энэ чиглэлийн хуулийн төсөл боловсруулагдсан болон санал өгсөн эсэх | Монгол Улсын Их Хурлын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн нэгдсэн чуулганаар Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга, хамт өргөн мэдүүлсэн 14 хуулийг хэлэлцэн баталсан. Дээрх хуулийг 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна. Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 25 дугаар зүйлд хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчин дахь хүүхэд хамгааллын талаар зохицуулалтыг хуульчилсан. Хүүхэд хамгааллын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 25 дугаар зүйлийн 25.11 дэх хэсэгт “25.11.Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журмыг цахим хөгжил, харилцаа холбооны, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.” гэж заасны дагуу 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд нарын "Журам батлах тухай" А/53/А/95/А/76 дугаар тушаалаар баталж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>https://legalinfo.mn/mn/detail?lawId=17430823278592 | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 54 | 106 | Засгийн газарт чиглэл өгөх тухай 2019-05-30 Дугаар 2019_104 | 1.2.. Цахим орчинд тавих хяналтын тухай хууль тогтоомжийг шинээр боловсруулж, нийгмийн сүлжээнд Харилцаа холбооны зохицуулах хороо болон хууль сахиулах байгууллагаас хяналт тавьж, болзошгүй эрсдлээс сэргийлж, IPTV болон нийтийн мэдээллийн хэрэгсэл, интернетийн сүлжээнд шаардлагтай хязгаарлалтуудыг тухай бүр хийх зохицуулалтыг бий болгох. | Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25.11-д “Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журмыг цахим хөгжил, харилцаа холбооны, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.” гэж заасны дагуу Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран журмын төслийг боловсруулж, 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд нарын "Журам батлах тухай" А/53/А/95/А/76 дугаар тушаалаар батлуулсан.Энэхүү журмаар цахим орчинд хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хортой болон хориотой агуулгыг түгээснээс үүсэх эрсдэлийг таних, мэдээлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг нарийвчлан зохицуулахаар тусгалаа. Мөн уг үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх, үүргийг тодорхой болгосноос гадна иргэн, хуулийн этгээдээс өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар нийтэд ил тод мэдээлэхээр журамласан. Өргөн нэвтрүүлгийн орчинд хүүхэд залуусын сэтгэхүйд сөргөөр нөлөөлөх, хүчирхийлэл, садар самууны сурталчлах, гэмт хэргийн үйлдлийг нарийвчлан зааварчилсан контентоос урьдчилан сэргийлэх зорилгоор IPTV, интернэтийн үйлчилгээнд эцэг эхийн хяналтын тохиргооны функцыг нэвтрүүлсэн. Энэ үйлчилгээ нь хүүхдийн профайлаараа зөвхөн зөвшөөрөгдсөн суваг, кино контентыг үзэх боломжтой болсон. https://legalinfo.mn/mn/detail?lawId=17430823278592 | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 55 | 107 | Засгийн газарт чиглэл өгөх тухай 2021-08-27 Дугаар 2021_22 | 1.3. Хүүхэд бүрт улсын хэмжээний олимдиадад оролцох тэгш боломжийг бүрдүүлэх үүднээс улсын хэмжээгээр бүх сурагчдыг бие даан суралцаж өөрийгөө хөгжүүлэх, олимпиадад бэлтгэх, шинжлэх ухааны чиглэлээр тогтмол сургалт, хэлэлцүүлэг, цахимаар сорил, олимпиадад хамрагдах боломжоор хангасан нэгдсэн цахим дэд бүтцийг хөгжүүлэх, уг цахим дэд бүтцийн үйл ажиллагааны хэвийн, тасралтгүй байдлыг хангахад онцгойлон анхаарах.<br><br>Тайлбар: Тайланд хийсэн ХШҮ-ний дагуу энэхүү заалтыг иргүүлэхдээ дараах зүйлийг анхаарна уу: Цахим дэд бүтцийг бий болгох, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах чиглэлээр хийсэн ажлуудыг тусгахЦахим дэд бүтцийг бий болгох, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах чиглэлээр хийсэн ажлуудыг тусгах | 1.Мэдээллийн технологийн улсын олимпиад (Улсын программчлалын 33 дугаар олимпиад)-ыг 2025 оны 04 дүгээр сарын 25-27-ны өдрүүдэд Монгол Улсын Боловсролын их сургуульд зохион байгуулсан. Уг олимпиадад нийт 7 сургуулийн 11 багийн 33 оюутан оролцон 2 өдрийн турш 6 бодлогыг шийдвэрлэх программ бичиж өрсөлдсөн. Хиймэл оюуны Улсын олимдиадыг www.kaggle.com платформыг ашиглан 2025 оны 05 дугаар сарын 02-26-ны өдөр явуулсан. Уг олимпиадад нийслэл, орон нутгаас нийт 272 сурагч бүртгүүлэн оролцсоноос нэгдүгээр шатанд 91, хоёрдугаар шатанд 50 сурагч тус тус хамрагдсан. Хоёрдугаар шатнаас шалгарсан 8 сурагч Хиймэл оюуны олон улсын II олимпиадад Монгол Улсаа төлөөлөн оролцохоор тодорсон.<br>2.НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газартай хамтран Дархан-Уул аймагт төрийн цахим үйлчилгээний хөдөлгөөнт Хурдан цэг бүхий төрийн албан хаагчид, иргэд, хүүхдүүдийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх танхимыг байгуулж 4,823 иргэнд төрийн цахим үйлчилгээг үзүүлсэн.<br>Улсын хэмжээнд олимпиадад оролцох тэгж боломжийг бүрдүүлэх үндсэн чиг үүргийг Боловсролын яам хариуцах бөгөөд олимпиадад хамрагдах боломжоор хангасан нэгдсэн цахим дэд бүтцийг хөгжүүлэх /төсөв болон бусад холбогдох асуудал/-д хамтарч ажиллах боломжтой байна. Тус яамнаас нэгдсэн цахим дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр ажил хийгдээгүй. | Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 56 | 108 | Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58 | 2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай. | 1.Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийн хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/120 дугаар "Бүх нийтийн мод тарих үндэсний өдөр мод арчлан хамгаалах арга хэмжээ зохион байгуулах" тушаалаар тус яамны хамт олон 2024 оны 05 дугаар сарын 19-ны өдөр Хан-уул дүүргийн 14 хорооны нутаг дэвсгэр Түргэний гол дагуух “Ногоон хэрэм” зурваст мод тарих, арчлан хамгаалах арга хэмжээнд яамны албан хаагчид очиж 1000 хайлаас, хүрэн монос, шар хайлаас, бургас, гацуур модны үрсэлгээ, тарьц суулгасан. Мөн 2025 оны 05 дугаар сарын 10-ны өдөр Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Түргэний гол дагуух Ногоон хэрэм” зурваст 10 гацуур, 1000 хайлаас, 20 нарс тарьж, өмнө жил тарьсан модоо арчилж, хамгааллаа. 2.1.“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тарьсан мод бүрийг бүртгэлжүүлэх, хяналт, урамшууллын үйл ажиллагааг төрийн үйлчилгээний нэгдсэн “И-Монголиа” системд нэгтгэх талаар хууль, дүрэм журмын зохицуулалтыг судалж, санал боловсруулан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Ойн газрын төлөөллүүдэд танилцуулсан. Мод бүртгүүлэх үйлчилгээг Төрийн үйлчилгээний E-Mongolia нэгдсэн системд шинээр нэмж хэрэглээнд нэвтрүүлсэн. Иргэд E-Mongolia аппликэйшнд нэвтрэн “мод бүртгүүлэх” цэс рүү орж, өмнө болон шинээр тарьсан модоо бүртгүүлэх, ямар төрлийн модыг хаана, хэзээ тарьсан болон тарьж ургуулсан модны зургийг оруулах нөхцөлийг бүрдүүлсэн.<br><br>Хавсралт : 2 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 57 | 109 | Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай 2022-07-11 Дугаар 2022_159 | 4. Монгол хүн бүр Их Монгол Улсын гал голомтыг сахиж буйгаа гүнээ ухамсарлан, Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, эв нээ сахин бататгаж, улс орноо мандуулахад хувь нэмрээ оруулахыг уриалсугай. | Цахим хөгжил харилцаа холбооны яам болон харьяа байгууллагын албан хаагчдыг Их Монгол Улсын гал голомтыг сахиж буйгаа гүнээ ухамсарлан, Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, эв нээ сахин бататгаж, улс орноо мандуулахад хувь нэмрээ оруулахыг уриалсан. Мөн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залсан болно.<br><br>Хавсралт : 1 зураг | Хэрэгжсэн - 100% | Тийм | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залсан болно. |
| 58 | 110 | Журам шинэчлэн батлах тухай (Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам) 2024-05-27 Дугаар 2024_73 | 4.2.1. Энэхүү журмын 5.2.1, 5.2.2-т заасан шаардлагад нийцсэн мэдээллийг 5.3-т заасан хугацаанд Ажлын албанд ирүүлэх;<br>(Хавсралтад заасны дагуу нийслэлд 5, аймагт 4 төрлийн мэдээлэл, ЗГХЭГ, ЗГХХГ болон яам, агентлаг тус бүрийн чиг үүрэгт хамаарах хавсралтад заасан мэдээлэл) (3.2 дахь заалт "Төрийн холбогдох байгууллагууд Зөвлөлийг энэхүү журмын хавсралтаар батлагдсан мэдээллээр тодорхой давтамжтайгаар тогтоосон хугацаанд тасралтгүй хангах үүрэг хүлээнэ") | Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны 73 дугаар зарлигаар батлагдсан "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам"-ын хэрэгжилтийг ханган ажиллаж, "Чиглэл хүргүүлэх тухай" 2024 оны 4/242 дугаартай албан бичгийн хавсралтаар ирүүлсэн мэдээллийн жагсаалтын дагуу тус яамнаас 2025 оны эхний хагас жилийн мэдээллийг 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 01/1568 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. 2025 оны жилийн эцсийн тайланг хүргүүлэхээр нэгтгэж байна.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 59 | 111 | Тэрбум мод тарих үндэсний өдөр зарлах тухай<br>2025-04-03<br>Дугаар 2025_44 | 1.. Жил бүрийн 5, 9 дүгээр саруудын Бямба, Ням гарагуудыг тэрбум мод тарих үндэсний өдөр болгон зарласугай.<br>2. Тэрбум мод үндэсний өдрийн хүрээнд бүх нийтээр мод, сөөг тарих, арчлан ургуулах үйл хэрэгт идэвхтэй оролцож, сурталчлан таниулж, түгээн дэлгэрүүлэхийг Монгол Улсын нийт ард иргэд, айл өрх, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хөгжлийн түнш байгууллагууд, хандивлагч нарт уриалсугай. | 1.Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийн хүрээнд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/130 дугаар "Бүх нийтийн мод тарих үндэсний өдөр мод тарих арчлан хамгаалах арга хэмжээ зохион байгуулах" тушаалаар тус яамны хамт олон 2025 оны 05 дугаар сарын 10-ны өдөр Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Түргэний гол дагуух Ногоон хэрэм” зурваст 10 гацуур, 1000 хайлаас, 20 нарс тарьж, өмнө жил тарьсан модоо арчилж, хамгаалсан. Тайланг Хяналт хэрэгжүүлэх газарт 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 02/984 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br>2.Тэрбум мод үндэсний өдрийн хүрээнд бүх нийтээр мод, сөөг тарих, арчлан ургуулах үйл хэрэгт идэвхтэй оролцож, сурталчлан таниулж, түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд мод бүртгүүлэх үйлчилгээг E-Mongolia.mn платформд 2025 оны 05 дугаар сарын 10-ны өдөр нэвтрүүлсэн бөгөөд 6614 /шинэ тарьсан 1746, өмнө тарьсан 4868/ хүсэлт ирүүлснээс мод тариулах хүсэлт 1480 байна.<br><br>Хавсралт : 2 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| ҮАБЗ-ийн зөвлөмж | | | | | | | |
| 60 | 112 | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай<br>2018-02-05<br>Дугаар 2018_06/05 | 1.12. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг ил болон далд хэлбэрээр сурталчилсан хэвлэл мэдээллийн байгууллагын тусгай зөвшөөрлийг цуцлах, цахим сайт, хаягуудыг хориглох, ийм төрлийн сэдэвтэй гэмт хэрэг үйлдэхийг өөгшүүлэн сурталчилсан, үйлдэх аргыг нарийвчлан харуулсан бүх төрлийн кино, нэвтрүүлэг, нийтлэл болон бусад уран бүтээлийг олон нийтэд хүргэхгүй байх арга хэмжээг тухай бүр авах. | Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчсөн утга агуулгатай контентыг нийтэлсэн тул ОӨГ, ЦЕГ, ШӨХТГ, ТЕГ зэрэг эрх бүхий байгууллагын шийдвэр, дүгнэлтээр 2025 онд нийт 512 вебсайтыг зөрчилтэй домэйн нэрийн жагсаалт (black-list.mn)-д оруулж Монгол Улсын нутаг дэвсгэрээс хандах хандалтыг хязгаарлах технологийн арга хэмжээ авч ажилласан. 2025 онд эрх бүхий байгууллагаас мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг сурталчилсан гэх агуулга бүхий контентыг устгуулах хүсэлт ирээгүй болно. Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ нь интернэтийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудтай мэдээлэл солилцох гэрээг байгуулж, IP хаяг эзэмшигчийг тогтоож чаддаг болсноор халдлага, зөрчилд өртсөн иргэн, хуулийн этгээдийг олж, халдлага зөрчилд хариу үзүүлэх заавар зөвлөмжийг хүргүүлэх, уялдуулан зохицуулах үйл ажиллагааг цаг алдалгүй хийж байна. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх Үндэсний хорооны 2025 оны хурлуудад оролцож, хариуцсан чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| ЗГ-ын тогтоол | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 61 | 113 | Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай<br>2022-01-05<br>Дугаар 2022_7 | 5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай:<br><br>5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томьёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх;<br><br>5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх;<br><br>5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших;<br><br>5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх;<br><br>5.5. төрийн байгууллагын гадна | 1.Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Ажлын албанд 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 03/170 дугаартай албан бичгээр Artificial intelligence (AI) гэсэн нэр томъёог монгол хэлнээ орчуулах асуудлаар зөвлөмж хүссэн. Тус албанаас 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 20 дугаартай албан бичгээр уг нэр томъёог "хиймэл оюун" гэж орчуулахыг зөвлөсний дагуу нийтийн хэрэглээнд нэвтрүүлэн ажиллаж байна.<br>2.Тус яамны албан хэрэг хөтлөлтийг үндэсний бичгээр хөтөлж хэвшсэн. Төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлсэн. Байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлсэн. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн түвшинг тогтоох судалгаанд хамрагдсан. Архивын улсын үзлэгээр тус яам 91,8 хувийн үнэлгээтэй үнэлэгдсэн.<br><br>Хавсралт нийт : 2 Файл : 1 Зураг : 1 | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 62 | 114 | Төрийн албан хаагчийн богино хугацааны сургалт зохион байгуулах тухай<br>2022-04-06<br>Дугаар 2022_139 | 3. Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын агуулга, хөтөлбөрт 2023 оноос эхлэн уг сургалтыг нэмж тусган батлуулах арга хэмжээ авахыг “Удирдлагын академи” төрийн өмчит үйлдвэрийн газар (Д.Сүрэнчимэг)-т, сургалт зохион байгуулахтай холбоотой зардлыг “Удирдлагын академи”-ийн төсөвт тусгаж байхыг Сангийн сайд Б.Жавхланд, тус сургалтад хамруулах албан хаагчдынхаа зардлыг тухайн жилийн төсвийн төсөлд тусгаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус даалгасугай. | Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтад хамруулах албан хаагчдынхаа зардлыгжил бүр төсвийн төсөлд тусган ажиллаж байна. 2025 оны байдлаар төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 2, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2, эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2, нийт 6 албан хаагчийг өөрийн болон улсын төсвийн санхүүжилтээр суралцуулахаар 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 03/106 дугаар албан бичгийг Удирдлагын академид хүргүүлсэн. Мөн ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 5, эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 3 албан хаагчийг өөрийн төсвийн санхүүжилтээр суралцуулах хүсэлтийг Удирдлагын академид 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 03/638 дугаар албан бичгээр хүргүүлж, албан хаагчид суралцаж төгссөн.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 63 | 115 | “Шинэ Зуунмод” хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай<br>2022-04-06<br>Дугаар 2022_143 | 2. Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт орших “Шинэ Зуунмод” хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хавсралтад заасан бүрдэлтэйгээр батлсугай.<br><br>2. Батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу “Шинэ Зуунмод” хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, инженерийн болон нийгмийн дэд бүтэц, эх үүсвэрийн зураг төслийг боловсруулах болон барьж байгуулахад шаардагдах зардлыг улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улс, орон нутгийн жил бүрийн төсөвт тусгах болон гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулах, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах замаар шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан, | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2024 оны 120 дугаар тушаалаар байгуулагдсан Шинэ Зуунмод хот болон Эдийн засгийг чөлөөт бүсийн хөгжлийг дэмжих төслийн хамтарсан зохицуулах хороо болон уг зохицуулах хорооны үйл ажиллагаанд шаардагдах судалгаа, тооцоо, мэдээллийг бэлтгэх, байгууллага хоорондын уялдаа холбоог зохицуулах, санал, зөвлөмж боловсруулах ажлыг шуурхай зохион байгуулж, хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийн 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдөр, 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдөр хуралд оролцож уг ажлын хэсгийн ажиллах төлөвлөгөөнд санал өгч, батлуулсан. | Зохион байгуулалтаас - 0% | Үгүй | |
| 64 | 116 | Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2022-05-11<br>Дугаар 2022_187 | 1.5.. Иргэн, хуулийн этгээдийн өргөдөл, гомдлыг хүлээн авах төрийн байгууллагын дуудлагын утсыг нэгтгэх болон цахимаар хүлээн авах техникийн шинэчлэл хийх, түүнд шаардагдах хөрөнгийг тооцож жил бүрийн улсын төсвийн төсөлд үе шаттайгаар тусгаж байхыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан нарт. | 1.ЦХИХХ-ны сайдын 2024 оны А/42 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулж, үр дүнг Засгийн газрын 2024.11.27-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. Улмаар 41 дүгээр тэмдэглэл батлагдсан. 2.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу Иргэд, олон нийттэй харилцах төв “11-11”-ийн мэдээллийн системийг 2024.11.12-ны өдрөөс мэдэгдэл хүргэх системтэй холбож, улмаар иргэдийн ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлтэд мэдэгдэл хүргэдэг болсон. 3.Засгийн газрын "Их өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт, нэгдсэн мэдээлэл хяналтын систем"-д 11-11, 101, 102, 103, 105 дугаарт ирүүлсэн дуудлага, түүний төрөл, шийдвэрлэлтийн статистик мэдээллийг “дашбоард” хэлбэрээр харах боломжийг бүрдүүлсэн. 4.Иргэдийн асуултад хариулах, хууль эрх зүйн зөвлөмж өгөх, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явцыг мэдээлэх чадвартай хиймэл оюунд суурилсан “IVA” системийг “11-11.mn” веб хуудсанд холбож, “Харилцагчийн үйлчилгээний хиймэл оюуны виртуал ажилтан, операторын үйлчилгээ”-г 2025.03.31-ний өдөр ЗГХЭГ-тай хамтран нэвтрүүлсэн. 5.Засгийн газрын “11-11”, нийслэлийн “1800-1200” дугаарын үйл ажиллагаанд ашиглаж буй мэдээллийн сан, системийг нэгтгэх шийдлийг боловсруулж, “API” сервисийн хөгжүүлэлт хийх чиглэлийг И Монгол академид 2025 оны 02/1204 бичгээр хүргүүлж, хөгжүүлэлтийн ажлыг эхлүүлсэн. ЗГХЭГ-ын Тэргүүн дэд даргын 2025.05.27-ны өдрийн 175 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулан III улиралд багтаан дуусгахаар ажиллаж байна. 6.Төрийн байгууллагын дуудлагын утсыг нэгтгэх технологийн шийдлийг судлах талаар 2025.06.13-ны өдрийн 02/1412 албан бичгийг ХХЗХ-нд хүргүүлсэн. Гадаад улсаас дуудлагыг хүлээх авах талаар саналыг ЗГХЭГ-т 2025 оны 01/613, мөн явцын тайланг 01/1195 албан бичгээр хүргүүлж, ИЦББХ-ны хурал 05 сарын 28-нд танилцуулсан. 7.Үндсэн системд түшиглэн "Өргөдөл, гомдлын нэгдсэн сан"-г үүсгэж, мэдээлэл дамжуулах API 6 сервисийг хөгжүүлж, нээлттэй байршуулсан бөгөөд 17 ERP систем хөгжүүлэгчид холболт хийх талаар 2025.09.16-ны өдрийн 02/2142 албан бичгийг хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 65 | 117 | Журам батлах тухай<br>2022-05-31<br>Дугаар 2022_219 | 2. “Нийтийн мэдээллийн дэд бүтэц, төрийн цахим үйл ажиллагаанд хамаарах цахим төсөл, хөтөлбөр, арга хэмжээний нэгдсэн бүртгэл хөтлөх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.<br><br>2. Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд үүрэг болгосугай. | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 219 дүгээр тогтоолоор баталсан "Нийтийн мэдээллийн дэд бүтэц, төрийн цахим үйл ажиллагаанд хамаарах цахим төсөл, хөтөлбөр, арга хэмжээний нэгдсэн бүртгэл хөтлөх журам”-ын дагуу төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, нийслэлийн төр захиргааны байгууллагаас 2025 онд хэрэгжүүлж буй нийтийн мэдээллийн дэд бүтцэд хамаарах 28 төсөл хөтөлбөрийн мэдээллийг бүртгэн ажиллаж байна. Мөн Сангийн яамнаас Улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн мэдээллийг авч нэгтгэсэн. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 66 | 118 | Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2022-09-14<br>Дугаар 2022_340 | 1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах зорилгоор төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг сонгон шалгаруулалтын үндсэн дээр зохих хууль журмын дагуу хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус үүрэг болгосугай. | Тус яамнаас Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр “Их өгөгдөл, хиймэл оюуны стратеги” анхдугаар чуулганыг Төрийн ордны Их танхимд зохион байгуулсан. Уг анхдугаар чуулганд төрийн байгууллага, бусад улсаас Монгол улсад суугаа элчин сайд, олон улсын байгууллага, аймаг орон нутгийн болон салбарын харьяа байгууллага, их дээд сургууль, мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгчид, арилжааны банк, финтекийн холбооны нийт 1077 төлөөлөл оролцож, их өгөгдөл, хиймэл оюуны өнөөгийн нөхцөл байдал, бэлэн байдлын үнэлгээ, мөн хувийн хэвшлийн бүтээгдэхүүн үйлчилгээ болон хиймэл оюуны стратегийн төслийг оролцогчдод танилцуулан, хэлэлцүүлэг өрнүүлсэн. Мөн Цахим хөгжил инновац харилцаа холбооны сайдын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/42 тушаалаар "Их өгөгдөл, хиймэл оюун стратеги хэлэлцүүлэх анхдугаар чуулга"-ны хэлэлцүүлэгт оролцсон олон улсын судлаачид, хувийн хэвшлийн төлөөлөл, мэргэжлийн холбоо, төрийн байгууллагуудаас гаргасан саналыг нэгтгэн боловсруулж, Их өгөгдөл хиймэл оюуны стратегийн талаар Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 18 дугаар хуралдаанд танилцуулж, уг стратегид тусгагдсан зорилт, арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төсөлд тусгахаар даалгасан.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 119 | | 3. Эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх чиглэлээр шаардлагатай бол холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах санал боловсруулж, хэлэлцүүлэхийг Засгийн газрын гишүүдэд даалгасугай. | Тус яамнаас “Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд эрхэлж байгаа зарим ажил, чиг үүргийг хувийн хэвшил, төрийн бус байгууллагад шилжүүлэх арга хэмжээний 2024 оны төлөвлөгөөний төслийн саналыг 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 03/72 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Мөн тус салбарын нийгэмд үзүүлж байгаа төрийн үйлчилгээг хувийн хэвшил болон мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх судалгааг хийсэн.<br><br>Хавсралт : 1 файл | Ахиц гарсан - 50% | Үгүй | |
| | 120 | | 5. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа харьяа төсөвт байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, түүний салбар, нэгж болон салбарын нийт албан хаагчдынхаа 10-аас доошгүй хувийг орон нутаг руу шилжүүлэх бодлогын чиглэл баримталж, үе шаттайгаар хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд тус тус үүрэг болгосугай. | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 499 дүгээр тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар байгуулагдсан. Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар нь 21 аймагт хэлтэстэй ба 92 албан хаагч ажиллаж байна. | Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 67 | 121 | Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2022-11-23<br>Дугаар 2022_419 | 9. Төрийн байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээнүүдийг нэгтгэж, мэдээлэл солилцооны цахим шилжилтийг нэвтрүүлэх арга хэмжээг эрчимжүүлж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд, холбогдох мэдээллээр хангаж, дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт даалгасугай. | 1.Төрийн байгууллагаас цахим хэлбэрээр үзүүлж болох 785 үйлчилгээ (лавлагаа тодорхойлолт 106, нэг шатлалт үйлчилгээ буюу үйлчилгээний хүсэлтийг хандсан цэгээс нь нэмэлт шат, дамжлагагүй шийдвэрлэн хариу өгөх боломжтой үйлчилгээ 144, олон шатлалт үйлчилгээ буюу нийтийн мэдээллийн системээр дамжуулан үйлчилгээний хүсэлтийг хүлээн авч эрх бүхий байгууллагад шилжүүлж, шийдвэрлүүлэх 535)-нээс 43 байгууллагын 451 үйлчилгээг төрийн үйлчилгээний ХУРДАН цэг, киоск машинаар хүн, хуулийн этгээдэд үзүүлж байна. Мөн Засгийн газрын 2023 оны 100 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан жагсаалтыг шинэчлэн батлуулахаар Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулга, Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас хүн, хуулийн этгээдэд үзүүлэх үйлчилгээний жагсаалтыг холбогдох журамд нийцүүлэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 01/2732 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br>2.Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (www.e-mongolia.mn)-д 2021 онд 59 байгууллагын 606, 2022 онд 69 байгууллагын 897, 2023 онд 86 байгууллагын 1170, 2024 онд 87 байгууллагын 1263, 2025 онд 88 байгууллагын 1268 үйлчилгээг хүргэсэн. Тус системд бүртгэлтэй 2,091,011 иргэнд 92 сая удаа амжилттай үзүүлээд байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 68 | 122 | Жагсаалт батлах тухай<br>2022-12-14<br>Дугаар 2022_460 | 2. Энэ тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан төсөл, арга хэмжээ бүрийн техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт шилжүүлэхийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтад Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын багцад батлагдсан XVIII.1.4 Үүрэн холбооны сүлжээ /Баянхонгор/ төсөл, арга хэмжээ 2024 онд шилжин хэрэгжиж, тус төсөл гүйцэтгэхээр тендерт шалгарсан "Мянган өндөр цахир" ХХК-тай 2023 оны 5 дугаар сарын 04-ний өдөр гэрээ байгуулан ажилласан. Гүйцэтгэгч "Мянган өндөр цахир" ХХК-иас 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 23/199 дүгээр албан бичгээр гэрээний дагуу ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн бөгөөд байнгын ашиглалтад оруулах комисс ажиллуулах талаар албан бичиг ирүүлсэн. 2023 оны 12 дугаар сарын 07-ноос 15-ны өдрүүдэд байнгын ашиглалтад оруулах улсын комисс ажиллаж, төслийн 6 цэгийг Байнгын ашиглалтад оруулах улсын комиссын 2023 оны ББКД-64-39/23, ББКД-64-38/23, ББКД-64-37/23, ББКД-64-37/23, ББКД-64-03/24, ББКД-64-02/24 дугаартай дүгнэлтээр хүлээж авсан бөгөөд төслийн эхний санхүүжилт болох нэг тэрбум төгрөгийг Монгол Улсын Засгийн газрын 278 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан журмын дагуу "Мянган өндөр цахир ХХК'' -ийн эцсийн санхүүжилтийн материалыг хянаж, санхүүжилтийн эрх нээлгэх хүсэлтийг Сангийн яаманд 2024 оны 07 сарын 09-ний өдрийн 03/1407 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 69 | 123 | Улаанбаатар хотын “Шинэ тойрог зам”-ыг барьж байгуулах тухай<br>2022-12-21<br>Дугаар 2022_476 | 5. 5.Авто замын чигийн дагуух ногоо байгууламж, инженерийн болон цахилгааны шугам, сүлжээ, гэрэлтүүлэг, холбооны кабелийг зөөх, шилжүүлэх, хүчитгэх, хамгаалах ажлыг 2023 оны 4 дүгээр сард багтаан зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт, уг ажлыг гүйцэтгэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт тус тус даалгасугай. | Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар Улаанбаатар "Шинэ тойрог зам" барих төслийн 55км автозамын ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээний тендерийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn)-д 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр нээлттэй зарласан. ХЗТ автозам ХХК-тай 2023 оны 07 дугаар сарын 21-ний өдөр гэрээ байгуулсан байна. | Ахиц гарсан - 50% | Үгүй | |
| 70 | 124 | Агентлаг байгуулах тухай<br>2022-12-28<br>Дугаар 2022_499 | 8. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар байгуулагдсантай холбогдуулан нийслэл, орон нутгийн “Үйлчилгээний нэгдсэн төв”-ийг нийтийн мэдээллийн дэд бүтэцтэй холбогдож төрийн үйлчилгээ үзүүлэхэд удирдлага, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд үүрэг болгосугай. | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 499 дүгээр тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар байгуулагдсан. Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар нь 21 аймагт хэлтэстэй ба 92 албан хаагч ажиллаж байна. Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын нийслэл дэх 144, орон нутаг дахь 405, хилийн чанад дахь дипломат төлөөлөгчийн газар дахь 31 улсын 47 буюу нийт 596 төрийн үйлчилгээний хурдан цэгээр дамжуулан төрийн 43 байгууллагын 451 үйлчилгээг 1,581,079 удаа амжилттай үзүүлээд байна.<br>https://khurdan.gov.mn/%d1%85%d1%83%d1%80%d0%b4%d0%b0%d0%bd-%d1%86%d1%8d%d0%b3%d0%b8%d0%b9%d0%bd-%d0%b1%d0%b0%d0%b9%d1%80%d1%88%d0%b8%d0%bb | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 71 | 125 | Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай<br>2023-01-11<br>Дугаар 2023_79 | 4. Салбар хоорондын уялдаа холбоог хангаж, хяналт шалгалтыг давхардуулахгүй, бүртгэл, хяналтын удирдлагын нэгдсэн цахим системийг шинэчилж, хэвийн, аюулгүй байдлыг хангаж хариуцаж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд даалгасугай. | Засгийн газрын 2023 оны 79 дүгээр тогтоолын 4 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 48 дугаар хуралдааны тэмдэглэлээр Цахим, хөгжил, харилцаа холбооны яаманд Хяналт шалгалтын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан (www.shilenkhyanalt.gov.mn) цахим системийг ашиглалтад оруулах үүрэг даалгавар өгсөн. Тус үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх хүрээнд 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрөөс ашиглалтад оруулсан. Цахим системд 11 яам, 2 төрийн захиргааны байгууллагын 28 хяналтын чиглэлийн нийт 979 улсын (ахлах) байцаагч бүх төрлийн хяналт, шалгалтуудыг хяналт шалгалтын бүртгэл мэдээллийн санд угсрах ажил хийгдэж байна. Хийгдэж байгаа хяналт шалгалтын мэдээллүүдэд хяналт тавьж, системд ажиллах зааварчилгааг өдөр тутамд өгч ажиллаж байна.<br>www.shilenkhyanalt.gov.mn | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 72 | 126 | “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа байгуулах тухай<br>2023-02-01<br>Дугаар 2023_40 | 4. “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, салбар хоорондын уялдааг хангаж, хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай. | Шинэ Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалтын ажлын хүрээнд хийгдэх эхний ээлжийн арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, төлөвлөгөөг гаргаж 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/438 дугаар албан бичгээр, мөн танилцуулгыг 2024 оны 04 сарын 12-ны өдрийн 01/780 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Шинэ Хархорум хотын эхний ээлжийн мэдээлэл, харилцаа холбооны худаг, сувагчлал, шилэн кабелийн ажлын зураг, төсөв боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам яамны төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч болон Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 2024/02 дугаар бүхий ажлын даалгаврыг батлуулсан. Шинэ Хархорум хотын эхний ээлжийн мэдээлэл, харилцаа холбооны худаг, сувагчлал, шилэн кабелийн ажлын зураг, төсөв боловсруулах ажлын өртөгт санал өгч ЦХИХХЯ-ны 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 03/385 албан бичгээр ХББОСЯ-нд хүргүүлсэн. Шинэ хар хорум бүтээн байгуулалтын үндэсний хорооны 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд санал өгч 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр Шинэ хар хорум хотын захиргаанд хүргүүлсэн. 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдөр нээлттэй тендер шалгаруулалтыг Төрийн худалдан авах ажиллагааны газраас зарласан боловч шаардлага хангасан тендер ирүүлээгүй тул тендер шалгаруулалт амжилтгүй болсон. 2025 оны төсвийн тухай хуулийн тодортголоор төсөвт өртөг татагдсан.<br><br>Хавсралт : 1 файл | Санхүү, хөрөнгө оруулалтаас - 0% | Үгүй | |
| 73 | 127 | Дүрэм, журам батлах тухай<br>2023-02-01<br>Дугаар 2023_42 | 2. Кибер аюулгүй байдлын зөвлөл, түүний Ажлын албаны үйл ажиллагааны зардлыг 2023 оны батлагдсан төсөв, орон тоондоо багтаан хэрэгжүүлэх, цаашид шаардагдах зардлыг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгуулж байхыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд даалгасугай. | Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн А/72 дугаар тушаалаар Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны бүтэц, орон тоо, цалингийн хэмжээг баталсан. Ажлын албаны үйл ажлагааны зардлыг 2023 оны батлагдсан төсөвт багтаан хэрэгжүүлсэн ба үйл ажиллагааны зардлыг жил бүрийн сайдын багцад тусган ажиллаж байна.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 74 | 128 | 2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай 2023-02-08 Дугаар 2023_49 | X-1.2. Шүгэл үлээх үйл ажиллагааг бүх талаар дэмжих хөдөлгөөн зохион байгуулж, авлигыг үл тэвчих, үл эвлэрэх хандлагыг төлөвшүүлэх, олон нийтийн дэмжлэг авах; | "Авлигатай тэмцэх "Шүгэл ажиллагаа"-ны хүрээнд Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн "Нэгдье" аяны зурагт хуудаст байгууллагын логог байрлуулан аянд нэгдэж буйгаа илэрхийлэн байгууллагын цахим хуудас https://mddc.gov.mn/mn/13368/ болон олон нийтийн сүлжээн дэх хуудаснууд, харьяа байгууллага болох Үндэсний дата төв УТҮГ, И-Монгол академи УТҮГ, Радио, телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын олон нийтийн сүлжээн дэх цахим хуудаст зурагт хуудаснууд болон "Үгүй гэж хэлээд өөрчилье" видео шторкийг байрлуулсан. Тус яамны болон харьяа байгууллагын нийтийн албан тушаалтнуудад авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, төсвийн хөрөнгийг захиран зарцуулахтай холбоотой гарч буй эрсдэл, төсвийг зориулалтын дагуу зарцуулах, гэрээний гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах, албан тушаалтанд хуулиар хүлээлгэсэн хориглолт, хязгаарлалтыг мөрдөх талаар албан хаагчдын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд сургалт авах хүсэлтийг 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 03/903 дугаар албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдөр цахим хэлбэрээр зохион байгуулсан сургалтад яамны болон харьяа улсын төсөвт үйлдвэрийн газрын 60 гаруй албан хаагчдыг хамруулсан. Аймгийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийн хяналт шалгалтын газар, Харилцаа холбооны зохицуулах хороо, Зэвсэгт хүчний жанжин штабын Мэдээлэл, харилцаа холбооны хяналтын 31 улсын (ахлах) байцаагчдад 2025 оны 04 дүгээр сарын 23-25-ны өдөр нийслэлийн Прокурорын газар, Авлигатай тэмцэх газар болон бусад байгууллага, сургагч багш нар хөтөлбөрийн дагуу хяналт шалгалтын арга хэлбэрийг илүү боловсронгуй болгох, хяналт шалгалтаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад учруулж буй бэрхшээл, хүндрэлийг хөнгөвчлөх, хяналт шалгалтын давхардлыг арилгах, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулах, аливаа аюул, эрсдэл, авлига ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх, хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг сайжруулан иргэд, аж ахуйн нэгжүүдийн талархлыг хүлээсэн шинэчлэлт, өөрчлөлтийг хийж ажиллахыг улсын (ахлах) байцаагчдад чиглэл өгсөн. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 129 | | X-1.3. Төрийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдлийг багасгах, иргэд, хувийн хэвшлийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, хамтран ажиллах. | Иргэнд e-mongolia, e-business, ХУРДАН цэг, ХУРДАН киоск, lavlagaa.e-mongolia.mn, мобайл аппликейшн гэсэн 6 үндсэн сувгаар хүн, хуулийн этгээдэд үзүүлж, чирэгдлийг багасгаж, хүнд суртлыг бууруулан ажиллаж байна. Үүнд:<br>1.Төрийн байгууллагаас цахим хэлбэрээр үзүүлж болох 785 үйлчилгээ (лавлагаа тодорхойлолт 106, нэг шатлалт үйлчилгээ буюу үйлчилгээний хүсэлтийг хандсан цэгээс нь нэмэлт шат, дамжлагагүй шийдвэрлэн хариу өгөх боломжтой үйлчилгээ 144, олон шатлалт үйлчилгээ буюу нийтийн мэдээллийн системээр дамжуулан үйлчилгээний хүсэлтийг хүлээн авч эрх бүхий байгууллагад шилжүүлж, шийдвэрлүүлэх 535)-нээс 43 байгууллагын 451 үйлчилгээг төрийн үйлчилгээний цэг, киоск машинаар хүн, хуулийн этгээдэд үзүүлж байна.<br>2025 онд Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын нийслэл дэх 144, орон нутаг дахь 405, хилийн чанад дахь дипломат төлөөлөгчийн газар дахь 31 улсын 47 буюу нийт 596 төрийн үйлчилгээний хурдан цэгээр дамжуулан төрийн 43 байгууллагын 451 үйлчилгээг 1,581,079 удаа амжилттай үзүүлээд байна.<br>2.Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (www.e-mongolia.mn)-д 2021 онд 59 байгууллагын 606, 2022 онд 69 байгууллагын 897, 2023 онд 86 байгууллагын 1170, 2024 онд 87 байгууллагын 1263, 2025 онд 88 байгууллагын 1268 болгон нэмэгдүүлэн үйлчилгээг хүргэсэн. Тус системд бүртгэлтэй 2,091,011 иргэнд 92 сая удаа амжилттай үзүүлээд байна.<br>3.Бизнес эрхлэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хуулийн этгээдэд зориулсан платформ И-Бизнес (e-business)-ийг 2023 оны 07 дугаар сард 800 үйлчилгээтэйгээр хэрэглээнд нэвтрүүлсэн. 2025 онд хуулийн этгээдтэй холбоотой нийт 88 төрийн байгууллагын 953 үйлчилгээг нэгтгэж, иргэд 339,342 удаа үйлчилгээ авсан байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 130 | | X-5.1. Цахимжилтыг эрчимжүүлж, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, хүнд суртлыг арилгах, бүх төрлийн сонгон шалгаруулалтыг нээлттэй болгох; | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээлэл хариуцагч байгууллага байнга ил тод, нээлттэй байлгах 67 төрлийн мэдээллийг нээлттэй байршуулсан эсэх талаарх “Шилэн индекс”-ийн тайланг тус яамны харьяа Засгийн газрын агентлаг-Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар хүлээн авч, үнэлгээ хийж байна. Тус нээлттэй мэдээллийн "shilen.gov.mn" 2.0 системд 2025 оны 3 дугаар улирлын байдлаар хандах эрхийг мэдээлэл хариуцагч 4,583 үүсгэн сургалтад 10511 албан хаагчийг хамруулаад байна. (2025 оны 4 дүгээр улирлын тайланг үнэлэх ажил хийгдэж байна.) Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсээр дамжуулан шаардлагатай мэргэжил, арга зүйн зөвлөгөөг тогтмол өгч ажиллаж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 75 | 131 | Хот, хөдөөгийн сэргэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2023-02-08<br>Дугаар 2023_68 | 5. Хот, хөдөөгийн сэргэлтийн зорилтыг хангах зорилгоор харьяа төсөвт байгууллага, төрийн өмчийн үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, түүний салбар, нэгж болон салбарын нийт албан хаагчдын тодорхой хувийг орон нутагт шилжүүлэх ажлыг хэрэгжүүлэхэд зориулан 2023 оны батлагдсан төсвөөс 50.0 (тавин) саяас доошгүй төгрөгийг зарцуулах, цаашид уг зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж байхыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай. | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 499 дүгээр тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар байгуулагдсан. Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар нь 21 аймагт хэлтэстэй ба 92 албан хаагч ажиллаж байна. | Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50% | Үгүй | |
| | 132 | | 7. Шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, хөрөнгө оруулагчдад мэдээлэл өгөх цахим платформыг үүсгэн, төрийн үйлчилгээг цахимжуулан “Цахим аймаг” болгох арга хэмжээ авч ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны яам (Н.Учрал), аймгийн Засаг дарга нарт даалгасугай. | Цахим аймаг бодлогын зөвлөмжийг аймаг, нийслэл, сум, дүүрэгт хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад, бодлогын дэмжлэг үзүүлж ажиллахыг ЦХИХХ-ны сайдад даалгасан. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/66 дугаар тушаалаар "Цахим аймаг" бодлогын зөвлөмжийг аймаг, нийслэл, сум дүүрэгт хэрэгжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийг байгуулан “Аймаг, орон нутгийн цахим шилжилтийг эрчимжүүлэх, иргэн аж, ахуйн нэгжид чиглэсэн нэгдсэн систем нэвтрүүлэх” төслийн ажлыг 2024 онд Дархан-Уул, Өвөрхангай аймагт хэрэгжүүлээд байна. Мөн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны А/07 дугаар тушаалаар Иргэдийн амьжиргаа, цаг хугацааг хэмнэх амьдрах таатай орчныг бүрдүүлэх “Дижитал-Аймаг, Дижитал-Хот” бодлогын зөвлөмжийг боловсруулан хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, зөвлөмжийн төслийг боловсруулсан. “Дижитал-Аймаг, Дижитал-Хот” бодлогын зөвлөмжийг 2025 онд Булган, Баянхонгор, Говь-Алтай, Дундговь, Сэлэнгэ, Төв, Хэнтий аймагт хэрэгжүүлэхээр ажлын даалгаврыг 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр батлан, худалдан авах ажиллагааг 2025 оны 05 дугаар сарын 08-29-ны өдөр нийтэд нээлттэй тендер зарлаж 4 оролцогч оролцсоноос шаардлага хангасан тендер ирүүлээгүй гэж үзэж мэдэгдлийг хүргүүлсэн. 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрөөс 07 дугаар сарын 08-ны өдрийн хооронд гомдол гарч тендерийг түр түтгэлзүүлсэн. Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж баталсан. Төсвийн тодотголоор тус яамны урсгал зардлын хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний санхүүжилт хасагдаж, санхүүжилтийн эх үүсвэргүй болсон.<br><br>Хавсралт : 1 файл | Ахиц гарсан - 50% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 76 | 133 | Журам, жагсаалт, загвар батлах тухай<br>2023-03-15<br>Дугаар 2023_100 | 2. Журмын хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд үүрэг болгосугай. | “Цахим аймаг” бодлогын зөвлөмжийг орон нутагт хэрэгжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах, дотоодын мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгчдийн хөгжүүлж байгаа программ хангамж, бүтээгдэхүүнийг сурталчлан таниулах зорилгоор “Digital First-D1” арга хэмжээг “Цахимд хэвшье” уриатайгаар 21 аймагт зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/22 дугаар тушаалаар байгуулсан. Тус арга хэмжээний хүрээнд 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрөөс 05 дугаар сарын 03-ны өдрүүдэд 21 аймагт ажиллаж, цахим шилжилтийн хүрээнд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар танилцуулсан ба цахим боловсрол олгох сургалтад 21 аймгийн Засаг даргын Тамгын газрын удирдах албан тушаалтан, төрийн 3,492 албан хаагч хамрагдсан байна.<br><br>https://mddic.gov.mn/mn/2024/04/16667/ | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 77 | 134 | Оюутны талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2023-03-29<br>Дугаар 2023_111 | 6. Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн системд оюутанд зориулсан тусгай цэс бий болгож, номын сан, соёлын зэрэг үйлчилгээ авах, хөнгөлөлт эдлэх боломжийг бүрдүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт даалгасугай. | Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-Mongolia.mn)-д идэвхтэй суралцаж буй оюутнуудад "оюутан" цэс бий болгож, оюутны цахим үнэмлэхийг байршуулсан. Оюутны автобусны карт захиалах (Хамтарсан карт холбох) үйлчилгээг 7791 хэрэглэгч, Оюутны автобусны карт захиалах (Шинэ карт захиалах) үйлчилгээг 49615 хэрэглэгч, их, дээд сургууль, коллежид суралцаж байгаа тодорхойлолтыг 148084 удаа авсан. Мөн Нийтийн тээврийн бодлогын газар, Улаанбаатар смарт карт ХХК-иас Боловсролын ерөнхий хуульд зааснаар оюутнууд нийтийн тээврээр хөнгөлөлттэй зорчих тусгайлсан картгүй болсон тул И Монголиа платформоор дамжуулан оюутны картын хүсэлт авах ажлыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс зогсоосон. Төрийн үйлчилгээний нэгдсэн системд номын сангийн үнэмлэх захиалах үйлчилгээг нэгтгэсэн. https://ema.gov.mn/archives/6161<br><br>Хавсралт нийт : 2 Файл : 1 Зураг : 1 | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 78 | 135 | Шинжлэх ухаан, технологийн салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай<br>2023-04-05<br>Дугаар 2023_120 | 2.4. “Ногоон хөгжлийн сэргэлт”-ийн хүрээнд Монгол орны бүс нутагт тохирсон төрөл зүйл модны үр, хөрсийг бий болгох, тарьж ургуулах технологи дамжуулах, нутагшуулах судалгааны суурийг аймаг, нийслэлд бүсчлэн байгуулах, усны нөөцийн хадгалалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн цогц судалгаа хийх, ундны усны чанарыг сайжруулах, хаягдал ус цэвэрлэх, усны хэмнэлттэй технологи боловсруулах, байгальд ээлтэй дэвшилтэт технологи, ногоон санхүүжилтийн механизмыг бүрдүүлж, хог хаягдлыг дахин боловсруулах болон электрон хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр байгуулах, устгалд оруулах технологийн шийдэл бүхий техник эдийн засгийн үндэслэлийг тус тус боловсруулж, танилцуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт; | Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас өөрийн эрхлэх асуудлын хүрээнд “Ногоон хөгжлийн сэргэлт”-ийн ажлыг эхлүүлсний үндсэн дээр тус яамнаас хамтран ажиллах боломжтой юм. | Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 136 | | 3. Энэ тогтоолд заасан арга хэмжээг 2024 оноос эхлэн хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, холбогдох Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт тус тус даалгасугай. | Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас өөрийн эрхлэх асуудлын хүрээнд “Ногоон хөгжлийн сэргэлт”-ийн ажлыг эхлүүлсний үндсэн дээр тус яамнаас хамтран ажиллах боломжтой юм. | Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй | Үгүй | |
| 79 | 137 | Төрөлжсөн бүртгэлийн жагсаалт батлах тухай<br>2023-05-03<br>Дугаар 2023_164 | 2. 2.Улсын бүртгэлийн мэдээлэлд үндэслэн холбогдох хуульд заасан төрөлжсөн бүртгэл хөтлөж, сан үүсгэхийг холбогдох байгууллагуудад, уг бүртгэл хөтлөх үйл ажиллагааг цахимжуулах ажлыг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэхийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд үүрэг болгосугай. | Бүртгэл хөтлөх үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэхэд шаардлагатай ""Төрийн мэдээллийн систем, өгөгдлийн сангийн бүртгэл, дүгнэлт зөвлөмжийн нэгдсэн систем""-ийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна. Засгийн газрын 2024 оны 77 дугаар тогтоолоор баталсан “Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах” журамд нийцүүлэн “Төрөлжсөн бүртгэлийн сангийн нэгдсэн систем”-ийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн. Тус системд мэдээлэл хариуцагч байгууллагын мэдээллийн сан - 68, статистикийн – 48, хүснэгт - 718, үзүүлэлт – 10528, ангилал, код - 1686 бүртгэгдсэн байна. | Ахиц гарсан - 50% | Үгүй | |
| 80 | 138 | Худалдааг хөнгөвчлөх, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай<br>2023-05-17<br>Дугаар 2023_178 | 2.2. Иргэн, хуулийн этгээдэд гадаад худалдаатай холбоотой төрийн үйлчилгээг үзүүлэхэд төрийн мэдээллийн үндсэн системээр дамжуулан авах, солилцох боломжтой мэдээллийг шаардахгүй байх талаар холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах арга хэмжээ авахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд; | Монгол Улсын Засгийн газраас санаачлан боловсруулсан төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, хүн, хуулийн этгээдийн төрийн байгууллагаас авах үйлчилгээг цахимжуулах, цахим баримт бичгийг хүлээн зөвшөөрөх, төр өөрт байгаа мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор нийт 109 хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан. Үүнд иргэн, хуулийн этгээдэд гадаад худалдаатай холбоотой төрийн үйлчилгээг үзүүлэхэд төрийн мэдээллийн үндсэн системээр дамжуулан авах, солилцох боломжтой мэдээллийг шаардахгүй байх талаар холбогдох хуулиуд болох Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Валютын зохицуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн тариф, Гаалийн татварын тухай хуульд хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг хуулиуд багтсан. Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэгт “Засгийн газар, холбогдох төрийн захиргааны төв байгууллага хууль тогтоомжийг өөрийн бүрэн эрх, чиг үүргийн дагуу харьяалах салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулна.” гэж заасны дагуу дээр дурдсан хуулиудад орсон нэмэлт, өөрчлөлтийг танилцуулах, хуулийн хэрэгжилтийг зохион байгуулахтай холбогдуулан хууль зүй, эрүүл мэнд, банк, санхүүгийн салбарт “Шилэн төр, төрийн хурдан үйлчилгээ” сэдэвт уулзалт, зөвлөгөөнийг 2024 оны 03 дугаар сарын 14, 26-ны өдөр боловсролын салбарын 500 орчим албан хаагч, эрүүл мэндийн салбарын 400 орчим албан хаагчийг хамруулан зохион байгуулж, арга хэмжээний үеэр Цахим хөгжил, харилцаа холбооны сайд “Шилэн төр, төрийн хурдан үйлчилгээ” сэдэвт илтгэл тавьсан. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 139 | | 6. Энэ тогтоолоор өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, хэрэгжилтийн явц, тайлан, мэдээг улирал тутам Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлж ажиллахыг холбогдох байгууллага, албан тушаалтанд даалгасугай. | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 178 дугаар тогтоолын биелэлтийг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 03/1618 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 81 | 140 | Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 2023-06-21 Дугаар 2023_233 | 1. Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдээс олгох зөвшөөрлийг цахим хэлбэрээр шийдвэрлэх харилцааг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт, тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох шийдвэр гаргах үйл ажиллагааг 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдөрт багтаан цахим хэлбэрт шилжүүлж, төрийн үйлчилгээний нэгдсэн системд холбох арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв (Т.Батбилэг), И-Монгол академи (Б.Мягмарнаран)-д тус тус даалгасугай. | Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын А/27 дугаар тушаалаар Ажлын дэд хэсгийн хурлын шийдвэрийн дагуу Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх зорилгоор төрөөс аж ахуйн нэгжтэй харилцах бүхий л үйл ажиллагааг "Төрийн үйлчилгээний нэгдсэн систем “e-Business”-д нэгтгэх ажлын хүрээнд ажиллах төлөвлөгөө болон Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн "Ажил хариуцуулах тухай" тушаалыг А/135 дугаар тушаал, 10 дугаар сарын 16-ны өдрийн 01/2379 албан бичгээр холбогдох байгууллагуудад, 10 дугаар сарын 22-ны өдрийн 02/2412 албан бичгээр харьяа байгууллагуудад тус тус хүргүүлсэн. Холбогдох байгууллагууд нь төлөвлөгөөний дагуу арга хэмжээг хэрэгжүүлж байна:<br>•Зөвшөөрлийн нэгдсэн сангаас зөвшөөрлийн хүсэлт гаргасан байгууллага, олгосон байгууллага, шийдвэрлэлтийн төлөв зэрэг мэдээллийг Төрд байгаа миний мэдээлэл цэс-Зөвшөөрлийн мэдээлэл- цэсээр e-Mongolia системд хөгжүүлэн 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр хэрэглээнд нэвтрүүлсэн. Зөвшөөрлийн нэгдсэн санд нэвтрүүлсэн зөвшөөрлүүдийг e-business системд “Oauth” системээр дамжуулан нэвтрэлтийг дамжуулан зөвшөөрөл авах боломжийг бүрдүүлэн ажилласан.<br>•2025 оны жилийн эцсийн байдлаар e-business платформд 832 үйлчилгээ нэвтэрсэн. Зөвшөөрлийн тухай хуульд заасан 254 тусгай зөвшөөрлөөс e-business платформд 44 цахимжиж, 134 линкээр холбогдож, 76 цахим хэлбэрт шилжээгүй, харин 124 энгийн зөвшөөрлөөс 23 цахимжиж, 43 линкээр холбогдож, 58 цахим хэлбэрт шилжээгүй байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 81 | 141 | Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 2023-06-21 Дугаар 2023_233 | 7. Өмнөговь аймгийн Цагаан хад суурьшлын бүс дэх нүүрс ачилт, буулгалтын талбайн үйл ажиллагааны шат дамжлагууд дээрх нүүрсний тоон хэмжээний мэдээллийг олборлогч, тээвэрлэгч компаниуд цахим системээр зэрэг хянах боломжийг бүрдүүлэх, нүүрсийг экспортод гаргах гаалийн бүрдүүлэлтийг цахимжуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Гаалийн ерөнхий газар (Р.Отгонжаргал)-т тус тус даалгасугай. | Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон "И-Монгол академи" УТҮГ-ын албан хаагчид 2023 оны 08 дугаар сарын 01-04-ний өдөр Дорноговь аймгийн Замын-Үүд сумanд ажиллаж, Хилийн боомт дахь хил хяналтын байгууллагуудын үйл ажиллагааны зураглал хийж, тулгамдаж буй асуудлыг тодорхойлсон. Мөн тус аймгийн Засаг даргын Тамгын газарт ажиллан цахим шилжилтийн чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар судалгааг хийж гүйцэтгэсэн. Судалгааны үр дүнд үндэслэн Замын-Үүд суманд цахим шилжилт хийх төслийн баримт бичгийг, төсвийн төсөөллийн хамт боловсруулсан. Хилийн боомтын захиргаанаас 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 23/247 дугаар албан бичгээр “Хилийн боомтын мэдээллийн нэгдсэн систем”-д зөвлөмж, дүгнэлт авах хүсэлтийг тус яаманд ирүүлсний дагуу дүгнэлт, зөвлөмжийг боловсруулан 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 03/2367 дугаар албан бичгээр хариу хүргүүлсэн. Хилийн боомтын захиргаанаас "Үндэсний дата төв" УТҮГ төвд сервер байршуулахтай холбоотой системийн дэд бүтцийн судалгаа, хур мэдээлэл солилцооны системээр дамжуулан мэдээлэл солилцох зориулалтын судалгаа хийгдэж танилцуулсан.<br><br>Хавсралт : 1 файл | Ахиц гарсан - 50% | Үгүй | |
| 81 | 142 | Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 2023-06-21 Дугаар 2023_233 | 12. Энэ тогтоолоор өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, хэрэгжилтийн явц, тайлан, мэдээг сар тутам Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлж ажиллахыг холбогдох байгууллага, албан тушаалтанд даалгасугай. | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас дээрх тогтоолтой холбоотойгоор өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу Эдийн засаг, хөгжлийн яамтай хамтран ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 178 дугаар тогтоолын биелэлтийг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 03/1618 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 82 | 143 | "Журам батлах тухай" /Зөвшөөрлийн нэгдсэн сангийн мэдээлэл түүнийг бүрдүүлэх, уг санд зөвшөөрлийг бүртгэх, лавлагаа мэдээлэл өгөх/ Засгийн газрын тогтоол 2023-07-05 Дугаар 2023_251 | 1. 2.Журмын хэрэгжилтийг зохион байгуулж, ажиллахыг зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдэд үүрэг болгосугай. | 1.Зөвшөөрлийн нэгдсэн санд байгаа зөвшөөрлийн төлөвийн мэдээллийг e-mongolia мобайл аппликейшний “Төрд байгаа мэдээлэл” цэсэд байршуулсан.<br>2.Мөн license.mn системийг e-business.mn системд нэгтгэн Зөвшөөрлийн цахим систем цонхонд харуулах хөгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Зөвшөөрлийн тухай хуульд заасан 254 тусгай зөвшөөрлөөс e-business платформд 44 цахимжиж, 134 линкээр холбогдож, 76 цахим хэлбэрт шилжээгүй, харин 124 энгийн зөвшөөрлөөс 23 цахимжиж, 43 линкээр холбогдож, 58 цахим хэлбэрт шилжээгүй байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 83 | 144 | Журам шинэчлэн батлах тухай 2023-07-19 Дугаар 2023_278 | 2. Энэ журмыг хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай.(1."Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам) | Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын дагуу 2025 онд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцын нийт 7 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулах, эрх шилжүүлэх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах үйл ажиллагааг www.publicinvestment.gov.mn цахим системд иж бүрэн, Төсвийн тухай хуулийн цаглабрын дагуу тайлагнаж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 84 | 145 | Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн зарим арга хэмжээний тухай 2023-08-30 Дугаар 2023_321 | 2. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг харьяалах салбар, нутаг дэвсгэртээ зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шаардагдах зардлыг төсвийн ерөнхийлөн захирагч нарын саналыг харгалзан улсын нэгдсэн төсвийн төсөлд тусган, хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхланд даалгасугай. | Эрүүл мэндийн яамны харьяа Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Иргэдийн хэрэглээний боловсролын төвөөс тус яамны нийт албан хаагчдад 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдөр “Иргэн бүрт эрүүл мэнд”-ийн боловсрол олгох зорилтын хүрээнд ажлын байран дахь эрүүл зөв хооллолт, амьдралын зөв дадал, зуршил, хамт олны дотоод харилцаа, уур амьсгал сэдэвт сургалт зохион байгуулсан. Цахим хөгжил, харилцаа холбооны яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих, өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулах ажлын хүрээнд Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А116 дугаар тушаалын дагуу албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг Хавдар судлалын үндэсний төв эмнэлэгтэй хамтран 2024 оны 05 дугаар сарын 29, 06 дугаар сарын 15-ны өдөр “Ажилтны урьдчилан сэргийлэх багц” үйлчилгээнд хамрагдсан. Илрүүлэг үзлэгт эрэгтэй 32, эмэгтэй 53, нийт 85 албан хаагч хамрагдсан. Тус яамны албан хаагчдын эрүүл мэндийн урьдчилсан үзлэгийг 2026 онд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 85 | 146 | “Их өгөгдлийн (big data) сан” үүсгэх тухай<br>2023-11-08<br>Дугаар 2023_403 | 1. Үндэсний хэмжээний нэгдсэн мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийх, шийдвэр гаргалтад ашиглах нөхцөлийг бүрдүүлэх, мэдээллийн ил тод байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Их өгөгдлийн (big data) сан”-г үүсгэж, хэрэглээнд нэвтрүүлэх арга хэмжээг Үндэсний статистикийн хороотой хамтран хэрэгжүүлэхийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд даалгасугай. | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны А/51 дүгээр тушаалаар их өгөгдлийн сан үүсгэн бүрдүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, хэрэгжилтийг ханган ажилласан. Хүний хувийн мэдээлэлд хамаарах 35, хуулийн этгээдэд хамаарах 14 төрлийн мэдээллийг тодорхойлох боломжгүй болгосон. Нийгмийн даатгалын мэдээллийн сан, Нийгмийн халамжийн мэдээллийн сан, Хүн амын өрхийн мэдээллийн сан, Мал тооллогын мэдээллийн сан, Бизнес регистрийн мэдээллийн сангийн мета-өгөгдлийг тус тус мэдээлэл хариуцагчдаас гаргуулан авах ажлыг зохион байгуулсан. Өгөгдлийг 5 төрөл (Hashed keys, Masking, Obfuscataion, Generalization, Perturbation) – өөр тодорхойлох боломжгүй болгон хувиргах хэрэгсэл, хувиргасан өгөгдлийг нууцлалтайгаар ХУР системээр дамжуулах сервисийг тус тус хөгжүүлж, хөдөлмөр, халамж, статистик, даатгалын мэдээллийн сан хариуцсан 3 байгууллагад туршилтаар суурилуулсан. Үндэсний статистикийн хороо, Мэдээллийн технологийн төвд өгөгдлийг хувиргах, нууцлан дамжуулах явцад гарсан эх кодын алдааг засварлах, турших ажлуудыг 2025 оны 05 дугаар сарын 27-28-ны өдөр хийж гүйцэтгэсэн. Цуглуулсан өгөгдлүүдийг нэгтгэн боловсруулалт хийх виртуал орчинг үүсгэсэн. Их өгөгдлийн сан үүсгэн бүрдүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэхэд шаардлагатай систем, техник хэрэгсэл, хүний нөөцийн тооцоо судалгаа хийгдсэн.<br>Мэдээллийн сангуудын өгөгдлийг нэгтгэхэд шаардлагатай нөөц (CPU 16 Core, RAM - 24GB, HDD-40GB)-ийг Үндэсний дата төвд үүсгэсэн. Мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгох хэрэгсэл, хувиргасан өгөгдлийг ХУР системээр дамжуулах сервисийг ашиглан Нийгмийн даатгалын мэдээллийн сан, Нийгмийн халамжийн мэдээллийн сан, Хүн амын өрхийн мэдээллийн сан, Мал тооллогын мэдээллийн сан, Бизнес регистрийн мэдээллийн санг Үндэсний дата төв УТҮГ-т байрлах өгөгдлийн санд туршилтаар байршуулсан. Төрийн их өгөгдлийн сан үүсгэн бүрдүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэхэд шаардлагатай дэд бүтцийн бэлэн байдлыг хангах” төслийн саналыг Ухаалаг засаг2 төслийн нэгжид хүргүүлсэн | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 147 | | 2. Энэ тогтоолын 1-д заасан санг үүсгэхдээ хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүйгээр, хязгаарлалттай мэдээллийн хүн, хуулийн этгээдэд хамаарах мэдээллийг тодорхойлох боломжгүй болгон боловсруулж, төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР)-ээр дамжуулах нөхцөлийг бүрдүүлэхийг “И-Монгол академи” улсын төсөвт үйлдвэрийн газар (Б.Мягмарнаран)-т үүрэг болгосугай. | Хязгаарлалттай мэдээллийг тодорхойлох боломжгүй болгох арга хэрэгсэл бүхий хэрэгсэл (tool) хөгжүүлэх ажлын хүрээнд өгөгдлийг 5 төрөл (Hashed keys, Masking, Obfuscataion, Generalization, Perturbation)-өөр тодорхойлох боломжгүй болгон хувиргах хэрэгслийг хөгжүүлж, тус хэрэгслийг Үндэсний статистикийн хороо, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт суурилуулан амжилттай туршсан. Мөн их өгөгдлийн сан үүсгэх дэд бүтцийг бэлдэх ажлын хүрээнд Үндэсний дата төв УТҮГ нь 500GB санах ой бүхий нөөцийг үүсгэсэн. И-Монгол академи УТҮГ-ын төлөөлөлтэй хамтран Үндэсний статистикийн хороо, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Мэдээллийн технологийн төвд 2025 оны 05 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд ажиллаж, өгөгдлийг хувиргах, нууцлан дамжуулах явцад гарсан эх кодын алдааг засварлах, турших ажлуудыг хийж гүйцэтгэсэн. - Мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгох хэрэгсэл, хувиргасан өгөгдлийг ХУР системээр дамжуулах сервисийг ашиглан Үндэсний статистикийн хороо (өрхийн мэдээлэл - 1,000,313 мөр өгөгдөл, иргэний - 3,531,278 мөр өгөгдөл), Нийгмийн даатгал (даатгуулагч иргэний - 18,142,864 мөр өгөгдөл) -ын мэдээллийг Үндэсний дата төв УТҮГ-т байрлах өгөгдлийн санд байршуулсан. - Цуглуулсан өгөгдлүүдийг нэгтгэн боловсруулалт хийх виртуал орчинг үүсгэсэн. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 148 | | 4. Энэ тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд үүрэг болгосугай. | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/51 дүгээр тушаалаар хэрэгжилтийг зохион байгуулах ажлын хэсэг байгуулсан. Хязгаарлалттай мэдээллийг тодорхойлох боломжгүй болгох заавтыг боловсруулсан. Мөн мэдээллийн сангийн мета-өгөгдлийг цуглуулахад дэмжлэг үзүүлж ажилласан. Өгөгдөл хувиргах хэрэгслийг суулгаж, тохируулах гарын авлага, хувиргасан өгөгдлийг ХУР системээр дамжуулах заавтыг мэдээлэл нийлүүлэгч байгууллагуудад хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 1 файл | Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 86 | 149 | Жагсаалт батлах тухай<br>2023-11-22<br>Дугаар 2023_409 | 4.. Худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр зохион байгуулж, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар батлагдсан хуулийн дугаар, төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил, төслийн код (“УТ” код)-ыг батлагдсан хэлбэрээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд нийтэлж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч, Төрийн худалдан авах ажиллагааны газарт тус тус даалгасугай. | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төсөл, арга хэмжээнд УТ2406700144, УТ2406700137, УТ2406700138, УТ2406700146, УТ2406700145-3, УТ2406700145-5 дугаарыг тус тус олгож, тендер шалгаруулалтыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр зохион байгуулсан. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 150 | | 5. Тогтоолын хавсралтад заасан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу ашиг сонирхлын зөрчил, авлигаас ангид байх зарчмыг баримтлан шуурхай зохион байгуулж ажиллахыг Төрийн худалдан авах ажиллагааны газар, төсвийн ерөнхийлөн захирагч нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд тус тус үүрэг болгосугай. | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төсөл арга хэмжээнд УТ2406700144, УТ2406700137, УТ2406700138, УТ2406700146, УТ2406700145-3, УТ2406700145 дугаар төслийн тендер шалгаруулалтыг зохион байгуулахад үнэлгээний хорооны гишүүдээс хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийн маягтыг тухай бүр эрх бүхий албан тушаалтан авч, хянаж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 87 | 151 | Нийслэл Улаанбаатар хотод Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро” байгуулах тухай (2023 оны 484-р тогтоолоор өөрчлөлт орсон)<br>2023-11-22<br>Дугаар 2023_411 | 9. Энэ тогтоол гарсантай холбогдуулан нарийн мэргэжлийн зайлшгүй шаардлагатай ажилтан, албан хаагчийг түр хугацаагаар шилжүүлэн ажиллуулах, төслийн хэрэгжилтийг хангахтай холбоотой мэдээ, мэдээллийг цаг алдалгүй шуурхай гаргаж өгөх, судалгаа тооцоолол хийх зэрэг үйл ажиллагаанд эрхэлсэн салбар, чиглэлд хамаарах асуудлаар бүхий л талын туслалцаа, дэмжлэг үзүүлж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зөвлөмжөөр хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн удирдлагуудад тус тус үүрэг болгосугай. | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас эрхэлсэн салбар, чиглэлд хамаарах асуудлаар бүхий л талын туслалцаа, дэмжлэг үзүүлж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зөвлөмжөөр хангаж ажиллах албан тушаалтан /тус яамны Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга/-д үүрэг болгож, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 88 | 152 | ПРОЦЕССЫН ДАХИН ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ<br>2023-11-29<br>Дугаар 2023_419 | 5.. E-Mongolia цахим системд төрийн үйлчилгээ авсан иргэдийн сэтгэл ханамж, санал, хүсэлтийг авах боломжийг бүрдүүлэх арга хэмжээ авахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд даалгасугай. | Төрийн үйлчилгээний нэгдсэн e-Mongolia системийн аппликэйшн, портал, оператор 3 сувгаас үйлчилгээ авсан иргэн тухайн үйлчилгээг авсаны дараа сэтгэл ханамж, санал хүсэлтээ үнэлгээгээр илэрхийлэх боломжтой бөгөөд 3 дугаар улирлын байдлаар 912,224 үнэлгээ ирсэн байна. Үнэлгээ өгсөн үйлчилгээнүүд харилцан адилгүй бөгөөд ихэнх нь лавлагаа тодорхойлолтын үйлчилгээ байна. Жишээлбэл Иргэний үнэмлэхний лавлагаа үйлчилгээг авахад иргэдийн 40.6% нь Маш хялбар гэж үнэлсэн бол 50.3% нь Хэцүүвтэр, үлдсэн 9.1% нь бусад гэж үзсэн байна. Иргэний үнэмлэхийн лавлагаа Хэцүүвтэр (3 оноо) 51,962, Маш хялбар (7 оноо) 64,238, Хялбар (6 оноо) 8,391, Мэдэхгүй (4 оноо) 392, Маш хэцүү (1 оноо) 835, Хэцүү (2 оноо) 406 Дундаж (5 оноо) 1,555 гэж үнэлгээ өгсөн байна. 2025 оны жилийн эцсийн үнэлгээ хийгдэж байна.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 89 | 153 | Түлхүүр үг батлах тухай<br>2023-12-06<br>Дугаар 2023_433 | 4.. Түлхүүр үгийг 2024 оноос хэрэглэж эхлэхтэй холбогдуулан бэлтгэл ажлыг 2023 онд багтаан хангаж, бэлтгэл ажилд шаардагдах зардлыг батлагдсан төсвийн хүрээнд шийдвэрлэж ажиллахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Соёлын сайд Ч.Номин, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт үүрэг болгосугай. | Түлхүүр үгийг 2025 оноос хэрэглэж эхлэхтэй холбогдуулан шаардагдах зардлыг батлагдсан төсвийн хүрээнд шийдвэрлэн ажиллаж байна. | Зохион байгуулалтаас - 0% | Үгүй | |
| 90 | 154 | Иргэдийг орон сууцжуулах талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2023-12-27<br>Дугаар 2023_483 | 2.11.. Дээрх төрийн орон сууцны дэмжлэгт хамруулах иргэн, өрхийг тодорхойлж, мэдээллийн сан үүсгэх ажлыг зохион байгуулахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяад, тодорхойлсон мэдээллийн санг цахим системд нэвтрүүлж, хэрэгжүүлэгч байгууллагууд тухай бүр хандах боломж нөхцөлөөр хангаж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Үндэсний статистикийн хороо (Б.Батдаваа)-нд. | Монгол Улсын Засгийн газрын “Иргэдийг орон сууцжуулах талаар авах арга хэмжээний тухай” 2023 оны 483 дугаар тогтоолын 2.11 дэх хэсэгт заасны дагуу төрийн орон сууцны дэмжлэгт хамруулах иргэн, өрхийг тодорхойлж, мэдээллийн сан үүсгэх ажлыг эрчимжүүлэх зорилготойгоор Барилга, хот байгуулалтын яамнаас зохион байгуулсан уулзалтад 2024 оны 03 дугаар сарын18-ны өдөр оролцсон. Тус уулзалтаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас төрийн орон сууцны дэмжлэгт хамруулах иргэн, өрхийг тодорхойлсны дараа ЦХИХХЯ мэдээллийн сан үүсгэх, мэдээлэл солилцохтой холбоотой асуудлыг хамтран шийдвэрлэхээр тохиролцсон. Мөн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас шаардлагатай тохиолдолд ажлын хэсэг байгуулан ажиллахаар тогтсон. | Зохион байгуулалтаас - 0% | Үгүй | |
| 91 | 155 | Фестиваль зохион байгуулах тухай<br>2024-01-25<br>Дугаар 2024_41 | 3. Фестивалийг зохион байгуулахад зохих дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нар тус тус даалгасугай.(1.“Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалийг жил бүр зохион байгуулж байхаар тогтсугай.) | Фестивалийг зохион байгуулахад Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, түүний харьяа байгууллагууд, үүрэн холбооны хувийн хэвшлийн байгууллагууд иргэдэд мэдээлэл, мессеж хүргэх зэрэг ажилд дэмжлэг үзүүлэн ажилласан. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 92 | 156 | “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2024-01-31<br>Дугаар 2024_45 | 3. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн энгийн хувьцаа эзэмшиж байгаа иргэдийн мэдээллийг боловсруулж, бүртгэлийг цахимжуулан, мэдээллийг шуурхай солилцож ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Улсын бүртгэлийн ерөнхий газар (Д.Дэлгэрсайхан), “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК (М.Энхсайхан) нарт тус тус даалгасугай. | "Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн энгийн хувьцаа эзэмшиж байгаа иргэдийн мэдээллийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвтэй хамтран и-монгол системийн мобайл аппликейншийн үнэт цаас хувьцаа цэсэд ногдол ашиг хэсэг нэмж, ногдол ашгийн он, ногдол ашгийн дүн, ногдол ашиг хүлээн авах данс зэрэг мэдээллийг харуулах боломжийг бүрдүүлсэн. Мөн мэдэгдэл явуулах интерфэйс (API) гаргасан. www.e-mongolia.mn | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 93 | 157 | Журам батлах тухай<br>2024-02-28<br>Дугаар 2024_77 | 3. Энэ журмыг үйл ажиллагаанда мөрдөж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсүгэй. (Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах нөхцөл, бүртгүүлэх журам") | "Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах нөхцөл, бүртгүүлэх журам"-ын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна:<br>-"Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах" журамд нийцүүлэн Төрөлжсөн бүртгэлийн сангийн нэгдсэн систем (infodata.gov.mn)-ийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн.<br>-"Төрөлжсөн мэдээллийн сангийн нэгдсэн систем"-д мэдээлэл хариуцагч байгууллагын мэдээллийн сан - 68, статистикийн – 48, хүснэгт - 718, үзүүлэлт – 10528, ангилал, код - 1686 бүртгэгдсэн. (infodata.gov.mn)<br>2025 оны жилийн эцсийн байдлаар мэдээлэл хариуцагч байгууллагуудаас суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах хүсэлт ирүүлээгүй байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 94 | 158 | Журам батлах тухай<br>2024-03-06<br>Дугаар 2024_100 | 2.. Журмын хэрэгжилтийг хангах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт тус тус үүрэг болгосугай.<br>("Эрүүл мэндийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, аюулгүй байдлыг хангах журам") | "Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн чиглэлээр хийсэн ажлын үр дүнг ЗГ-ын 2024.03.26, 07.24-ний өдрийн хуралдаанд танилцуулсан. Эрүүл мэндийн төрөлжсөн мэдээллийн санг үүсгэж, "ХУР"-д 24 шинэ сервисийг нэвтрүүлсэн, 2025.06.24-ний өдрийн байдлаар 443 эмнэлэг холбосон. Иргэнээс зөвшөөрөл авах нөхцөлийг SMS (OTP), хурууны хээ, Push notification, G-Sign хэлбэрээр бүрдүүлсэн. Эмнэлгийн систем хөгжүүлэгч компаниудтай гэрээ байгуулан, VPN, API-г тохируулж, ХУР, Мэдэгдлийн системийн төлбөрийг 2025 оныг дуустал чөлөөлсөн. И-Монгол системд эрүүл мэндийн 25 үйлчилгээг нэвтрүүлэн ба 37 сая мэдэгдлийг хүргэж, 1.4 сая хандалтыг авсан. Цахим эрүүл мэндийн нөхцөл байдлын үнэлгээний судалгааг 325 байгууллагаас авч, үр дүнг нээлттэй байршуулсан. ЭМТХ-ийн 8.4, 8.10 дахь хэсэгт заасан журмыг ЗГ-ын 2024 оны 100 дугаар тогтоол, ЭМС, ЦХИХХС-ын хамтарсан 2025.04.16-ны өдрийн А/130, А/58 тушаалаар батлуулан 2025.05.13-ны өдөр захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн. Эрүүл мэндийн 109 байгууллагын 111 rack, 67 VPS, 153 mail, 137 website, 293 domain-ны үйлчилгээг ҮДТ-өөс үзүүлж байна. "Төрийн бүтээмжийн сэргэлт-Цахим эрүүл мэнд" үндэсний зөвлөлдөх уулзалтыг 2024.04.08,09-нд 150 байгууллагын 380 ажилтанд /digitalhealth.gov.mn/, сургалтыг 2024.04.16-нд анхан шатлалын байгууллагын 200 төлөөлөлд, 2024.05.04-24-нд 21 аймаг, нийслэлд зохион байгуулж эрүүл мэндийн ажилтнуудыг хамруулсан. Монгол Улсын "Цахим эрүүл мэнд"-ийн цогц арга хэмжээний төлөвлөгөө (2025-2028)-г хэлэлцэх уулзалт, хэлэлцүүлгийг НҮБ-ын Хүүхдийн Сангийн дэмжлэгтэйгээр 2025.04.10, 11-ний өдрүүдэд 20 байгууллагын 52 албан хаагчийн дунд зохион байгуулсан. "Эрүүл мэндийн салбарын дижитал шилжилтийн цогц арга хэмжээний төлөвлөгөө"-г ЭМС, ЦХИХХС-ын хамтарсан 2025.05.24-ний өдрийн А/201, А/81 тушаалаар баталсан. Хэлэлцүүлэг, уулзалтын тайланг оролцогч 20 байгууллагад 2025.06.05-ны өдрийн 02/1348, ЗГЭХГ-т 2025.05.20-ны өдрийн 01/1195 албан бичгээр хүргүүлж, ИЦББХ-ны 2025.05.28-ны өдрийн хурлаар танилцуулсан.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 95 | 159 | Жагсаалт батлах тухай<br>2024-04-17<br>Дугаар 2024_162 | 3 . Ерөнхий гэрээний аргаар зохио байгуулах тендер шалгаруулалтад шаардагдах техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, холбогдох бусад материалыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | Тус яаманд ерөнхий гэрээний аргаар зохион байгуулах тендер шалгаруулалт төлөвлөөгүй болно. | Хэрэгжүүлэх хугацаа тодорхойгүй | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 96 | 160 | Багшийн гурван тулгуурт бодлого цогц арга хэмжээг батлах тухай<br>2024-05-01<br>Дугаар 2024_192 | 3.. Багшийн гурван тулгуурт бодлого" цогц арга хэмжээ"-г хэрэгжүүлж, багш мэргэжлийн нэр хүнд, үнэлэмжийг нэмэгдүүлэхэд салбараас хамаарах шаардлагатай дэмжлэг, туслалцааг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд тус тус үүрэг болгосугай | "Багшийн гурван тулгуурт бодлого"-ын зорилго нь сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын багшийн хүртээмжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх билээ. Энэ хүрээнд бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулах ажлыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газар эхлүүлэн, зохион байгуулж байна. "И-Монгол академи" УТҮГ, Нийслэлийн боловсролын газартай хамтран сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдэд зориулсан сургалтыг 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулсан. https://www.facebook.com/share/p/AspoeScTThzcKW9P/?mibextid=WC7FNe<br>НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран хэрэгжүүлсэн ОНЦМА туршилтын төсөл 2024.04.01.-2025.04.30 хооронд зохион байгуулсан. Тус төсөлд хөдөө орон нутгийн 35 сургуулийн 70 ОНЦМА багш, 10 боловсролын газрын мэргэжилтэн өөрсдийн орон нутагтаа сургалт, мэдээлэл түгээх, ОНЦМА-гаар дамжуулан сурагчдыг сургалтад хамруулж, 35 өсвөрийн цахим манлайлагч нарыг бэлтгэсэн. Эдгээр ОНЦМА нарын зохион байгуулсан сургалтад 10 000 орчим иргэн хамрагдаж, цахим ур чадварын мэдлэг олгосон байна.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 97 | 161 | Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим системийн талаар авах арга хэмжээний тухай<br>2024-05-08<br>Дугаар 2024_196 | 3.. "Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим систем"-ийг ашиглан эрхлэх асуудлынхаа хүрээндээ төрийн албан хаагчийн мэдээллийн бүрдүүлэлт, үнэн зөв байдалд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай | Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим систем"-ийг ашиглалтад ороогүй байна. Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны систем /erp-mongolia.mn/, Төрийн албаны "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим систем /https://ta.hrm.csc.gov.mn/login/-ийн төрийн албан хаагчийн порталыг үйл ажиллагаанд 2025 оноос эхлэн нэвтрүүлсэн бөгөөд албан хаагчдын бүртгэл үүсэж, тухай бүр мэдээллээ шинэчилж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 98 | 162 | Цахим шилжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай<br>2024-05-15<br>Дугаар 2024_215 | 2.. Төрийн байгууллага өөрт байгаа, эсхүл нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх, үүнтэй холбогдсон гомдлыг Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан авч, зөрчил гаргасан албан тушаалтанд хуульд заасан үндэслэл, журмын дагуу хариуцлага тооцож байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай | Нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх, үүнтэй холбогдсон гомдол одоогоор ирээгүй болно. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 163 | | 3.. Монгол Улсын иргэнд тоон гарын үсгийн гэрчилгээ эзэмших хүсэлтийг цахим хэлбэрээр төрийн үйлчилгээний "ХУРДАН" цэг болон киоск машинаар дамжуулан олгох боломжийг судалж, зохих арга хэмжээ авахыг Улсын бүртгэлийн ерөнхий газар (Д.Дэлгэрсайхан), Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар (П.Батбаатар)-т тус тус үүрэг болгосугай | Монгол Улсын хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 1,945,161 буюу Монпасс СА ХХК 95554, Ньюкомпасс ХХК 49,985, Тридум 46,445, Үндэсний дата төв 14,293, Ви Эс Эм 138, Улсын бүртгэлийн ерөнхий газар 1,738,746 иргэнд тоон гарын үсэг олгосон байна. Үүнээс Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын салбар Төрийн үйлчилгээний "ХУРДАН" цэгийн нийслэл дэх 144, орон нутаг дахь 405 цэгээр дамжуулан нийт 46,487 иргэнд тоон гарын үсэг олгоод байна. Мөн Төрийн үйлчилгээний ХУРДАН киоск машиныг нийслэлд 143, орон нутагт 339 буюу нийт 482 киоск машиныг байршуулан төрийн үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд хүндрэл чирэгдэлгүй үзүүлэх боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.<br>https://khurdan.gov.mn/%d1%85%d1%83%d1%80%d0%b4%d0%b0%d0%bd-%d1%86%d1%8d%d0%b3%d0%b8%d0%b9%d0%bd-%d0%b1%d0%b0%d0%b9%d1%80%d1%88%d0%b8%d0%bb | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 164 | | 4.. Төрийн байгууллага хоорондоо төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад албан бичгийг илгээх, хүлээн авахдаа албан бичиг солилцооны дундын систем (Docx)-ийг ашиглаж байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шүүх, прокурор, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог төрийн байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсүгэй. | 1.Албан бичиг солилцооны дундын систем DocX-ээр дамжуулан 2025 оны жилийн эцсийн байдлаар 3,040 байгууллага тус системтэй холболт хийж, 354,888 бичиг илгээж, 402,724 албан бичиг хүлээн аваад байна.<br>2.Тус яам болон түүний харьяа 5, салбар 4 байгууллагууд Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны нэгдсэн системийг бүрэн ашиглаж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 99 | 165 | Зарим яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай<br>2024-07-24<br>Дугаар 2024_06 | 4.. Яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд болон ажилтнууд нь чиг үүргийн давхардалгүй байхаар яамны үйл ажиллагааг зохион байгуулах, яамны бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан төрийн жинхэнэ албан хаагчдыгтомилох, чөлөөлөхөд Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, журмыг баримталж ажиллахыг яамдын Төрийн нарийн бичгийн дарга нарт үүрэг болгосугай. | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 06 дугаар тогтоолоор Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг баталсан ба 2024 оны 08 дугаар сард багтаан Засгийн газрын хуралд танилцуулахаар бэлтгэн ажиллаж байна. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөлд санал авах албан бичгийг 2024 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 01/103 дугаар албан бичгээр 21 сайдад хүргүүлсэн. Тус яамны бүтэц, зохион байгуулалтыг 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А/80 дугаар тушаалаар баталсан. Засгийн газрын 2025 оны 07 дугаар тогтоолын дагуу Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/263 дугаар тушаалаар тус яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн албан тушаалын нэр, ангилал, зэрэглэл орон тоог баталсан. Бүтэц, орон тоо батлагдсантай холбогдуулан Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн Б/141 дүгээр тушаалаар тус яамны албан хаагчдыг Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, журмыг баримтлан томилсон. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 100 | 166 | Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2025 оны төсвийн хязгаарыг батлах тухай<br>2024-07-24<br>Дугаар 2024_10 | 2.. Энэ тогтоолоор баталсан төсвийн хязгаарт нийцүүлэн 2025 оны төсвийн төслийг боловсруулахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны төсвийн төслийг 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 01/25 дугаартай албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Үүнээс урсгалд зардалд 124 тэрбум, хөрөнгө оруулалтын зардалд 144 тэрбум төгрөгийн санал хүргүүлсэн. Мөн Сангийн яамнаас сайдын багц төсөв хянаж байгаатай холбогдуулан нэмэлт мэдээллийг тухай бүр хүргүүлэн ажиллаж байна.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 167 | | 3. Теле камерын хяналтын төвүүдийн үйл ажиллагаанд Кибер аюулгүй байдлын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл нарт даалгасугай. | Хууль зүй, дотоод хэргийн яамны 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 7/2857 дугаар албан бичгээр “улсын хэмжээнд нэгдсэн дугаарлалтын систем нэвтрүүлэх, нийслэлд Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн үйл ажиллагааг өргөтгөх, орон нутагт дуудлага хүлээн авах ажиллагааг Телекамерын хяналтын дэд төвтэй уялдуулан зохион байгуулах” ажлын Техник, эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/ боловсруулахад шаардлагатай системийн шинжилгээ хийлгэх танилцуулга ирүүлсний дагуу холбогдох албан хаагчтай мэдээлэл солилцох зорилго бүхий уулзалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 101 | 168 | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай<br>2024-09-18<br>Дугаар 2024_86-1 | 4 . Теле камераар цуглуулса мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд ашиглахгүй байх нөхцөлийг бүрдүүлж, эрсдэлээс хамгаалах шаардлагатай арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгож, шүүх, прокурор, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог төрийн байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсүгэй. | Хууль зүй, дотоод хэргийн яамны 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 7/2857 дугаар албан бичгээр “улсын хэмжээнд нэгдсэн дугаарлалтын систем нэвтрүүлэх, нийслэлд Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн үйл ажиллагааг өргөтгөх, орон нутагт дуудлага хүлээн авах ажиллагааг Телекамерын хяналтын дэд төвтэй уялдуулан зохион байгуулах” ажлын Техник, эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/ боловсруулахад шаардлагатай системийн шинжилгээ хийлгэх танилцуулга ирүүлсний дагуу холбогдох албан хаагчтай мэдээлэл солилцох зорилго бүхий уулзалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан. | Ахиц гарсан - 50% | Үгүй | |
| | 169 | | 6. Монгол Улсад хүчин төгөлде мөрдөгдөж байгаа теле камерын стандартыг шинэчлэн боловсруулах ажлыг удирдан зохион байгуулахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүд, стандартыг холбогдох журмын дагуу батлахыг Стандарт, хэмжил зүйн газар (С.Батбаатар)-т даалгасугай | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/39 дүгээр тушаалаар теле хяналтын камерын стандартыг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулж, теле хяналтын камераар цуглуулсан мэдээллийн аюулгүй байдлыг хангах зөвлөмж боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба, Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын төв, Эрүүгийн цагдаагийн албаны Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газар, Тээврийн цагдаагийн алба, Харилцаа холбооны зохицуулах хорооны бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллаж байна. Ажлын хэсэг 2024 оны 11 дүгээр сарын 04, 28-ны өдрүүдэд хуралдаж, одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Теле хяналтын системийн техникийн шаардлага MNS 6423:2019 стандартыг судалж, тээврийн хэрэгслийн дүрс бичлэгийн камер болон цагдаагийн энгэрийн камер, түүнд тавигдах шаардлагуудыг хариуцсан чиглэлийн дагуу боловсруулж, стандартын төслийн эхний хувилбарыг гаргаад байна. Мөн аймаг, дүүргийн Засаг даргын дэргэд байгуулагдах теле хяналтын нэгдсэн төв болон дэд төвүүд теле хяналтын камераар цуглуулсан мэдээллийн аюулгүй байдлыг хангах зөвлөмж боловсруулахаар ажиллаж байна. | Ахиц гарсан - 50% | Үгүй | |
| 102 | 170 | Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулж, журам батлах тухай<br>2024-09-25<br>Дугаар 2024_97_1 | 4. 4.Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх үндэсний зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг жил бүрийн батлагдсан төсөвтөө багтаан санхүүжүүлэхийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүд даалгасугай. | Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.7-д заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 97 дугаар тогтоолоор “Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх үндэсний зөвлөл, түүний бүрэлдэхүүн, ажиллах журам”-ыг баталсан. Зөвлөлийн анхдугаар хуралдааныг 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулсан. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 13.4-т заасны дагуу “Виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд үзүүлэх татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх журам”-ын төслийг Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан. Мөн 2025 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх үндэсний зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах зардал болон хуулийг даган гарах журмын төсөл боловсруулах зэрэг төсвийг тусган баталсан.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 103 | 171 | Журам батлах тухай “Төрийн нууцад хамаарах худалдан авах ажиллагааг зохицуулах журам” 2024-10-09 Дугаар 2024_120_1 | 2.. Энэ тогтоолын хавсралтаар баталсан журмыг (Төрийн нууцад хамаарах худалдан авах ажиллагааг зохицуулах журам) үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг холбогдох төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагад тус тус үүрэг болгосугай. (3.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Тагнуулын ерөнхий газар (П.Одонбаатар)-т тус тус даалгасугай) | 2024 оноос 2026 он хүртэл Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, түүний харьяа байгууллагууд төрийн нууцад хамаарах худалдан авах ажиллагаа одоогоор хийгдээгүй болно. | Хэрэгжүүлэх хугацаа тодорхойгүй | Үгүй | |
| 103 | 172 | ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ | 2. 2.Төрийн захиргааны байгууллагын албан хэрэгцээнд ашиглах баримт бичиг боловсруулах программ хангамжийн лицензийг Ерөнхий гэрээгээр худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу нэгдсэн журмаар зохион байгуулахыг Монгол Улсын Шадар сайд Т.Доржхандад, холбогдох зардлыг төсвийн багцдаа тусган санхүүжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус үүрэг болгосугай. | Төрийн байгууллагуудын албан хэрэгцээнд ашиглах баримт бичиг боловсруулах программыг нэгдсэн зохион байгуулалттайгаар худалдан авах боломжийг судлах, нэгж лицензийн үнийг бууруулах асуудлаар Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Шадар сайдын ажлын алба, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Төрийн худалдан авах ажиллагааны газар, Микрософт ХХК-ийн төлөөлөл бүхий уулзалтыг 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас зохион байгуулсан. Тус уулзалтын үр дүнд Microsoft компанийн зүгээс нэгж лицензийн үнийг бууруулах боломжийг судалж, эргүүлэн хариу өгөхөөр харилцан тохиролцоод байна. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Шадар сайдын Ажлын алба, Тагнуулын ерөнхий газар, Төрийн худалдан авах ажиллагааны газар, Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төв, Үндэсний дата төв УТҮГ-ын хамтарсан ажлын хэсгийг 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн А/37 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна. Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нар болон мэдээлэл хариуцагч нийт 60 гаруй байгууллагад 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01/153 дугаартай албан бичгийг хүргүүлж, 939 байгууллагаас нэгж лиценз бууруулахад шаардлагатай мэдээлэл, судалгаа ирүүлснийг нэгтгэн ажлын хэсэгт танилцуулсан. Төрийн худалдан авах ажиллагаа цахим системээр Microsoft-ийн 12 бүтээгдэхүүнийг цахимаар худалдан авах боломж бүрдсэн. | Ахиц гарсан - 50% | Үгүй | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 104 | 173 | АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ ШИЛЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ<br>2024-11-13<br>Дугаар 2024_163 | 3. Төрийн албан хаагчдын цахим ур чадварыг сайжруулах сургалтын хөтөлбөрийг боловсруулж, сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэхийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүд даалгасугай. | 1.Засгийн газраас тогтоосон цахим ур чадварын бүтцийн хүрээний агуулгын дагуу орон нутгийн төрийн албан хаагчдын цахим ур чадварыг сайжруулах хөтөлбөр боловсруулж, сургалт зохион байгуулах асуудлын хүрээнд цахим ур чадварын бүтцийн хүрээний агуулгын дагуу2022 онд Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх I, II, III шатны 1,132 удаагийн 2,444 цагийн цахим ур чадварын сургалтад нийт 84,744 хүнийг хамруулсан. Үүнээс 56,677 нь төрийн албан хаагч, 26,524 иргэн, хөгжлийн бэрхшээлтэй 687 иргэн хамрагдаж, 867 сургагч багш бэлтгэгдсэн байна. 2.Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх I, II, III шатны сургалтыг 21 аймаг дахь Мэдээллийн технологийн хэлтэс, "ХУРДАН" клубээрээ дамжуулан үе шаттай зохион байгуулж, нийт 90,037 хүнд сургалт явуулсан. Төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, олон нийтийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх (DEMOSC) төслийн хүрээнд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газартай хамтран Дархан-Уул аймагт төрийн цахим үйлчилгээний хөдөлгөөнт Хурдан цэг, Төрийн албан хаагчид, иргэд, хүүхдүүдийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх танхимыг байгуулж 4,823 иргэнд төрийн цахим үйлчилгээг үзүүлсэн.<br>2.Цахим шилжилтийг эрчимжүүлэх, иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх, мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх зорилгоор бүх нийтийн цахим ур чадвар олгох V аяны хүрээнд 2025 онд үндэсний хэмжээнд 21 аймагт 105 удаа, 112 суманд 560 удаагийн сургалтад нийт 48248 иргэнийг хамруулсан байна. Бүх нийтийн харилцаа холбоо, мэдээллийн суурь мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилгоор иргэдэд цахим ур чадвар олгох суурь сургалтыг 2025 онд 63 удаагийн давтамжтай нийт 5008 иргэнийг хамруулсан байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 105 | 174 | ХУУЛИЙН БИЕЛЭЛТИЙГ ХАНГАХ ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ<br>2024-11-13<br>Дугаар 2024_164_01 | 1.. "Нийслэл Улаанбаатар хотын авто замын хөдөлгөөний ачааллыг бууруулах зорилгоор ажлын зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд төрийн албан хаагч, ажилтныг долоо хоногийн ажлын нэг өдөр зайнаас ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг нийслэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон нутгийн захиргааны байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд болон бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгож, .... " | Тус хуулийн биелэлтийн хүрээнд хүсэлт гаргасан 1 албан хаагчийг Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны Б/61 дүгээр тушаалаар ажлын 5 хоногийн нэг өдөр цахимаар 2024.11.21-2024.12.31-ний өдрийг дуустал хугацаанд ажиллуулсан. Тус хуулийн биелэлтийн хүрээнд 2025 онд 1 албан хаагчийг өөрийн гаргасан хүсэлтийн дагуу цахимаар ажиллуулж байна. Мөн тус хуулийн биелэлтийн хүрээнд Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/355 дугаар тушаалаар албан хаагчдыг ажлын зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд долоо хоногийн ажлын нэг өдөр зайнаас ажиллуулах хуваарийг батлан хэрэгжүүлж ажиллаж байна.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 106 | 175 | Монгол улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай<br>2024-11-20<br>Дугаар 2024_181 | 3.. Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэлд тусгагдаагүй боловч хууль тогтоомжоор зохицуулах зайлшгүй шаардлагатай хууль тогтоомжийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж байхыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай. | Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд тус яамнаас хариуцан боловсруулахаар Дэлхийн шуудан холбооны дүрмийн арваннэгдүгээр нэмэлт протоколыг соёрхон батлах тухай, Шуудангийн тухай хууль (Шинэчилсэн найруулга), Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон)-ийн тухай хууль (Анхдагч хуулийн төсөл), Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль туссан бөгөөд сансрын болон өгөгдөл хамгаалах, хуваалцахтай холбоотой харилцааг хууль тогтоомжоор зохицуулах зайлшгүй шаардлага үүссэн гэж үзэж хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны ажлыг тус яамны 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна. | Тодорхой үр дүнд хүрсэн - 50% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 107 | 176 | Жуулчдын урсгалыг нэмэгдүүлж, дөрвөн улирлын турш жуулчин хүлээн авах зорилтын хүрээнд хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай<br>2024-11-27<br>Дугаар 2024_191_01 | 2.3.. Аялал жуулчлалын нэгдсэн цаглабрыг боловсруулж, улирлын онцлогийг харгалзан салбарын олон улсын хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн, урлаг, соёл, спортын зарим арга хэмжээг жил бүрийн 10 дугаар сараас дараа жилийн 4 дүгээр сар хүртэл хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт. | 1.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээг олон нийтэд сурталчлан таниулах, төрийн болон салбарын хувийн хэвшлийн байгууллагуудын дунд салбар хэлэлцүүлэг, "ICT EXPO-2025" үзэсгэлэнг 2025 оны 09 дүгээр сарын 21-26-ны өдрүүдэд зохион байгуулсан.<br>2.Харилцаа холбооны зохицуулах хорооноос 2025 оны 09 дүгээр сарын 24–25-ны өдрүүдэд Монгол Улсад зохицуулах байгууллага байгуулагдсаны 30 жилийн ойд зориулан “Харилцаа холбооны зохицуулалт 2025” олон улсын форумыг зохион байгуулсан бөгөөд дижитал шилжилтийн эринд зохицуулалтын бодлого, зохион байгуулалтын шинэчлэл, олон улсын чиг хандлага, туршлагыг хэлэлцэх чухал арга хэмжээ бөгөөд тус арга хэмжээнд Форумд Олон Улсын Цахилгаан Холбооны Байгууллага, Дэлхийн худалдааны байгууллагын Эрх зүйн асуудлаар зөвлөх төв, Интернэтийн нэр, тоон хаягийн корпораци, Хөдөлгөөнт харилцаа холбооны ассосацийн глобал систем, Азийн Номхон далайн бүс нутгийн сүлжээний мэдээллийн төв, Тайланд Улсын зохицуулах байгууллага, Малайз Улсын зохицуулах байгууллага, технологи үйлдвэрлэгч Huawei компани зэрэг олон улсын байгууллага, салбарын гол тоглогчид болон Монголын оператор компаниуд оролцсон. | Хэрэгжсэн - 100% | Тийм | Бүрэн хэрэгжсэн. |
| 108 | 177 | Танилт, нэвтрэлтийн арга, хэрэгсэл батлах тухай<br>2024-12-18<br>Дугаар 2024_217 | 2. 2. Хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхэд танилт, нэвтрэлтийн системийг ашиглахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга нарт болон төрийн захиргааны бүх шатны байгууллагын удирдлагад тус тус үүрэг болгосугай. | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 196 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам"-ын дагуу 2025 оны жилийн эцсийн байдлаар Танилт, нэвтрэлтийн нэгдсэн систем (ДАН)-д төрийн 101 байгууллагын 224, хувийн 323 байгууллагын 367 систем бүртгэлтэй 2,293,457 иргэн байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 178 | | 3. 3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүд даалгасугай. | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт “Төрөөс хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхдээ хүн, хуулийн этгээдийг цахим гарын үсэг болон Засгийн газраас тогтоосон арга, хэрэгсэл бүхий танилт, нэвтрэлтийн системийг ашиглан таньж, баталгаажуулна” гэж заасны дагуу “Танилт, нэвтрэлтийн арга, хэрэгсэл батлах тухай” Засгийн газрын тогтоолыг 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн Засгийн газрын 217 дугаар тогтоолоор батлуулсан.<br>Цахим хуудаст хандах: https://legalinfo.mn/mn/detail?lawId=17355322506031<br>Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 196 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам"-ын дагуу 2025 оны жилийн эцсийн байдлаар Танилт, нэвтрэлтийн нэгдсэн систем (ДАН)-д төрийн 101 байгууллагын 224, хувийн 323 байгууллагын 367 систем бүртгэлтэй 2,293,457 иргэн байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 109 | 179 | Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай<br>2024-12-20<br>Дугаар 2024_226 | 2. 2. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд Агаарын тухай хууль, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга болон нийслэлийн бүх шатны Засаг дарга нарт даалгасугай. | Мэдээлэл, харилцаа холбооны улсын албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөөг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/90 дүгээр тушаалаар батлаж, тодотгол хийж, зардлыг улсын төсөвт жил бүр шийдвэрлүүлж байна. Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/47 дугаар тушаалаар Цагаан сарын баяраар хариуцлагатай жижүүрийг томилж, ажилласан талаарх илтгэх хуудсыг Төрийн ордны Онцгой байдлын албанд 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 03/568 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Онцгой байдлын ерөнхий газраас Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах хэлэлцүүлэгт 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөс 04 дүгээр сарын 04-ний өдөр оролцон мэдээлэл, харилцаа холбооны салбарын мэдээ мэдээллийг өгч ажиллалаа. Тус яамны нийт албан хаагчид 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр гамшгийн зарлан мэдээллийн дуут дохиогоор цугларах цэг /Сүхбаатарын талбай/-т гамшгийн үед авах арга хэмжээний талаарх мэдлэгээ бататган дадлага сургуулилалт хийсэн.<br><br>Хавсралт нийт : 8 Файл : 1 Зураг : 7 | Хэрэгжсэн - 100% | Тийм | Тогтоолоор өгөгдсөн үүрэг даалгаврын хугацаа дууссан. Мөн хугацаанд бүрэн хэрэгжүүлсэн. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 110 | 180 | Жагсаалт батлах тухай<br>2024-12-25<br>Дугаар 2024_233 | 2. 2. Энэ тогтоолын 1, 2 дугаар хавсралтад заасан төсөл, арга хэмжээ бүрийн техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны газар, аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газарт 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн дотор тус тус хүргүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцад батлагдсан Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ төсөл,Сэлгэн ажиллах дата төвийн нөөцийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/ төсөл, Хил хамгаалах ерөнхий газарт хэрэгжүүлэх “BPF-24mn” дрон бүтээх, турших, үйлдвэрлэж албанд нэвтрүүлэх гурван төсөл, арга хэмжээнүүдийг батлагдсан техникийн тодорхойлолт болон үнэлгээний хороонд захиалагчийг төлөөлж, үнэлгээний хороонд ажиллах албан хаагчдын мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 181 | | 3. 3.Худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.tn)-ээр зохион байгуулж, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд заасан дугаар төсөл. арга хэмжээний дугаар нэр хүчин чадал, байршил төслийн код (“УТ” код)-ыг батлагдсан хэлбэрээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд нийтэлж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч, Төрийн худалдан авах ажиллагааны газарт тус тус даалгасугай. | Худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр зохион байгуулж, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд заасан Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ төсөл (УТ2506700069), Сэлгэн ажиллах дата төвийн нөөцийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/ төсөл (УТ2506700014), Хил хамгаалах ерөнхий газарт хэрэгжүүлэх “BPF-24mn” дрон бүтээх, турших, үйлдвэрлэж албанд нэвтрүүлэх (УТ2506700099) кодоор батлагдсанаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд нийтэлж ажиллаж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 182 | | 4. 4.Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчмыг баримтлан шуурхай зохион байгуулж ажиллахыг Төрийн худалдан авах ажиллагааны газар, төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар баталсан 2025 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийг үндэслэн авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчмыг баримтлан ажиллаж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 111 | 183 | Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай<br>2024-12-25<br>Дугаар 2024_238_1 | 2. 2. Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлж, 2025 онд орон тооны дээд хязгаарыг нэмэгдүүлэхгүй байхыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлж, 2025 онд орон тооны дээд хязгаарыг мөрдөн ажиллаж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 112 | 184 | Цагааннуур” чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай<br>2025-01-08<br>Дугаар 2025_09 | 2. 2.“Цагааннуур” чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл, үе шатны ажлын зураг төслийг боловсруулах, барилга байгууламжийг барьж байгуулахад шаардагдах зардлыг улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улс, орон нутгийн жил бүрийн төсөвт тусгаж, бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрийг гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжаар хэрэгжүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Монгол Улсы.ч Шадар сайд С.Амарсайхан, Сангийн сайд Б.Жавхпан. Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү нарт даалгасугай. | Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 2025 онд арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдаагүй. | Санхүү, хөрөнгө оруулалтаас - 0% | Үгүй | |
| 113 | 185 | Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс”-ийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай<br>2025-01-08<br>Дугаар 2025_10 | 2. 2.“Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс”-ийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл, үе шатны ажлын зураг төслийг боловсруулах, барилга байгууламжийг барьж байгуулахад шаардагдах зардлыг улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улс, орон нутгийн жил бүрийн төсөвт тусгаж, бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрийг гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжаар хэрэгжүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Сангийн сайд Б.Жавхлан, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Б.Дэлгэрсайхан, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нарт даалгасугай. | “Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс”-ийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл, үе шатны ажлын зураг төслийг боловсруулах, барилга байгууламжийг барьж байгуулахад шаардагдах зардлыг улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улс, орон нутгийн жил бүрийн төсөвт тусгаж, бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрийг гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжаар хэрэгжүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах арга хэмжээ авч ажиллахаар төлөвлөж байна. | Зохион байгуулалтаас - 0% | Үгүй | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 114 | 186 | Яаралтай тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2025-02-05<br>Дугаар 2025_67 | 2. 2 .Яаралтай тусламжийн дуудлага, мэдээллийг нэгдсэн “112” дугаарлалтад хүлээн авах техникийн нөхцөлийг цахилгаан холбооны үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдтэй хамтран бүрдүүлж, нэгдсэн дугаарлалтад шилжих системийг нийтийн мэдээллийн дэд бүтцэд нийцүүлэн боловсруулах, хиймэл оюун ухаанд суурилсан технологийн шийдлийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Харилцаа холбооны зохицуулах хороо (Г.Чинзориг)-д тус тус үүрэг болгосугай. | Яаралтай тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэхтэй холбоотой яаралтай тусламжийн дугаарыг нэгдсэн 112 дугаарт шилжүүлэх арга хэмжээг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яам, Харилцаа холбооны зохицуулах хороо, Цагдаагийн ерөнхий газар, Мэдээлэл, шуурхай удирдлагын төв, Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн түргэн тусламжийн төв зэрэг байгууллагуудын хамтарсан уулзалтад 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр оролцож одоогийн нөхцөл байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцсон. Тус яамны 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд “Яаралтай тусламжийн үйл ажиллагаанд нэгдсэн 112 дугаарлалтыг нэвтрүүлэхэд шаардлагатай технологийн шийдлийг боловсруулж, нэвтрүүлэх нөхцөлийг судлах”-аар туссан. “Тусгай дугаар 112”-ын үйл ажиллагаанд шаардлагатай технологийн шийдлийг боловсруулж, нэвтрүүлэх нөхцөлийг судлах ажлын даалгаврыг 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр баталж, 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр худалдан авах ажиллагааг зарласан. Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж батлагдсан. Төсвийн тодотголоор тус яамны урсгал зардлын хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний санхүүжилт хасагдаж, санхүүжилтийн эх үүсвэргүй болсон. | Санхүү, хөрөнгө оруулалтаас - 0% | Үгүй | |
| 115 | 187 | 'Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс"-ийн Захирагчийн ажлын албаны бүтэц, орон тооны хязгаар батлах тухай<br>2025-02-12<br>Дугаар 2025_83 | 3. 3 .“Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс”-ийн Захирагчийн ажлын албаны үйл ажиллагааны зардлыг 2025 оны батлагдсан төсөвтөө багтаан, цаашид жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Сангийн сайд Б.Жавхлан нарт, чөлөөт бүсийн бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэхэд холбогдох хууль тогтоомжийн дагуу өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгасугай. | Тус байгууллагаас 2024, 2025 онд чөлөөт бүсийн бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэхэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хамтран ажиллах санал ирүүлээгүй байна. | Хийгдэх үйл ажиллагаа, зорилго тодорхойгүй | Үгүй | |
| 116 | 188 | Экспортын орлогыг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай<br>2025-02-19<br>Дугаар 2025_94 | 2. 2. Томоохон төсөл, арга хэмжээний санхүүжилт, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэхдээ гадаад валютын улсын нөөцөд богино, дунд, урт хугацаанд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нар, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад тус тус үүрэг болгосугай. | 2026 оны төсвийн төлөвлөгөөнд томоохон төсөл, арга хэмжээний санхүүжилт, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэхдээ гадаад валютын улсын нөөцөд богино, дунд, урт хугацаанд сөрөг нөлөө үзүүлэхгүй байхаар тус тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 116 | 189 | Экспортын орлогыг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай<br>2025-02-19<br>Дугаар 2025_94 | 4. 4. Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, хөрөнгө оруулалт татах зорилгоор гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж болон иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэж ажиллахыг бүх шатны төрийн захиргааны байгууллагад үүрэг болгосугай. | 2026 оны төсвийн төлөвлөгөөнд томоохон төсөл, арга хэмжээний санхүүжилт, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэхдээ гадаад валютын улсын нөөцөд богино, дунд, урт хугацаанд сөрөг нөлөө үзүүлэхгүй байхаар тус тогтоолыг барин ажиллаж байна. Аж ахуйн нэгж, иргэнээс экспортын орлогыг нэмэгдүүлэх талаарх 2025 оны жилийн эцсийн байдлаар гаргасан өргөдөл, гомдол байхгүй болно. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 117 | 190 | Захиргааг өөрчлөн зохион байгуулах тухай<br>2025-03-12<br>Дугаар 2025_131 | 4. 4.“20 минутын хот хөгжлийн төв”-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, эрхлэх асуудлын хүрээний бодлого, төлөвлөлттэй харилцан уялдуулж, хамтран ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | Тус байгууллагаас 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 01/109 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа” төсөвт байгууллагыг “Хот байгуулалт, хөгжлийн үндэсний хүрээлэн” төсөвт байгууллага болгон өөрчлөн байгуулах тухай Засгийн газрын тогтоолын төсөлд 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 01/547 дугаартай албан бичгээр, мөн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 01/1218 дугаартай албан бичгээр тус тус санал хүргүүлж, хамтран ажилласан. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 118 | 191 | Олон улсын худалдааны тарифын нөхцөл байдалтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай<br>2025-03-12<br>Дугаар 2025_132 | 1. Олон улсад үүсэж байгаа геополитикийн болон худалдааны хурцадмал, тодорхойгүй нөхцөл байдалтай холбогдуулан хүн амд үзүүлэх үйлчилгээний зохицуулалтын уялдааг хангах, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх орчны тогтвортой байдлыг дэмжих зорилгоор төрөөс иргэн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа бүх төрлийн үйлчилгээний төлбөр, хураамжийг 2025 оны төсвийн жилд нэмэгдүүлэхгүй байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нар, зөвлөл, хороо, комиссын дарга нар, бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | Тус яам нь хүн амд үзүүлэх үйлчилгээний зохицуулалтын уялдааг хангаж, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх орчны тогтвортой байдлыг дэмжиж төрөөс иргэн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа бүх төрлийн үйлчилгээний төлбөр, хураамжийг 2025 оны төсвийн жилд нэмэгдүүлэхгүй ажиллаж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 119 | 192 | Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай | 2. 2.Энэ тогтоолын хавсралтад заасан байршилд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд бөгөөд Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны дарга С.Одонтуяа, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь нарт, төлөвлөгөөний биелэлтийг 2025 оны III улирал багтаан хангахыг Засгийн газрын гишүүд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нарт тус тус үүрэг болгосугай. | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 133 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын ногоон бүсийн айл, өрхүүдийн гэр, амины орон сууцны дулаалга, хатуу түлшний хэрэглээнд хяналт тавих хуваарийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд санал өгсөн.<br>Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2025 оны нэгдсэн төлөвлөгөөнд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам хариуцан хэрэгжүүлэхээр туссан "Төрийн нэгдсэн цахим хуудас дээр агаарын бохирдолын мэдээллийг хүргэх хөгжүүлэлтийг хийх" ажлын хүрээнд Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia.mn)-д агаарын чанарын индексийг 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрөөс хэрэглээнд нэвтрүүлсэн. Цаг агаар, агаарын чанарын мэдээллийг жил бүрийн 09 дүгээр сарын 01-ний өдрөөс ирэх жилийн 03 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд 2,091,011 иргэнд мэдээллэдэг. Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia.mn)-ийн 5.0 хувилбарыг 2025 оны 09 дүгээр сарын 20-ний өдөр ашиглалтад нэвтрүүлсэн бөгөөд улирал харгалзахгүй Улаанбаатар хотын орчим 19 цэгт агаар бохирдуулах бодисыг 6 үзүүлэлтээр агаарын чанарын индексийг тогтмол олон нийтэд мэдээлж байна. Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хороонд 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 01/2892 дугаартай албан бичгээр "Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны нэгтгэсэн 2025 оны төлөвлөгөө"-ний жилийн эцсийн биелэлтийг хүргүүлсэн.<br>Цахим хуудаст хандах: https://e-mongolia.mn/weather<br><br>Хавсралт : 2 файл | Тодорхой үр дүнд хүрсэн - 50% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 119 | 193 | хэмжээний тухай<br>2025-03-19<br>Дугаар 2025_133 | 3.7. 3.7.Эрчим хүчний хэмнэлттэй ногоон орон сууцны пассив стандарт, хийн түлшний болон цахилгаан халаагуур, бусад дэвшилтэт технологийн шийдлийг хэрэглэх талаар олон нийтэд мэдээлэл хүргэх, сурталчлан таниулах арга хэмжээ зохион байгуулж, үр дүн тооцож ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн нарт; | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 133 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын ногоон бүсийн айл, өрхүүдийн гэр, амины орон сууцны дулаалга, хатуу түлшний хэрэглээнд хяналт тавих хуваарийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд санал өгсөн. Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2025 оны нэгдсэн төлөвлөгөөнд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам хариуцан хэрэгжүүлэхээр туссан "Төрийн нэгдсэн цахим хуудас дээр агаарын бохирдолын мэдээллийг хүргэх хөгжүүлэлтийг хийх" ажлын хүрээнд Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia.mn)-д агаарын чанарын индексийг 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрөөс хэрэглээнд нэвтрүүлсэн. Цаг агаар, агаарын чанарын мэдээллийг жил бүрийн 09 дүгээр сарын 01-ний өдрөөс ирэх жилийн 03 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд 2,091,011 иргэнд мэдээллэдэг. Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia.mn)-ийн 5.0 хувилбарыг 2025 оны 09 дүгээр сарын 20-ний өдөр ашиглалтад нэвтрүүлсэн бөгөөд улирал харгалзахгүй Улаанбаатар хотын орчим 19 цэгт агаар бохирдуулах бодисыг 6 үзүүлэлтээр агаарын чанарын индексийг тогтмол олон нийтэд мэдээлж байна. Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хороонд 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 01/2892 дугаартай албан бичгээр "Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны нэгтгэсэн 2025 оны төлөвлөгөө"-ний жилийн эцсийн биелэлтийг хүргүүлсэн.<br>Цахим хуудаст хандах: https://e-mongolia.mn/weather<br><br>Хавсралт : 2 файл | Тодорхой үр дүнд хүрсэн - 50% | Үгүй | |
| 120 | 194 | 2026 оныг “Боловсролыг дэмжих жил болгон зарлах тухай<br>2025-04-02<br>Дугаар 2025_158 | 3. 3.Боловсролыг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засагдарга нарт үүрэг болгосугай. | "Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратеги”-ийн төслийн хэлэлцүүлгийг эрүүл мэнд, боловсрол, хууль сахиулах, шүүхийн салбарын хэмжээнд зохион байгуулах саналыг Боловсролын яаманд 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 02/1429 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Тус хэлэлцүүлгийг 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдөр НҮБ-ын төв байранд Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүүхдийн сантай хамтран зохион байгуулж, "Хиймэл оюун, их өгөгдлийн стратеги"-ийг салбар бүртээ хэрэгжүүлэх нийт 40 гаруй байгууллагын 120 гаруй албан хаагчид оролцсон. "Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратеги”-ийн төсөлд Боловсролын салбарын хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжийг нэгтгэн тусгаж стратегийн төслийг төлөвлөгөөний хамт боловсруулсан. Уг стратегийн талаар Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 18 дугаар хуралдаанд танилцуулж, тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын дагуу Их өгөгдл, хиймэл оюуны үндэсний стратегид тусгагдсан зорилт, арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төсөлд тусгасан.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 195 | | 1.5.1.. 1.5.1.Хөвсгөл аймгийн Мөрөн суманд Бүсийн дата төв, Орхон аймгийн Эрдэнэт хотод Мэдээллийн технологийн төрөлжсөн төв байгуулах асуудлыг судалж, холбогдох арга хэмжээ авахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Хойд бүсийн зөвлөл (Д.Пүрэв-Очир)-д; | Мэдээлэл технологийн төрөлжсөн төв байгуулах ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах ажлын хүрээнд хийсэн судалгаанд үндэслэн байршлыг оноочлолын аргаар тодруулахад Хойд бүсийн төрөлжсөн төвийг Орхон аймагт байгуулахаар сонгогдсон. Үүнтэй холбогдуулан Орхон аймагт уг төвийг барих газрын мэдээллийг Орхон аймгийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 29-ний 01/1888 дугаар албан бичгээр баталгаажуулан авч, ТЭЗҮ, зураг төслийн ажил хийж байна. | Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 121 | 196 | Хойд бүсийн хөгжлийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай<br>2025-04-28<br>Дугаар 2025_204 | 1.5.2.. 1.5.2.“Цахим аймаг, ухаалаг хот” зөвлөмжийг баталж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хойд бүсийн зөвлөл (Д.Пүрэв-Очир)-д, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүд. | Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/53 дугаар тушаалаар "Цахим аймаг" бодлогын зөвлөмжийг баталсан. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанд танилцуулж, Засгийн газрын 25 дугаар тэмдэглэлээр Цахим аймаг бодлогын зөвлөмжийг аймаг, нийслэл, сум, дүүрэгт хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад, бодлогын дэмжлэг үзүүлж ажиллахыг ЦХИХХ-ны сайдад даалгасан. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/66 дугаар тушаалаар "Цахим аймаг" бодлогын зөвлөмжийг аймаг, нийслэл, сум дүүрэгт хэрэгжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийг байгуулан “Аймаг, орон нутгийн цахим шилжилтийг эрчимжүүлэх, иргэн аж, ахуйн нэгжид чиглэсэн нэгдсэн систем нэвтрүүлэх” төслийн ажлыг 2024 онд Дархан-Уул, Өвөрхангай аймагт хэрэгжүүлээд байна. Мөн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны А/07 дугаар тушаалаар Иргэдийн амьжиргаа, цаг хугацааг хэмнэх амьдрах таатай орчныг бүрдүүлэх “Дижитал-Аймаг, Дижитал-Хот” бодлогын зөвлөмжийг боловсруулан хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, зөвлөмжийн төслийг боловсруулсан. “Дижитал-Аймаг, Дижитал-Хот” бодлогын зөвлөмжийг 2025 онд Булган, Баянхонгор, Говь-Алтай, Дундговь, Сэлэнгэ, Төв, Хэнтий аймагт хэрэгжүүлэхээр ажлын даалгаврыг 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр батлан, худалдан авах ажиллагааг 2025 оны 05 дугаар сарын 08-29-ны өдөр нийтэд нээлттэй тендер зарлаж 4 оролцогч оролцсоноос шаардлага хангасан тендер ирүүлээгүй гэж үзэж мэдэгдлийг хүргүүлсэн. 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрөөс 07 дугаар сарын 08-ны өдрийн хооронд гомдол гарч тендерийг түр түтгэлзүүлсэн. Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж баталсан. Төсвийн тодотголоор тус яамны урсгал зардлын хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний санхүүжилт хасагдаж, санхүүжилтийн эх үүсвэргүй болсон. | Тодорхой үр дүнд хүрсэн - 50% | Үгүй | |
| 122 | 197 | Журам батлах тухай<br>2025-05-07<br>Дугаар 2025_224 | 2.3. 2.3 Энэ тогтоолын 1-д зааса санхүүжилт болон грант олгоход шаардагдах зардлыг 2025 оны батлагдсан төсөвтөө багтаан, цаашид шаардагдах зардлыг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусган санхүүжүүлж байхыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгасугай. | 1. Засгийн газрын 2025 оны 224 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Инновацын төслийг улсын төсвөөс санхүүжүүлэх журам”-ын 3.4-т заасан “Инновацын бүтээгдэхүүний талаар дүгнэлт гаргах, мэргэжлийн шинжээчдийн ажиллах журам”-ын төслийг боловсруулан олон нийтээс санал авахаар яамны цахим хуудас (www.mddic.gov.mn)-т нийтлэн холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. 2. 2025 оны төсөв, Засгийн газрын 2025 оны 224 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан “Инновацын үйл ажиллагаанд оролцогчид грант олгох журам”-ын хүрээнд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/88 дугаар тушаалаар Инновацын шийдлийг сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсэг, сонгон шалгаруулалтын удирдамжийг баталж, сонгон шалгаруулалтыг 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр олон нийтэд нээлттэй зарласан. Сонгон шалгаруулалтад нийт 59 инновацын шийдэл бүхий төслийн материал ирүүлснээс 14 шилдэг төслийг шалгаруулан грантын дэмжлэг олгохоор гэрээ байгуулан ажиллаж байна. 2026 оны төсвийн төсөлд "Инновац өндөр технологи"-д зориулан урсгал зардал дээр 72 тэрбум санал өгсөн боловч 51 сая төгрөгөөр тусгагдсан. 2026 оны төсөв батлагдаагүй байна. | Ахиц гарсан - 50% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 198 | | 2.4. 2.4 Журмын хэрэгжилтийг зохио байгуулж, хяналт тавьж ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүд үүрэг болгосугай. | 1.Засгийн газрын 2025 оны 224 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Инновацын төслийг улсын төсвөөс санхүүжүүлэх журам”-ын 3.4-т заасан “Инновацын бүтээгдэхүүний талаар дүгнэлт гаргах, мэргэжлийн шинжээчдийн ажиллах журам”-ын төслийг боловсруулан олон нийтээс санал авахаар яамны цахим хуудас (www.mddic.gov.mn)-т нийтлэн холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.<br>2. 2025 оны төсөв, Засгийн газрын 2025 оны 224 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан “Инновацын үйл ажиллагаанд оролцогчид грант олгох журам”-ын хүрээнд Инновацын шийдлийг сонгон шалгаруулалтыг 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр олон нийтэд нээлттэй зарлаж, зохион байгуулсан. Сонгон шалгаруулалтад нийт 59 инновацын шийдэл бүхий төслийн материал ирүүлснээс 14 шилдэг төслийг шалгаруулан грантын дэмжлэг олгосон. 2026 оны төсвийн төсөлд ""Инновац өндөр технологи""-д зориулан урсгал зардал дээр 72 тэрбум төгрөгийн санал өгсөн болович 51 сая төгрөгөөр тусгагдсан. 2026 оны төсөв батлагдаагүй байна. | Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50% | Үгүй | |
| 123 | 199 | Ажил, амралтын цагийн зохицуулалтын тухай<br>2025-06-04<br>Дугаар 2025_279 | 1. 1.Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярын 2025 оны 07 дугаар сарын 12, 13-ны өдрүүд нь Бямба, Ням гарагт тохиож байгаатай холбогдуулан 2025 оны 07 дугаар сарын 16, 17-ны өдрийн Лхагва, Пүрэв гарагт ажилтан, албан хаагчдыг амрааж, 2025 онд багтаан нөхөн ажиллуулах зохицуулалт хийхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад даалгасугай. | Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярын 2025 оны 07 дугаар сарын 12, 13-ны өдрүүд нь Бямба, Ням гарагт тохиож байгаатай холбогдуулан тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн А/204 дүгээр тушаалаар 2025 оны 07 дугаар сарын 16, 17-ны өдрийн Лхагва, Пүрэв гарагт албан хаагчдыг амрааж, 2025 оны 06 дугаар сарын 28, 07 дугаар сарын 26-ны бямба гарагт нөхөж ажиллуулсан.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Тийм | бүрэн хэрэгжсэн. |
| 124 | 200 | Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2026 оны төсвийн хязгаарыг батлах тухай<br>2025-06-18<br>Дугаар 2025_01 | 2. 2.Энэ тогтоолоор баталсан төсвийн хязгаарт нийцүүлэн 2026 оны төсвийн төслийг боловсруулахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | Сангийн яамнаас Төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн хязгаарыг 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 01/6731 дугаартай албан бичгээр ирүүлсэн. Төсвийн хязгаарт үндэслэн тухай хуулийн 8 дугаар зүйл “Төсвийн цагалбар", 27 дугаар зүйл “Төсвийн төсөл боловсруулахад тавигдах шаардлага", 31 дүгээр зүйл “Төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн төсөл" болон бусад холбогдох хууль эрх зүйн үндэслэлийн дагуу Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны төсвийн төслийг боловсруулан 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 01/1713 дугаар албан бичгээр Сангийн яам, УИХТГ, Үндэсний аудитын газарт тус тус хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 201 | | 1.. Төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлт болон төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр батлагдсан боловч 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор худалдан авах ажиллагааны дүнд гүйцэтгэгчтэй гэрээ байгуулаагүй төсөл,<br>арга хэмжээний дараах санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцож, хэмнэлтийг тухайн шатны төсөвт төвлөрүүлэх арга хэмжээ авахыг төсвийн холбогдох захирагч нарт даалгасугай: | Төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр батлагдсан Сэлгэн ажиллах дата төвийн нөөцийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг УТ2506700014, Хил хамгаалах ерөнхий газарт хэрэгжүүлэх “BPF-24mn” дрон бүтээх, турших, үйлдвэрлэж албанд нэвтрүүлэх УТ2506700099 тус төсөл арга хэмжээ 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор худалдан авах ажиллагааны дүнд гүйцэтгэгчтэй гэрээ байгуулаагүй тул төсвийн хэмнэлтэд тооцсон болно. | Тодорхой үр дүнд хүрсэн - 50% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 125 | 202 | Төсвийн хэмнэлтэд тооцох тухай<br>2025-06-20<br>Дугаар 2025_02 | 1.1. 1.1. улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр батлагдсан, хавсралтад заасан төсөл, арга хэмжээний нийт 535,908.1 сая (таван зуун гучин таван тэрбум есөн зуун найман сая нэг зуун мянга) төгрөгийн хэмнэлт, санхүүжилт; | Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр батлагдсан, хавсралтад заасан төсөл, арга хэмжээний хүрээнд нийт 535,908.1 сая (таван зуун гучин таван тэрбум есөн зуун найман сая нэг зуун мянга) төгрөгийн хэмнэлт, санхүүжилтийг баталсан бөгөөд уг тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд "Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/" УТ2506700069 дугаартай төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан болно.<br>Тус төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан хууль, журамд заасан холбогдох худалдан авах ажиллагааг зохион байгуулж, улмаар 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр "Ай Ти Зон" ХХК-тай гэрээ байгуулан төслийн хэрэгжилтийг эхлүүлээд байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 203 | | 1.2. орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлт болон 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор худалдан авах ажиллагааны дүнд гүйцэтгэгчтэй гэрээ байгуулаагүй төсөл, арга хэмжээний санхүүжилт. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээ байхгүй. | Хэрэгжүүлэх зардал, санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй | Үгүй | |
| 126 | 204 | Аймаг, орон нутгийн талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2025-07-02<br>Дугаар 2025_11 | 1.3. Засгийн газраас гаргах тогтоол, шийдвэрийн төсөлд олон нийт, ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас цахим хэлбэрээр санал авах, хэлэлцүүлэх нөхцөлийг "И-Монголиа" системд түшиглэн 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн дотор бүрдүүлэхийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт нарт; | Иргэд e-Mongolia платформ, 11-11 төв болон яамдын цахим хуудсаар дамжуулан 6 асуултаас бүрдэх санал асуулгад оролцож, салбар тус бүрээр санал өгөх (нэг асуултад дээд тал нь 3 сонголт хийх) болон нээлттэй санал, тайлбар бичих боломжтой болсон. Мөн 2025 оны 8 дугаар сарын 4-14-ний өдрүүдэд 2026 оны төсвийн саналыг цахим болон танхимаар салбарын хэлэлцүүлгүүд зохион байгуулагдсан. E-Mongolia платформоор дамжуулан 190,000 гаруй иргэд цахимаар төсвийн санал асуулгад оролцож, шийдвэр гаргах үйл явцад шууд оролцсон. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 205 | | 1.5. салбарын хэмжээнд гаргасан бодлого, шийдвэрийн биелэлт, үр дүнтэй орон нутагт биечлэн танилцаж, хэрэгжилтийг зохион байгуулах, тулгамдсан асуудлыг шуурхай шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүдэд. | Салбарын шинэ мэдлэг, технологи, инновац, ирээдүйн чиг хандлага, хөрөнгө оруулалт болон бодлого, шийдвэрийн биелэлт, туршлага солилцож, талуудын бодит оролцоог хангах үндэсний хэмжээний цогц арга хэмжээг бий болгох зорилготой "Технологийн салбарынхныг нэгтгэх долоо хоног-TechWeek 2025" арга хэмжээг 2025 оны 09 дүгээр сарын 19-24-ний өдөр 21 аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэс зохион байгуулсан. Арга хэмжээнд аймгийн удирдлагууд, харилцаа холбоо, мэдээллийн технологийн инженер, техникийн ажилтнууд, төрийн албан хаагч, мэдээлэл зүйн багш зэрэг 1927 төлөөлөгчид оролцож, салбарын өнөөгийн нөхцөл байдал, дэвшилтэт технологийг нутагшуулах боломж, төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар санал солилцсон.<br>Цахим хуудаст хандах: https://tech-week.mn/, https://mddic.gov.mn/mn/2025/09/22632/<br>Түүнчлэн 2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр Засгийн газраас зохион байгуулсан аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулах гэрээний хэрэгжилтийн талаар болон цаашид орон нутагт салбарын бодлогыг хэрэгжүүлэх талаарх цахим уулзалтад Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны дэд сайд төлөөлөн оролцож санал солилцсон. Үүний үр дүнд аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулах гэрээний заалтад санал авах болон гэрээний хэрэгжилтийн мэдээллийг сар бүр хүлээн авч хамтран ажиллахаар тохиролцсон. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 127 | 206 | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2025-07-23 Дугаар 2025_29 | 3. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх арга хэмжээний хэрэгжилтийг хангах хүрээнд бүх талын дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчсөн утга агуулгатай контентыг нийтэлсэн тул ОӨГ, ЦЕГ, ШӨХТГ, ТЕГ зэрэг эрх бүхий байгууллагын шийдвэр, дүгнэлтээр 2025 онд нийт 512 вебсайтыг зөрчилтэй домэйн нэрийн жагсаалт (black-list.mn)-д оруулж Монгол Улсын нутаг дэвсгэрээс хандах хандалтыг хязгаарлах технологийн арга хэмжээ авч ажилласан. 2023 онд эрх бүхий байгууллагаас мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг сурталчилсан гэх агуулга бүхий контентыг устгуулах хүсэлт ирээгүй болно. Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ нь интернэтийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудтай мэдээлэл солилцох гэрээг байгуулж, IP хаяг эзэмшигчийг тогтоож чаддаг болсноор халдлага, зөрчилд өртсөн иргэн, хуулийн этгээдийг олж, халдлага зөрчилд хариу үзүүлэх заавар зөвлөмжийг хүргүүлэх, уялдуулан зохицуулах үйл ажиллагааг цаг алдалгүй хийж байна. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх Үндэсний хорооны 2025 оны хурлуудад оролцож, хариуцсан чиглэлээр мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 128 | 207 | Экспортыг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2025-08-20 Дугаар 2025_51 | 5. “Гадаад худалдааны цахим нэг цонх” мэдээллийн системийг нэвтрүүлэхэд шаардагдах санхүүжилтийн асуудлыг шуурхай шийдвэрлэж, худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулахыг Сангийн сайд Б.Жавхланд, мэдээллийн системийг e-business.mn цахим системд холбохыг Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар нарт даалгасугай. | Хөгжүүлэлтийн ажлын даалгавар болон процессын шинжилгээнд шаардлагатай хэрэглэгчийн ангилал, мэдээллийн жагсаалт болон хүрэх үр дүнг тайлбарласан мэдээллийг боловсруулсан. Эдийн засаг, хөгжлийн яамтай хамтран үйлчилгээг И-Бизнес платформд нэгтгэх ажлын бодлогын даалгавар боловсруулсан. И-Бизнес 1.0 mobile хувилбарын ажлын бодлогын даалгаваруудыг хийж гүйцэтгэж дууссан. Иймд бодлогын даалгаврын дагуу хөгжүүлэлт хийж эхэлсэн. Дээрх ажлын хүрээнд И-Бизнес платформ хөгжүүлэлтийн mobile хувилбарын хөгжүүлэлттэй холбоотой ажлуудыг төлөвлөгөөний дагуу хийж, "Нэг цэгийн үйлчилгээний төв"-ийн үйлчилгээг И-Монгол платформын И-Бизнес хэсэгт 2026 оны 2 дугаар улиралд нэгтгэж дуусгахаар ажиллаж байна. | Ахиц гарсан - 50% | Үгүй | |
| 129 | 208 | Иргэдийн санал, санаачилгын цахим системийг нэвтрүүлэх тухай 2025-09-10 Дугаар 2025_84 | 1. Иргэддээ ойр, нээлттэй засаглалыг хөгжүүлэх, төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зорилтын хүрээнд Засгийн газрын бодлого, шийдвэрийг төлөвлөх, боловсруулах үйл явцад иргэдийн саналыг авах, нийгэмд тулгамдаж буй асуудлаар цахим хэлэлцүүлэг явуулах цахим системийг нэвтрүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар нарт үүрэг болгосугай. | 1.Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” болон “Иргэдийн санал, санаачилгын цахим системийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын төслүүдэд 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 01/2020 дугаар албан бичгээр санал хүргүүлсэн.<br>2."Засгийн газрын бүрэн эрхийн хүрээнд хамаарах нийтийн ашиг сонирхлыг хөндсөн дараах асуудлаар гаргасан иргэн, хуулийн этгээдийн саналыг Монгол Улсын 18 насанд хүрсэн 50 мянган иргэн дэмжсэн бол хуралдаанаар хэлэлцүүлнэ.” гэж Засгийн газрын хуралдааны журамд өөрчлөлт орсны дагуу иргэдийн санал, санаачилгыг хүлээн авах Засгийн газрын цахим систем (d-gov.mn)-ийг хөгжүүлж, 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр ашиглалтад оруулсан.<br>Цахим хуудаст хандах: https://www.d-gov.mn/ | Хэрэгжсэн - 100% | Тийм | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай. |
| | 209 | | 3. Цахим системийн үйл ажиллагааг хариуцаж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогтод, хөгжүүлэлтийг хариуцаж ажиллахыг “И-Монгол академи” УТҮГ (Б.Мягмарнаран)-т, аюулгүй байдалд хяналт тавьж, нууцлалыг хангаж ажиллахыг Тагнуулын ерөнхий газар (П.Одонбаатар)-т тус тус үүрэг болгосугай. | "Засгийн газрын бүрэн эрхийн хүрээнд хамаарах нийтийн ашиг сонирхлыг хөндсөн дараах асуудлаар гаргасан иргэн, хуулийн этгээдийн саналыг Монгол Улсын 18 насанд хүрсэн 50 мянган иргэн дэмжсэн бол хуралдаанаар хэлэлцүүлнэ.” гэж Засгийн газрын хуралдааны журамд өөрчлөлт орсны дагуу иргэдийн санал, санаачилгыг хүлээн авах Засгийн газрын цахим систем (d-gov.mn)-ийг хөгжүүлж, 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр ашиглалтад оруулсан.<br>Цахим хуудаст хандах: https://www.d-gov.mn/ | Хэрэгжсэн - 100% | Тийм | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 130 | 210 | Зорилт шинэчлэн батлах тухай<br>2025-09-10<br>Дугаар 2025_91 | 3.. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, дасан зохицох салбар тус бүрийн зорилтыг эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | Цахим шилжилт, цаасгүй үйлчилгээ<br>1.Төрийн болон салбарын үйлчилгээг бүрэн цахим хэлбэрт шилжүүлэх, цахим гарын үсэг, цахим архив, цахим маягтыг нэвтрүүлснээр цаас, тээвэр, шуудангийн хэрэглээг бууруулж, шууд болон шууд бус хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах нөхцөлийг бүрдүүлэв. Төрийн үйлчилгээний нэгдсэн системд 2025 онд 1,064 хэрэглэгч шинээр нэмэгдсэнээр нийт бүртгэлтэй хэрэглэгчийн тоо 2,087,342 хүрч, нийт 88 байгууллагын 1268 үйлчилгээг 94 сая удаа үзүүлсэн байна. Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр үзүүлсэн нийт үйлчилгээ нь 1,902,352,347,902 төгрөгийн шууд бус зардлыг хэмнэсэн. Үүнээс 2025 онд 612,478,720,913 төгрөгийн хэмнэлт хийсэн байна.<br>2.Албан бичиг солилцооны дундын систем DocX-ээр дамжуулан 2025 онд 3,040 байгууллага тус системтэй холболт хийж, 354,888 бичиг илгээж, 402,724 албан бичиг хүлээн аваад байна.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 131 | 211 | 2027 оныг “Эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарлах тухай<br>2025-11-05<br>Дугаар 2025_154 | 4.. Эрүүл мэндийг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | Монгол Улсын “Цахим эрүүл мэнд”-ийн цогц арга хэмжээний төлөвлөгөө (2025-2028)-г хэлэлцэх уулзалт, хэлэлцүүлгийг НҮБ-ын Хүүхдийн Сангийн дэмжлэгтэйгээр 2025 оны 04 дүгээр сарын 10, 11-ний өдрүүдэд 20 байгууллагын 52 албан хаагчийн дунд зохион байгуулсан. Хэлэлцүүлгийн үр дүнд “Монгол Улсын эрүүл мэндийн салбарын дижитал шилжилтийн цогц арга хэмжээний төлөвлөгөө”-г Эрүүл мэндийн сайд, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын хамтарсан 2025 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/201, А/81 дугаар тушаалаар баталсан.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 132 | 212 | Хяналт шалгалтын 2026 оны төлөвлөгөө батлах тухай<br>2025-12-03<br>Дугаар 2025_184 | 2.. 2.Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан төлөвлөгөөнд нийцүүлэн салбарын хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтыг баталж, холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт шалгалт хийж ажиллахыг тухайн салбарын хяналтыг хариуцсан Засгийн газрын гишүүд болон Засгийн газрын агентлагийн дарга нарт үүрэг болгосугай. | Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 03-ний өдрийн 184 дүгээр тогтоолын дагуу Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/177 дугаар тушаалаар 2026 онд төлөвлөгөөт шалгалтад хамрагдах 171 объектын жагсаалтыг баталсан. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 213 | | 2.. 2.Энэ тогтоолын 1,2 дугаар хавсралтад заасан төсөл, арга хэмжээ бүрийн техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зурагтөсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны газар, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор тус тус хүргүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн "Жагсаалт батлах тухай" 187 дугаар тогтоолын дагуу Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2026 онд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцад хэрэгжүүлэх УТ2606700065 төслийн кодтой Үүрэн холбооны сүлжээ, дахин дамжуулах станц /Улсын хэмжээнд/, УТ2606700120 төслийн кодтой Үүрэн холбооны сүлжээ, дахин дамжуулах сүлжээ станц /Ховд/, УТ2606700121 төслийн кодтой Өсвөрийн инженерүүдийн инновацын төвийн барилгын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улаанбаатар, Баянгол дүүрэг/ төсөл, арга хэмжээний ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, захиалагчийг төлөөлж, үнэлгээний хороонд орж ажиллах худалдан авах ажиллагааны мэргэшсэн АЗ гэрчилгээтэй албан хаагчдын мэдээллийг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 02/3003 дугаартай албан бичгээр Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 133 | 214 | Жагсаалт батлах тухай<br>2025-12-03<br>Дугаар 2025_187 | 3.. 3.Худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn)-ээр зохион байгуулж, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил, төслийн код (“УТ” код)-ын дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд нийтэлж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч, Төрийн худалдан авах ажиллагааны газар (Ц.Батзул)-т тус тус үүрэг болгосугай. | Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2026 онд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцад хэрэгжүүлэх УТ2606700065 төслийн кодтой Үүрэн холбооны сүлжээ, дахин дамжуулах станц /Улсын хэмжээнд/, УТ2606700120 төслийн кодтой Үүрэн холбооны сүлжээ, дахин дамжуулах сүлжээ станц /Ховд/, УТ2606700121 төслийн кодтой Өсвөрийн инженерүүдийн инновацын төвийн барилгын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улаанбаатар, Баянгол дүүрэг/, УТ2606700119 төслийн кодтой Төрийн цахим үйлчилгээ, хиймэл оюун, их өгөгдөйн суурь дэд бүтцийн тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ тус тус төслүүдийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn)-ээр зохион байгуулж ажиллаж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 215 | | 4.. Худалдан авах ажиллагааг ашиг сонирхлын зөрчил, авлигаас ангид байх зарчмыг баримтлан, хууль тогтоомжийн дагуу Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтад заасан хугацаанд зохион байгуулахыг Төрийн худалдан авах ажиллагааны газар, төсвийн өрөнхийлөн захирагч нарт, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд Т.Доржхандад тус тус даалгасугай. | Тус яам нь худалдан авах ажиллагааг ашиг сонирхлын зөрчил, авлигаас ангид байх зарчмыг баримтлан, хууль тогтоомжийн дагуу ажиллаж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| Ерөнхий сайдын захирамж | | | | | | | |
| 134 | 216 | Ажлын хэсэг байгуулах тухай<br>2022-02-07<br>Дугаар 2022_13 | 2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулга, Кибер аюулгүй байдлын тухай хууль батлагдсантай холбогдуулан бэлтгэл ажлыг хангаж, хуульд заасан холбогдох журмын төслийг боловсруулах Ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар байгуулж, Ажлын хэсгээс хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар баталсугай.<br><br>2. Бэлтгэл ажлыг хангаж, холбогдох журмын төслийг 2022 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсэг (Л.Энх-Амгалан)-т даалгасугай. | Цахим шилжилтийг дэмжсэн 4 багц хуулийн хэрэгжилтийг хангуулан ажиллах хүрээнд хууль тогтоомжоор эрх олгогдсон нийт 43 хэм хэмжээний акт /дүрэм, журам, стандарт/-ыг шинээр болон шинэчлэн боловсруулах ажлыг гүйцэтгэж байгаагаас тайлант хугацаанд Нийтийн мэдээллий ил тод байдлыг хангах тухай хуулийн хүрээнд 21 акт батлахаас батлуулсан 17, Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хүрээнд 11 акт батлахаас батлуулсан 11, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хүрээнд 4 акт батлахаас батлуулсан 2, Цахим гарын үсгийн тухай хуулийн хүрээнд 7 акт батлахаас батлуулсан 4 актын хэрэгжилтийг хангуулан ажиллаж, үлдсэн 9 актын төслийг боловсруулах ажлыг зохион байгуулж байна. | Ахиц гарсан - 50% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 135 | 217 | Ажил хариуцуулах тухай<br>2024-03-14<br>Дугаар 2024_34 | 3.. Үндэсний зөвлөл, Үндэсний хороо, зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн асуудлын хэрэгжилтийг зохион байгуулж, хуралдааны тэмдэглэл, шийдвэрийн төслийг хуралдаан зохион байгуулснаас хойш 7 хоногийн дотор, үйл ажиллагааны талаарх тайлан, мэдээг улирал бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэхийг Үндэсний зөвлөл, хорооны нарийн бичгийн дарга нарт үүрэг болгосугай. | Кибер аюулгүй байдлын зөвлөлийн 2025 оны анхдугаар хуралдааныг 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулсан. Хуралдаанаар Зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг дүгнэж, 2025 оны төлөвлөгөөг хэлэлцэн баталсан. КАБЗ-ийн 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн ээлжит хуралдаанаас гарсан шийдвэр, мэдээллийг Зөвлөлийн гишүүд болон холбогдох байгууллагуудад 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 10 дугаартай албан бичгээр, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын Салбарын бодлогын зохицуулалтын газарт мөн өдрийн 11 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлсэн. Мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2024 оны Зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэрийн биелэлт, хэрэгжилтийн тайланг хүргүүлсэн. https://mddic.gov.mn/mn/2025/01/20833/ | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 136 | 218 | Ажлын хэсэг байгуулах тухай /үндэсний хиймэл дагуулын төслийг хэрэгжүүлэх/<br>2024-08-13<br>Дугаар 2024_34 | 2.. Монгол Улсын харилцаа холбооны үндэсний хиймэл дагуулын төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Бүгд Найрамдах Франц Улсын талтай хэлэлцээ хийх, зээлийн ерөнхий нөхцөлийн талаарх олон улсын гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:<br><br>Ажлын хэсгийн удирдамжийг баталж, удирдамжийн дагуу захирамжийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Ажлын хэсэг (Н.Учрал)-т даалгасугай. | Бүгд найрамдах Франц Улсын Талес Алениа Спейс компани ЦХИХХЯ хоорондын байгуулах “Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуулын техникийн нөхцөлийг тодорхойлох, гэрээний төсөл боловсруулах” арилжааны гэрээний нөхцөлийг сайжруулах, гэрээний үнийн дүнг буулгах, гэрээний нөхцөлийг сайжруулах чиглэлээр Талес Алениа Спейс компанитай хамтран ажиллаж байна. Францын Сангийн яамтай хийсэн хэлэлцээрийн дүнд Талес Алейна Спейс компаниас ирүүлсэн төслийн санхүүжилтийн саналын арилжааны зээлээр санхүүжүүлэх хэсгийг Засгийн газрын нэн хөнгөлөлттэй зээлд хамруулах тохиролцоонд хүрээд байна. | Ахиц гарсан - 50% | Үгүй | |
| 137 | 219 | Нийгэмд шударга ёсыг бэхжүүлэх, авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай<br>2025-08-13<br>Дугаар 2025_64 | 5.. Авлигатай тэмцэх хүсэл зориг, хүчин чармайлтыг манлайлж, ил тод байдлыг бэхжүүлэн, бүх түвшинд шударга ёсыг эрхэмлэж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллахыг Засгийн газрын гишүүд, яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, нийт төрийн албан хаагчдад үүрэг болгосугай. | Тус яамнаас иргэнийг шинээр томилох, албан хаагчийг шилжүүлэн томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх эсэх, зөрчилтэй гэж ойлгогдох нөхцөл байдал үүсэх эсэхийг тогтоосны дараа албан тушаалд томилох шийдвэрийг гаргаж байна. 2025 онд нийт 92 иргэн, албан хаагчийн хувийн ашиг сонирхлын байдлыг Авлигатай тэмцэх газраар хянуулж, дүгнэлт гаргуулсан. ”АВЛИГАТАЙ ТЭМЦЬЕ” уриатай Авлигатай тэмцэх газрын гомдол, мэдээлэл хүлээж авах “Авлигыг мэдээлэх 110” тусгай дугаарын талаар Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба, тус яамны харьяа 5 байгууллага, 4 салбар байгууллага цахим хуудас болон цахим сүлжээнд бүрэн байршуулж, шударга ёсыг эрхэмлэж, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллахыг нийт албан хаагчид, олон нийтэд уриаллаа.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 138 | 220 | 2021 оны 2 дугаар сарын 10-ны өдөр 9 дүгээр тэмдэглэл<br>2021-02-10<br>Дугаар 2021_9 | XII.2. .<br>Монгол Улсын Ерөнхий сайд харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй хийсэн уулзалтын дүнгийн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:<br><br>1. “Бүгд Найрамдах Энэтхэг Улсын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд “Мэдээллийн технологийн боловсрол, аутсорсингийн төв”-ийг байгуулах, цаашид удирдан зохион байгуулах, Инновацын тухай хуулийн дагуу мэдээллийн технологийн гарааны компанид татварын хөнгөлөлт үзүүлэх боломжийг судлах, дээд боловсролын салбарт мэдээллийн технологийн өндөр түвшний мэргэжилтэн бэлтгэх, Шинжлэх ухаан технологийн сангаар дамжуулан мэдээллийн технологийн компанийг дэмжих, “Боловсролын цахим шилжилт” арга хэмжээг хэрэгжүүлэх, Ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрт мэдээллийн технологийн чиглэлийн сургалтын агуулгыг нэмэгдүүлэх | "Тус яам болон Мэдээлэл технологийн үндэсний парк – National Information Technology Park дэмжлэгтэйгээр 2023 оны 08 дугаар сард ШУТИС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургуульд мэдээллийн технологийн гүнзгийрүүлсэн сургалттай анги нээсэн. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай анхдагч хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж эцэслэн батлуулав. Хуулиар мэдээллийн технологийн гарааны компанид татварын хөнгөлөлт үзүүлэх талаар оруулж баталсан. https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140722436571&sword=%D0%A1%D1%82%D0%B0%D0%BD%D0%B4%D0%B0%D1%80%D1%82,%20%D1%85%D1%8D%D0%BC%D0%B6%D0%B8%D0%BB%20%D0%B7%D2%AF%D0%B9""" | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 221 | | XII.2. 2. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн компанийг олон улсын зах зээлд гарахад нь төрөөс дэмжлэг үзүүлэх, гадаадын хөрөнгө оруулалт татах, гарааны бизнесийг дэмжих дундын хөрөнгө оруулалтын сан байгуулах чиглэлээр хувийн хэвшилтэй хамтарсан Ажлын хэсэг байгуулж ажиллахыг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар (Б.Болор-Эрдэнэ)-т даалгав. | Инновацын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7-д Засгийн газар нь инновацийн төслийг улсын төсвөөс санхүүжүүлэх, инновацийн үйл ажиллагаанд оролцогчид грант олгох журам, нөхцөлийг тогтооно гэж заасны дагуу “Инновацийн төслийг улсын төсвөөс санхүүжүүлэх журам”, “Инновацийн үйл ажиллагаанд оролцогчид грант олгох журам”-ыг шинэчлэн батлах тухай тогтоолын төслийг боловсруулж Засгийн газрын 2025 оны 05 дугээр сарын 07-ны өдрийн 224 дүгээр тогтоолоор батлуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 224 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Инновацын үйл ажиллагаанд оролцогчид грант олгох журам”-ын дагуу Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 95 дугаар тогтоолоор батлагдсан “Инновацын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл (2020-2025)”-ийн хүрээнд инновацын шийдлийг сонгон шалгаруулалтыг 2025 оны 06 дугаар сарын 18-нд зарласан. Сонгон шалгаруулалтад нийт 59 инновацын шийдэл бүхий төслийн материал ирүүлснээс 14 шилдэг төслийг шалгаруулан грантын дэмжлэг олгосон. Монгол Улсын онцлог, хэрэгцээ шаардлагад нийцэх хувилбаруудыг гаргах зорилгоор Matching fund буюу төр, хувийн хэвшлийн хамтарсан санхүүжилтийн загвар зэрэг боломжит хувилбаруудыг судалж, тэдгээрийн давуу, сул тал, хэрэгжих боломжийг шинжилсэн. Энэхүү судалгааны үр дүнд үндэслэн боломжит санхүүжилтийн загварыг хөгжүүлэх зөвлөмж гаргасан. Мөн Япон Улсын Хамтын ажиллагааны байгууллага (JICA)-тай хамтран Startup Ecosystem судалгаа хийсэн бөгөөд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл боловсруулсан. https://docs.google.com/presentation/d/1Cddy81L6pZ7k9Dntut7NysAsknFXiOJA/edit?slide=id.p7#slide=id.p7 | Ахиц гарсан - 50% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 139 | 222 | 2021 оны3 дугаар сарын 3-ны өдөр 14 дүгээр тэмдэглэл 2021-03-03 Дугаар 2021_14 | XII.3. 8. Аялал жуулчлалын салбарт зайлшгүй шаардлагатай үйлчилгээг тодорхойлж, цахим хэлбэрт шилжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар (Б.Болор-Эрдэнэ)-т; | 1.Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны 16 үйлчилгээг www.e-mongolia.mn болон e-bisiness.mn цахим системд нэвтрүүлсэн.<br>2.Дэлхийн Банкны Олон Улсын Хөгжлийн Ассоциацийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх "Ухаалаг засаг 2" төслийн хүрээнд "Монгол Улсын аялал жуучлалын порталыг хөгжүүлэх" төслийн ажлын даалгаварыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас ирүүлж, Дэлхийн Банкаар хянуулан баталгаажуулсан. 2026 онд худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар ажиллаж байна. | Ахиц гарсан - 50% | Үгүй | |
| 140 | 223 | 2021 оны 6 дугаар сарын 8-ны өдөр 34 дүгээр тэмдэглэл 2021-06-08 Дугаар 2021_34 | ҮIII.5.1. . Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлд заасныг хэрэгжүүлж ажиллах, энэ хүрээнд өөрийн эрхэлсэн салбарын төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагад нэг буюу түүнээс дээш тооны хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Засгийн газрын нийт гишүүдэд;<br>("Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар 2021-2024 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа Засгийн газрын гишүүдэд танилцуулав. ) | Тус яамны Цахим шилжилтийн бодлого зохицуулалтын газрын Цахим шилжилт хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Бадамсүрэнгийн эрүүл мэндийн байдлыг Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын 2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн шийдвэр, мөн өөрийн гаргасан хүсэлтийг харгалзан Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны Б/64, 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн Б/63, 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн Б/73 дугаар тушаалаар 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаагаар хариуцсан чиг үүргийн ажлыг зайнаас цахим сүлжээгээр ажилуулахаар хугацааг сунгасан. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 224 | | ҮIII.5.2 . Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хамгаалж, холбогдох хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэртээ хангуулах, хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны А/83 дугаар тушаалаар салбарын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хангахад чиглэсэн хууль, тогтоомж, төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын орон тооны бус дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Азийн хүний хөгжлийн төв НҮТББ, Японы "Астем" ХК-тай хамтарсан мэдээллийн хүртээмжийн семинарыг цахим хэлбэрээр тус яам болон харьяа байгууллагын холбогдох албан тушаалтнууд 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдөр оролцсон. Мөн тус байгууллагуудаас 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдөр Япон Улсын "eye dragon" системийн танилцуулж, телевизүүдийн хөтөлбөрийг хадмал тайлбар, дохионы орчуулга гэх мэт хүртээмжтэй байдлаар хүргэх, цаашид Монгол Улсын холбогдох талуудтай хэрхэн хамтран ажиллах боломжтой талаар ЦХИХХЯ, И-Монгол академи УТҮГ, ХХЗХ-ны хамтарсан уулзалтуудыг зохион байгуулсан. Монгол Улсын сонсголгүй иргэдийн холбооноос "Дохионы хэлний олон улсын өдөр" болгон тэмдэглэхтэй холбогдуулан 2025 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр гэрэл асааж, сонсголгүй иргэдийн эрхийг хамгаалах үйл ажиллагаанд харьяа, салбар байгууллагын албан хаагчид оролцсон. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн зөрчил, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам-2025" эрдэм шинжилгээний хуралд "И-Монгол академи" УТҮГ-ын газрын Сургалтын хэлтсийн Цахим ур чадварын сургалт хариуцсан мэргэжилтэн Г.Батдэлгэр эрдэм шинжилгээний өгүүллээр оролцсон. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 225 | | ҮIII.5.5.. Цахим хуудас, телевизийн мэдээ, мэдээлэл, танин мэдэхүйн болон өргөн нэвтрүүлгийг дохионы хэлний хэлмэрчтэй, текст унших боломжтой байдлаар нэвтрүүлэх чиглэлээр холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллахыг Харилцаа холбооны зохицуулах хороо (Г.Чинзориг)-нд.” гэжээ. | ХХЗХ-оос хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах, өргөн нэвтрүүлгийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.4 дэх хэсэгт “телевизийн мэдээ, мэдээлэл, танин мэдэхүйн болон өргөн нэвтрүүлгийг дохионы хэлний хэлмэрчтэй, текст унших боломжтой байдлаар нэвтрүүлэх арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх” гэж заасан байдаг. Тус Хорооноос ӨНТХ-ийн 23 дугаар зүйлийн 23.5.4-т заасан хадмал тайлбар, дохионы хэл бүхий нэвтрүүлгийн хувь хэмжээг тодорхойлох чиг үүргийн дагуу МУ-д хамрах хүрээтэй телевизүүдэд мэдээ, мэдээллийн хөтөлбөр, хүүхдийн болон танин мэдэхүйн нэвтрүүлгийг дохионы хэлмэрчтэй эсхүл хадмал тайлбартай гаргах үе шаттай төлөвлөгөөг өөрийн боломжид тулгуурлан гаргах үүргийг хүлээлгэсэн болно. Энэ нь дохионы хэлний хэлмэрчийн олдоц хязгаарлагдмал байдлыг харгалзан шат дараатай авч буй арга хэмжээний нэг юм. Монгол Улсад хамрах хүрээтэй Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн 18, орон нутгийн 3 телевиз болон цаг үеийн мэдээ, мэдээлэл, хүүхдийн болон танин мэдэхүйн нэвтрүүлэгтэй арилжааны 26 нийт 47 телевизэд дохионы хэлтэй, эсхүл хадмал тайлбартай нэвтрүүлэг нэвтрүүлэх үүрэг хүлээлгэж байна. Харин арилжааны 13 телевизийн хувьд хэдийгээр МУ-д хамрах хүрээтэй ч спорт, кино, теле-худалдаа гм төрөлжсөн хөтөлбөртэй, хөтөлбөрт нь мэдээ, мэдээлэл, танин мэдэхүй, хүүхдийн нэвтрүүлэг байхгүй тул дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлэг нэвтрүүлэх дээрх телевизүүдийн тоонд ороогүй болно. Дохионы хэлний хэлмэрчтэй нэвтрүүлэг нэвтрүүлсэн ТВ тоо, цаг. Нийт 55 ТВ /МҮОНТ-5, ӨнТВ-18, АрТВ- 30/ нийт 6642:08:02 цагийн нэвтрүүлэг, Хадмал тайлбартай нэвтрүүлэг нэвтрүүлсэн ТВ тоо, цаг. Нийт 48 ТВ /МҮОНТ-4, ӨнТВ-18, АрТВ- 26/ нийт 1924:29:20 цагийн нэвтрүүлгийг тус тус нэвтрүүлсэн байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 141 | 226 | 2021 оны 8 дугаар сарын 11-ний өдөр 46 дугаар тэмдэглэл 2021-08-11 Дугаар 2021_46 | ХҮII.7. . Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн ажлын явцын талаар Эрүүл мэндийн сайд С.Энхболд Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан Цахим шилжилтийн асуудлаар Эстони Улсын туршлага, жишиг загварыг ашиглах боломжийг судалж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ нарт даалгав. | Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал тэргүүтэй харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын төлөөлөгчид 2023 оны 09 дүгээр сарын 04-08-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Эстони Улсын Таллин хотноо зохион байгуулагдсан “Цахим Таллин Чуулган 2023” болон 8 дахь удаагийн “Нээлттэй засаглалын түншлэл” олон улсын чуулганд оролцож, Эстони Улсын Нийгмийн халамж, эрүүл мэндийн технологийн төв (TEHIK)-д зочилж, тус төвийн үйл ажиллагаа, Эстони Улсын эрүүл мэндийн технологийн дэвшил, үндэсний эрүүл мэндийн мэдээлэл солилцооны системийн талаар туршлагыг судалсан. Тус арга хэмжээний үр дүнгийн танилцуулгыг 2023 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 01/1822 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 142 | 227 | 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр 51 дүгээр тэмдэглэл 2021-09-15 Дугаар 2021_51 | X.2.2. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн газрын албаны мэдээллийн сан болон төрийн тусгай хэрэгцээнд авсан газрын талаарх мэдээллийг “Орон зайн мэдээллийн сан”-д оруулах, мэдээллийг нийтэд нээлттэй болгох ажлыг эрчимжүүлж, ажлын явц, үр дүнгийн талаар Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Байгаль орчин, аялал жуучлалын сайд Н.Уртнасан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ нарт даалгав. | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас мэдээлэл хариуцагч нээлттэй байх мэдээллийг ил тод байршуулж байгаа эсэхэд хяналт тавьж байна. 2025 оны 2 дугаар улирлын байдлаар Байгаль орчин уур амьсгалын сан 1091 зөвшөөрөл, Байгаль орчны ерөнхий нөлөөллийн үнэлгээ 26.310, Барилга байгууламжийн улсын комиссын дүгнэлт 8,437, Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл 2,598 бүртгэгдсэн байна. Нийт 970.355 мэдээлэл нээлттэй байршиж, 16,496,136 удаагийн хандалт авсан байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 143 | 228 | 2022 оны 2 дугаар сарын 16-ны өдөр 11 дүгээр тэмдэглэл 2022-02-16 Дугаар 2022_11 | XIX.6.2. “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Төрийн бүтээмжийг сайжруулах шинэчлэлтийг хэрэгжүүлэх, төрийн байгууллага цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх шаардлагыг тогтоох, байгууллага, албан тушаалтан иргэнтэй шууд харьцах замаар үйлчилгээ үзүүлдэг байдлыг халах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагад даалгав. | Бизнес эрхлэгчдэд зориулсан цахим систем (e-business.mn) нь хуулийн этгээд үүсгэн байгуулахаас эхлээд бүх төрлийн үйлчилгээг цахимжуулж, олон төрлийн зөвшөөрөл хүсэх, сунгах, байгууллагын лавлагааг нэг дороос авах боломжийг бүрдүүлэх зорилготой систем бөгөөд одоогийн байдлаар иргэн, аж ахуйн нэгж байгууллагад төрийн 68 байгууллагын 832 үйлчилгээг цахимаар хүргэн ажиллаж байна. 1.Зөвшөөрлийн нэгдсэн систем license.mn-тэй хамтран зөвшөөрлийн нэгдсэн санд байгаа зөвшөөрлийн төлөвийн мэдээллийг e-mongolia мобайл аппликейшний “Төрд байгаа мэдээлэл” цэсэд харуулахаар хөгжүүлэлтийг хийсэн. 2. Мөн license.mn системийг e-business.mn системд нэгтгэн Зөвшөөрлийн цахим систем цонхонд харуулах хөгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Зөвшөөрлийн тухай хуульд заасан 254 тусгай зөвшөөрлөөс e-business платформд 44 цахимжиж, 134 линкээр холбогдож, 76 цахим хэлбэрт шилжээгүй, харин 124 энгийн зөвшөөрлөөс 23 цахимжиж, 43 линкээр холбогдож, 58 цахим хэлбэрт шилжээгүй байна. 3. Мөн https://www.d-gov.mn/ хуудсаар иргэдийн санал хүсэлтийг хүлээж авах нөхцлийг бүрдүүлсэн.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 144 | 229 | 2022 оны 3 дугаар сарын 16-ны өдөр 16 дугаар тэмдэглэл 2022-03-16 Дугаар 2022_16 | XYIII.2.3. Эмнэлгийн тусламж, үйлчилгээг чирэгдэлгүй, чанартай, хүртээмжтэй, шуурхай хүргэх хүрээнд эрүүл мэндийн салбарт цахим шилжилт хийхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд даалгав; | Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн чиглэлээр хийсэн ажлын үр дүнг ЗГ-ын 2024.03.26, 07.24-ний өдрийн хуралдаанд танилцуулсан. Эрүүл мэндийн төрөлжсөн мэдээллийн санг үүсгэж, “ХУР”-д 24 шинэ сервисийг нэвтрүүлсэн, 2025.06.24-ний өдрийн байдлаар 443 эмнэлэг холбосон. Иргэнээс зөвшөөрөл авах нөхцөлийг SMS (OTP), хурууны хээ, Push notification, G-Sign хэлбэрээр бүрдүүлсэн. Эмнэлгийн систем хөгжүүлэгч компаниудтай гэрээ байгуулан, VPN, API-г тохируулж, ХУР, Мэдэгдлийн системийн төлбөрийг 2025 оныг дуустал чөлөөлсөн. И-Монгол системд эрүүл мэндийн 25 үйлчилгээг нэвтрүүлэн ба 37 сая мэдэгдлийг хүргэж, 1.4 сая хандалтыг авсан. Цахим эрүүл мэндийн нөхцөл байдлын үнэлгээний судалгааг 325 байгууллагаас авч, үр дүнг нээлттэй байршуулсан. ЭМТХ-ийн 8.4, 8.10 дахь хэсэгт заасан журмыг ЗГ-ын 2024 оны 100 дугаар тогтоол, ЭМС, ЦХИХХС-ын хамтарсан 2025.04.16-ны өдрийн А/130, А/58 тушаалаар батлуулан 2025.05.13-ны өдөр захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн. Эрүүл мэндийн 109 байгууллагын 111 rack, 67 VPS, 153 mail, 137 website, 293 domain-ны үйлчилгээг ҮДТ-өөс үзүүлж байна. “Төрийн бүтээмжийн сэргэлт-Цахим эрүүл мэнд” үндэсний зөвлөлдөх уулзалтыг 2024.04.08,09-нд 150 байгууллагын 380 ажилтанд /digitalhealth.gov.mn/, сургалтыг 2024.04.16-нд анхан шатлалын байгууллагын 200 төлөөлөлд, 2024.05.04-24-нд 21 аймаг, нийслэлд зохион байгуулж эрүүл мэндийн ажилтнуудыг хамруулсан. Монгол Улсын “Цахим эрүүл мэнд”-ийн цогц арга хэмжээний төлөвлөгөө (2025-2028)-г хэлэлцэх уулзалт, хэлэлцүүлгийг НҮБ-ын Хүүхдийн Сангийн дэмжлэгтэйгээр 2025.04.10, 11-ний өдрүүдэд 20 байгууллагын 52 албан хаагчийн дунд зохион байгуулсан. “Эрүүл мэндийн салбарын дижитал шилжилтийн цогц арга хэмжээний төлөвлөгөө”-г ЭМС, ЦХИХХС-ын хамтарсан 2025.05.24-ний өдрийн А/201, А/81 тушаалаар баталсан. Хэлэлцүүлэг, уулзалтын тайланг оролцогч 20 байгууллагад 2025.06.05-ны өдрийн 02/1348, ЗГЭХГ-т 2025.05.20-ны өдрийн 01/1195 албан бичгээр хүргүүлж, ИЦББХ-ны 2025.05.28-ны өдрийн хурлаар танилцуулсан.<br><br>Хавсралт : 3 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 145 | 230 | 2022 оны 5 дугаар сарын 4-ний өдөр 27 дугаар тэмдэглэл 2022-05-04 Дугаар 2022_27 | XYIII.3. . Аялал жуулчлалын нэгдсэн мэдээллийн цахим платформ нэвтрүүлэх талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан аялал жуулчлалын салбарыг дэмжих, гадаадын жуулчдад зориулсан мэдээллийн нэгдсэн цахим платформыг хөгжүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд, цахим платформыг ашиглалтад оруулж, хөгжүүлэх, холбогдох мэдээ, мэдээллийг тогтмол шинэчилж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Соёлын сайд Ч.Номинд тус тус даалгав. | Дэлхийн Банкны Олон Улсын Хөгжлийн Ассоциацийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Ухаалаг засаг 2" төслийн хүрээнд "Монгол Улсын аялал жуулчлалын порталыг хөгжүүлэх” төслийн ажлын даалгаварыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас боловсруулан ирүүлж, Дэлхийн Банкаар хянуулан баталгаажуулсан. 2026 онд худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар ажиллаж байна. | Санхүү, хөрөнгө оруулалтаас - 0% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 146 | 231 | 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл 2022-05-11 Дугаар 2022_28 | XX.1.2. Төрийн тусламж үйлчилгээ, лавлагаа мэдээллийн тусгай дугааруудыг нэгтгэн, нэгдсэн системээр мэдээлэл, тусламж үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх асуудлыг судалж, танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан нарт даалгав. | Яаралтай тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэхтэй холбоотой яаралтай тусламжийн дугаарыг нэгдсэн 112 дугаарт шилжүүлэх арга хэмжээг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яам, Харилцаа холбооны зохицуулах хороо, Цагдаагийн ерөнхий газар, Мэдээлэл, шуурхай удирдлагын төв, Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн түргэн тусламжийн төв зэрэг байгууллагуудын хамтарсан уулзалтад 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр оролцож, нөхцөл байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцсон. Тус яамны 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд “Яаралтай тусламжийн үйл ажиллагаанд нэгдсэн 112 дугаарлалтыг нэвтрүүлэхэд шаардлагатай технологийн шийдлийг боловсруулж, нэвтрүүлэх нөхцөлийг судлах”-аар туссан. Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсөв татагдсан. | Санхүү, хөрөнгө оруулалтаас - 0% | Үгүй | |
| | 232 | | XX.7. . Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов. | Монгол Улсын хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 1,945,161 буюу Монпасс СА ХХК 95554, Ньюкомпасс ХХК 49,985, Тридум 46,445, Үндэсний дата төв 14,293, Ви Эс Эм 138, Улсын бүртгэлийн ерөнхий газар 1,738,746 иргэнд тоон гарын үсэг олгосон байна. Үүнээс Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын салбар Төрийн үйлчилгээний "ХУРДАН" цэгийн нийслэл дэх 144, орон нутаг дахь 405 цэгээр дамжуулан нийт 46,487 иргэнд тоон гарын үсэг олгоод байна. Мөн Төрийн үйлчилгээний ХУРДАН киоск машиныг нийслэлд 143, орон нутагт 339 буюу нийт 482 киоск машиныг байршуулан төрийн үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд хүндрэл чирэгдэлгүй үзүүлж байна.<br>https://khurdan.gov.mn/%d1%85%d1%83%d1%80%d0%b4%d0%b0%d0%bd-%d1%86%d1%8d%d0%b3%d0%b8%d0%b9%d0%bd-%d0%b1%d0%b0%d0%b9%d1%80%d1%88%d0%b8%d0%bb" | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 147 | 233 | 2022 оны 8 дугаар сарын 24-ний өдөр 42 дугаар тэмдэглэл 2022-08-24 Дугаар 2022_42 | XY.3. . Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааны явцын талаар Эрүүл мэндийн сайд С.Энхболд Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэхийг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод, уг үйл ажиллагаанд салбарын болон төрийн бүх шатны байгууллагуудын ажилтан, албан хаагчдыг хамруулах, энэ чиглэлд салбарын болон нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг уриалах ажлыг зохион байгуулж зохих арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав. | Цахим хөгжил, харилцаа холбооны яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих, өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулах ажлын хүрээнд Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/116 дугаар тушаалын дагуу албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг Хавдар судлалын үндэсний төв эмнэлэгтэй хамтран 2024 оны 05 дугаар сарын 29, 06 дугаар сарын 15-ны өдөр “Ажилтны урьдчилан сэргийлэх багц” үйлчилгээнд хамрагдсан. Илрүүлэг үзлэгт эрэгтэй 32, эмэгтэй 53, нийт 85 албан хаагч хамрагдсан. 2026 онд урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэгт албан хаагчдыг хамруулахаар төлөвлөн ажиллаж байна. | Тодорхой үр дүнд хүрсэн - 50% | Үгүй | |
| 148 | 234 | 2022 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр 44 дүгээр тэмдэглэл 2022-09-05 Дугаар 2022_44 | II.2. Их өгөгдлийн (big data) сан байгуулах, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох талаар Үндэсний статистикийн хороотой хамтран холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт даалгав. | Их өгөгдлийн (big data) сан үүсгэхэд хүн, хуулийн этгээдэд хамаарах мэдээллийг тодорхойлсон. “Их өгөгдлийн (big data) сан” үүсгэх тухай Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 403 дугаар тогтоолыг батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Их өгөгдлийн сан үүсгэх туршилт хийгдсэн. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны А/51 дүгээр тушаалаар их өгөгдлийн сан үүсгэн бүрдүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, хэрэгжилтийг ханган ажилласан. - Хүний хувийн мэдээлэлд хамаарах 35, хуулийн этгээдэд хамаарах 14 төрлийн мэдээллийг тодорхойлох боломжгүй болгох арга, аргачлалын хамт И-Монгол академи УТҮГ-т хүргүүлж, арга зүйгээр хангаж ажилласан. - Нийгмийн даатгалын мэдээллийн сан, Нийгмийн халамжийн мэдээллийн сан, Хүн амын өрхийн мэдээллийн сан, Мал тооллогын мэдээллийн сан, Бизнес регистрийн мэдээллийн сангийн мета-өгөгдлийг тус тус мэдээлэл хариуцагчдаас гаргуулан авсан. - Өгөгдлийг 5 төрөл (Hashed keys, Masking, Obfuscataion, Generalization, Perturbation) – өөр тодорхойлох боломжгүй болгон хувиргах хэрэгсэл, хувиргасан өгөгдлийг нууцлалтайгаар ХУР системээр дамжуулах сервисийг тус тус хөгжүүлж, хөдөлмөр, халамж, статистик, даатгалын мэдээллийн сан хариуцсан 3 байгууллагад туршилтаар суурилуулж, заавар гарын авлагаар хангаж ажилласан. - “И-Монгол академи” УТҮГ-төлөөлөлтэй хамтран Үндэсний статистикийн хороо, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Мэдээллийн технологийн төв дээр 2025 оны 05 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд ажиллаж, өгөгдлийг хувиргах, нууцлан дамжуулах явцад гарсан эх кодын алдааг засварлах, турших ажлуудыг хийж гүйцэтгэсэн. "Төрийн мета-өгөгдлийн нэгдсэн сан"-д 2025 онд мэдээлэл хариуцагч 68 байгууллагын 110 мэдээллийн сан (статистикийн 48), 718 хүснэгт 10,528 үзүүлэлт, 1,686 ангилал код бүхий өгөгдлийг бүрдүүлээд байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 149 | 235 | 2022 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр 45 дугаар тэмдэглэл 2022-09-14 Дугаар 2022_45 | I.2. Төрийн байгууллагын албан хэрэг хөтлөлтөд цахим хэлбэрээр баримт бичиг солилцох нөхцөл бүрдүүлэх, аюулгүй байдлыг хангах асуудлыг судалж, зохих арга хэмжээ авах саналаа танилцуулахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан нарт даалгав. | Тагнуулын ерөнхий газраар "Албан бичиг солилцооны дундын систем (DocX)"-д мэдээллийн аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээг хийлгэсэн. Тагнуулын ерөнхий газраас 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн ТЕГ03/173 дугаар албан бичгээр үнэлгээгээр илэрсэн эмзэг байдлууд, тэдгээрийн эрсдэлийн түвшинг тодорхойлсон зөвлөмжийг ирүүлсэн ба тус зөвлөмжийн дагуу уг системд холбогдох сайжруулалтыг хийсэн. Системийг шинэ дэд бүтэц рүү шилжүүлсэн. Аюулгүй байдал цэсэнд давхар хамгаалалттай нэвтрэх сонголтыг нэмсэн ба гар утасны бүх хувилбар дээр аппликэйшн ашиглах боломжтой болсон.<br>Албан бичиг солилцооны дундын систем DocX-ээр дамжуулан 2025 онд 3,040 байгууллага тус системтэй холболт хийж, 354,888 бичиг илгээж, 402,724 албан бичиг хүлээн аваад байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 236 | | XX.4.2. Цахим хөгжил, харилцаа холбооны яам, түүний харьяа болон салбар байгууллагыг “Буянт-Ухаа Олон улсын нисэх буудал”-ын Зорчигч үйлчилгээний барилгын тодорхой хэсэгт байршуулахтай холбоотой тооцоо, судалгааг хийж, нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Иргэний нисэхийн ерөнхий газар (С.Мөнхнасан), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгав; | Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2022 оны 53 дугаар тушаалаар Цахим хөгжил, харилцаа холбооны яам, түүний харьяа болон салбар байгууллагыг “Буянт-Ухаа Олон улсын нисэх буудал”-ын Зорчигч үйлчилгээний барилгын тодорхой хэсэгт байршуулахтай холбоотой тооцоо, судалгааг хийж, нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны яам, түүний харьяа болон салбар байгууллагыг “Буянт-Ухаа Олон улсын нисэх буудал”-ын Зорчигч үйлчилгээний барилгад шилжүүлэхтэй холбоотойгоор тус барилгын зориулалт өөрчлөх, технологийн шийдэл гаргах чиг үүрэг бүхий "дэд ажлын хэсэг" Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/56 дугаар тушаалаар байгуулагдан ажилласан ба уг ажлын хэсгээс шаардлагатай төсвийн тооцоолол болон тохижилт, засварын загварыг боловсруулан ажлын хэсгийн ахлагчид танилцуулсан. Үүний үр дүнд “Монгол шуудан” ХК-ийн зарим хэсгийг “Буянт Ухаа Олон улсын нисэх буудал”-ын Зорчигч үйлчилгээний барилгын хэсэгт шилжүүлэн байршуулах зохион байгуулалтын арга хэмжээг авсан. Биелэлтэд хамаарах нотлох баримтыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/56 дугаар тушаалын дагуу холбогдох газраас гаргуулах нь зүйтэй байна. | Хэрэгжсэн - 100% | Тийм | Хяналтаас хасуулах саналтай байна |
| | 237 | | XX.4.3. Цахим хөгжил, харилцаа холбооны яам, түүний харьяа болон салбар байгууллагыг нүүлгэн шилжүүлэх, тэдгээрийн үйл ажиллагааг жигдрүүлэх, байр ашиглахад шаардагдах зардлын тооцоог нарийвчлан гаргаж, улсын 2023 оны төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгав; | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, түүний харьяа болон салбар байгууллагыг нүүлгэхтэй холбоотойгоор шилжүүлэх, тэдгээрийн үйл ажиллагааг жигдрүүлэх, байр ашиглахад шаардагдах зардлын тооцоог эхний байдлаар гарган ажлын хэсгийн ахлагчид танилцуулсан. Тус байгууламжид яамны болон харьяа байгууллага нүүхэд ашиглалтын болон захиргааны зардал хэт өндөр бөгөөд зөвхөн засварын зураг төсөв гүйцэтгэх зардалд 698 сая, Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төвийг байршуулах зардал 2.6 тэрбум орчим төгрөг гарахаар тооцоолсон болно. Иймд холбогдох зардлыг улсын төсөвт тусгуулах боломжгүй болсон. | Санхүү, хөрөнгө оруулалтаас - 0% | Үгүй | |
| 150 | 238 | 2022 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр 46 дугаар тэмдэглэл 2022-09-22 Дугаар 2022_46 | X.1. Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээнд Онцгой байдлын ерөнхий газрыг шилжүүлэх, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны харьяанд Улсын бүртгэлийн ерөнхий газрыг шилжүүлэх боломжтой эсэхийг судлан үзэхийг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт; | Улсын бүртгэлийн ерөнхий газрыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлэх боломжгүй талаар Ерөнхий сайдад танилцуулсан бөгөөд Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг дагалдуулан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 499 дүгээр тогтоолоор Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрыг шинээр байгуулан салбар хоорондын уялдаа холбоог ханган ажиллаж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 151 | 239 | 2022 оны 10 дугаар сарын 5-ны өдөр 48 дугаар тэмдэглэл<br>2022-10-05<br>Дугаар 2022_48 | XII.1.2. Дараахь арга хэмжээг хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд даалгав:<br><br>2.1. Эрхлэх асуудлын хүрээнд стандарт, техникийн зохицуулалтын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд;<br><br>2.2. “Үзлэгийн мөрөөр авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2019 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 235 дугаар тогтоолын хэрэгжилтийг дүгнэж, салбарын шаардлагатай стандарт, техникийн зохицуулалтыг 2022 онд багтаан боловсруулж, батлуулахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд; | 1.Цахим аймаг, хотын хөгжлийн жишиг загвар, тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг Төрийн нарийн бичгийн дарга 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр баталсан. 2.Банкны холбоо болон 12 арилжааны банкны мэдээллийн технологийн албан хаагчдад “lavlagaa.e-mongolia.mn” системийн ашиглалтын талаарх сургалтыг 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулсан. Мөн Хүн, хуулийн этгээд үндсэн систем ашиглан үйлчилгээ үзүүлэхдээ мэдээллийн эзний зөвшөөрлөөр хязгаарлалттай мэдээлэлд хандах, төрийн үйлчилгээний нэгдсэн системээс гарах лавлагаа, тодорхойлолтыг файл хэлбэрээр авах боломжийг бүрдүүлж lavlagaa.e-mongolia.mn системийг хөгжүүлсэн. “Үндсэн систем (ХУР)-ийг ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээ”-ний 8.2 дахь хэсгийг үндэслэн "Үндсэн систем ашиглан үйлчилгээ үзүүлэх нэмэлт гэрээ" байгуулсан. 3. Монгол Улсын Шадар сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын хамтарсан 81/А/69 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс “Төрийн үйлчилгээг операторын горимоор үзүүлэхэд тавих ерөнхий шаардлага”-ын стандартыг боловсруулж, Техникийн хорооны хурлаар хэлэцүүлж, стандарт, хэмжил зүйн газрын 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн С/51 дүгээр тушаалаар MNS 6984:2022 баталсан. Стандартыг нээлттэй цахим номын санд байршуулан нийтийн хүртээл болгосон. https://mongolmedleg.org/books1/toriin-uilchilgee/ | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 152 | 240 | 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдөр 50 дугаар тэмдэглэл<br>2022-10-19<br>Дугаар 2022_50 | XII.3.2. Хилээр нэвтэрсэн болон улсын бүртгэл, нийгмийн даатгал, татварын байгууллагад бүртгэгдсэн гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдтэй холбоотой дундын мэдээллийн санг бий болгох талаар зохих арга хэмжээ авахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт даалгав. | Эдийн засаг, хөгжлийн яам хөрөнгө оруулагчдад зориулсан цахим үйлчилгээний нэгдсэн “e-invest” порталыг 2019 оноос хэрэглээнд нэвтрүүлсэн. Уг порталд гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгууллагын нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, татварын тооцоотой эсэх, хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа, хөрөнгө оруулагчийн тодорхойлолт авах зэрэг 6 байгууллагын 11 үйлчилгээг байршуулсан. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 153 | 241 | 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл<br>2022-12-07<br>Дугаар 2022_58 | XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:<br><br>1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг болгов; | 1.Албан бичиг солилцооны дундын систем DocX-ээр дамжуулан 2025 оны жилийн эцсийн байдлаар 3,040 байгууллага тус системтэй холболт хийж, 354,888 бичиг илгээж, 402,724 албан бичиг хүлээн аваад байна.<br>2.Тус яам болон түүний харьяа 5, салбар 4 байгууллагууд Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны нэгдсэн системийг бүрэн ашиглаж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 242 | | XXI.6.2. Төрийн байгууллагын албан хэрэг хөтлөлтийн цахим системийн аюулгүй байдлыг хангаж, кибер халдлага, зөрчлөөс сэргийлж ажиллахыг Тагнуулын ерөнхий газар (П.Одонбаатар)-т, цахим системийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллахыг “И-Монгол академи” УТҮГ-ын захирал Л.Энхбатад тус тус даалгав. | 1.Тагнуулын ерөнхий газраар ""Албан бичиг солилцооны дундын систем (DocX)""-д мэдээллийн аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээг хийлгэсэн. Тагнуулын ерөнхий газраас 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн ТЕГ03/173 дугаар албан бичгээр үнэлгээгээр илэрсэн эмзэг байдлууд, тэдгээрийн эрсдэлийн түвшинг тодорхойлсон зөвлөмжийг ирүүлсэн ба тус зөвлөмжийн дагуу уг системд холбогдох сайжруулалтыг хийсэн. Системийг шинэ дэд бүтэц рүү шилжүүлсэн. Аюулгүй байдал цэсэнд давхар хамгаалалттай нэвтрэх сонголтыг нэмсэн ба гар утасны бүх хувилбар дээр аппликэйшн ашиглах боломжтой болсон.<br>2.Албан бичиг солилцооны дундын систем DocX-ээр дамжуулан 2025 оны жилийн эцсийн байдлаар 3,040 байгууллага тус системтэй холболт хийж, 354,888 бичиг илгээж, 402,724 албан бичиг хүлээн аваад байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 154 | 243 | 2023 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр 5 дугаар тэмдэглэл 2023-01-25 Дугаар 2023_5 | X.1.2. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9.6.5-д заасны дагуу Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” бодлогын баримт бичгийг эрхлэх асуудлын хүрээ, тухайн салбарт хэрэгжүүлэх төлөвлөгөг батлан хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгав. | Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” бодлогын баримт бичгийн тус яамны чиг үүрэгт хамаарах 6 арга хэмжээний 2024 оны жилийн эцсийн биелэлтийг 12 дугаар сарын 31-ний өдрийн 03/1396 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн. Мөн “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” бодлогын баримт бичгийг эрхлэх асуудлын хүрээ, тухайн салбарт хэрэгжүүлэхээр Цахим хөгжил, харилцаа холбооны яамны стратеги, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган ажиллаж байна. Мөн “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д туссан 6 зорилтын биелэлтийн тайланг 96.67%-тай үнэлгээ хийж, Засгийн газарт тайлагнасан. Мөн 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 01/1640 дугаар албан бичгээр "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн баримт бичгийн хэрэгжилтийг гарган Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн бөгөөд цахим системээр 2025 оны хагас жил хүртэлх хэрэгжилтийг гарган хүргүүлэхэд 88 хувьтай хэрэгжсэн байна. 2025 оны жилийн эцсийн тайланг үнэлж байна.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 244 | | X.1.3. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан зорилго, зорилтыг тухайн салбарт хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулахдаа өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах арга хэмжээ, үйл ажиллагаа, тэдгээрийн тухайн оны хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт, хүрэх (зорилтот) түвшинг урьдчилан тодорхойлж, байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгах, бусад төрийн захиргааны төв байгууллагын арга хэмжээтэй уялдуулах зорилгоор Эдийн засаг, хөгжлийн яамны саналыг тусган хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгав. | 1.Эдийн засгийн хөгжлийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/09 дүгээр тушаалаар байгуулсан Бүсчилсэн хөгжлийн үзэл баримлалын төсөл боловсруулах үүрэг бүхий Дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, харилцаа холбооны чиглэлээр хэрэгжүүлэх төслүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл бэлтгэж, munkhsaikhan.d@med.gov.mn цахим шуудангаар хүргүүлсэн.<br>2.Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөлд холбогдох нэгжүүдээс санал авч нэгтгэн, боловсруулж, 2024 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 01/89 дугаартай албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн.<br>3.Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 01/677 дугаар бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн.<br>4.Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах арга хэмжээ, үйл ажиллагаа, тэдгээрийн тухайн оны хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт, хүрэх (зорилтот) түвшинг урьдчилан тодорхойлж, Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 01/2285 дугаартай албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд санал хүргүүлсэн.<br>5.Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөнд холбогдох саналыг хүргүүлэхээр бэлтгэж байна.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 245 | | X.2.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж, тухайн жилд хүргэхээр тооцсон зорилтот түвшинд хүргэх арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын холбогдох агентлагийн дарга нарт үүрэг болгов. | Тус яаманд хамаарах Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 31 арга хэмжээг 2024 оны жилийн эцсийн байдлаар 83,8%-тай үнэлэгдэн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 03/1400 дугаар албан бичгээр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн. Мөн Хяналт хэрэгжүүлэх газарт 2025 оны эхний хагас жилийн тайланг 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 01/1564, жилийн эцсийн тайланг 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 01/2954 дугаартай бичгээр хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 246 | | X.3.. Хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан өөрийн эрхэлсэн асуудлын хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг гарган, хэрэгжилтийг оны эхнээс жигд хангаж ажиллах, хэрэгжилт хангалтгүй төсөл, арга хэмжээг дараа жилийн төлөвлөгөөнд тусган бүрэн хэрэгжүүлж дуусгахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгав. | 1.Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний биелэлтийг 2024 оны 01/2719, 2024 оны жилийн эцсийн биелэлтийг 03/1385, 2025 оны төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлтийг 2025 оны 01/2978 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br>2.Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг ЦХИХХ-ны сайдын 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 05 дугаар тушаалаар баталсан. Тус яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээнүүдийг тусган төлөвлөж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br><br>Хавсралт : 4 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 155 | 247 | 2023 оны 2 дугаар сарын 1-ний өдөр 6 дугаар тэмдэглэл<br>2023-02-01<br>Дугаар 2023_6 | XIY.1.2. Судалгааны сангийн нэгдсэн системийг ашиглах журам, хэрэглэгчийн зааварчилгааг боловсруулан баталж, мөрдүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт; | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/88 дугаар тушаалаар төрийн байгууллагуудын захиалгаар хийгдсэн судалгаа, зөвлөх үйлчилгээний тайлангуудыг олон нийтэд нээлттэй болгох, давхцалыг арилгах, төсвийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, Үндэсний судалгааны нэгдсэн систем (sudalgaa.gov.mn)-ийг хөгжүүлж, 2023 оны 6 дугаар сард хэрэглээнд нэвтрүүлсэн. Тус системийн тасралтгүй, найдвартай үйл ажиллагааг "И-Монгол академи" УТҮГ хангаж ажиллаж байна. Судалгааны санд 1308 хэрэглэгч бүртгэлтэй бөгөөд 2306 судалгааг нээлттэй байршуулсан байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар тус системд 11,569 хандалт хийгдсэн байна. Судалгааны сангийн нэгдсэн системийг ашиглах журам, хэрэглэгчийн зааварчилгааг боловсруулан баталж, мөрдүүлэх ажлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хариуцан ажиллаж байна.<br>Цахим хуудаст хандах: https://sudalgaa.gov.mn/ | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 248 | | XIY.1.3. Төрийн байгууллагууд болон зөвлөх үйлчилгээний захиалгаар хийлгэсэн судалгааны ажлын тайланг судалгааны нэгдсэн сангийн системд байршуулах, хянах, засварлах, хэрэглэгчийн саналыг хүлээн авах ажлыг холбогдох албан тушаалтанд хариуцуулж ажиллуулахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, төрийн болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээд, компани, үйлдвэрийн газрын удирдлагад; | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/88 дугаар тушаалаар төрийн байгууллагуудын захиалгаар хийгдсэн судалгаа, зөвлөх үйлчилгээний тайлангуудыг олон нийтэд нээлттэй болгох, давхцалыг арилгах, төсвийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, Үндэсний судалгааны нэгдсэн систем (sudalgaa.gov.mn)-ийг хөгжүүлж, 2023 оны 6 дугаар сард хэрэглээнд нэвтрүүлсэн. Тус системийн тасралтгүй, найдвартай үйл ажиллагааг "И-Монгол академи" УТҮГ хангаж ажиллаж байна. Судалгааны санд 1308 хэрэглэгч бүртгэлтэй бөгөөд 2306 судалгааг нээлттэй байршуулсан байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар тус системд 11569 хандалт хийгдсэн байна. Судалгааны сангийн нэгдсэн системийг ашиглах журам, хэрэглэгчийн зааварчилгааг боловсруулан баталж, мөрдүүлэх ажлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хариуцан ажиллаж байна.<br>Цахим хуудаст хандах: https://sudalgaa.gov.mn/ | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 156 | 249 | 2023 оны 2 дугаар сарын 8-ны өдөр 8 дугаар тэмдэглэл 2023-02-08 Дугаар 2023_8 | XXXY.11.2. “Цахим эрүүл мэнд” төслийг шинэчлэн боловсруулж, цахим шилжилтийг үргэлжлүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг нарт даалгав;<br><br>3.“Цахим эрүүл мэнд” төслийг хэрэгжүүлэх явцад гарсан хууль бус үйлдэл, үйл ажиллагааг Авлигатай тэмцэх газарт шилжүүлж шалгуулах, уг хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн ашиг сонирхлыг хамгаалах этгээдээр прокурорын байгууллагыг оролцуулах арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Хууль зүй дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт даалгав. | Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн чиглэлээр хийсэн ажлын үр дүнг ЗГ-ын 2024.03.26, 07.24-ний өдрийн хуралдаанд танилцуулсан. Эрүүл мэндийн төрөлжсөн мэдээллийн санг үүсгэж, “ХУР”-д 24 шинэ сервисийг нэвтрүүлсэн, 2025.06.24-ний өдрийн байдлаар 443 эмнэлэг холбосон. Иргэнээс зөвшөөрөл авах нөхцөлийг SMS (OTP), хурууны хээ, Push notification, G-Sign хэлбэрээр бүрдүүлсэн. Эмнэлгийн систем хөгжүүлэгч компаниудтай гэрээ байгуулан, VPN, API-г тохируулж, ХУР, Мэдэгдлийн системийн төлбөрийг 2025 оныг дуустал чөлөөлсөн. И-Монгол системд эрүүл мэндийн 25 үйлчилгээг нэвтрүүлэн ба 37 сая мэдэгдлийг хүргэж, 1.4 сая хандалтыг авсан. Цахим эрүүл мэндийн нөхцөл байдлын үнэлгээний судалгааг 325 байгууллагаас авч, үр дүнг нээлттэй байршуулсан. ЭМТХ-ийн 8.4, 8.10 дахь хэсэгт заасан журмыг ЗГ-ын 2024 оны 100 дугаар тогтоол, ЭМС, ЦХИХХС-ын хамтарсан 2025.04.16-ны өдрийн А/130, А/58 тушаалаар батлуулан 2025.05.13-ны өдөр захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн. Эрүүл мэндийн 109 байгууллагын 111 rack, 67 VPS, 153 mail, 137 website, 293 domain-ны үйлчилгээг ҮДТ-өөс үзүүлж байна. “Төрийн бүтээмжийн сэргэлт-Цахим эрүүл мэнд” үндэсний зөвлөлдөх уулзалтыг 2024.04.08,09-нд 150 байгууллагын 380 ажилтанд /digitalhealth.gov.mn/, сургалтыг 2024.04.16-нд анхан шатлалын байгууллагын 200 төлөөлөлд, 2024.05.04-24-нд 21 аймаг, нийслэлд зохион байгуулж эрүүл мэндийн ажилтнуудыг хамруулсан. Монгол Улсын “Цахим эрүүл мэнд”-ийн цогц арга хэмжээний төлөвлөгөө (2025-2028)-г хэлэлцэх уулзалт, хэлэлцүүлгийг НҮБ-ын Хүүхдийн Сангийн дэмжлэгтэйгээр 2025.04.10, 11-ний өдрүүдэд 20 байгууллагын 52 албан хаагчийн дунд зохион байгуулсан. “Эрүүл мэндийн салбарын дижитал шилжилтийн цогц арга хэмжээний төлөвлөгөө”-г ЭМС, ЦХИХХС-ын хамтарсан 2025.05.24-ний өдрийн А/201, А/81 тушаалаар баталсан. Хэлэлцүүлэг, уулзалтын тайланг оролцогч 20 байгууллагад 2025.06.05-ны өдрийн 02/1348, ЗГЭХГ-т 2025.05.20-ны өдрийн 01/1195 албан бичгээр хүргүүлж, ИЦББХ-ны 2025.05.28-ны өдрийн хурлаар танилцуулсан.<br><br>Хавсралт : 2 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 157 | 250 | 2023 оны 2 дугаар сарын 20-ны өдөр 9 дүгээр тэмдэглэл 2023-02-20 Дугаар 2023_9 | III.6. Засгийн газрын бодлого, шийдвэр нийгмийн хүлээлттэй хэрхэн уялдаж байгаа талаар судалгаа хийж, гарсан дүн шинжилгээнд тулгуурлан үндэслэл бүхий тайлбар, холбогдох мэдээллийг олон нийтэд хүргэж байхыг Засгийн газрын гишүүдэд даалгав. | Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийг үндэслэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2023 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн А/19 дүгээр тушаалаар Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг баталсан. Мөн тус яамны Бодлого төлөвлөлтийн газрын Судалгаа шинжилгээний хэлтсээс Мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт техник технологид суурилсан төрөл бүрийн үйлчилгээнүүдийн талаарх судалгаа, Өрхийн мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хэрэглээ, хүртээмжийн судалгааг хийсэн ба энэ талаарх мэдээллийг байгууллагын веб сайт хуудасны мэдээ цэсний, судалгаа дэд цэсэд байршуулсан. Мөн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны цахим хуудаст Засгийн газрын бодлого шийдвэр, нийгмийн хүлээлттэй холбоотой олон мэдээ мэдээллийг мэдээ цэсэнд байршуулан ажиллаж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 158 | 251 | 2023 оны 3 дугаар сарын 07-ний өдөр 11 дүгээр тэмдэглэл 2023-03-07 Дугаар 2023_11 | XII.5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон салбарын бодлого, стратегийн төлөвлөгөө, Жендэрийн үндэсний хорооны 2023 оны ээлжит хуралдаанаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллахыг Засгийн газрын гишүүд, яамдын жендэрийн салбар зөвлөл, орон нутгийн салбар хорооны дарга, Жендэрийн үндэсний хорооны гишүүдэд тус тус даалгав. | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны А/314 дүгээр тушаалаар “Жендерийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам”-ыг шинэчлэн баталсан. ЦХХХСайдын 2023 оны А/05 дугаар тушаалаар баталсан “Харилцаа холбооны салбарт баримтлах жендэрийн стратеги, үйл ажиллагааны чиглэл (2023-2026)"-д жендэрийн мониторинг үнэлгээ хийж, салбарын хэрэгцээг тодорхойлон цаашид үйл ажиллагаандаа тусгах санал зөвлөмжийг боловсруулж байна. “Монгол Улсад жендерийн эрх тэгш байдлыг хангах, үндэсний чадавхыг бэхжүүлэх нь төслийн хүрээнд 2025.05.21-ний өдөр Жендерийн асуудал хариуцсан мэргэжилтэн, шинжээч, багш нарын уулзалт, 2025.05.22-23-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан "Жендерийн эрх тэгш байдал ба уур амьсгалын өөрчлөлт” олон улсын хурал харьяа, салбар байгууллагын жендер хариуцсан албан хаагчдыг хамруулж, жендерийн тухай хууль, мэдрэмжтэй ажлын байрны бодлого, бусад холбогдох мэдээллээр хангасан. Жендерийн үндэсний хорооноос “Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”, “Монгол цэргийн өдөр”-ийг тохиолдуулан жендерийн тэгш бус байдал, жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, бууруулахад залуучууд, олон нийтийн жендерийн боловсролыг нэмэгдүүлэх мэдээ, мэдээллийг 2025.03.03-2025.04.01-ний хооронд түгээх, бодлогын нөлөөллийн аяны хүрээнд И-Монгол академи УТҮГ, Монголын цахилгаан холбоо ХК, Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ зэрэг байгууллагууд оролцсон. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 252 | | XII.2.3. Эрүүл мэндийн салбарын цахим системийн хэвийн найдвартай үйл ажиллагааг хангах чиглэлээр зохих арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт; | Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн чиглэлээр хийсэн ажлын үр дүнг ЗГ-ын 2024.03.26, 07.24-ний өдрийн хуралдаанд танилцуулсан. Эрүүл мэндийн төрөлжсөн мэдээллийн санг үүсгэж, “ХУР”-д 24 шинэ сервисийг нэвтрүүлсэн, 2025.06.24-ний өдрийн байдлаар 443 эмнэлэг холбосон. Иргэнээс зөвшөөрөл авах нөхцөлийг SMS (OTP), хурууны хээ, Push notification, G-Sign хэлбэрээр бүрдүүлсэн. Эмнэлгийн систем хөгжүүлэгч компаниудтай гэрээ байгуулан, VPN, API-г тохируулж, ХУР, Мэдэгдлийн системийн төлбөрийг 2025 оныг дуустал чөлөөлсөн. И-Монгол системд эрүүл мэндийн 25 үйлчилгээг нэвтрүүлэн ба 37 сая мэдэгдлийг хүргэж, 1.4 сая хандалтыг авсан. Цахим эрүүл мэндийн нөхцөл байдлын үнэлгээний судалгааг 325 байгууллагаас авч, үр дүнг нээлттэй байршуулсан. ЭМТХ-ийн 8.4, 8.10 дахь хэсэгт заасан журмыг ЗГ-ын 2024 оны 100 дугаар тогтоол, ЭМС, ЦХИХХС-ын хамтарсан 2025.04.16-ны өдрийн А/130, А/58 тушаалаар батлуулан 2025.05.13-ны өдөр захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн. Эрүүл мэндийн 109 байгууллагын 111 rack, 67 VPS, 153 mail, 137 website, 293 domain-ны үйлчилгээг ҮДТ-өөс үзүүлж байна. “Төрийн бүтээмжийн сэргэлт-Цахим эрүүл мэнд” үндэсний зөвлөлдөх уулзалтыг 2024.04.08,09-нд 150 байгууллагын 380 ажилтанд /digitalhealth.gov.mn/, сургалтыг 2024.04.16-нд анхан шатлалын байгууллагын 200 төлөөлөлд, 2024.05.04-24-нд 21 аймаг, нийслэлд зохион байгуулж эрүүл мэндийн ажилтнуудыг хамруулсан. Монгол Улсын “Цахим эрүүл мэнд”-ийн цогц арга хэмжээний төлөвлөгөө (2025-2028)-г хэлэлцэх уулзалт, хэлэлцүүлгийг НҮБ-ын Хүүхдийн Сангийн дэмжлэгтэйгээр 2025.04.10, 11-ний өдрүүдэд 20 байгууллагын 52 албан хаагчийн дунд зохион байгуулсан. “Эрүүл мэндийн салбарын дижитал шилжилтийн цогц арга хэмжээний төлөвлөгөө”-г ЭМС, ЦХИХХС-ын хамтарсан 2025.05.24-ний өдрийн А/201, А/81 тушаалаар баталсан. Хэлэлцүүлэг, уулзалтын тайланг оролцогч 20 байгууллагад 2025.06.05-ны өдрийн 02/1348, ЗГЭХГ-т 2025.05.20-ны өдрийн 01/1195 албан бичгээр хүргүүлж, ИЦББХ-ны 2025.05.28-ны өдрийн хурлаар танилцуулсан.<br><br>Хавсралт : 2 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 159 | 253 | 2023 оны 3 дугаар сарын 29-ний өдөр 14 дүгээр тэмдэглэл 2023-03-29 Дугаар 2023_14 | 2. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг шинэчилж, хууль тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичиг, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах, үнэлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох, олон улсын жишигт нийцүүлэх, цахимжуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар /Б.Баасандорж/, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт тус тус даалгав”. гэжээ. | Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас 2025 оны 01/103 дугаар албан бичгээр "Олон улсын үнэлгээний цогц систем"-ийг Дэлхийн банкны "Ухаалаг засаг 2" төслийн хүрээнд хэрэгжүүлэх саналаа ирүүлсэн. Саналыг "Ухаалаг засаг 2" төслийн худалдан авалтын төлөвлөгөөнд тусгасан бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас "Олон улсын үнэлгээний цогц систем"-ийн ажлын даалгаврыг боловсруулан Дэлхийн банкаар хянуулан ажиллаж байна.<br><br>Хавсралт : 1 файл | Х.Б | Үгүй | |
| | 254 | | XVIII.7.3. Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллагын ажилтнуудтай 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдөр хийсэн уулзалтын талаар Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгав:<br>3.Олон улсын байгууллагын техник туслалцааны төслийн хүрээнд гадаад улсад магистр, доктор болон ахисан түвшний сургалтад хамрагдсан төрийн албан хаагчдыг төгсмөгц, ажлын байранд нь эргүүлэн томилж ажиллуулах арга хэмжээ авч байхыг яамдын Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга нарт; | Ази, Номхон Далайн Сансрын Хамтын Ажиллагааны Байгууллагын тэтгэлэгээр тус яамны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа нь Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Бэйханг Их сургуульд Сансрын төсөл хөтөлбөрийн менежментийн удирдлагын чиглэлээр магистрын хөтөлбөрт суралцаж байна. | Х.Б | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 255 | | XVIII.7.4. Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллагын ажилтнуудтай 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдөр хийсэн уулзалтын талаар Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгав:<br>Олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлэх төслийн хүрээнд төрийн албан хаагчийг мэргэшүүлэх зорилгоор гадаад улсад туршлага судлах сургалт, аялалд хамруулах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд; | "Мэдээллийн технологийн 1000 залуу инженер бэлтгэх" хөтөлбөрийн хүрээнд 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр зохион байгуулагдсан Tech4Good бүсийн уралдаанд Монгол Улсаас 10 иргэн /тус яамнаас 3 албан хаагч/ оролцсон. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 160 | 256 | 2023 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр 15 дугаар тэмдэглэл<br>2023-04-05<br>Дугаар 2023_15 | XI.8.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн явц болон төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системийн ашиглалтын талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг эрчимжүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системийн ашиглалтыг бүх түвшинд сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг доор дурдсан албан тушаалтанд даалгав:<br><br>Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх үйл ажиллагааг "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-д заасны дагуу Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS)-ээр хэрэгжүүлэх, төсвийн хэмнэлтийн хүрээнд энэ чиглэлийн | Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын дагуу төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах үйл ажиллагааг publicinvestment.gov.mn цахим системд тайлагнан ажиллаж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 161 | 257 | 2023 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 16 дугаар тэмдэглэл<br>2023-04-12<br>Дугаар 2023_16 | XIX.1. Нийслэлийн хүн амын 2023 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан бэлтгэсэн нөөцийн махыг худалдан борлуулах цэгийг нэмэгдүүлэх, төв цэнгэлдэх хүрээлэнд худалдаалах цэг гаргах, аймаг, орон нутгаас мах ачсан тээврийн хэрэгслийг нийслэл хот руу саадгүй нэвтрүүлэх, нөөцийн махны чанарын асуудлаар мэдээлэл хийх зэрэг арга хэмжээ авч ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун нарт, уг ажилд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд даалгав.<br><br>Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөлтэй хийх уулзалтын үеэр “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг сурталчлан таниулж, хэрэгжилтийн явцын талаар мэдээлж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав.<br><br>Төрийн ордны хашааны засварын | Тус яамны чиг үүрэгт хамаарах “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 54 заалтын хэрэгжилтийн тайланг 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 02/2354, Засгийн газрын “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хэрэгжилтийн тайланг жилд 1 удаа тайлагнаж 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 02/2045 дугаартай бичгээр Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн. Мөн Цахим хөгжил, харилцаа холбооны яамны албан хаагчид Удирдлагын академиас зохион байгуулж буй “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилтыг төрийн албан хаагчдад сурталчлан таниулах зорилго бүхий танхимын сургалтад, Эдийн засаг, хөгжлийн яамнаас зохион байгуулсан Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний сургалт болон шинэ сэргэлтийн бодлогын сургалтад яамнаас 3 албан хаагч тус тус хамрагдсан.<br><br>Хавсралт : 2 файл | Хэрэгжсэн - 100% | Тийм | Хяналтаас хасуулах саналтай. |
| | 258 | | XX.7. Эмнэлэгт өвчтөн илгээх 13А маягтыг цахимжуулах талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан Эмнэлэгт өвчтөн илгээх АМ-13А, АМ-13Б, АМ-13В маягтыг цахим хэлбэрээр олгох нөхцөлийг бүрдүүлж, эрүүл мэндийн салбарын хэмжээнд хэрэглээнд нэвтрүүлэн ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт даалгав. | Эрүүл мэндийн яам тус маягтыг хэрэглэхээ болих шийдвэр гаргах хүртэл 2023 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 4-ний өдөр хүртэл 6 сарын хугацаанд нийт 53,330 цахим маягт илгээгдсэн болно. Тус маягтууд эрүүл мэндийн салбарт хэрэглэхгүй болсон тул энэхүү цахим системийг ашиглахгүй болсон. | Хэрэгжсэн - 100% | Тийм | Цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болж, шийдвэр цуцлагдсан тул хяналтаас хасуулах саналтай. |
| | 259 | | XIX.2.5. Төрийн болон албаны нууцын тухай хуулийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нийцүүлэх асуудлыг судлан холбогдох саналаа боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт тус тус даалгав | Төрийн болон албаны нууцын тухай хуулийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нийцүүлэх талаар санал ирүүлээгүй бөгөөд тус яамны хяналтаас хасуулах саналтай байна. | Хэмжигдэхүйц биш | Тийм | Хяналтаас хасуулах саналтай. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 162 | 260 | 2023 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр 17 дугаар тэмдэглэл 2023-04-19 Дугаар 2023_17 | XIX.1.4. “Шинэ тойрог зам” төслийн урд хэсэг, Туулын авто зам болон Туулын авто замыг Нисэхийн хурдны авто замтай холбох (Туулын авто замаас Нүхтийн авто зам хүртэл) авто замын төслийн техник, эдийн засгийн үндэслэл, барилгын ажлын нарийвчилсан зураг төслийг баталгаажуулахад шаардлагатай холбогдох техникийн нөхцөлийг шуурхай олгож ажиллахыг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт; | Зам, тээврийн яам "Шинэ тойрог зам" барих төслийн гүйцэтгэгч сонгон шалгаруулж, гүйцэтгэгч харилцаа холбооны техникийн нөхцөл авах хүсэлт ирүүлсний дараа уг техникийн нөхцөлийг олгох асуудлыг шийдвэрлэнэ. | Х.Б | Үгүй | |
| | 261 | | XYIII.3.2. Шаардлагатай мэдээлэл, тайланг бэлтгэхэд оролцох албан хаагчийг томилон ажиллуулахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд даалгав. (Авлигын төсөөллийн индексийг тооцоход нөлөө үзүүлэх шалгуур үзүүлэлт (индекс)-ийг тодорхойлоход оролцдог байгууллагуудтай хамтран ажиллах, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын төлөвлөгөө гаргаж, холбогдон гарах зардлыг судлан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт) | Шаардлагатай мэдээлэл, тайланг бэлтгэн тухай бүрт нь хүргүүлэн ажиллаж байна. Тухайлбал, Авлигатай тэмцэх газрын захиалгаар Бодлын шийдэл ТББ-аас 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрөөс 2025 оны 07 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл хугацаанд тус яамны албан хаагч, үйлчлүүлэгчдээс Шударга байдлын үнэлгээний асуулга авахад оролцох албан хаагч болон бусад мэдээллийг бэлтгэхэд оролцсон. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 163 | 262 | 2023 оны 5 дугаар сарын 03-ны өдөр 19 дүгээр тэмдэглэл | XYIII.8.1. Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газар, байнгын ажиллагаатай хилийн боомтод төрийн үйлчилгээний цэгийг нээх ажлыг үе шаттайгаар зохион байгуулахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд; | Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын нийслэл дэх 144, орон нутаг дахь 405, хилийн чанад дахь дипломат төлөөлөгчийн газар дахь 31 улсын 47 буюу нийт 596 төрийн үйлчилгээний хурдан цэгээр дамжуулан төрийн 43 байгууллагын 451 үйлчилгээг 1,581,079 удаа амжилттай үзүүлээд байна. Цахим хуудаст хандах: https://khurdan.gov.mn/%d1%85%d1%83%d1%80%d0%b4%d0%b0%d0%bd-%d1%86%d1%8d%d0%b3%d0%b8%d0%b9%d0%bd-%d0%b1%d0%b0%d0%b9%d1%80%d1%88%d0%b8%d0%bb | Хэрэгжсэн - 100% | Тийм | Бүрэн хэрэгжсэн тул хасуулах саналтай байна |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 163 | 263 | 2023-05-03<br>Дугаар 2023_19 | XYIII.9. Нэмэгдсэн өртгийн албан татвар, түүний хэрэгжилт, тулгамдаж байгаа асуудлын талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br>Үүнтэй холбогдуулан эрхэлсэн хүрээний асуудалд хамаарах бараа, ажил, үйлчилгээнд ногдох нэмэгдсэн өртгийн албан татвартай холбоотой хууль тогтоомжийн төслийг Сангийн сайдтай урьдчилан зөвшилцсөний үндсэн дээр боловсруулж байхыг Засгийн газрын гишүүдэд даалгав. | Нэмэгдсэн өртгийн албан татвар, түүний хэрэгжилтийн хүрээнд 2023 оны 7 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн бараа бүтээгдэхүүний худалдан авалт болон үйлчилгээний төлбөр төлсөн тухай бүр үйлдсэн төлбөрийн баримтын мэдээллийг автоматаар ибаримт системд бүртгэх үйлчилгээ 300 гаруй салбарт ашиглаж байна. Мөн эрхэлсэн хүрээний асуудалд хамаарах бараа, ажил, үйлчилгээнд ногдох нэмэгдсэн өртгийн албан татвартай холбоотой хууль тогтоомжийн төсөл боловсруулаагүй болно. И-Баримтыг банкны картаар дамжуулан НӨАТ-ын системд автоматаар бүртгэх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлээд байна:<br>1.Монголбанк, Монголын Банкны холбоо ТББ, Арилжааны банкнуудын хамтарсан уулзалтыг зохион байгуулж, И-Баримтыг банкны картаар дамжуулан НӨАТ-ын системд автоматаар бүртгэх шийдлийн талаарх танилцуулсан;<br>2.И-Баримтыг банкны картаар дамжуулан НӨАТ-ын системд автоматаар бүртгэх нөхцөлийг бүрдүүлэх талаар 12 арилжааны банканд мэдээлэл хүргүүлсэн;<br>3.Санхүүгийн мэдээллийн технологийн төв УТҮГ, арилжааны банкнууд, хэрэглэгчийн систем нийлүүлэгч байгууллагууд тус бүр хөгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэж байна.<br>- Нийт 28 систем нийлүүлэгчийн 1437 аж ахуйн нэгж байгууллага картын хялбар бүртгэлээр баримт бүртгэх боломжтой болсон байна. Картын хялбар бүртгэлээр нийт 604954 баримт баталгаажсан байна. Сүлжээ дэлгүүрүүдээс GS25 болон Номин сүлжээ дэлгүүрийн хөгжүүлэлтээ хийсэн салбаруудад нэвтрүүлэх ажил хийгдэж байна. Хаан банк 437101 хэрэглэгч картаа холболт хийсэн байна. https://sugalaa.ebarimt.mn | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 164 | 264 | 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдөр 21 дүгээр тэмдэглэл<br>2023-05-17<br>Дугаар 2023_21 | XVIII.2.3. Монгол Улсын хөгжлийн бодлого, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хүний хөгжил, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд эерэг үр нөлөөтэй байхад чиглүүлэн бодитой, үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав. | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны чиг үүрэгт хамаарах Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний цахим систем www.unelgee.gov.mn-д оруулж тайлагнаж байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хяналтад авсан 358 зүйл, заалтын хэрэгжилтийг дунджаар 89,19%-тай үнэлэгдэн 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 03/1291 дугаар албан бичгээр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн. Үүрэг, даалгаврын хэрэгжилтийн явц, үр дүнгийн тайланг улирал тутамд Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлж ажиллаж байна. 2025 оны 1 дүгээр улирлын 246 заалтын биелэлтийг 2025 оны 02 дугаар сарын 03/511 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлж, Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний цахим систем www.unelgee.gov.mn-д оруулсан. Мөн хэрэгжилт удаашралтай, эрчимжүүлэх шаардлагатай 22 заалтын биелэлтийг 05 дугаар сарын 14-ний өдөр тус системээр тайлагнасан. ЗГҮАХ-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 2025 оны жилийн тайланг Хяналт хэрэгжүүлэх газарт 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 01/2954, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний биелэлтийг 2025 оны 01/2978 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 3 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 165 | 265 | 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр 23 дугаар тэмдэглэл 2023-05-31 Дугаар 2023_23 | XXII.2.. “Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгов:<br><br>1.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг өөрийн байгууллагын цахим хуудаст, шаардлагатай мэдээллийг нэгдсэн систем (shilen.gov.mn)-д байршуулж, тухай бүр шинэчилж ажиллах;<br><br>2.Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-д мэдээллийг шууд холбох боломжтой байдлаар өөрийн байгууллагын системийн бэлэн байдлыг хангах;<br><br>3.Мэдээллийн сан, системийн хэвийн үйл ажиллагаа болон | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны А/46 дугаар тушаалаар Авлигатай тэмцэх “5Ш” ажиллагааны хүрээнд “Шил ажиллагаа”-ны хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангаn, шаардлагатай мэдээ, мэдээллийг нэгтгэж, шилэн индексийн үнэлгээг зарлах үүрэг бүхий Штабыг шинэчлэн байгуулан ажиллаж байна. Тус штаб нь мэдээлэл хариуцагч байгууллага хуульд ил тод, нээлттэй байхаар заасан мэдээллийг ил тод байршуулсан эсэхэд Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-ээр дамжуулан үнэлгээ өгөн холбогдох заавар, мэдээллээр хангаn ажиллаж байна. Энэ хүрээнд төрийн захиргааны төв байгууллага болон Засгийн газрын 40 агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тухай бүр албан бичиг хүргүүлэн, нийт 4,583 байгууллагын 5,113 албан хаагчдад системийн хандах эрхийг олгож, 10511 албан хаагчдад сургалтыг үе шаттай зохион байгуулан ажиллаж байна. Мөн нээлттэй мэдээллийг сурталчлан таниулах зорилгоор Монголын Үндэсний Олон нийтийн телевиз, “Ийгл” телевизүүдээр мэдээллийг хүргэн ажилласан.<br>2025 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 1,876 байгууллага мэдээллийн ил тод байдлын "Шилэн индекс"-ийн тайланг нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-ээр дамжуулан илгээсэн ба төрийн захиргааны төв байгууллага 49.4% (Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон 14 яам), төрийн захиргааны байгууллага 78.08% (33 агентлаг), Нийслэлийн Засаг даргын Тамгын газар 74.9% (8 ЗДТГ), нутгийн захиргааны байгууллага 77,09% (21 аймаг)-тай үнэлэгдээд байна. 2025 оны жилийн эцсийн "Шилэн индекс"-ийн тайланг үнэлж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 166 | 266 | 2023 оны 6 дугаар сарын 07-ны өдөр 24 дүгээр тэмдэглэл 2023-06-07 Дугаар 2023_24 | XXV.12.2. Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 151 дүгээр захирамжаар байгуулагдсан “Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах салбар болон орон нутгийн хүрээнд хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болох чиг үүрэг, үйл ажиллагаа, үйлчилгээний чиглэл боловсруулах Ажлын хэсгээс баталсан “2023 онд яам, агентлаг, харьяа байгууллагын эрхэлж байгаа зарим ажил, чиг үүргийг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх төлөвлөгөө”-г хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав. | Тус яамнаас “Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд эрхэлж байгаа зарим ажил, чиг үүргийг хувийн хэвшил, төрийн бус байгууллагад шилжүүлэх арга хэмжээний 2024 оны төлөвлөгөөний төслийн санал авах тухай 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 03/2668 дугаар албан бичгийг харьяа байгууллагуудад хүргүүлэн саналыг нэгтгэж, 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 03/72 дугаар албан бичгээр төлөвлөгөөний төслийн саналыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 2 файл | Хэрэгжсэн - 100% | Тийм | Цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон тул хяналтаас хасуулах саналтай. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 167 | 267 | 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдөр 25 дугаар тэмдэглэл 2023-06-14 Дугаар 2023_25 | XIII.5.2. 2. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг ард иргэд, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг аймаг, дүүргүүдэд зохион байгуулахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, | Бүсчилсэн хөгжлийн зорилтын хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны яамны санаачилгаар 21 аймгийн цахим шилжилтэд тулгамдаж буй нийтлэг асуултуудад хариулт өгөх, орон нутагт цахим шилжилтийг эрчимжүүлэх, иргэн төвтэй засаглалыг хөгжүүлэх зорилгоор “Цахим аймаг” бодлогын зөвлөмжийг хэрэгжүүлэхэд бодлого, арга зүйн дэмжлэг үзүүлэх, орон нутагт өндөр бүтээмжтэй, үр ашигтай эдийн засаг, нийгмийн гарцыг бий болгоход чиглэсэн мэдээллийн технологийн дэвшилтэт бүтээгдэхүүн, программ хангамжийг сурталчлан таниулах зорилгоор төр болон хувийн хэвшил хамтран “Digital First-D1” арга хэмжээг “Цахимд хэвшье” уриатайгаар 21 аймагт зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/22 дугаар тушаалаар байгуулсан. Тус арга хэмжээний хүрээнд 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрөөс 05 дугаар сарын 03-ны өдрүүдэд 21 аймагт ажилласан. Ажлын үр дүнд төрийн албан хаагч, ерөнхий боловсролын сурагч, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч нийт 30,000 иргэн цахим ур чадвар олгох сургалт, экспо арга хэмжээнд хамрагдсан бөгөөд хувийн хэвшлийн мэдээллийн технологи үйлдвэрлэгч байгууллага нь төрийн байгууллагатай хамтран ажиллах 14 гэрээ, 116 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Тус яамнаас Дархан-Уул, Өвөрхангай аймагт “Аймаг, орон нутгийн цахим шилжилтийг эрчимжүүлэх, иргэн аж, ахуй нэгжид чиглэсэн нэгдсэн систем нэвтрүүлэх” төслийг 2024 оны 04 дүгээр сараас хэрэгжүүлж, 2024 оны 09 дүгээр сарын 09-10-ны өдөр Дархан-Уул аймагт цахимжилтын үр дүнг танилцуулах “Нээлттэй хаалганы өдөрлөг” арга зохион байгуулсан. Дархан-Уул аймаг Монгол Улсын анхны жишиг “Цахим аймаг”-ийн эхлэлийг тавьсан.Зүүн бүсийн цахим шилжилтийг эрчимжүүлэх, бүс нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, орон нутгийн мэдээллийн технологийн салбарыг хөгжүүлэх зорилгоор “Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын зүүн бүсийн чуулга уулзалт”-ыг Хэнтий аймгийн төв Чингис хотод 2025 оны 03 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулсан. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 268 | | XIII.3. Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 49 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Авлигатай тэмцэх таван ажиллагаа"-ны хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгав. | 1.2025.09.19-ний өдрийн байдлаар 39 төрлийн1,076,407 мэдээллийг байршуулж, 16,474,627 удаагийн хандалтыг авсан. 2. Шил ажиллагааны хэрэгжилтийг 2023.04.05, 05.31, 08.16 болон 2024.04.17-ны өдрийн ЗГ-ын хуралдаанд нийт 4 удаа танилцуулж, холбогдох төрийн байгууллагад чиглэл хүргүүлсэн. 3. ЕС-ын 2023 оны 01 дүгээр албан даалгаварын, биелэлтийг "Хангалттай" гэж үзэн 2023 оны 01/1174 дүгээр албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.4. Мэдээлэл хариуцагчаас ирүүлсэн 6,090 хуудас мэдээллийн архивын материалыг бэлтгэн, нийт мэдээллийг машинд уншигдах хэлбэрээр бэлдэж 2023 оныы 01/2240 дугаар албан бичгээр АТГ-т, хэрэгжилтийг УИХ-д танилцуулахаар 2024 оны 01/858 дугаар албан бичгээр ЕСАА-нд, мөн 2024 оны 01/1142 дугаар албан бичгийг ЗГ-ын гишүүд, аймаг, нийслэлийн ЗД нарт, "Шилэн индекс"-ийг үнэлгээг хянан баталгаажуулах, холбогдох сургалтыг зохион байгуулах чиглэлийг 2024 оны 01/1147дугаар албан бичгээр ТЦҮЗГ-т тус тус хүргүүлсэн. 5. АМТ зөвшөөрлийн мэдээллийн санд хиймэл оюуны сүүлийн үеийн (GPT) технологийг сургаж, ашиглалтад оруулсан. 6. 2.0 системд хандах эрх олгох, сургалтад хамруулах тухай 2024 оны 01/817 дугаар албан бичгийг ЗГ-ын гишүүд, Аймаг, Нийслэлийн ЗД нарт, шил ажиллагааны хүрээнд хамтран ажилласан 123 байгууллагын 257 албан хаагч нарт цахим шуудангаар хүргүүлж, 2024.12.09-ний өдрийн байдлаар хандах эрхийг мэдээлэл хариуцагч 1328 байгууллагын 1569 албан хаагчдад үүсгэж, 6 удаагийн сургалтад хамруулсан. 7. ХУР систем, тусгай зөвшөөрлийн licence.mn системүүдийг холбосон. 8. ЦХИХХЯ эрхэлсэн асуудлын хүрээнд салбарын байгууллагуудын Шилэн индексийн үнэлгээ, нээлттэй мэдээллийг бүрэн байршуулсан. ЦХИХХСайдын 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн "Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай" 01/924 дугаартай албан бичгийг ЗГ-ын гишүүд болон аймаг, нийслэлийн ЗД, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар буюу нийт 45 байгууллагад хүргэгдсэн. Мөн 01/983 дугаартай албан бичгээр ажил эрчимжүүлэх чиглэлийг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газарт хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 7 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 269 | | XIII.10.. “Цахим аймаг” бодлогын зөвлөмжийн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан “Цахим аймаг” бодлогын зөвлөмжийг аймаг, нийслэл, сум, дүүрэгт хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад, бодлогын дэмжлэг үзүүлж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт тус тус даалгав. | Цахим хөгжил, харилцаа холбооны сайд "Цахим аймаг" бодлогын зөвлөмж батлах тухай 2023 оны А/53 дугаар тушаалыг баталсан. Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар танилцуулж 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн Засгийн газрын 25 дугаар тэмдэглэлээр Цахим аймаг бодлогын зөвлөмжийг аймаг, нийслэл, сум, дүүрэгт хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад, бодлогын дэмжлэг үзүүлж ажиллахыг тус яамны сайдад даалгасан. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/66 дугаар тушаалаар "Цахим аймаг" бодлогын зөвлөмжийг аймаг, нийслэл, сум дүүрэгт хэрэгжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийг байгуулан “Аймаг, орон нутгийн цахим шилжилтийг эрчимжүүлэх, иргэн аж, ахуй нэгжид чиглэсэн нэгдсэн систем нэвтрүүлэх” төслийн ажлыг 2024 онд Дархан-Уул, Өвөрхангай аймагт хэрэгжүүлээд байна. 2025 онд Булган аймаг, Баянхонгор аймаг, Говь-Алтай аймаг, Дундговь аймаг, Сэлэнгэ аймаг, Төв аймаг, Хэнтий аймаг нийт 7 аймагт хэрэгжүүлэхээр 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр ажлын даалгаврыг баталж, худалдан авах ажиллагааг 2025 оны 04 дүгээр сард зарласан. 2025 оны 07 дугаар сард санхүүжилт татагдсан байна. Бодлогын хувьд тухай бүр дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 270 | | 2.. Мэдээллийн технологийн чиглэлээр мэргэшсэн ажилтан бэлтгэх тусгай хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэхийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нарт; | 1.Мэдээлэл, харилцаа холбооны технологийн мэргэжилтэй хүний нөөцийг бэлтгэх ажлын төлөвлөгөөг БШУ-ны сайд, ЦХХХ-ны сайдын 2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/440, А/70 тушаалаар баталсан.<br>2.Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “Хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэл батлах тухай” 115 дугаар тогтоолоор тэргүүлэх мэргэжлийн чиглэлд “Мэдээллийн технологи”, “Программ хангамжийн инженерчлэл”, “Электроникийн инженерчлэл”, “Үйлдвэрлэлийн автоматжуулалт”, “Ухаалаг технологи” гэх мэт 14 төрлийн мэргэжлийн чиглэл багтсан. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны “Мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, индекс шинэчлэн батлах тухай” А/146 дугаар тушаалаар “Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, индекс“-ийг баталсан. Тус индексээр Мэдээлэл харилцаа холбооны мэргэжилтэн бэлтгэх чиглэлээр 21 индексийг батлан дээд боловсролын салбарт мэргэжилтэн бэлтгэж, хөдөлмөрийн зах зээлд боловсон хүчний хэрэгцээг хангаж байна.<br><br>Хавсралт : 2 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 168 | 271 | 2023 оны 7 дугаар сарын 5-ны өдөр 28 дугаар тэмдэглэл 2023-07-05 Дугаар 2023_28 | 3.. Цахим ур чадварыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх, зорилтот бүлэгт чиглэсэн арга хэмжээг тогтмол зохион байгуулж ажиллахыг Харилцаа, холбооны зохицуулах хороо /Г.Чинзориг /; | 1.Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх I, II, III шатны 2022 онд 1,132 удаагийн 2,444 цагийн цахим ур чадварын сургалтад нийт 84,744 хүнийг хамруулсан. Үүнээс 56,677 нь төрийн албан хаагч, 26,524 иргэн, хөгжлийн бэрхшээлтэй 687 иргэн хамрагдаж, 867 сургагч багш бэлтгэгдсэн. 21 аймаг дахь Мэдээллийн технологийн хэлтэс, "ХУРДАН" клубээр дамжуулан үе шаттай зохион байгуулж, нийт 90,037 хүнд сургалт явуулсан. 2025 онд V аяны хүрээнд 21 аймагт 105 удаа, 112 суманд 560 удаагийн сургалтад нийт 48248 иргэнийг хамруулсан. Бүх нийтийн харилцаа холбоо, мэдээллийн суурь мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилгоор иргэдэд цахим ур чадвар олгох суурь сургалтыг 63 удаагийн давтамжтай нийт 5008 иргэнийг хамруулсан байна.<br>2.Төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, олон нийтийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх (DEMOSC) төслийн хүрээнд Дархан-Уул аймагт төрийн цахим үйлчилгээний Хөдөлгөөнт Хурдан цэг, Төрийн албан хаагчид, иргэд, хүүхдүүдийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх танхимыг байгуулж 4,823 иргэнд төрийн цахим үйлчилгээг үзүүлсэн. Мөн Багахангай, Баянзүрх, Налайх, Сонгинохайрхан дүүрэг, Дархан-Уул, Хэнтий, Дорнод аймгийн болон эрүүл мэндийн салбарын нийт 800 гаруй төрийн албан хаагч болон 2,715 иргэнд цахим ур чадварын практик сургалтууд зохион байгуулж, тайлангийн хурлыг 2025 оны 06 сард зохион байгуулсан. "Олон нийтийн цахим мэдээллийн ажилтан" бэлтгэх туршилтын төслийг зохион байгуулж, зорилтот байршлын ерөнхий боловсролын 35 сургуульд түшиглэн 70 багшийг олон нийтийн цахим мэдээллийн ажилтнаар бэлтгэж, 350 хүүхдийг "өсвөрийн цахим манлайлагч" болгон бэлтгэсэн. Эдгээр өсвөрийн цахим манлайлагчид сургуулийн ажилтан, албан хаагчид болон орон нутгийн алслагдсан сум, багуудад амьдарч байгаа иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх, төрийн цахим үйлчилгээг хэрхэн ашиглах талаар мэдээлэл, сургалт зохион байгуулж, нийт 10,000 иргэнийг хамруулж, тайлангийн хурлыг 2025 оны 04 дүгээр сард зохион байгуулсан. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 272 | | XIII.7.. Цахим орчинд контент бүтээж орлого олох боломжийг бүрдүүлж, олон улсын жишигт нийцүүлэх асуудлыг 2023 онд багтаан шийдвэрлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал даалгаж, Монголбанк (Б.Лхагвасүрэн)-нд зөвлөмж болгов. | Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хурдалдаанаар Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг хэлэлцүүлэн батлуулсан. Тус хуулийн 7 дугаар зүйлд Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хамрах хүрээ, чиглэлд дижитал контент бүтээх чиглэл туссан болно. https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140710682191<br>Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА)-тай хамтран Кибер аюулгүй байдлын чиглэлээр 15 богино хэмжээний контент болон 2 нэвтрүүлгийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба болон Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ-ын цахим хуудас болон youtube сувгаар дамжуулан иргэд, олон нийтэд түгээсэн. Олон улсын эрүүгийн цагдаагийн байгууллага-Интерполын #ThinkTwice #ДахинНягтал аянд нэгдэж байна. Ransomware буюу компьютер, гар утас, таблет зэрэг цахим төхөөрөмжид хадгалагдаж байгаа халдлага зөрчлийн талаар олон нийтэд видео контент хүргэсэн. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдөр Баянхошуу Бизнес инкубатор, сургалт үйлдвэрлэлийн төвд "Өсвөр үеийнхэнд зориулсан цахим аюулгүй байдлын воркшоп" зохион байгуулсан ба Сонгинохайрхан дүүргийн ахлах ангийн 40 сурагчийг хамруулсан.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 169 | 273 | 2023 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр 36 дугаар тэмдэглэл 2023-09-06 Дугаар 2023_36 | XIII.7.4. Монгол Улсын талаар болон Монголоос олон улсын зах зээлд нийлүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Сангийн сайд Б.Жавхлан, Соёлын сайд Ч.Номин, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт тус тус даалгав. | БНХАУ-ын цахим худалдааны хаб Ханжоу хотноо 2023 оны 11 дүгээр сарын 22-24-ны өдрүүдэд Төв Азийн Эдийн Засгийн Хамтын ажиллагаа (CAREC)-ны гишүүн 10 улсын 200 гаруй төлөөлөгчид чуулж, бүс нутгийн цахим худалдааны экосистем бүрдүүлж, цахим эдийн засгийн коридор байгуулахад шаардлагатай технологиудтай танилцаж, бодлогын шийдлүүдийг хэлэлцэв. Монгол Улсаас Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Жижиг дунд үйлдвэрийн газар, Говь ХК, APU ХХК, Lhamour, Airee зэрэг үйлвэрлэгч компаниуд, Shoppy, Intelmind, Fibo Cloud, Erxes, Go Lab зэрэг технологийн компаниуд төдийгүй тээвэр ложистикийн тэргүүлэгч компаниудын нэг Ти Ай Ложистик ХХК төлөөлөгчид оролцсон. Бүс нутгийн цахим худалдааны сүлжээнд холбогдож, хамтын ажиллагааны боломж эрэлхийлэх зорилго бүхий тус айчлалын хүрээнд төлөөлөгчид Ant International, Alibaba-ийн төвөөр зочилж, цахим худалдааны экосистемийг хөгжүүлэх сургалтад хамрагдаж, Ханжоу хил дамнасан цахим худалдааны тусгай бүс, Freshippo хиймэл оюун ухаанд суурилсан, бүрэн автоматжсан супермаркет, Alibaba-ийн олон улсын цахим худалдааны ухаалаг агуулах Cainiao зэрэг байгууллагуудаар зочилж, туршлага судлав. Мөн төлөөлөгчид цахим худалдааны экосистемд оролцогч 800 орчим компаниуд үзэсгэлэн гаргаж, 50,000 орчим зочид цугласан Global Digital Trade Expo-д оролцож, хамтын ажиллагааны санал солилцож байна. CAREC International Innovation Conference үеэр Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх Б.Тэмүүлэн Монгол Улсад цахим эдийн засаг хөгжүүлэх “Mining to Mind стратеги болон бүс нутгийн хамтын ажиллагааны боломж” танилцуулж, Gobi, Airee зэрэг байгууллагууд өөрсдийн бүтээгдэхүүн үйлчилгээг танилцуулж оролцсон. Мөн жил бүр Харилцаа холбоо, мэдээллийн технологийн олон улсын хамгийн том арга хэмжээ “Дэлхийн үүрэн холбооны конгресс ” /Mobile world congress/-д Монгол Улсын Харилцаа холбоо, мэдээллийн технологийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагуудын төлөөлөл оролцон бүтээгдэхүүн үйлчилгээгээ олон улсад сурталчлан таниулан ажиллаж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 170 | 274 | 2023 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр 37 дугаар тэмдэглэл 2023-09-13 Дугаар 2023_37 | XV.9.. “Нээлттэй засаглалын түншлэл” олон улсын чуулга уулзалтын талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан Монгол Улсад цахим шилжилтийг эрчимжүүлэх, мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих асуудлыг судалж, холбогдох саналаа Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд даалгав. | Монгол Улсад цахим шилжилтийг эрчимжүүлэх, мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих асуудлыг судалж, хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хурдалдаанаар Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг хэлэлцүүлэн батлуулсан. Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх үндэсний зөвлөлийн 2025 оны 03 дугаар тогтоолоор “Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх стратеги” төлөвлөгөөг батлуулсан. Тус хуулийн 13 дугаар зүйлд тусгасан татварын болон татварын бус нийт 9 төрлийн дэмжлэгийг мэдээллийн технологийн аж ахуйн нэгжид үзүүлэх ажлыг бодитоор хэрэгжүүлэх зорилгоор “Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх үндэсний зөвлөл, түүний бүрэлдэхүүн, ажиллах журам”-ыг боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 97 дугаар тогтоолоор Үндэсний зөвлөлийг байгуулсан. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 13.4-т заасны дагуу “Виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд үзүүлэх татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх журам”-ын төслийг боловсруулан Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх Үндэсний зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн хурлад танилцуулан хэлэлцүүлсэн. Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 17-ны хуралдаанаар "Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн ажиллах журам", "Виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх журам"-ыг тус тус батлуулсан. Их өгөгдлийг хиймэл оюунд зориулан боловсруулах, мөн хиймэл оюуныг шийдлийг тэргүүлэх салбаруудад нэвтрүүлэн төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх боломжийг тусгасан.<br><br>Хавсралт : 4 файл | Хэрэгжсэн - 100% | Тийм | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 171 | 275 | 2023 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр 39 дүгээр тэмдэглэл<br>2023-09-26<br>Дугаар 2023_39 | XVIII.1.10. Зураг төсөл нь батлагдсан, газар эзэмших, ашиглах зөвшөөрөлтэй, инженерийн дэд бүтэц нь шийдэгдсэн барилга, байгууламжийн төслийг улсын төсвөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналд тусгаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт; | Тус яамнаас нийт 7 барилга байгууламжийн шинэ төсөл, арга хэмжээг улсын төсвөөр хэрэгжүүлэх саналыг Сангийн яаманд 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 01/25 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Үүнээс 5 төсөл, арга хэмжээ нь нэг маягийн зурагтай, 2 төсөл, арга хэмжээ зураг төсөл батлагдаагүй байна. /Газар эзэмших болон ашиглах зөвшөөрөлгүй, инженерийн дэд бүтэц нь шийдэгдээгүй./<br><br>Хавсралт : 2 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 172 | 276 | 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр 45 дугаар тэмдэглэл<br>2023-11-08<br>Дугаар 2023_45 | XI.1.2. Хөгжлийн бодлогын төлөвлөлт, тайлагналт, хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн цахим системийг одоогийн цахим системд тулгуурлан хөгжүүлэх боломжийг судалж, танилцуулахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд даалгав | Хууль, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт үнэлгээний системийн сайжруулалт зөвлөхөөс бусад үйлчилгээний тендерийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим хуудас (www.tender.gov.mn)-д 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдөр нээлттэй байршуулж, 10 дугаар сарын 30-ны өдөр тендерийг нээсэн. Тус тендерт оролцогч байхгүй байсан тул тендер амжилтгүй болсон. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг 2025 оны 43 дугаар тогтоолоор шинэчлэгдсэн бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас 2025 оны 01/103 дугаар албан бичгээр "Олон улсын үнэлгээний цогц систем"-ийг Дэлхийн банкны "Ухаалаг засаг 2" төслийн хүрээнд хэрэгжүүлэх саналаа ирүүлсэн. Саналыг "Ухаалаг засаг 2" төслийн худалдан авалтын төлөвлөгөөнд тусгасан бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас "Олон улсын үнэлгээний цогц систем"-ийн ажлын даалгаврыг боловсруулан Дэлхийн банкаар хянуулан ажиллаж байна.<br><br>Хавсралт : 1 файл | Тодорхой үр дүнд хүрсэн - 50% | Үгүй | |
| 173 | 277 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдааны 1 дүгээр тэмдэглэл<br>2024-01-03<br>Дугаар 2024_1 | 7.1.6. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын холбогдох байгууллагатай байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгүүдийн хэрэгжилтийн явц, тайланг хагас жил тутам Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлж ажиллахыг холбогдох сайд нарт | Бүгд Найрамдах Хятад Ард Улсын холбогдох байгууллагатай байгуулсан харилцан ойлголцлын санамж бичигт тус яамнаас хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээ байхгүй болно. БНХАУ-ын Худалдааны яамнаас 2024 оны 03, 09, 11 сард зохион байгуулсан “Цахим худалдаа” сэдэвт сургалтад Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 8 албан хаагч оролцсон ба тус сургалтад 2025 оны 4 дүгээр сард 6 албан хаагч тус тус хамрагдсан. БНХАУ-д зохион байгуулагдсан арга хэмжээнд оролцож эх орны бүтээгдэхүүн үйлчилгээг танилцуулсан. | Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй | Үгүй | |
| 174 | 278 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 9 дүгээр тэмдэглэл<br>2024-03-06<br>Дугаар 2024_9 | 31.5. Үүнтэй холбогдуулан улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн болон болзошгүй гамшгийн эрсдэлийн бэлэн байдлын үед нэрвэгдэж болзошгүй иргэдэд мэдээлэл хүргэх, харилцаа холбооны тасралтгүй байдлыг хангах зорилгоор төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн мэдээлэл, харилцаа холбооны гадаад, дотоод сүлжээний дэд бүтцийг шийдвэрлэх, интернэт урсгалын хурдыг нэмэгдүүлэх, алслагдсан дүүрэг, сум, багийн сургуулийг нөөц эх үүсвэртэй болгох асуудлыг судалж, зохих арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт нарт даалгав.(Боловсролын салбарын нэгдсэн сүлжээний өнөөгийн нөхцөл байдлын талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав) | БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Харилцаа холбооны салбарын хүртээмж, чанар, хяналтыг сайжруулах төсөл” /2025-2026 он/-ийн хүрээнд сумдын өндөр хурдны шилэн сүлжээний дамжуулах байгууламжийн хүчин чадлыг 10 дахин нэмэгдүүлэхээр ажиллаж байна. Үүнд: БНХАУ-ын төслийг хэрэгжүүлж буй талаас Монгол Улсад ирж, Сангийн яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай 2025 оны 04 дүгээр сард уулзалт хийж, төслийн талаар баталгаажуулсан. Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн зүгээс хөнгөлөлттэй зээлийн 5%-ийг шилжүүлсэн. Төслийн байгаль орчны үнэлгээний судалгаа, барилгын ерөнхий төлөвлөлтийн зураг боловсруулж дууссан.<br>Төслийн гүйцэтгэл төлөвлөгөөний дагуу ахиж, дараах үндсэн ажлууд хийгдсэн байна. Үүнд:<br>•EMC болон RF туршилтын лабораторийн төлөвлөлтийн зураг гурван удаа шинэчлэгдэн баталгаажуулсан;<br>•Радио мониторингийн тогтмол болон бүсийн хяналтын төвүүдийн зураг төслийн судалгаа, талбайн инженерийн хэмжилтүүд ашиглалтын болон гүйцэтгэгч талаас хамтран гүйцэтгэгдсэн;<br>•Гүйцэтгэгч болон зохицуулах байгууллагын инженерүүд БНХАУ-ын Чэнду хотод тоног төхөөрөмжийн үйлдвэрийн хяналт-шалгалт, тохиргооны үнэлгээ хийсэн;<br>•Шилэн кабелийн ерөнхий трассын зураглал баталгаажиж, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ дууссан;<br>•PTN, DWDM системүүд болон шилэн кабелийн материалын худалдан авалтын захиалгууд бүрэн хийгдэж, үйлдвэрлэл, нийлүүлэлт болон суурилуулалтын хуваарийн дагуу явагдаж байна. | Тодорхой үр дүнд хүрсэн - 50% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 279 | | 14.2.3.. Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн хүрээнд гааль, хилийн байгууллагуудын хяналт удирдлагын нэгдсэн систем хөгжүүлэх ажлыг эрчимжүүлж, ажиллахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт даалгав.” | Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон "И-Монгол академи" УТҮГ-ын албан хаагчид 2023 оны 08 дугаар сарын 01-04-ний өдөр Дорноговь аймгийн Замын-Үүд суманд ажиллаж, Хилийн боомт дахь хил хяналтын байгууллагуудын үйл ажиллагааны зураглал хийж, тулгамдаж буй асуудлыг тодорхойлсон. Мөн тус аймгийн Засаг даргын Тамгын газарт ажиллан цахим шилжилтийн чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар судалгааг хийж гүйцэтгэсэн. Судалгааны үр дүнд үндэслэн Замын-Үүд суманд цахим шилжилт хийх төслийн баримт бичгийг, төсвийн төсөөллийн хамт боловсруулсан. Хилийн боомтын захиргаанаас 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 23/247 дугаар албан бичгээр “Хилийн боомтын мэдээллийн нэгдсэн систем”-д зөвлөмж, дүгнэлт авах хүсэлтийг тус яаманд ирүүлсний дагуу дүгнэлт, зөвлөмжийг боловсруулан 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 03/2367 дугаар албан бичгээр хариу хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 1 файл | Тодорхой үр дүнд хүрсэн - 50% | Үгүй | |
| | 280 | | 14.8.<br>Үүнтэй холбогдуулан Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны 06 дугаар тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээд, компани, үйлдвэрийн газрын захирал, дарга нарт, үр дүнг нэгтгэж 2024 оны 06 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд тус тус даалгав.” (Үндэсний судалгааны нэгдсэн платформын ажлын явцын талаар ) | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/88 дугаар тушаалаар төрийн байгууллагуудын захиалгаар хийгдсэн судалгаа, зөвлөх үйлчилгээний тайлангуудыг олон нийтэд нээлттэй болгох, давхцалыг арилгах, төсвийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, Үндэсний судалгааны нэгдсэн систем (sudalgaa.gov.mn)-ийг хөгжүүлж, 2023 оны 6 дугаар сард хэрэглээнд нэвтрүүлсэн. Тус системийн тасралтгүй, найдвартай үйл ажиллагааг И-Монгол академи УТҮГ ханган ажиллаж байна. Судалгааны санд 1308 хэрэглэгч бүртгэлтэй бөгөөд 2306 судалгааг нээлттэй байршуулсан байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар тус системд 11569 хандалт хийгдсэн байна. Судалгааны сангийн нэгдсэн системийг ашиглах журам, хэрэглэгчийн зааварчилгааг боловсруулан баталж, мөрдүүлэх ажлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хариуцан ажиллаж байна. https://sudalgaa.gov.mn/ | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 175 | 281 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 12 дугаар тэмдэглэл<br>2024-03-27<br>Дугаар 2024_12 | 14.14.3.. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн систем “И-Монголиа”-д нэгтгэх ажлыг үе шаттай зохион байгуулах арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзоригт, дэмжлэг үзүүлж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал;(Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 206 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн үйл ажиллагааны хүрээнд эрүүл мэндийн цахим шилжилтийг эрчимжүүлэх ажлын хүрсэн үр дүнгийн талаар ) | Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн чиглэлээр хийсэн ажлын үр дүнг ЗГ-ын 2024.03.26, 07.24-ний өдрийн хуралдаанд танилцуулсан. Эрүүл мэндийн төрөлжсөн мэдээллийн санг үүсгэж, “ХУР”-д 24 шинэ сервисийг нэвтрүүлсэн, 2025.06.24-ний өдрийн байдлаар 443 эмнэлэг холбосон. Иргэнээс зөвшөөрөл авах нөхцөлийг SMS (OTP), хурууны хээ, Push notification, G-Sign хэлбэрээр бүрдүүлсэн. Эмнэлгийн систем хөгжүүлэгч компаниудтай гэрээ байгуулан, VPN, API-г тохируулж, ХУР, Мэдэгдлийн системийн төлбөрийг 2025 оныг дуустал чөлөөлсөн. И-Монгол системд эрүүл мэндийн 25 үйлчилгээг нэвтрүүлэн ба 37 сая мэдэгдлийг хүргэж, 1.4 сая хандалтыг авсан. Цахим эрүүл мэндийн нөхцөл байдлын үнэлгээний судалгааг 325 байгууллагаас авч, үр дүнг нээлттэй байршуулсан. ЭМТХ-ийн 8.4, 8.10 дахь хэсэгт заасан журмыг ЗГ-ын 2024 оны 100 дугаар тогтоол, ЭМС, ЦХИХХС-ын хамтарсан 2025.04.16-ны өдрийн А/130, А/58 тушаалаар батлуулан 2025.05.13-ны өдөр захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн. Эрүүл мэндийн 109 байгууллагын 111 rack, 67 VPS, 153 mail, 137 website, 293 domain-ны үйлчилгээг ҮДТ-өөс үзүүлж байна. “Төрийн бүтээмжийн сэргэлт-Цахим эрүүл мэнд” үндэсний зөвлөлдөх уулзалтыг 2024.04.08,09-нд 150 байгууллагын 380 ажилтанд /digitalhealth.gov.mn/, сургалтыг 2024.04.16-нд анхан шатлалын байгууллагын 200 төлөөлөлд, 2024.05.04-24-нд 21 аймаг, нийслэлд зохион байгуулж эрүүл мэндийн ажилтнуудыг хамруулсан. Монгол Улсын “Цахим эрүүл мэнд”-ийн цогц арга хэмжээний төлөвлөгөө (2025-2028)-г хэлэлцэх уулзалт, хэлэлцүүлгийг НҮБ-ын Хүүхдийн Сангийн дэмжлэгтэйгээр 2025.04.10, 11-ний өдрүүдэд 20 байгууллагын 52 албан хаагчийн дунд зохион байгуулсан. “Эрүүл мэндийн салбарын дижитал шилжилтийн цогц арга хэмжээний төлөвлөгөө”-г ЭМС, ЦХИХХС-ын хамтарсан 2025.05.24-ний өдрийн А/201, А/81 тушаалаар баталсан. Хэлэлцүүлэг, уулзалтын тайланг оролцогч 20 байгууллагад 2025.06.05-ны өдрийн 02/1348, ЗГЭХГ-т 2025.05.20-ны өдрийн 01/1195 албан бичгээр хүргүүлж, ИЦББХ-ны 2025.05.28-ны өдрийн хурлаар танилцуулсан.<br><br>Хавсралт : 2 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 282 | | 14.14.5.. Эрүүл мэндийн төрөлжсөн мэдээллийн сан хооронд мэдээлэл солилцоход мэргэжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлж ажиллахыг “И-Монгол академи” УТҮГ (Б.Мягмарнаран), “Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв” УҮГ (Т.Батбилэг)-т.” | Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн чиглэлээр хийсэн ажлын үр дүнг ЗГ-ын 2024.03.26, 07.24-ний өдрийн хуралдаанд танилцуулсан. Эрүүл мэндийн төрөлжсөн мэдээллийн санг үүсгэж, “ХУР”-д 24 шинэ сервисийг нэвтрүүлсэн, 2025.06.24-ний өдрийн байдлаар 443 эмнэлэг холбосон. Иргэнээс зөвшөөрөл авах нөхцөлийг SMS (OTP), хурууны хээ, Push notification, G-Sign хэлбэрээр бүрдүүлсэн. Эмнэлгийн систем хөгжүүлэгч компаниудтай гэрээ байгуулан, VPN, API-г тохируулж, ХУР, Мэдэгдлийн системийн төлбөрийг 2025 оныг дуустал чөлөөлсөн. И-Монгол системд эрүүл мэндийн 25 үйлчилгээг нэвтрүүлэн ба 37 сая мэдэгдлийг хүргэж, 1.4 сая хандалтыг авсан. Цахим эрүүл мэндийн нөхцөл байдлын үнэлгээний судалгааг 325 байгууллагаас авч, үр дүнг нээлттэй байршуулсан. ЭМТХ-ийн 8.4, 8.10 дахь хэсэгт заасан журмыг ЗГ-ын 2024 оны 100 дугаар тогтоол, ЭМС, ЦХИХХС-ын хамтарсан 2025.04.16-ны өдрийн А/130, А/58 тушаалаар батлуулан 2025.05.13-ны өдөр захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн. Эрүүл мэндийн 109 байгууллагын 111 rack, 67 VPS, 153 mail, 137 website, 293 domain-ны үйлчилгээг ҮДТ-өөс үзүүлж байна. “Төрийн бүтээмжийн сэргэлт-Цахим эрүүл мэнд” үндэсний зөвлөлдөх уулзалтыг 2024.04.08,09-нд 150 байгууллагын 380 ажилтанд /digitalhealth.gov.mn/, сургалтыг 2024.04.16-нд анхан шатлалын байгууллагын 200 төлөөлөлд, 2024.05.04-24-нд 21 аймаг, нийслэлд зохион байгуулж эрүүл мэндийн ажилтнуудыг хамруулсан. Монгол Улсын “Цахим эрүүл мэнд”-ийн цогц арга хэмжээний төлөвлөгөө (2025-2028)-г хэлэлцэх уулзалт, хэлэлцүүлгийг НҮБ-ын Хүүхдийн Сангийн дэмжлэгтэйгээр 2025.04.10, 11-ний өдрүүдэд 20 байгууллагын 52 албан хаагчийн дунд зохион байгуулсан. “Эрүүл мэндийн салбарын дижитал шилжилтийн цогц арга хэмжээний төлөвлөгөө”-г ЭМС, ЦХИХХС-ын хамтарсан 2025.05.24-ний өдрийн А/201, А/81 тушаалаар баталсан. Хэлэлцүүлэг, уулзалтын тайланг оролцогч 20 байгууллагад 2025.06.05-ны өдрийн 02/1348, ЗГЭХГ-т 2025.05.20-ны өдрийн 01/1195 албан бичгээр хүргүүлж, ИЦББХ-ны 2025.05.28-ны өдрийн хурлаар танилцуулсан.<br><br>Хавсралт : 2 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 176 | 283 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдааны 13 дугаар тэмдэглэл<br>2024-04-03<br>Дугаар 2024_13 | 22.6.1.. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулах, эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашгийн талаар мэдээллийг олон нийтэд сурталчлан таниулах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу тус тус авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт;(.Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн 2024 оны 1 дүгээр улирлын явц, гүйцэтгэлийн талаар) | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын багцад шилжих 2, шинээр хэрэгжих 9 нийт 11 төсөл, арга хэмжээнд 16,423.0 сая төгрөгийн төсөв батлагдсан. Шинээр хэрэгжиж буй төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 409 дүгээр тогтоол, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/140 дүгээр тушаалаар тус тус Увс, Хөвсгөл аймаг, мөн ТЕЗ-ын харьяа шууд захирагч нарт эрх шилжүүлэн зохион байгуулж, гэрээ байгуулан ажиллаж байна. Тайлант онд 316.6 сая төгрөгийн гүйцэтгэлийг санхүүжүүлсэн. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 284 | | 20.6.2. Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим системийг шинэчлэн хөгжүүлэх ажлыг 2024 оны 6 дугаар сард багтаан хэрэгжүүлэхийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд нарт; | Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас 2025 оны 01/103 дугаар албан бичгээр "Олон улсын үнэлгээний цогц систем"-ийг Дэлхийн банкны "Ухаалаг засаг 2" төслийн хүрээнд хэрэгжүүлэх саналаа ирүүлсэн. Саналыг "Ухаалаг засаг 2" төслийн худалдан авалтын төлөвлөгөөнд тусгасан бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас "Олон улсын үнэлгээний цогц систем"-ийн ажлын даалгаврыг боловсруулан Дэлхийн Банкаар хянуулан ажиллаж байна.<br><br>Хавсралт : 1 файл | Тодорхой үр дүнд хүрсэн - 50% | Үгүй | |
| | 285 | | 20.2. Үүнтэй холбогдуулан хууль тогтоомжийн төслийг боловсруулж, зохих журмын дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүдэд үүрэг болгов.” (Нийслэл хотын эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх, бие даан хөгжих баталгаагаар хангах хүрээнд хотын эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор боловсруулж байгаа хууль тогтоомжийн төслийн талаар Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Б.Дэлгэрсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав.) | Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас яамдын Төрийн нарийн бичгийн даргын бүрэлдэхүүнтэй “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг шинэчлэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж, эхний ажлын хэсгийн хуралдаанаар хариуцан гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг гаргаж, тус яамнаас холбогдох саналыг тусгасан. Мөн тус яамны худалдан авах ажиллагааны хүрээнд Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/186 дугаар "Үнэлгээний хороо байгуулах тухай" тушаалаар байгуулж, "үнэлгээний системийн сайжруулалт"-ын ажлын даалгаврыг боловсруулж, тендер зарласан боловч оролцогч шалгараагүй. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” нь 2025 оны 43 дугаар тогтоолоор шинэчлэгдсэн бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас 2025 оны 01/103 дугаар албан бичгээр "Олон улсын үнэлгээний цогц систем"-ийг Дэлхийн банкны "Ухаалаг засаг 2" төслийн хүрээнд хэрэгжүүлэх саналаа ирүүлсэн. Саналыг "Ухаалаг засаг 2" төслийн худалдан авалтын төлөвлөгөөнд тусгасан бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас "Олон улсын үнэлгээний цогц систем"-ийн ажлын даалгаврыг боловсруулан Дэлхийн Банкаар хянуулан ажиллаж байна.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 177 | 286 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны 15 дугаар тэмдэглэл<br>2024-04-17<br>Дугаар 2024_15 | 20.11.2. Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-ийн 2.0 хувилбарыг нэвтрүүлж, холбогдох сургалтыг зохион байгуулж, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэхийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд; | Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-ийн 2.0 хувилбарыг 2024 онд нэвтрүүлж мэдээлэл хариуцагч өөрийн байгууллагын цахим хуудас дахь ил тод байдлын хэрэгжилтийг илгээх нөхцлийг бүрдүүлсэн. Мэдээлэл хариуцагчаас ирүүлсэн 6,090 хуудас мэдээллийн архивын материалыг нийт мэдээллийг машинд уншигдах хэлбэрээр бэлдэж 2023 оны 01/2240 дугаар албан бичгээр Авлигатай тэмцэх газарт, хэрэгжилтийг УИХ-д танилцуулахаар 2024 оны 01/858 дугаар албан бичгээр Ерөнхий сайдын Ажлын албанд, мөн 2024 онд 01/1142 дугаар албан бичгээр Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, "Шилэн индекс"-ийг үнэлгээг хянан баталгаажуулах, холбогдох сургалтыг зохион байгуулах чиглэлийг 2024 оны 01/1147 дугаар албан бичгээр Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газарт, системд хандах эрх олгох, сургалтад хамруулах тухай 2024 оны 01/817 дугаар албан бичгийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлэн ажилласан. Тус системд 2025 оны 3 дугаар улирлын байдлаар 4583 байгууллагыг бүртгэн, 5,113 албан хаагчид системд хандах эрх олгоод байна. 2025 оны жилийн эцсийн тайлангийн үнэлгээ хийгдэж байна.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 287 | | 20.11.3. Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-ээс мэдээлэл хайх, авах үйлдлийг хөнгөвчлөх зорилгоор хиймэл оюуны хувилбарыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд | "Нээлттэй мэдээллийн систем (www.shilen.gov.mn)"-ийн 2.0 хувилбарыг ашиглалтад нэвтрүүлсэн. АМТ зөвшөөрлийн мэдээллийн санд хиймэл оюуны сүүлийн үеийн (GPT) технологийг сургаж, ашиглалтад оруулсан. Тус системд 2025 оны 3 дугаар улирлын байдлаар 4039 байгууллагыг бүртгэн, 4,557 албан хаагчид системд хандах эрх олгоод байна. "Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем (opendata.gov.mn)-ийн 3.0 хувилбарыг нэвтрүүлэх" ЦХИХХЯ/20250103045 дугаар төсөл, арга хэмжээний худалдан авах нээлттэй тендерийг 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр зарлаж Гөү Смарт ТМ ХХК шалгарч гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлийг 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 02/1462 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж батлагдсан. Төсвийн тодотголоор тус яамны урсгал зардлын хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний санхүүжилт хасагдаж, санхүүжилтийн эх үүсвэргүй болсон. Санхүүжилтгүй болсон тухай мэдэгдлийг 2025 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 02/1724 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 288 | | 20.11.4. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ хийх үйл ажиллагааг "Шилэн индекс"-тэй уялдуулан зохион байгуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт." | Мэдээлэл хариуцагч байгууллага өөрийн байгууллагын нээлттэй мэдээллийн үнэлгээг тухай бүр шинэчлэх, илгээх нөхцөлийг бүрдүүлэхээр Нээлттэй мэдээллийн систем (www.shilen.gov.mn)-ийн 2.0 хувилбарыг 2024 онд ашиглалтад нэвтрүүлсэнтэй холбогдуулан 67 нээлттэй мэдээллийг улирал бүр үнэлж "Шилэн Индекс"-ийг тухай бүр нийтэлж байна. Тус системд 2025 оны 3 дугаар улирлын байдлаар 4583 байгууллагыг бүртгэн, 5,113 албан хаагчид системд хандах эрх олгоод байна. 2025 оны жилийн эцсийн тайлангийн үнэлгээ хийгдэж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 178 | 289 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны 17 дугаар тэмдэглэл<br>2024-05-01<br>Дугаар 2024_17.1 | 20.4.. Гадаад улсаас ирж буй иргэдийг хилээр нэвтрүүлэх үйлчилгээг технологийн дэвшлийг ашиглан шуурхай, нэг цэгийн үйл ажиллагаанд шилжүүлэх асуудлыг судлан танилцуулахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр нарт тус тус даалгав. | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia)-д улсын хилээр нэвтэрсэн иргэний лавлагааг олгож байна. Тус лавлагаа нь визний материал бүрдүүлэх, эрүүл мэнд, нийгмийн даатгал, татвар, банк санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, орон сууцны корпораци, орон сууц, нийтийн аж ахуйн контор, гэр бүл цуцлуулах, цэрэг татлагатай холбоотой нийслэл, аймаг, дүүргүүдийн Цэргийн штаб гарган өгөх зэрэг шаардлагад нийцэж байна. https://e-mongolia.mn/service/ulsyn-khileer-nevtersen-irgenii-lavlagaa | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 179 | 290 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн хуралдааны 18 дугаар тэмдэглэл 2024-05-08 Дугаар 2024_18.1 | 18.17.2.. Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан нарт даалгав. | Тус хууль нь Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх хүрээний асуудалд тусгагдаагүй болно. | Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй | Тийм | Чиг үүрэгт хамааралгүй тул хасах саналтай. |
| | 291 | | 19.3.2.. Уг төлөвлөгөөнд туссан үйл ажиллагааг эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэрийн хүрээнд хэрэгжилтийг зохион байгуулах, шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хүрээнд шийдвэрлэж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн холбогдох байгууллагын төсвийн шууд захирагч нарт даалгав. | Тус хууль нь Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх хүрээний асуудалд тусгагдаагүй болно. | Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй | Тийм | Хяналтаас хасуулах саналтай |
| 180 | 292 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны 19 дүгээр тэмдэглэл 2024-05-15 Дугаар 2024_19.1 | 22.2.4.. Эрхэлсэн салбар, хариуцсан чиг үүргийн хүрээнд хэлэлцээний үйл ажиллагаанд зохих дэмжлэгийг үзүүлж, Хэлэлцээний багийн бүрэлдэхүүнд ажиллаж байгаа яам, агентлагийн албан хаагчдын идэвх, оролцоог хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав | Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс хоорондын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн хүрээнд Гадаад харилцааны яамнаас 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсан Үйлчилгээний бүлгийн ажлын хэсгийн уулзалтад оролцож, БНСУ-ын Сөүл хотноо 2023 оны 12 дугаар сард зохион байгуулсан эхний шатны хэлэлцээрийн талаар санал солилцов. Түүнчлэн 2024 оны 05 дугаар сарын сүүлээр Улаанбаатар хотноо зохион байгуулах хэлэлцээрийн бэлтгэл ажилд шаардлагатай мэдээлэл, саналыг Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран боловсруулсан. 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан Монгол Улс, БНСУ хооронд Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн “Үйлчилгээний худалдаа (Цахилгаан холбооны үйлчилгээ)”-ний хоёрдугаар шатны хэлэлцээрт хэлтсийн дарга Д.Батбаяр, ахлах шинжээч Б.Эрдэнэ нар оролцож, Бүгд Найрамдах Солонгос Улсын талаас ирүүлсэн хэлэлцээрийн төсөлд санал өгсөн. Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс хооронд байгуулах Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн Үйлчилгээний худалдааны хэлэлцээрт Харилцаа холбоо, Шуудан, Өргөн нэвтрүүлгийн салбарт тусгах саналыг боловсруулан баталгаажуулж, 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдөр bujinlkham.e@med.gov.mn цахим шуудангаар Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 293 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн хуралдааны 24 дүгээр | 12.5.2.. Эрүүл мэндийн салбарт цахим шилжилтийн олон улсын стандартыг нэвтрүүлэх, цогц арга хэмжээний төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү нар | Эрүүл мэндийн салбарт цахим шилжилтийн олон улсын стандартыг нэвтрүүлэх, цогц арга хэмжээний төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэхэд хэрхэн хамтран ажиллах талаар 2024 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 01/74 дүгээр албан бичгийг Эрүүл мэндийн сайдад хүргүүлсэн. Монгол Улсын “Цахим эрүүл мэнд”-ийн цогц арга хэмжээний төлөвлөгөө (2025-2028)-г хэлэлцэх уулзалт, хэлэлцүүлгийг НҮБ-ын Хүүхдийн Сангийн дэмжлэгтэйгээр 2025.04.10, 11-ний өдрүүдэд 20 байгууллагын 52 албан хаагч нарын дунд зохион байгуулсан. Үүнтэй холбогдуулан 2025 оны 03/03 бичгийг Эрүүл мэндийн яаманд, 03/07 дугаартай албан бичгийг оролцогч байгууллагуудад, 03/24 албан бичгийг УТҮГ-уудад, 02/749 тоот бичгийг И Монгол академи УТҮГ-т тус тус хүргүүлж, урьдчилсан бэлтгэл ажлыг хангаан ажилласан. Хэлэлцүүлгийн үр дүнд “Монгол Улсын эрүүл мэндийн салбарын дижитал шилжилтийн цогц арга хэмжээний төлөвлөгөө”-г Эрүүл мэндийн сайд, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын хамтарсан 2025.05.24-ний өдрийн А/201, А/81 дүгээр тушаалаар баталсан. Хэлэлцүүлэг, уулзалтын тайланг нэгтгэн боловсруулж, оролцогч 20 байгууллагад 2025.06.04-ний өдрийн 02/1348 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 2 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 181 | 294 | өдрийн хуралдааны 24 дүгээр тэмдэглэл<br>2024-07-24<br>Дугаар 2024_24 | 12.5.3.. Эрүүл мэндийн байгууллагуудад кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, аудит хийлгэх ажлыг зохион байгуулахыг Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайханд, дэмжлэг үзүүлж ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү нар | Эрүүл мэндийн байгууллагуудын кибер аюулгүй байдлыг хангах хүрээнд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий байгууллагуудтай 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр, эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, протез үйлдвэрлэх, худалдах, импортлох тусгай зөвшөөрөл бүхий байгууллагуудтай 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр тус тус уулзалт хийж, кибер аюулгүй байдлыг хангах хууль, журмын талаар танилцуулж, байгууллагын хэмжээнд кибер халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдээллийн аюулгүй байдлын аудит, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх талаар мэдээлэл хийсэн. Кибер аюулгүй байдлын тухай хуульд заасны дагуу төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагууд Тагнуулын байгууллагаар, эсхүл түүний зөвшөөрснөөр аудит, эрсдэлийн үнэлгээ хийх эрх бүхий байгууллагуудаар хийлгэнэ. Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын газраас хуваарь гаргаж, эрүүл мэндийн төвүүдэд кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг хийж байна. Мөн мэдээллийн технологийн аудит хийлгэх ажлыг эмнэлгүүд зохион байгуулж, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Хавдар судлалын үндэсний төв, Халдварт өвчин судлалын үндэсний төв зэрэг байгууллагууд аудит хийлгэж зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч байна. ЦХИХХСайдын зүгээс кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, аудит хийх тусгай зөвшөөрлийг хувийн хэвшлийн байгууллагуудад олгодог болно. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 182 | 295 | Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдааны 31 дүгээр тэмдэглэл<br>2024-09-04<br>Дугаар 2024_31 | 31.9.6. 1/ Төрийн байгууллагын “gov.mn” нэгдсэн цахим хуудаст иргэд, олон нийтийн саналыг авсны үндсэн дээр хөгжүүлэлт хийж, холбогдох төрийн байгууллагуудад сургалт зохион байгуулж, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг “И-Монгол академи” УТҮГ-т, техник хангамжийн бэлэн байдлыг хангаж, найдвартай үйл ажиллагаар хариуцаж ажиллахыг “Үндэсний дата төв” УТҮГ-т | Засгийн газрын нэгдсэн веб gov.mn цахим хуудсыг Е-Монголиа төрийн үйлчилгээний цахим платформд үндэслэн хөгжүүлж ашиглалтад орсон. “Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас gov.mn сургалтын хөтөлбөр”-ийг боловсруулан төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн Засаг даргын Тамгын газрын нэгдсэн цахим хуудасны үйл ажиллагааг хариуцан ажилладаг албан хаагч нарт танхимаар болон цахим хэлбэрээр 53 удаагийн сургалтыг зохион байгуулж 1416 байгууллагад хандах эрх олгосон. https://www.gov.mn/mn | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 296 | | 31.9.6. 3/ Төрийн байгууллагын “gov.mn” нэгдсэн цахим хуудсыг 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах арга хэмжээ авахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүд, энэ үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал нарт | Засгийн газрын нэгдсэн веб gov.mn цахим хуудсыг Е-Монголиа төрийн үйлчилгээний цахим платформд үндэслэн хөгжүүлж, ашиглалтад орсон. “Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас gov.mn сургалтын хөтөлбөр”-ийг боловсруулан төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн Засаг даргын Тамгын газрын нэгдсэн цахим хуудасны үйл ажиллагааг хариуцан ажилладаг албан хаагч нарт танхимаар болон цахим хэлбэрээр 53 удаагийн сургалтыг зохион байгуулж 1416 байгууллага(Төсвийн байгууллагын 25%)-д хандах эрх олгосон. 2024 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар нэгдсэн вэб хуудасны хөгжүүлэлтийн гүйцэтгэл, ашиглах журмыг хэлэлцүүлж, Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудасны талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын 2024 оны 208 дугаар тогтоолыг батлуулсан. 2025 оны 02 дугаар сараас төрийн байгууллагын нэгдсэн вэб хуудсыг нээлттэй мэдээллийн shilen.gov.mn системтэй уялдуулан хөгжүүлсэн. 2025 оны 9 дүгээр сарын 11, 12-ны өдөр админ түвшний сургалтыг төрийн захиргааны төв байгууллагууд болон төрийн захиргааны байгууллагуудад цахимаар хэлбэрээр хийж, байгууллагуудын эрхийг үүсгэж өгсөн. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 183 | 297 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн хуралдааны 35 дугаар тэмдэглэлд<br>2024-10-02<br>Дугаар 2024_35 | 14.2.1.. Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн үйл ажиллагааг Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагаатай уялдуулж, санал, хүсэлт хүлээн авах дуудлагын утсыг нэгтгэх техник, технологийн боломжийг судалж, шийдвэрлэх арга хэмжээг Сангийн сайд Б.Жавхлан, Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нартай хамтран хэрэгжүүлж, үр дүнг 14 хоногт багтаан танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учралд | 1.Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны А/42 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулан ажиллаж, үр дүнг Засгийн газрын 2024.11.27-ны өдрийн хуралдаанд танилцуулж, 41 дүгээр тэмдэглэлээр албажсан. 2.Иргэд, олон нийттэй харилцах төв “11-11”-ийн мэдээллийн системийг 2024.11.12-ны өдрөөс мэдэгдэл хүргэх системтэй холбож, мэдэгдэл хүргэдэг болсон. 3."Их өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт, нэгдсэн мэдээлэл хяналтын систем"-д 11-11, 101, 102, 103, 105 дугаарт ирүүлсэн дуудлага, түүний төрөл, шийдвэрлэлтийн статистик мэдээллийг “дашбоард” хэлбэрээр харах боломжийг бүрдүүлсэн. 4.Иргэдийн асуултад хариулах, хууль эрх зүйн зөвлөмж өгөх, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явцыг мэдээлэх чадвартай хиймэл оюунд суурилсан “IVA” системийг “11-11.mn” веб хуудсанд холбож, “Харилцагчийн үйлчилгээний хиймэл оюуны виртуал ажилтан, операторын үйлчилгээ”-г 2025.03.31-ний өдөр ЗГХЭГ-тай хамтран нэвтрүүлсэн. 5.Засгийн газрын “11-11”, нийслэлийн “1800-1200” дугаарын үйл ажиллагаанд ашиглаж буй мэдээллийн сан, системийг нэгтгэх шийдлийг боловсруулж, “API” сервисийн хөгжүүлэлт хийх чиглэлийг 2025 оны 02/1204 бичгээр И Монгол академид хүргүүлэн хөгжүүлэлтийн ажлыг эхлүүлсэн. ЗГХЭГ-ын Тэргүүн дэд даргын 2025.05.27-ны өдрийн 175 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдан III дугаар улиралд багтаан дуусгах үүргийг өгсөн. 6.Иргэдээс өргөдөл, гомдол, санал, хүсэлт хүлээн авдаг төрийн байгууллагын дуудлагын утсыг нэгтгэх технологийн шийдлийг судлан хамтран ажиллах 2025.06.13-ны өдрийн 02/1412 албан бичгийг ХХЗХ-нд, “11-11” төвд иргэдийн гадаад улсаас хийх дуудлагыг хүлээх авах боломжийг судалж, холбогдох саналыг 2025 оны 01/613 албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Явцын тайланг 2025.05.20-ны өдрийн 01/1195 албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлж, 2025.05.28-ны ИЦББХ-ны хурлаар танилцуулсан. 7."Өргөдөл, гомдлын нэгдсэн сан"-г үүсгэж, мэдээлэл дамжуулах API 6 сервисийг хөгжүүлж, нээлттэй байршуулан 17 ERP систем хөгжүүлэгчид холболт хийх талаар 2025.09.16-ны өдрийн 02/2142 албан бичгийг хүргүүлсэн<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 298 | | 14.3.2.. “Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуул” төслийн бэлтгэл ажлыг хангах, төслийн хэрэгжилтийг хариуцан ажиллах чиг үүргийг Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанд, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүд үүрэг болгов | Бүгд Найрамдах Франц Улсын Талес Алениа Спейс компани Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам хооронд байгуулах “Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуулын техникийн нөхцөлийг тодорхойлох, гэрээний төсөл боловсруулах” арилжааны гэрээний нөхцөлийг сайжруулах, гэрээний үнийн дүнг буулгах, гэрээний нөхцөлийг сайжруулах чиглэлээр ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд 2025 оны 03 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд Парис хотноо УИХ-ын гишүүн Ч.Анараар ахлуулсан ажлын хэсэг Талес Алениа Спейс компанитай уулзалт хийсэн. Уулзалтын мөрөөр арилжааны гэрээний саналыг шинэчилсэн байдлаар 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд ирүүлсэн. Шинэчилэн ирүүлсэн саналд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг ажиллаж, хариу санал боловсруулан Талес Алениа Спейс компанид 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр хүргүүлсэн. Бүгд найрамдах Франц Улсын Талес Алениа Спейс компани ЦХИХХЯ хооронд байгуулах “Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуулын техникийн нөхцөлийг тодорхойлох, гэрээний төсөл боловсруулах” арилжааны гэрээний нөхцөлийг сайжруулах, гэрээний үнийн дүнг буулгах, гэрээний нөхцөлийг сайжруулах чиглэлээр Талес Алениа Спейс компанитай хамтран ажиллаж байна. Францын Сангийн яамтай хийсэн хэлэлцээрийн дүнд Талес Алейна Спейс компаниас ирүүлсэн төслийн санхүүжилтийн саналын арилжааны зээлээр санхүүжүүлэх хэсгийг Засгийн газрын нэн хөнгөлөлттэй зээлд хамруулах тохиролцоонд хүрээд байна. /нууцын зэрэглэлтэй/ | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 299 | | 14.3.3.. “Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуул” төслийн оператор компаниар “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийг ажиллуулах асуудлыг судалж, холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Цахим хөгжил, инновац, харилцааны холбооны сайд Ц.Баатархүү нарт даалгав.” гэжээ | Төслийг хэрэгжүүлж эхлэх нь тодорхойгүй байх тул хяналтаас хасах саналтай байна. | Х.Б | Тийм | Төслийг хэрэгжүүлж эхлэх нь тодорхойгүй байх тул хяналтаас хасах саналтай байна. |
| 184 | 300 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны 38 дугаар тэмдэглэл<br>2024-10-30<br>Дугаар 2024_38 | 38.17.9.5. Боловсрол, шинжлэх ухаан, мэдээллийн технологи:<br>• Хоёр улсын Засгийн газры тэтгэлгээр Монгол, Казахстаны оюутан залуусыг их, дээд сургуульд харилцан сургах, бусад тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх,<br>• Шинжлэх ухаан, стратег судалгааны шилдэг туршлагыг харилцан солилцох, хамтран судалгаа, шинжилгээний ажил хийх,<br>• Цахим хөгжил, мэдээллий технологи, цахим засаглал, сансрын технологи, харилцаа холбооны салбарын чиглэлээр хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхийг Боловсролын яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд. | Монгол Улсын Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Бүгд Найрамдах Казахстан Улсын Цахим хөгжил, инновац, сансрын аж үйлдвэрийн яам хооронд харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарт хамтран ажиллах санамж бичгийг 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан. Энэхүү хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд Талууд үндэсний хэмжээний тулгамдсан асуудлуудыг харилцаа холбоо, мэдээллийн технологи ашиглан тодорхойлох, дүн шинжилгээ хийх, шийдвэрлэх чиглэлээр туршлага хуваалцах; Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын жижиг, дунд үйлдвэрлэл, инновац, гарааны бизнес эрхлэлтийг дэмжсэн хөрөнгө оруулалт татах чиглэлээр хамтран ажиллах;Шинэ болон нэн шинэ технологи, шинжлэх ухаан, өндөр технологийн чиглэлээр мэдээллийн технологийн парк, академи болон бусад байгууллагуудын сайн туршлагыг хуваалцах, хүний нөөцийг чадавхжуулах, мэргэжилтнүүдийг бэлтгэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, хамтран ажиллах, Хиймэл оюун, их өгөгдлийн шинжилгээ, өндөр хүчин чадалтай тооцоолол, блокчейн, зүйлсийн интернэт зэрэг нэн шинэ технологи, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарт хамтран ажиллах, хиймэл оюун дээр түшиглэсэн шийдлийг улсын байгууллагуудад нийлүүлдэг платформын талаар туршлага судлах талаар хамтран ажиллахаар зорьж байна. | Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50% | Үгүй | |
| | 301 | | 39.29.11.3. Энэ тэмдэглэлийн 2.1, 2.2, 2.3 дахь хэсэгт зааснаас гадна захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй байгаа өөрийн салбарын бусад шийдвэрийг дараах чиглэлээр хянан үзэж, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бичгээр хариу мэдэгдэхийг бүх шатны захиргааны байгууллагын удирдлагад даалгав:<br> (Үүнд :3.1.хүчингүй болсон тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх;<br>3.2. ач холбогдлоо алдсан, дага мөрдөгдөхгүй тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх;<br>3.3. нэмэлт, өөрчлөлт оруулсан бүх хэдэлгөөн хийгдээгүй тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх;<br>3.4. хууль тогтоомжтой давхардсан зөрчилдсөн тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх;<br>3.5. хуулиар тусгайлан эрх олгогдсо боловч батлаагүй тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх;<br>3.6. захиргааны хэм хэмжээний акты улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэлгүй даган мөрдөж байгаа тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх;<br>3.7. энэ тэмдэглэлийн 3.2, 3.4- заасан захиргааны хэм хэмжээний актын талаарх мэдээллийг хууль | 3.1.Тус яамнаас боловсруулсан 25 акт захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй байна. Тайлант хугацаанд Зөвшөөрлийн зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтийн дагуу зөвшөөрөлтэй холбоотой харилцааг зохицуулж байгаа салбарын сайдаас баталсан 2, ХХЗХ-оос баталсан 44 актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. ЦХХСайдын 2022 оны А/81 дүгээр тушаалаар баталсан “Гэрчилгээжүүлэх үйл ажиллагааны журамд тавигдах шаардлага”-ыг 2025 оны А/35 дугаар тушаалаар хүчингүй болгож, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2025 оны 1/1414 дугаар албан бичгээр захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд хасалт хийсэн талаар хариуг ирүүлсэн. 3.2.ХХЗХ-ноос баталсан 27 актыг хуулиар захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгогдоогүй, хуулиар олгосон эрхийг хэтрүүлсэн, Зөвшөөрлийн тухай хуулийг зөрчсөн, бизнес эрхлэгчдэд дарамт, тээг болсон шат дамжлага үүсгэсэн шинжтэй гэж үзэж зөрчилтэй актуудыг хуульд нийцүүлж, хүчингүй болгох арга хэмжээ авах талаар чиглэл хүргүүлсэн бөгөөд тус хорооноос 6 актыг бүхэлд нь, 8 актын 82 заалтыг тус тус хүчингүй болгосон талаар 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 01/289 дугаартай албан бичгээр мэдэгдээд байна. 3.3.Байхгүй 3.4.ЦХХСайдын 2022 оны А/30 дугаар тушаалаар баталсан “Тоон гарын үсгийн гэрчилгээний үндэсний санг бүрдүүлэх, ашиглах журам”-аар зохицуулж байгаа харилцаа нь ХХЗХ-ны 2022 оны 53 дугаар тогтоолоор баталсан “Тоон гарын үсгийн гэрчилгээний мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах, хадгалах журам”-аар зохицуулсан харилцаа давхардсан байх тул эдгээр журмыг нэгтгэн батлах зохицуулалтыг хуульд тусгах талаар Цахим гарын үсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулаад байна. 3.5.Хуулиар нийт 84 хэм хэмжээний акт батлах эрх олгогдсоноос Засгийн газар батлах 35 актаас баталсан 27, батлагдаагүй 8, Засгийн газрын гишүүн батлах 49 актаас баталсан 35, батлаагүй 14 акт байна. Дээрх 22 актын төслийг боловсруулах ажил хийгдэж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 302 | | 39.29.11.4. Дараах асуудлыг судалж, холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулан Засгийн газарт танилцуулахыг Засгийн газрын гишүүдэд даалгав.<br>( Үүнд:4.1. Хууль зүй, дотоод хэргий яамнаас хийсэн судалгаа болон захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлсэн шийдвэрүүдийг онол, арга зүйн хувьд нягтлан судалж, дүн шинжилгээ хийн Засгийн газрын 2023 оны 48 дугаар тэмдэглэлийн 4 дэх заалтаар өгөгдсөн захиргааны хэм хэмжээний актыг 2 дахин багасгах үүргийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх;<br>4.2. хуулийн төсөлд захиргааны хэ хэмжээний актаар зайлшгүй зохицуулах хэм хэмжээг тусгаҳдаа түүний агуулга, тавигдах шаардлагыг тодорхой зааж, хуулийн төсөлд заасан захиргааны хэм хэмжээний актын төслийг хамтад нь боловсруулж хэлэлцүүлэн, санал авч байх;<br>4.3. хуулиар тусгайлан эрх олгоогү асуудлаар захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр батлан гаргахгүй байх.<br>-ыг заалт бүрээр гаргаж тайлагнах ) | 4.1.Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/21 дүгээр тушаалаар сайдын эрхлэх асуудлын хүрээний хуулиар захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалтад дүн шинжилгээ хийх, тухайн харилцааг хуулиар зохицуулах шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Дэд ажлын хэсгийг яам болон Харилцаа холбооны зохицуулах хорооны төлөөллийг оролцуулан байгуулсан. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Харилцаа холбооны тухай, Шуудангийн тухай, Радио долгионы тухай, Өргөн нэвтрүүлгийн тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Цахим гарын үсгийн тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Кибер аюулгүй байдлын тухай, Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулиар захиргааны хэм хэмжээний акт батлах эрхийг Засгийн газарт олгосон 35, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдад олгосон 49, Харилцаа холбооны зохицуулах хороонд олгосон 23 зохицуулалтын хүрээнд сайд баталсан 51, Харилцаа холбооны зохицуулах хороо баталсан 46 хэм хэмжээний актад дүн шинжилгээ хийж, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор “Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цахим гарын үсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл”-ийг холбогдох хуулийн төслийн хамт боловсруулсан. 4.2.Хууль тогтоомжийн тухай хуулийн 271 дүгээр зүйлд заасан хуулийн төсөлд захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалт тусгахад тавих шаардлагыг хуулийн төслийг боловсруулахад мөрдөн ажиллаж байна. 4.3.Захиргааны ерөнхий хуулийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Тайлант үеийн байдлаар тус яамнаас хуулиар тусгайлан эрх олгогдоогүй асуудлаар захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргаагүй болно. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 303 | | 39.29.12.1. Кибер аюулгүй байдлыг хангахад зориулсан зардлыг төсвийн эдийн засгийн ангилалд тусгах асуудлыг судалж, шийдвэрлэхийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Сангийн сайд Б.Жавхлан нарт | Кибер аюулгүй байдлыг хангахад зориулсан зардлыг төсвийн эдийн засгийн ангилалд тусгах асуудлыг шийдвэрлүүлэхээр Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-т кибер аюулгүй байдлын зардлын ангиллыг шинээр нэмж тусгуулах санал, танилцуулгыг Сангийн сайдад 2024 оны 01/724, 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01/518 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлээд байна. Улмаар кибер аюулгүй байдлын зардлын зориулалтыг шинээр бий болгосон. 2026 оны төсвийн төсөлд салбарын хэмжээнд кибер аюулгүй байдлыг хангахад 4.5 тэрбум төгрөгийг зарцуулахаар төсвийн төсөлд тусгуулсан.<br><br>Хавсралт : 2 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 185 | 304 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны 39 дүгээр тэмдэглэл<br>2024-11-13<br>Дугаар 2024_39 | 39.29.12.2. Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын жагсаалт”-д нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судалж, саналаа Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүд; | Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын кибер аюулгүй байдлыг хангах өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлж, жагсаалтыг шинэчлэх суурь судалгааны асуулгыг 3 бүлэг 93 асуулттайгаар боловсруулсан. Судалгааны асуулга бүхий вэб хуудсыг хөгжүүлж, онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагуудад 2024 оны 03/710 дугаартай албан бичгийг хүргүүлж, судалгаа авсан. Судалгааны үр дүнгээс үзэхэд онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын жагсаалтад байгаа байгууллагуудын 77.5 хувь нь уг жагсаалтад багтах шаардлагатай гэж үзэж байгаа бол 22.5 хувь энэ жагсаалтаас хасуулах хүсэлтэй байсан. “Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын жагсаалт”-д нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/105 дугаар тушаалаар Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, хурлыг зохион байгуулсан. Ажлын хэсгийн гишүүд хамтран кибер аюулгүй байдлын тухай хуульд нийцүүлэн онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагад тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлсон. Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагыг үйл ажиллагааны чиглэлээр тодорхойлох нь оновчтой гэж үзсэн. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 305 | | 39.29.12.3. Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага кибер аюулгүй байдлыг хангах чиг үүргээ тодорхой албан тушаалтанд хариуцуулж, үйл ажиллагааны болон кибер аюулгүй байдлыг хангахад шаардагдах зардлыг жил бүрийн төсвийн төсөлд тусгаж байхыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт | Тус яам нь Засгийн газрын 2022 оны 207 дугаар тогтоолоор баталсан "Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын жагсаалт"-д багтаагүй. Байгууллагын кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг хариуцах албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг "Албан тушаалын тодорхойлолт батлах тухай" Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/263 дугаар тушаалын хавсралтаар баталсан.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 306 | | 39.29.11.1.2. эрхэлсэн асуудал, чиг үүргийнхээ хүрээнд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрүүдийг хууль тогтоомжийн өөрчлөлттэй уялдуулан дагаж мөрдөхгүй болсон, эрх зүйн үйлчлэлийн хугацаа дууссан, хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн, Хууль зүй, дотоод хэргийн сайдаас хүчингүй болгох дүгнэлт гаргаж хүргүүлсэн боловч хүчингүй болгоогүй, мөн хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын хүрээнд хуульд нийцүүлэхээр ажиллаж байгаа талаар хариу ирүүлсэн шийдвэрүүдийг дүгнэлтийн дагуу хүчингүй болгон, хуульд нийцүүлэх арга хэмжээг авч, 2025 оны 1 дүгээр улиралд багтаан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэх (1.1Захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн үр дүнгийн тайлан, цаашид авах арга хэмжээний талаар танилцуулсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн болон бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгож, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газрын бус бие даасан агентлаг болон эрх шилжүүлэн авсан нийтийн | Зөвшөөрлийн зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн өргөтгөсөн хуралдаанаас гарсан дүгнэлтийн дагуу зөвшөөрөл олгоход ач холбогдолгүй цаг хугацаа шаардсан, шат дамжлага үүсгэсэн баримт бичгийг хүчингүй болгох хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/81 дүгээр тушаалаар баталсан “Гэрчилгээжүүлэх үйл ажиллагааны журамд тавигдах шаардлага”-ыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/35 дугаар тушаалаар хүчингүй болгож, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангаас хасуулах хүсэлтийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 03/353 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/74 дүгээр тушаалаар баталсан “Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх этгээдийг бүртгэх, аудит хийх журам”-ыг сайдаас хүчингүй болгох шаардлагагүй гэж үзэн хэвээр үлдээсэн. Тайлант хугацаанд "Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам", "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамжид тавигдах шаардлага", "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамжид үнэлгээ хийх, шаардлагад нийцсэн программ хангамжийг мэдээлэх журам", "Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт", "Аж ахуйн нэгжийн орлого олох үйл ажиллагаатай хамааралгүй, нийгмийн хариуцлагын хүрээнд харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарт хэрэгжүүлсэн орлогын албан татварын хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага, стандарт батлах тухай" баталж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүтгэлд бүртгүүлж, нийтэд мэдээлсэн байна.<br>https://legalinfo.mn/mn/detail?lawId=17430823278592<br>https://legalinfo.mn/mn/detail?lawId=17431252533582<br>https://legalinfo.mn/mn/detail?lawId=17430556993352<br>https://legalinfo.mn/mn/detail?lawId=17431391477802 | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 307 | | 39.29.11.1.3. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хийсэн судалгаа, түүнчлэн өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дагаж мөрдөж байгаа хуулиудаас тусгайлан эрх олгосон заалтын судалгааг гаргаж, батлах зохицуулалттай боловч батлаагүй, баталсан боловч захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэлгүй даган мөрдөж байгаа шийдвэрүүдийг хянан үзэж, тэдгээрийг батлах, бүртгүүлэх арга хэмжээг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан авч хэрэгжүүлэх;(1.4. цаашид нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрт тогтмол дүн шинжилгээ хийж, шинээр батлагдсан хууль тогтоомжид нийцүүлэн холбогдох шийдвэрт тухай бүр нь нэмэлт, өөрчлөлт оруулж, сан хөдөлгөөн хийлгэх ажлыг хэвшүүлэх; 1.5. шийдвэрийг баталснаас хойш ажлын 5 өдрийн дотор хянуулж, бүртгүүлэх хугацааг баримталж ажиллах; 1.6. Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулж, бүртгүүлсэн шийдвэрүүдээр салбарын сан байгуулж, иргэдэд үйлчлэх чиг үүргээ биелүүлж ажиллах; ) ) | 1.4.Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамааруулан хуулиар нийт 84 хэм хэмжээний акт батлах эрх олгогдсоноос Засгийн газар батлах 35 актаас баталсан 27, батлагдаагүй 8, Засгийн газрын гишүүн батлах 49 актаас баталсан 35, батлаагүй 14 акт байна. Дээрх 22 актын төслийг боловсруулах ажил хийгдэж байна. Энэ хүрээнд холбогдох хуульд өөрчлөлт оруулах болон бүртгэгдсэн журамд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 1.5.Тайлант хугацаанд дор дурдсан захиргааны хэм хэмжээний актыг боловсруулан баталсныг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хугацаанд багтаан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлийг хийлгэсэн: 1. Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам; 2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамжид тавигдах шаардлагад 3. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамжид үнэлгээ хийх, шаардлагад нийцсэн программ хангамжийг мэдээлэх журам; 4. Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт; 5. Аж ахуйн нэгжийн орлого олох үйл ажиллагаатай хамааралгүй, нийгмийн хариуцлагын хүрээнд харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарт хэрэгжүүлсэн орлогын албан татварын хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага. 1.6.Тус яамны Салбарын эрх зүйн орчны шинэчлэл, хуулийн хэлтсээс салбарын сан байгуулах, иргэдийг мэдээллээр хангах ажлыг хариуцан ажиллаж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 308 | | 39.29.11.1.7. Захиргааны ерөнхий хуулийг үйл ажиллагаандаа дагаж мөрдөн хэвшүүлэх, цаашид уг хуультай холбоотой зөрчил гаргахгүй байх, гаргасан тохиолдолд холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцож ажиллах | Захиргааны ерөнхий хуульд заасан захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд мөрдөх зохицуулалтыг Хөдөлмөрийн дотоод журам, Албан хэрэг хөтлөлтийн дотоод журам, Гэрээ байгуулахад мөрдөх дотоод журамд тусган хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. Одоогоор хуулийн зохицуулалтыг мөрдүүлэхтэй холбоотой зөрчил гарсан тохиолдол байхгүй болно. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 186 | 309 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны 43 дугаар тэмдэглэл 2024-12-04 Дугаар 2024_43 | 43.6.2.. Төсвийн жилд багтаан барьцаа хөрөнгийн данснаас чөлөөлөх боломжгүй, хэрэгжилт удаашралтай, зогссон төслүүдийн гэрээг дүгнэж, эцсийн тооцоог баталгаажуулан барьцаа хөрөнгийн данс дахь санхүүжилтийн үлдэгдлийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэхийг төсвийн холбогдох ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэлийн Засагдарга нарт даалгав | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын багцад батлагдсан XIX.1.4 Үүрэн холбооны дахин дамжуулах сүлжээ станц /Увс, Бөхмөрөн, Өмнөговь, Баруунтуруун сум/ төслийн ББАОК-н дүгнэлт 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр, XIX.1.1 Шилэн кабельд холбох, зураг төсөв боловсруулах /Баян-Өлгий, Улаанхус сум, Хөххөтөл баг/ шилжих Багц-5 төслийн комиссын дүгнэлт 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдөр тус тус гарч эцсийн санхүүжилтийг олгосон. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 187 | 310 | Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны 45 дугаар тэмдэглэл<br>2024-12-20<br>Дугаар 2024_45 | 45.7. Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай асуудлыг хэлэлцээд агаар, хөрсний бохирдлыг бууруулах үйл ажиллагааг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9 дэх хэсэгт заасан зохицуулалттай уялдуулан дэмжиж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгаж, мөн үйл ажиллагааг дэмжих чиглэлээр Засгийн газраас холбогдох шийдвэр гаргах нь зүйтэй гэж үзэв(Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай) | 1.Цаг агаар, агаарын чанарын мэдээллийг жил бүрийн 09 дүгээр сарын 01-ний өдрөөс ирэх жилийн 03 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд 2,091,011 иргэнд мэдээлдэг. Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia.mn)-ийн 5.0 хувилбарыг 2025 оны 09 дүгээр сарын 20-ний өдөр ашиглалтад нэвтрүүлсэн бөгөөд улирал харгалзахгүй Улаанбаатар хотын орчим 19 цэгт агаар бохирдуулах бодисыг 6 үзүүлэлтээр агаарын чанарын индексийг тогтмол олон нийтэд мэдээлж байна. Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хороонд 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 01/2892 дугаартай албан бичгээр "Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны нэгтгэсэн 2025 оны төлөвлөгөө"-ний жилийн эцсийн биелэлтийг хүргүүлсэн.<br>Цахим хуудаст хандах: https://e-mongolia.mn/weather<br>2.Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia.mn)-ээр дамжуулан мод бүртгүүлэх үйлчилгээг 2025 оны 05 дугаар сарын 10-ны өдөр нэвтрүүлсэн бөгөөд 2025 оны жилийн эцсийн байдлаар 6614 /шинэ тарьсан 1746, өмнө тарьсан 4868/, мод тариулах 1480 хүсэлт ирсэн байна.<br><br>Хавсралт : 2 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 188 | 311 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдааны 3 дугаар тэмдэглэл<br>2025-01-14<br>Дугаар 2025_03 | 3.12.3.1. Шуурхай штабаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг яаралтай зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар нарт даалгав;(Монгол Улсын Засгийн газраас “2025 оныг нийслэлийн дэд бүтцийн хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан нийслэл Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, дэд бүтцийн бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, салбар хоорондын зохицуулалт, шуурхай удирдлагаар хангах Шуурхай штабын анхдугаар хуралдааны талаар ) | Монгол Улсын Засгийн газраас “2025 оныг нийслэлийн дэд бүтцийн хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан нийслэл Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, дэд бүтцийн бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, салбар хоорондын зохицуулалт тухай бүхий асуудалд тухай бүр санал өгсөн. Тухайлбал, тус яамнаас "Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын тогтоолын төсөлд 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 01/719 дугаартай албан бичгээр хариу хүргүүлсэн. Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2025 оны нэгдсэн төлөвлөгөөнд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам хариуцан хэрэгжүүлэхээр туссан "Төрийн нэгдсэн цахим хуудас дээр агаарын бохирдолын мэдээллийг хүргэх хөгжүүлэлтийг хийх" ажлын хүрээнд цаг агаар, агаарын чанарын мэдээллийг жил бүрийн 09 дүгээр сарын 01-ний өдрөөс ирэх жилийн 03 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд 2,091,011 иргэнд мэдээлдэг. Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia.mn)-ийн 5.0 хувилбарыг 2025 оны 09 дүгээр сарын 20-ний өдөр ашиглалтад нэвтрүүлсэн бөгөөд улирал харгалзахгүй Улаанбаатар хотын орчим 19 цэгт агаар бохирдуулах бодисыг 6 үзүүлэлтээр агаарын чанарын индексийг тогтмол олон нийтэд мэдээлж байна. Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хороонд 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 01/2892 дугаартай албан бичгээр "Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны нэгтгэсэн 2025 оны төлөвлөгөө"-ний жилийн эцсийн биелэлтийг хүргүүлсэн.<br>Цахим хуудаст хандах: https://e-mongolia.mn/weather<br><br>Хавсралт : 2 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 312 | | 44.22.1.11. Агаар, орчны бохирдлын талаар холбогдох төрийн байгууллагуудын тоон болон чанарын үзүүлэлт бүхий мэдээллийг нэгтгэсэн мэдээллийн сан, нэгдсэн дашбоард үүсгэхийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүд, холбогдох мэдээллийн үнэн зөв, бодит байдалд хяналт тавьж, тухай бүр шинэчилж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд | Цаг агаар, агаарын чанарын мэдээллийг жил бүрийн 09 дүгээр сарын 01-ний өдрөөс ирэх жилийн 03 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд 2,091,011 иргэнд мэдээлдэг. Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia.mn)-ийн 5.0 хувилбарыг 2025 оны 09 дүгээр сарын 20-ний өдөр ашиглалтад нэвтрүүлсэн бөгөөд улирал харгалзахгүй Улаанбаатар хотын орчим 19 цэгт агаар бохирдуулах бодисыг 6 үзүүлэлтээр агаарын чанарын индексийг тогтмол олон нийтэд мэдээлж байна. Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хороонд 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 01/2892 дугаартай албан бичгээр "Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны нэгтгэсэн 2025 оны төлөвлөгөө"-ний жилийн эцсийн биелэлтийг хүргүүлсэн.<br>Цахим хуудаст хандах: https://e-mongolia.mn/weather<br><br>Хавсралт : 2 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 189 | 313 | Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны 44 дүгээр тэмдэглэл 2025-01-18 Дугаар 2024_44 | 44.22.3.7. Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх зорилгоор төрөөс аж ахуйн нэгжтэй харилцах бүхий л үйл ажиллагааг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем "e-Mongolia-д нэгтгэх ажлыг зохион байгуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү нарт." | 2025 оны жилийн эцсийн байдлаар e-business платформд 832 үйлчилгээ нэвтэрсэн. Зөвшөөрлийн тухай хуульд заасан 254 тусгай зөвшөөрлөөс e-business платформд 44 цахимжиж, 134 линкээр холбогдож, 76 цахим хэлбэрт шилжээгүй, харин 124 энгийн зөвшөөрлөөс 23 цахимжиж, 43 линкээр холбогдож, 58 цахим хэлбэрт шилжээгүй байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 314 | | 44.22.6.1. Монгол Улс, Евразийн эдийн засгийн холбоо хооронд байгуулах Чөлөөт худалдааны түр хэлэлцээрийн төслийг хэлэлцэн тохиролцох үүрэг бүхий Ажлын хэсгийг холбогдох талын оролцоог хангуулан шинэчлэн байгуулж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөрт, Ажлын хэсэгт хариуцсан чиг үүргийн дагуу удирдах албан тушаалтныг оруулан идэвх, оролцоог хангаж ажиллуулах, шаардлагатай мэдээллийг тухай бүр хүргүүлж хамтран ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд тус тус даалгав | Монгол Улс, Евразийн эдийн засгийн холбоо хооронд байгуулах Чөлөөт худалдааны түр хэлэлцээрийн төсөл болон холбогдох баримт бичигтэй танилцаад, 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 01/730 дугаартай албан бичгээр хариу хүргүүлсэн. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 315 | | 44.22.8.1. Хяналт, удирдлагын нэгдсэн цахим систем (shilenkhyanalt.gov.mn)-ийн шинэчлэлийг хийж, системийн хэвийн ажиллагааг хангаж ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүд; | Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргын 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/12 дугаар тушаалаар Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны ажлын албаны даргаар ахлуулсан ажлын хэсэг ажилласан болно. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнээр Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны Ажлын албаны Үндсэн үйл ажиллагааны хэлтсийн дарга, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ, мониторингийн газрын ахлах референт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын салбарын бодлого зохицуулалтын газрын шинжээч, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны салбарын хяналтын газрын эрсдэлийн удирдлага хариуцсан ахлах мэргэжилтэн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны бодлого төлөвлөлт, судалгааны хэлтсийн мэргэжилтэн, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Тамгын газрын ахлах шинжээчийн бүрдэлдэхүүнтэй 2 удаагийн хурлаар Хяналт, удирдлагын нэгдсэн цахим системийн хэвийн, аюулгүй ажиллагааг хангах зорилгоор системийн шинэчлэл хийхэд шаардлагатай ажлын даалгавар боловсруулж тус ажлын тендер зарлагдахад бэлэн болсон. Засгийн газар бүх шатанд төсвийн хэмнэлтийн горимыг сахин, үр ашиггүй зардлыг танах, төрийн чиг үүргийн давхардлыг арилгаж, орон тоог үе шаттай цөөлөх зорилтын хүрээнд Засгийн газрын хуралдаанаар 29 хороо зөвлөлийг татан буулгах Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 22 дугаар тогтоолоор Хяналт, үнэлгээний үндэсний хороо татан буугдснаар Хяналт, удирдлагын нэгдсэн цахим систем http://shilenkhyanalt.gov.mn/-ийг шинэчлэх ажил зогссон болно. | Зохион байгуулалтаас - 0% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 190 | 316 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдааны 5 дугаар тэмдэглэл<br>2025-01-22<br>Дугаар 2025_05 | 5.24.10.1. Бүсийн хамтын ажиллагааг дэмжих, идэвхжүүлэх хөдөлгөөн өрнүүлэх хүрээнд олон талт арга хэмжээ зохион байгуулж, хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.(Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан зохион байгуулах төлөвлөгөөний талаар ) | Зүүн бүсийн цахим шилжилтийг эрчимжүүлэх, бүс нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, орон нутгийн мэдээллийн технологийн салбарыг хөгжүүлэх, эдийн засаг, нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхэд цахим технологийн гүйцэтгэх үүргийг тодорхойлох, зүүн бүс нутагт ажиллаж байгаа салбарын мэргэжилтэн, албан хаагчдын санал санаачилгыг дэмжих, санал хүсэлтийг бодлого, арга хэмжээнд тусган ажиллах зорилготойгоор харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын нэгдсэн чуулга уулзалтыг Хэнтий аймгийн төв Чингис хотод 2025 оны 03 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулсан. Тус чуулганы үеэр: 1.Мэдээллийн технологийн төрөлжсөн ХАБ-ыг Хэнтий аймагт байгуулах санамж бичгийг Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар, Мэдээлэл технологийн үндэсний парк хооронд байгуулсан. Санамж бичигт мэдээллийн технологи ба дэвшилтэт технологи, инновацын технологийн төрөлжсөн хабыг байгуулах, мэдээллийн технологийн төрөлжсөн хабыг түшиглэн хувийн хэвшлийн санаачилгыг дэмжин бүх төрлийн хөрөнгө оруулалт хийх, арга хэмжээг зохион байгуулах, хөтөлбөр хэрэгжүүлэхэд хамтран ажиллах талаар тусгасан. Мөн Хэнтий аймагт Зүүн бүсийн логистикийн төв байгуулах санамж бичгийг Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар, Монгол шуудан ХК хооронд байгуулсан. Санамж бичигт Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газраас тус төвийг байгуулах газар, дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх, Монгол шуудан ХК-иас уг төвийг бүтээн байгуулж, зүүн бүсийн иргэдийн тээвэр логистикийн хэрэгцээг хангах, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний бодит өртгийг бууруулах боломжийг бүрдүүлэх чиглэлд хамтран ажиллахаар болсон. 2.Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн мэдээллийн технологийн болон захиргааны албан хаагчид мэдээллийн аюулгүй байдлын мэргэшүүлэх сургалтад хамрагдсан. 3.Зүүн бүсийн бүх сум төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх зорилгоор бүсийн Хэнтий аймгийн 17 сум, Сүхбаатар аймгийн 13 сум, Дорнод аймгийн 14 сум, нийт 45 суманд Төрийн үйлчилгээний киоск машиныг гардуулсан. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 317 | | 5.24.1.1. Шуурхай штабын хуралдааны үеэр Ерөнхий сайдаас өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг шуурхай зохион байгуулах, Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлэхээр тогтсон асуудалд холбогдох саналаа яаралтай горимоор өгч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд; | Монгол Улсын Засгийн газраас “2025 оныг нийслэлийн дэд бүтцийн хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан нийслэл Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, дэд бүтцийн бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, салбар хоорондын зохицуулалт бүхий асуудалд тухай бүр санал өгсөн. Тухайлбал, тус яамнаас "Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын тогтоолын төсөлд 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 01/719 дугаартай албан бичгээр хариу хүргүүлсэн. Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2025 оны нэгдсэн төлөвлөгөөнд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам хариуцан хэрэгжүүлэхээр туссан "Төрийн нэгдсэн цахим хуудас дээр агаарын бохирдолын мэдээллийг хүргэх хөгжүүлэлтийг хийх" ажлын хүрээнд цаг агаар, агаарын чанарын мэдээллийг жил бүрийн 09 дүгээр сарын 01-ний өдрөөс ирэх жилийн 03 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд 2,091,011 иргэнд мэдээлэлдэг. Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia.mn)-ийн 5.0 хувилбарыг 2025 оны 09 дүгээр сарын 20-ний өдөр ашиглалтад нэвтрүүлсэн бөгөөд улирал харгалзахгүй Улаанбаатар хотын орчим 19 цэгт агаар бохирдуулах бодисыг 6 үзүүлэлтээр агаарын чанарын индексийг тогтмол олон нийтэд мэдээлж байна. Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хороонд 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 01/2892 дугаартай албан бичгээр "Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны нэгтгэсэн 2025 оны төлөвлөгөө"-ний жилийн эцсийн биелэлтийг хүргүүлсэн.<br>Цахим хуудаст хандах: https://e-mongolia.mn/weather<br><br>Хавсралт : 2 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 191 | 318 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 6 дугаар хуралдааны тэмдэглэл<br>2025-01-29<br>Дугаар 2025_06 | 6.26.5.2.2. “Засгийн газрын үйл ажиллагааны 2024-2028 оны хөтөлбөр”-т тусгагдсан 4 бодлогын 16 чиглэлийн 620 зорилтын хэрэгжилтийг эрчимжүүлэхэд анхаарч ажиллахыг Засгийн газрын гишүүд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт | Алсын хараа-2050 урт хугацааны хөгжлийн бодлого, “Засгийн газрын үйл ажиллагааны 2024-2028 оны хөтөлбөр”, Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Хиймэл оюун ухаан (AI), өндөр технологийн шилжилт, ногоон хөгжлийн шилжилт, хөдөлмөрийн зах зээл, хүний нөөцийн ур чадварын шилжилт хийх стратеги төлөвлөгөөг боловсруулсан. Их өгөгдөл хиймэл оюуны стратегийн талаар Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 18 дугаар хуралдаанд танилцуулсан. Уг стратегид тусгагдсан зорилт, арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төсөлд тусгахаар даалгасны дагуу тусгасан. Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх үндэсний зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 03 дугаар тогтоолоор “Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх стратеги” төлөвлөгөөг баталсан. Шаардагдах төсвийг тухайн жилийн төсөвт тусган хэрэгжүүлэн ажиллаж байна.<br><br>Хавсралт : 2 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 191 | 319 | | 7.26.1.1. Шуурхай штабын хуралдаан дээр Ерөнхий сайдаас өгсөн шуурхай үүрэг даалгаврын хэрэгжилтийн тайланг тухай бүр ERP системд тусгаж ажиллахыг Засгийн газрын нийт гишүүдэд; | Монгол Улсын Засгийн газраас “2025 оныг нийслэлийн дэд бүтцийн хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан нийслэл Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, дэд бүтцийн бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, салбар хоорондын зохицуулалт бүхий асуудалд тухай бүр санал өгсөн. Тухайлбал, тус яамнаас "Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын тогтоолын төсөлд 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 01/719 дугаартай албан бичгээр хариу хүргүүлсэн. Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2025 оны нэгдсэн төлөвлөгөөнд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам хариуцан хэрэгжүүлэхээр туссан "Төрийн нэгдсэн цахим хуудас дээр агаарын бохирдолын мэдээллийг хүргэх хөгжүүлэлтийг хийх" ажлын хүрээнд цаг агаар, агаарын чанарын мэдээллийг жил бүрийн 09 дүгээр сарын 01-ний өдрөөс ирэх жилийн 03 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд 2,091,011 иргэнд мэдээллэдэг. Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia.mn)-ийн 5.0 хувилбарыг 2025 оны 09 дүгээр сарын 20-ний өдөр ашиглалтад нэвтрүүлсэн бөгөөд улирал харгалзахгүй Улаанбаатар хотын орчим 19 цэгт агаар бохирдуулах бодисыг 6 үзүүлэлтээр агаарын чанарын индексийг тогтмол олон нийтэд мэдээлж байна. Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хороонд 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 01/2892 дугаартай албан бичгээр "Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны нэгтгэсэн 2025 оны төлөвлөгөө"-ний жилийн эцсийн биелэлтийг хүргүүлсэн.<br>Цахим хуудаст хандах: https://e-mongolia.mn/weather<br>Хуралдааны тэмдэглэлээр өгөгдсөн үүргийг тухай бүр Unelgee.gov.mn цахим системээр тайлагнан ажиллаж байна. Түүнчлэн Ерөнхий сайдаас өгсөн шуурхай үүрэг даалгаврыг ERP системд тухай бүр бүртгэн ажиллаж байна.<br><br>Хавсралт : 2 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 192 | 320 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 7 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-02-05 Дугаар 2025_07 | 7.26.2.2.1. хуулийн этгээд байгуулах шат дамжлагыг цөөлж, цахимжуулах замаар хугацааг багасгаж, ажлын 3 өдөрт багтаан ашгийн төлөө хуулийн этгээд улсын бүртгэлд бүртгэх боломжийг судалж, холбогдох зохицуулалтыг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан хэрэгжүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү нарт; (2. Аж ахуйн үйл ажиллагааг эхлүүлэх үе шатанд тулгардаг хүндрэл, шат дамжлага, хугацааг багасгах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллага, албан тушаалтанд даалгав:) | Улсын бүртгэлийн ерөнхий газартай хамтран ажиллах төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу И-Бизнес системийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын хуулийн этгээдийн “ERS” системтэй мэдээлэл солилцох холболтыг хийх, хуулийн этгээдийн нэрийн давхардлыг хиймэл оюуны тусламжтай шалгах боломжийг бүрдүүлэхээр холбогдох чиглэлийг 2025 он 01/729 дугаартай албан бичгээр И Монгол академи УТҮГ-т хүргүүлсэн. УБЕГ-ын хуулийн этгээдийн бүртгэлийн системийн шинэчлэлтийг АХБ-ны дэмжлэгтэйгээр "Аствишн" ХХК гүйцэтгэж байна. "ERS" систем болон "E-Business" платформын холбох, хуулийн этгээдийн нэрийн давхардлыг хиймэл оюуны тусламжтай шалгах системийн ажлын даалгаврыг боловсруулсан боловч санхүүжилт шийдвэрлэгдээгүй. Өнөөдрийн байдлаар Экспортыг нэмэгдүүлэх, худалдааг дэмжих, бизнес эрхлэх орчныг сайжруулах хүрээнд "Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх зорилгоор төрөөс аж ахуйн нэгжтэй харилцах бүхий л үйл ажиллагааг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем "e-Business"-т нэгтгэх үүрэг бүхий ажлын дэд хэсэг МУ-ын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны А/27 дугаар тушаалаар байгуулагдан ажиллаж байна. Тус ажлын хэсгийн хурлыг 2 удаа зохион байгуулж, УБЕГ-тай хамтран хуулийн этгээд шинээр байгуулахад бүртгүүлэх шат дамжлагыг бууруулах процессын алхмыг тодорхойлоод байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 321 | | 7.26.2.2.4. харьяа салбарын хүрээнд тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох шийдвэр гаргах үйл ажиллагааг цахимжуулж, цахимаар шийдвэр гаргах хугацааг тогтоож, зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан (www.licence.mn)-д 2025 оны 2 дугаар улиралд багтаан оруулах, төрийн үйлчилгээний нэгдсэн системд холбох арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, “Санхүүгийн мэдээллийн технологийн төв" УТҮГ (Т.Батбилэг), “И-Монгол академи” УТҮГ (Б.Мягмарнаран)-т. (2.Аж ахуйн үйл ажиллагааг эхлүүлэх үе шатанд тулгардаг хүндрэл, шат дамжлага, хугацааг багасгах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллага, албан тушаалтанд даалгав) | 1.Зөвшөөрлийн нэгдсэн санд байгаа зөвшөөрлийн төлөвийн мэдээллийг e-mongolia мобайл аппликейшний “Төрд байгаа мэдээлэл” цэсэд байршуулсан. 2.Мөн license.mn системийг e-business.mn системд нэгтгэн Зөвшөөрлийн цахим систем цонхонд харуулах хөгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Зөвшөөрлийн тухай хуульд заасан 254 тусгай зөвшөөрлөөс e-business платформд 44 цахимжиж, 134 линкээр холбогдож, 76 цахим хэлбэрт шилжээгүй, харин 124 энгийн зөвшөөрлөөс 23 цахимжиж, 43 линкээр холбогдож, 58 цахим хэлбэрт шилжээгүй байна.4. E-Business.mn платформын хэрэглээг нэмэгдүүлэхээр ухаалаг утасны хувилбарт хөгжүүлэлт хийн ажиллаж байгаа бөгөөд 2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр дуусгахаар хөгжүүлэлтийн төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. 5. 2025 онд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад төрийн 3113 үйлчилгээг цахимаар хүргэн 396,817 үйлчилгээ авсан байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 322 | | 7.26.2.3.3.4. Энэ тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийн явц, үр дүнгийн тайланг улирал тутам Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлж ажиллахыг холбогдох байгууллага, албан тушаалтанд, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөрт даалгав. | Цахим хөгжил,инновац, харилцаа холбооны яамны чиг үүрэгт хамаарах Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний цахим систем www.unelgee.gov.mn-д оруулж тайлагнаж байна. Үүрэг, даалгаврын хэрэгжилтийн явц, үр дүнгийн тайланг улирал тутам цахим системээр тайлагнаж, ажиллаж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 193 | 323 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 9 дүгээр хуралдааны тэмдэглэл<br>2025-02-19<br>Дугаар 2025_09 | 9.24.2.2. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн олгосон ногдол ашгийг иргэд хуримтлалын нэрийн дансандаа шилжүүлэх болон төрөлжсөн сан хооронд шилжүүлж хуримтлуулах, арвижуулах нөхцөл боломжийг судлан үзэж, холбогдох зохицуулалтыг бий болгох чиглэлээр зохих шийдвэрийн төсөл боловсруулж танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Сангийн сайд Б.Жавхлан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, “И-Монгол академи” УТҮГ-ын захирал (Б.Мягмарнаран), “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх удирдлага (С.Наранцогт)-д; | Үндэсний баялагийн сангийн Хуримтлалын сан дахь иргэдийн нэрийн дансны орлогын мэдээллийг ХУР сервисээр авч харуулах талаар холбогдох байгууллагатай И Монгол академиас 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр уулзалт хийж, шийдэл боловсруулсан. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн олгосон ногдол ашгийг иргэд хуримтлалын нэрийн дансандаа шилжүүлэх болон төрөлжсөн сан хооронд шилжүүлж хуримтлуулах, арвижуулах нөхцөл боломжийг бий болгох, Үндэсний баялгийн сангийн Хуримтлалын сан дахь иргэдийн нэрийн дансны орлогын мэдээллийг виртуал карт, хадгаламжийн дэвтэр болон бусад хэлбэрээр иргэдэд хүргэх асуудлыг судлан хэрэгжүүлэхийг даалгасны дагуу Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан санал асуулга авахад 505,318 иргэн оролцсоноос 481,809 нь “Бэлэн мөнгө”, 22,242 нь “Хуримтлалын сан”, 1,267 иргэн “Хандив” гэсэн сонголт хийсэн байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 324 | | 9.24.2.3. Үндэсний баялгийн сангийн Хуримтлалын сан дахь иргэдийн нэрийн дансны орлогын мэдээллийг виртуал карт, хадгаламжийн дэвтэр болон бусад хэлбэрээр иргэдэд хүргэх асуудлыг судалж, хэрэгжүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, “И-Монгол академи” УТҮГ-ын захирал (Б.Мягмарнаран), “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх удирдлага (С.Наранцогт)-д; | Монгол Улсын иргэн бүрд хуримтлалын нэрийн данс үүсгэх, хөтлөх, сангаас зарцуулалт хийх журмын 8.7.1 болон 8.7.2 дахь заалтын хүрээнд хуримтлалын нэрийн дансны мэдээлэл харуулах хөгжүүлэлтийг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia)-д хийж, 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр нэвтрүүлсэн. Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia)-ийн профайл цэсэнд Чингис хаан үндэсний баялагийн сан цэс байршиж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 325 | | 10.19.6.1. Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн энгийн хувьцааны 2024 оны ногдол ашгийг хуваарилахтай холбогдуулан “И-Монголиа” цахим системээр дамжуулан санал асуулгад оролцож, хуримтлуулах болон хандивлах санал өгсөн иргэдийн саналыг дахин баталгаажуулах арга хэмжээ авахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, “И-Монгол академи” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал (Б.Мягмарнаран) нарт;(19.6.Монгол Улсын иргэдэд эзэмшүүлсэн “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн энгийн хувьцаанд хуваарилах 2024 оны ногдол ашгийн талаар ) | Монгол Улсын иргэн бүрд хуримтлалын нэрийн данс үүсгэх, хөтлөх, сангаас зарцуулалт хийх журмын 8.7.1 болон 8.7.2 дахь заалтын хүрээнд хуримтлалын нэрийн дансны мэдээлэл харуулах хөгжүүлэлтийг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia)-д хийж 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр нэвтрүүлсэн. Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia)-ийн профайл цэсэнд Чингис хаан үндэсний баялагийн сан цэс байршиж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 194 | 326 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 10 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-02-26 Дугаар 2025_10 | 10.19.4.1. Тогтоол, шийдвэр батлах эрх зүйн үндэслэлд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан зорилго, зорилт, арга хэмжээний дугаар, өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлж дуусах хугацааг тодорхой заах байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засагдарга нарт:(19.4.Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд 2024 оны жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн талаар) | Тогтоол, шийдвэр батлах эрх зүйн үндэслэлд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан зорилго, зорилт, арга хэмжээний дугаар, өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлж дуусах хугацааг тодорхой тусгаж байна. Цахим хөгжил,инновац, харилцаа холбооны яамны чиг үүрэгт хамаарах 2024 оны жилийн эцсийн байдлаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хяналтад авсан 358 зүйл, заалтын хэрэгжилтийг дунджаар 89,19%-тай үнэлгэдэн 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 03/1221 дугаар албан бичгээр, 2025 оны 1 дүгээр улирлын 246 заалтын биелэлтийг 2025 оны 02 дугаар сарын 03/511 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлж, Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний цахим систем www.unelgee.gov.mn-д оруулсан. Мөн хэрэгжилт удаашралтай, эрчимжүүлэх шаардлагатай 22 заалтын биелэлтийг 05 дугаар сарын 14-ний өдөр тус системээр тайлагнасан. Хяналт хэрэгжүүлэх газарт тогтоол шийдвэрийн давхардлын судалгааг 2025 оны 07 дугаар сард цахимаар хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 327 | | 10.19.4.2. Холбогдох хууль тогтоомжоор өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг богино хугацаанд шуурхай зохион байгуулан бүрэн хангахад анхаарч, эрхлэх асуудлын хүрээнд дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | Цахим хөгжил,инновац, харилцаа холбооны яамны чиг үүрэгт хамаарах 2024 оны жилийн эцсийн байдлаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хяналтад авсан 358 зүйл, заалтын хэрэгжилтийг дунджаар 89,19%-тай үнэлгэдэн 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 03/1221 дугаар албан бичгээр, 2025 оны 1 дүгээр улирлын 246 заалтын биелэлтийг 2025 оны 02 дугаар сарын 03/511 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлж, Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний цахим систем www.unelgee.gov.mn-д оруулсан. Мөн хэрэгжилт удаашралтай, эрчимжүүлэх шаардлагатай 22 заалтын биелэлтийг 05 дугаар сарын 14-ний өдөр тус системээр тайлагнасан. Сар бүр албан даалгаврын хэрэгжилтийг цахим системээр тайлагнаж байна.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 195 | 328 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 12 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-03-12 Дугаар 2025_12 | 12.3.2. Уг хэлэлцээнд эрхэлсэн салбар, хариуцсан чиг үүргийн хүрээнд оролцох яам, агентлагийн албан хаагчдыг бүрэн хариуцлагатай оролцох байдлыг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав | Монгол Улс, Евразийн эдийн засгийн холбоо хооронд байгуулах Чөлөөт худалдааны түр хэлэлцээрийн төсөл болон холбогдох баримт бичигтэй танилцаад, 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 01/730 дугаар албан бичгээр хариу хүргүүлсэн. Уг хэлэлцээрийн талаар Эдийн засаг, хөгжлийн яаманд байгуулагдсан ажлын хэсэгт тус яамнаас албан хаагч ороогүй. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 329 | | 14.16.7.1.. Зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох болон зөвшөөрлийн хугацаа сунгах асуудлыг Зөвшөөрлийн тухай хуульд заасан хугацаанд шийдвэрлэх, хууль зөрчсөн зөвшөөрөл олгох шат дамжлагыг нэмэгдүүлсэн захиргааны хэм хэмжээний акт баталсан зөрчлийг даруй арилгаж цаашид гаргахгүй байхад анхаарч ажиллахыг зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд;(Зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хөнгөвчлөх, цахим хэлбэрт шилжүүлэх, холбогдох захиргааны хэм хэмжээний актуудыг хуульд нийцүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар ) | Цахим гарын үсгийн тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хүрээнд Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд заасан тоон гарын үсгийн гэрчилгээ олгох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх энгийн зөвшөөрлийг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгож ирсэн. Зөвшөөрлийн зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаас гарсан дүгнэлтийн дагуу зөвшөөрөл олгоход ач холбогдолгүй цаг хугацаа шаардсан, шат дамжлага үүсгэсэн баримт бичгийг хүчингүй болгох хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/81 дүгээр тушаалаар баталсан "Гэрчилгээжүүлэх үйл ажиллагааны журамд тавигдах шаардлага"-ыг олон улсын холбогдох стандартаар зохицуулах боломжтой гэж үзэж, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/35 дугаар тушаалаар хүчингүй болгон захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлээс хасуулахаар 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 03/353 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Мөн Цахим гарын үсгийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2025 оны 01/372 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 2 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 196 | 330 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 14 дүгээр хуралдааны тэмдэглэл<br>2025-03-26<br>Дугаар 2025_14 | 14.16.7.3.. Тусгай зөвшөөрлийн цахим систем (license), Төрийн үйлчилгээний "e-business.mn" системд холбогдох, ашиглалтыг хэвшүүлэх чиглэлээр зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагуудад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг "Санхүүгийн мэдээллийн технологийн төв" УТҮГ (Т.Батбилэг), "И-Монгол Академи" УТҮГ (Б.Мягмарнаран)-т; | Зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд нийт 251 тусгай зөвшөөрлөөс 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар "license.mn"-ээр 76, "e-business.mn"-ээр 43, эрх бүхий байгууллага өөрийн системээр 116, уламжлалт буюу цаасан хэлбэрээр 16 тусгай зөвшөөрлийг олгож байна.<br>Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын А/27 дугаар тушаалаар байгуулсан Ажлын дэд хэсгийн хурлын шийдвэрийн дагуу "Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх зорилгоор төрөөс аж ахуйн нэгжтэй харилцах бүхий л үйл ажиллагааг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем "e-Business"-д нэгтгэх" ажлын хүрээнд ажиллах төлөвлөгөөг ЦХИХХС баталсан. Энэхүү ажлын хүрээнд И-Монгол академи УТҮГ нь e-Business платформд холбогдох байгуулагуудтай тогтмол хамтран ажиллаж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж байгаа бөгөөд ЭЗХЯ, ТЦҮЗГ, ХОХГ, МНТ нь бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд шаардлагатай үйлчилгээг тодорхойлсон. Цаашид И-Монгол академи УТҮГ нь дээрх үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэн, e-Business платформд нэгтгэхэд үе шаттайгаар хамтран ажиллана. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 331 | | 14.16.9. Үүнтэй холбогдуулан салбарын хяналт шалгалтын давхардлын улмаас аж ахуйн нэгж, байгууллагад хүндрэл, чирэгдэл үүсгэж байгааг шийдвэрлэх зорилгоор хяналтын удирдлагын нэгдсэн цахим системийн үйл ажиллагааг сайжруулж, хяналтын байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү нарт даалгав." () | Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргын 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/12 дугаар тушаалаар Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны ажлын албаны даргаар ахлуулсан ажлын хэсэг ажилласан болно. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнээр Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны Ажлын албаны Үндсэн үйл ажиллагааны хэлтсийн дарга, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ, мониторингийн газрын ахлах референт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын салбарын бодлого зохицуулалтын газрын шинжээч, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны салбарын хяналтын газрын эрсдэлийн удирдлага хариуцсан ахлах мэргэжилтэн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны бодлого төлөвлөлт, судалгааны хэлтсийн мэргэжилтэн, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Тамгын газрын ахлах шинжээчийн бүрдэлдэхүүнтэй 2 удаагийн хурлаар Хяналт, удирдлагын нэгдсэн цахим системийн хэвийн, аюулгүй ажиллагааг хангах зорилгоор системийн шинэчлэл хийхэд шаардлагатай ажлын даалгавар боловсруулж, тус ажлын тендер зарлагдахад бэлэн болсон. Засгийн газар бүх шатанд төсвийн хэмнэлтийн горимыг сахин, үр ашиггүй зардлыг танах, төрийн чиг үүргийн давхардлыг арилгаж, орон тоог үе шаттай цөөлөх зорилтын хүрээнд Засгийн газрын хуралдаанаар 29 хороо зөвлөлийг татан буулгах Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 22 дугаар тогтоолоор Хяналт, үнэлгээний үндэсний хороо татан буугдснаар Хяналт, удирдлагын нэгдсэн цахим систем http://shilenkhyanalt.gov.mn/-ийг шинэчлэх ажил зогссон болно. 2026 оны хяналт шалгалтын төлөвлөгөө системд хийгдсэн. | Тодорхой үр дүнд хүрсэн - 50% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 332 | | 15.13.4.1.. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдааны 13 дугаар тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг хангуулж, дүнг 2025 онд багтаан танилцуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр нарт; (Иргэдээс төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандан 2024 онд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов:) | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу Иргэд, олон нийттэй харилцах төв “11-11”-ийн мэдээллийн системийг 2024.11.12-ны өдрөөс мэдэгдэл хүргэх системтэй холбож, улмаар иргэдийн ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлтэд мэдэгдэл хүргэдэг болсон. Иргэдийн асуултад хариулах, хууль эрх зүйн зөвлөмж өгөх, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явцыг мэдээлэх чадвартай хиймэл оюунд суурилсан “IVA” системийг “11-11.mn” веб хуудсанд холбож, “Харилцагчийн үйлчилгээний хиймэл оюуны виртуал ажилтан, операторын үйлчилгээ”-г 2025.03.31-ний өдөр ЗГХЭГ-тай хамтран нэвтрүүлсэн. Засгийн газрын “11-11”, нийслэлийн “1800-1200” дугаарын үйл ажиллагаанд ашиглаж буй мэдээллийн сан, системийг нэгтгэх шийдлийг боловсруулж, “API” сервисийн хөгжүүлэлт хийх чиглэлийг 2025 оны 02/1204 бичгээр И Монгол академид хүргүүлэн, хөгжүүлэлтийн ажлыг эхлүүлсэн. Үүнтэй холбогдуулан ЗГХЭГ, НЗДТГ, Иргэд олон нийттэй харилцах төв, Нийслэлийн нэгдсэн үйлчилгээний төв, И Монгол академи УТҮГ, ERP систем хөгжүүлэгч байгууллагууд болон тоон гарын үсгийн гэрчилгээжүүлэх байгууллагуудтай нийт 2 удаагийн уулзалтыг зохион байгуулж, ажлын хэсэг байгуулах төслийг ЗГХЭГ-т хүргүүлсэн. Улмаар ЗГХЭГ-ын Тэргүүн дэд даргын 2025.05.27-ны өдрийн 175 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Иргэдээс тус яам болон харьяа байгууллага, албан тушаалтанд хандан гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар тайланд жил бүр хяналт-шинжилгээ үнэлгээ хийж ажиллаж байна. 2025 оны тус яам болон харьяа байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлийн жилийн эцсийн тайланг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт 2026 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр хүргүүлсэн. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 333 | | 15.13.4.2.. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулах хүрээнд жилийн эцсийн тайлан, мэдээнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж, чиглэл хүргүүлж, хэрэгжилт, үр дүнг тооцон ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.” | Иргэдээс тус яам болон харьяа байгууллага, албан тушаалтанд хандан 2024 онд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар тайланд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Хяналт хэрэгжүүлэх газарт 2025 оны 01 дүгээр сарын 10-ны 03/68 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Иргэдээс тус яам болон харьяа байгууллага, албан тушаалтанд хандан гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар тайланд жил бүр хяналт-шинжилгээ үнэлгээ хийж ажиллаж байна. 2025 оны тус яам болон харьяа байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлийн жилийн эцсийн тайланг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт 2026 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр хүргүүлсэн. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 197 | 334 | Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 15 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-04-02 Дугаар 2025_15 | 15.13.5.1.. Нийслэлийн Шуурхай штабын хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврыг тогтоосон хугацаанд бүрэн хэрэгжүүлж, Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 7 дугаар хуралдааны тэмдэглэлээр даалгасны дагуу биелэлтийг тухай бүр ERP системээр тайлагнаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар, “Эрдэнэс Монгол” ХХК (С.Наранцогт)-д тус тус; | Монгол Улсын Засгийн газраас “2025 оныг нийслэлийн дэд бүтцийн хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан нийслэл Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, дэд бүтцийн бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, салбар хоорондын зохицуулалт бүхий асуудалд тухай бүр санал өгсөн. Тухайлбал, тус яамнаас "Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын тогтоолын төсөлд 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 01/719 дугаартай албан бичгээр хариу хүргүүлсэн. Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2025 оны нэгдсэн төлөвлөгөөнд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам хариуцан хэрэгжүүлэхээр туссан "Төрийн нэгдсэн цахим хуудас дээр агаарын бохирдолын мэдээллийг хүргэх хөгжүүлэлтийг хийх" ажлын хүрээнд цаг агаар, агаарын чанарын мэдээллийг жил бүрийн 09 дүгээр сарын 01-ний өдрөөс ирэх жилийн 03 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд 2,091,011 иргэнд мэдээллэдэг. Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia.mn)-ийн 5.0 хувилбарыг 2025 оны 09 дүгээр сарын 20-ний өдөр ашиглалтад нэвтрүүлсэн бөгөөд улирал харгалзахгүй Улаанбаатар хотын орчим 19 цэгт агаар бохирдуулах бодисыг 6 үзүүлэлтээр агаарын чанарын индексийг тогтмол олон нийтэд мэдээлж байна. Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хороонд 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 01/2892 дугаартай албан бичгээр "Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны нэгтгэсэн 2025 оны төлөвлөгөө"-ний жилийн эцсийн биелэлтийг хүргүүлсэн.<br>Цахим хуудаст хандах: https://e-mongolia.mn/weather<br>ERP системд бүртгэл хийж Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн системээр тайлагнаж байна.<br><br>Хавсралт : 2 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 335 | | 15.13.7.. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулж, эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэрт хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашгийн талаарх мэдээллийг олон нийтэд сурталчлан таниулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав. (Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн 2025 оны 1 дүгээр улирлын явц, гүйцэтгэлийн талаар ) | 2025 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх шинэ 3 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төсвийн тухай хууль болон холбогдох журам, графикийн дагуу зохион байгуулж, холбогдох эрх шилжүүлэлтийг хийж, санхүүжилтийн гүйцэтгэл, хэрэгжилтийн тайлагналтыг www.publicinvestment.gov.mn цахим системд цаг тухайд нь бүртгэн ажиллаж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 198 | 336 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 16 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-04-09 Дугаар 2025_16 | 16.20.1.2. Зайлшгүй шаардлагатайгаас бусад үйл ажиллагааг хуралдаантай давхцуулан зохион байгуулах, албан хаагчдыг томилолтоор ажиллуулахгүй байхад анхаарч, нэгдсэн журмаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Архангай аймгийн Засаг дарга Б.Цэрэннадмид, Баянхонгор аймгийн Засаг дарга Д.Мөнхсайхан, Өвөрхангай аймгийн Засаг дарга О.Пүрэвдорж нарт; | Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа-2050", "Шинэ сэргэлтийн бодлого", "Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-д нийцүүлж, хөгжлийн тулгамдсан асуудлыг цаг алдалгүй, хурдтай шийдвэрлэхийн тулд Засгийн газар 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 3 болон 5 дугаар тэмдэглэл, Бүсчилсэн хөгжлийн Үндэсний хорооны 2025 оны 1 дүгээр тогтоолоор “Бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдааныг бүс бүрд зохион байгуулж, бүсүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, бүс тус бүрд шаардлагатай мега төслийг танилцуулж, хэлэлцүүлэх шийдвэр гарсан. “Бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдаан”-ыг бүс тус бүрээр зохион байгуулахад тус яамнаас холбогдох албан хаагчид оролцсон бөгөөд “Хангайн бүсийн зөвлөл анхдугаар хуралдаан”-ыг 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр Архангай аймагт зохион байгуулж, тус яамнаас хэрэгжүүлж байгаа бодлого шийдвэрээ танилцуулж, оролцсон. 2025 оны 4 дүгээр сарын байдлаар Архангай- ХУРДАН ЦЭГ аймгийн төвд 2, суманд 19, ХУРДАН КИОСК 3 байсан бөгөөд 2025 онд 3ш нэмэхээр төлөвлөсөн. Хэвийн ажиллагаатай камер-419ш байна.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 337 | | 16.20.13.4. Үндэсний үйлдвэрлэл эрхлэгчдийн цахим бүртгэлийн системийг нэвтрүүлж, холбогдох төрийн байгууллагуудын цахим системтэй холбох арга хэмжээ авахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүд; (Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн Дархан-Уул аймагт ажилласан томилолтын талаар ЗГ-дэд танилцуулж дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгав:) | Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 9 дүгээр зүйлд мэдээллийн технологийн үндэсний паркын чиг үүргийг нарийвчлан тодорхойлсон бөгөөд 9.1.8 дахь хэсэгт зааснаар мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн Зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг гүйцэтгэхээр болсон. Үүний хүрээнд холбогдох бэлтгэл ажлыг хангаж Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 97 дугаар тогтоолоор Мэдээллийн технологийн үйлдвэрлэл дэвшилтэт технологийн үндэсний зөвлөлийг байгуулсан. Уг үндэсний зөвлөлийн анхдугаар хуралдаан 2024.11.27-ний өдөр хуралдаж хуралдааны дэг, Үйлдвэрлэлийн технологийг сайжруулах, зорилго бүхий технологийн бирж бий болгон ажлуулахын хүрээнд Шинжлэх ухааны академитай хамтран Монгол Улсын эрдэмтэн, зохион бүтээгч, инженерүүдийн бүтээсэн оюуны өмчөөр хамгаалагдсан эцсийн бүтээгдэхүүнийг эдийн засгийн эргэлтэнд оруулах үүднээс Технологи инновацийн дэлгүүрийг 2021 онд байгуулсан. Уг дэлгүүрээр өдгөө 204 нэр төрлийн бүтээгдэхүүн худалдаалж байгаа бөгөөд 2024 оны хувьд нийт 148 нэр төрлийн 2864 ширхэг бараа зарж 36488,900 төгрөгийн борлуулалт хийсэн байна. Үүнээс эрдэмтэн судлаагч, зохион бүтээгч нарт 27,366,675 төгрөгийн олголт хийсэн байна. Технологи инновацийн дэлгүүр нь үндэсний үйлдвэрлэл эрхлэгчдийн цахим бүртгэл бүхий дашбоардыг агуулж байгаа болно. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 199 | 338 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 18 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-04-16 Дугаар 2025_18 | 18.19.3.. Үүнтэй холбогдуулан төрийн байгууллагуудын оролцоотой, төсвийн хөрөнгөөр зохион байгуулж байгаа үндэсний спорт, соёл, урлагийн арга хэмжээг иргэд, олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр шууд дамжуулах эрхийг нээлттэй болгох асуудлыг судалж, санал боловсруулан танилцуулахыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Монополын эсрэг газар (Б.Билгүүн)-т даалгав.(Төрийн байгууллагын оролцоотой зохион байгуулдаг үндэсний бөхийн барилдааныг иргэд, олон нийтэд шууд дамжуулах эрхийн талаар ) | Монгол Улсын Их хурлаас өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх эрх зүйн үндсийг тодорхойлж, зах зээлийн шударга өрсөлдөөний таатай орчныг бүрдүүлэх, үндэсний болон нийтийн ашиг сонирхолд нийцсэн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийг баталсан. Тус хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний судалгааг хийлгэж, судалгааны тайланг үндэслэн өргөн нэвтрүүлгийн тухай хуульд үндэсний спорт, соёл, урлагийн арга хэмжээг иргэд, олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр шууд дамжуулах эрхийг нээлттэй болгох талаар нэмэлт, өөрчлөлт оруулахаар судалж байна. | Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 200 | 339 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 21 дүгээр хуралдааны тэмдэглэл 2025-04-30 Дугаар 2025_21 | 21.11.1.1.. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.11-д заасны дагуу хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага, стандартыг эрхлэх салбарын бодлоготой уялдуулан баталж, зохих журмын дагуу улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх ажлыг 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөрт багтаан зохион байгуулахыг Боловсролын сайд П.Наранбаяр, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан нарт даалгав.(Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9-д заасан татварын хөнгөлөлттэй холбогдох зохицуулалтын хэрэгжилтийн талаар ) | Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/79 дүгээр тушаалаар "Хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага стандарт батлах тухай" /Аж ахуйн нэгжийн орлого олох үйл ажиллагаатай хамааралгүй, нийгмийн хариуцлагын хүрээнд харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарт хэрэгжүүлсэн орлогын албан татварын хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага/ журам батлагдаж, тушаалыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 7258 дугаарт бүртгүүлж, яамны цахим хуудаст нээлттэй байршуулж, мэдээлсэн болно. https://legalinfo.mn/mn/detail?lawId=17431391477802 | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 201 | 340 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 22 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-05-07 Дугаар 2025_22 | 22.21.4.1. Ажлын байрны орчин, амьдарч байгаа хашаандаа байгаль, цаг уурын нөхцөл байдалд тохирсон, өсөлт, хөгжилт сайтай мод тарьж ургуулан, И-Монголиа төрийн үйлчилгээний нэгдсэн системд бүртгүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулах асуудлыг судалж, зохих арга хэмжээ авахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар нарт; | 1."Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд тарьсан мод бүрийг бүртгэлжүүлэх, хяналт, урамшууллын үйл ажиллагааг төрийн үйлчилгээний нэгдсэн "И-Монголиа" системд нэгтгэх талаар хууль, дүрэм журмын зохицуулалтыг судалж, санал боловсруулан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Ойн газрын төлөөллүүдэд танилцуулсан. 2. Мод бүртгүүлэх үйлчилгээг Төрийн үйлчилгээний E-Mongolia нэгдсэн системд шинээр нэмж хэрэглээнд нэвтрүүлсэн. Иргэд E-Mongolia аппликэйшнд нэвтрэн "мод бүртгүүлэх" цэс рүү орж, өмнө болон шинээр тарьсан модоо бүртгүүлэх, ямар төрлийн модыг хаана, хэзээ тарьсан болон тарьж ургуулсан модны зургийг оруулах нөхцөлийг бүрдүүлсэн. Мод бүртгүүлэх үйлчилгээг 2025.05.10-ны өдөр нэвтрүүлсэн бөгөөд 6614 /шинэ тарьсан 1,746, өмнө тарьсан 4,868/ хүсэлт ирсэн. Мод тариулах хүсэлт 1480 ирүүлсэн байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 341 | | 22.21.2.1. Бүсийн хөгжлийг дэмжих зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын тогтоолын төсөлд санал шуурхай боловсруулж ирүүлэхийг Засгийн газрын гишүүдэд; | "Говь, Хойд, Төвийн бүсийн хөгжлийг дэмжих зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын тогтоолын төсөлд санал боловсруулан 2025 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн 01/1186 дугаартай, 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 01/1324 дугаартай албан бичгээр Монгол Улсын шадар сайд С.Амарсайханд хүргүүлэв. Монгол Улсын газрын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 204 дүгээр тогтоолоор Хойд бүсийн цахим шилжилтийг эрчимжүүлэх хүрээнд Хөвсгөл аймгийн Мөрөн суманд Бүсийн дата төв, Орхон аймгийн Эрдэнэт хотод Мэдээллийн технологийн төрөлжсөн төв байгуулах төсөл хөтөлбөрүүд тусгагдсан. Бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан бүс, орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх мега төслүүдийн саналыг боловсруулан 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 01/1589 дугаартай албан бичгээр Монгол Улсын шадар сайд С.Амарсайханд хүргүүлэв.<br><br>Хавсралт : 3 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 342 | | 22.21.2.3.. Бүсийн зөвлөлийн хуралдаан болон Засгийн газрын өргөтгөсөн хуралдааны үеэр хуралдаан болох байршилд үүрэн холбооны сүлжээний 4G/LTE үйлчилгээний чанар, хүртээмж, суурин интернэтийн багтаамжийг нэмэгдүүлэх, бүсийн өргөтгөсөн хуралдаанд оролцогчдыг цахим хэлбэрээр бүртгэх арга хэмжээ авч ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүд, цахилгаан эрчим хүчний найдвартай ажиллагаа, нөөц эх үүсвэрийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Дорноговь аймгийн Засаг дарга О.Батжаргал нарт; | Хангайн бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдааны үеэр үүрэн холбооны яриа тасалдах, хөдөлгөөнт өргөн зурвасын интернэтийн хурд удаашрах, тасалдал үүсэх зэрэг доголдлууд гарсан тул цаашид зохион байгуулагдах бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан болох байршлуудад үүрэн холбооны сүлжээний үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, аливаа доголдлыг урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох техник, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх чиглэл хүргүүлэх тухай 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 02/936 албан бичгийг үүрэн холбооны оператор байгууллагууд болон Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-д хүргүүлсэн. “Бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдаан”-ыг бүс тус бүрээр зохион байгуулахад тус яамнаас холбогдох албан хаагчид оролцсон бөгөөд хуралдаан болох байршилд үүрэн холбооны сүлжээний 4G/LTE үйлчилгээний чанар, хүртээмж, суурин интернэтийн багтаамжийг нэмэгдүүлэх, бүсийн өргөтгөсөн хуралдаанд оролцогчдыг цахим хэлбэрээр бүртгэх /E-Mongolia/ арга хэмжээнд дэмжлэг үзүүлэн ажилласан.<br><br>Хавсралт : 4 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 343 | | 24.35.8.1.. Иргэдээс цахимаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг чиг үүргийн хүрээнд хууль тогтоомжид заасан хугацаанд шуурхай шийдвэрлэж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд; | Иргэд, олон нийттэй харилцах төв /11-11/-өөс 2025 оны жилийн эцсийн байдлаар 44 ирүүлсэн өргөдөл, гомдлыг чиг үүргийн хүрээнд хууль тогтоомжид заасан хугацаанд шуурхай шийдвэрлэсэн. Түүнчлэн иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайланг Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолд заасан хугацаанд тайлагнан ажиллаж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 344 | | 24.35.7.1.2.. Өөрийн эрхлэх асуудлын хүрээний орон нутаг дахь удирдлагын босоо тогтолцоотой нэгжийн үйл ажиллагааны бүтэц, чиг үүрэгт шинжилгээ, тооцоо судалгаа хийж, харьяа аймаг, сумын Засаг даргын Тамгын газар, иргэдийн саналыг үндэслэн байгууллагын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт оруулах өөрчлөлтийн санал боловсруулж, танилцуулахыг Засгийн газрын гишүүдэд; | Өөрийн эрхлэх асуудлын хүрээний орон нутаг дахь удирдлагын босоо тогтолцоотой нэгж байхгүй болно. | Х.Б | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 202 | 345 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 24 дүгээр хуралдааны тэмдэглэлд 2025-05-21 Дугаар 2025_24 | 24.35.7.1.4.. Төрийн байгууллагууд ашигладаг цахим систем, мэдээллийн санд дүн шинжилгээ хийж, мэдээллийн уялдаа холбоог ханган давхардлыг арилгах, систем хоорондын интеграци хийх, Засгийн газраас тогтоосон цахим ур чадварын бүтцийн хүрээний агуулгын дагуу орон нутгийн төрийн албан хаагчдын цахим ур чадварыг сайжруулах хөтөлбөр боловсруулж, сургалт зохион байгуулахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүд; | Төрийн байгууллагуудын ашиглаж байгаа цахим систем, мэдээллийн санд дүн шинжилгээ хийж, систем хоорондын залгамж, уялдаа холбоог ханган давхардлыг арилгах чиглэлээр холбогдох танилцуулгыг Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар 08 дугаар сарын 25-ны өдрийн 01/1936 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн. Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанд танилцуулж, дэмжигдэн байгууллагуудад үүрэг чиглэл хүргүүлсэн. Цаашид төрийн байгууллагууд өөрийн ашиглаж байгаа цахим системийг system.gov.mn цахим системээр бүртгүүлэх, эрхлэх асуудлын хүрээнд бүрдүүлсэн төрөлжсөн мэдээллийн сангийн мета-өгөгдлийг "Төрийн мета-өгөгдлийн нэгдсэн сан"-д бүртгүүлэх, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө system.gov.mn цахим системээр зөвлөмж, дүгнэлтийг тухай бүр авч уялдаа холбоог ханган ажиллаж байна. Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх I, II, III шатны сургалт 2022 онд 1,132 удаагийн 2,444 цагийн цахим ур чадварын сургалтад нийт 84,744 хүнийг хамруулсан. Мөн сургалтыг 21 аймаг дахь Мэдээллийн технологийн хэлтэс, “ХУРДАН” клубээрээ дамжуулан үе шаттай зохион байгуулж, нийт 90,037 хүнд сургалт явуулсан. Бүх нийтийн цахим ур чадвар олгох V аяны хүрээнд 2025 онд улсын хэмжээнд 21 аймагт 105 удаа, 112 суманд 560 удаагийн сургалтыг зохион байгуулж, нийт 48248 иргэнийг хамруулсан байна. Бүх нийтийн харилцаа холбоо, мэдээллийн суурь мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилгоор иргэдэд цахим ур чадвар олгох төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагуудтай хамтран танхим болон цахим хэлбэрээр 63 удаагийн давтамжтай сургалтад нийт 5008 иргэнийг хамруулсан байна.<br><br>Хавсралт : 2 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 346 | | 25.1.2. Аж ахуйн нэгжийн тооллогын мэдээллийг суурь болон төрөлжсөн мэдээллийн сангийн мэдээлэлд үндэслэн шинэчилж ажиллахыг Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваад зөвлөж, шаардлагатай дэд бүтцийн орчныг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүд даалгав.” | “Тооллого явуулахад дэмжлэг үзүүлэх тухай”, “Аж ахуйн нэгжийн тооллого явуулах тухай” Засгийн газрын тогтоолын төслүүдэд санал боловсруулан 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 01/1210 дугаар албан бичгээр Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 203 | 347 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 25 дугаар хуралдааны тэмдэглэл<br>2025-05-28<br>Дугаар 2025_25 | 25.2.2. Хүн ам, орон сууцны завсрын тооллогын мэдээллийг суурь болон төрөлжсөн мэдээллийн сангийн мэдээлэлд үндэслэн шинэчилж ажиллахыг Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваад зөвлөж, шаардлагатай дэд бүтцийн орчныг “Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газарт бий болгох асуудлыг судалж, зохих арга хэмжээ авахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүд даалгав.” | Үндэсний статистикийн хорооноос зөвлөмж, дүгнэлт гаргуулахаар 2024 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 07/889 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн систем”-ийг шинэчлэн хөгжүүлэх ажлын даалгаварыг нийтийн мэдээллийн систем хоорондын харилцан уялдаа, нийтийн мэдээллийн системийн эдийн засгийн үр ашигтай байдал, хэрэглэх технологийн нийцэл, хүний хэрэглээнд тохирсон байдал, аюулгүй, найдвартай байдлын шийдэл зэрэг шаардлагын дагуу хянан үзэж зөвлөмж, дүгнэлт гаргаж хүргүүлсэн. Үндэсний статистикийн хороо тооллогыг бүртгэлд суурилсан аргаар буюу төрийн 15 байгууллагын суурь болон төрөлжсөн мэдээллийн санг ашиглан иргэдийн төрд байгаа мэдээлэл (хүн амын шилжилт хөдөлгөөн, хөдөлмөр эрхлэлт, боловсрол, өрхийн орон сууцны төрөл, нөхцөл зэрэг үзүүлэлт)-ийг бүрдүүлэн зохион байгуулж байна. Суурь болон төрөлжсөн мэдээллийн сангийн мэдээллийг Төрийн мэдээлэл солилцооны ХУР системээр дамжуулан бүрдүүлж байгаа бөгөөд сервис гаргах хүсэлтийг тухай бүр шийдвэрлэж ажиллаж байна. Үүнд: - Үндэсний статистикийн хорооноос "Хүн ам, орон сууцны 2025 оны завсрын тооллого" хийж байгаатай холбогдуулан мэдэгдэл хүргүүлэх хүсэлт ирүүлсэний дагуу И-Монгол академи УТҮГ-т 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 02/1267 дугаар албан бичгээр хүргүүлж шийдвэрлэсэн. - Үндэсний статистикийн хорооноос боловсролын талаарх мэдээлэл авах хүсэлтийн дагуу "Боловсролын мэдээллийн технологийн төв" УТҮГ-аас үндсэн системд мэдээлэл нийлүүлэх хүсэлтийг И-Монгол академи УТҮГ-т 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 02/1689 дугаар албан бичгээр хүргүүлж шийдвэрлэсэн. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 348 | | 25.31.1.1. 2024 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнд үндэслэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь өөрийн үйл ажиллагаанд дүгнэлт хийж, хэрэгжээгүй болон хэрэгжилт хангалтгүй байгаа арга хэмжээг эрчимжүүлэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлж, дүнг 2025 оны 4 дүгээр улиралд багтаан Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт ирүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны чиг үүрэгт хамаарах Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний цахим систем www.unelgee.gov.mn-д оруулж тайлагнаж байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хяналтад авсан 358 зүйл, заалтын хэрэгжилтийг дунджаар 89,19%-тай үнэлгдэн 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 03/1291 дугаар албан бичгээр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн. Үүрэг, даалгаврын хэрэгжилтийн явц, үр дүнгийн тайланг улирал тутамд Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлж байна. 2025 оны 1 дүгээр улирлын 246 заалтын биелэлтийг 2025 оны 02 дугаар сарын 03/511 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлж, Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний цахим систем www.unelgee.gov.mn-д оруулсан. Мөн хэрэгжилт удаашралтай, эрчимжүүлэх шаардлагатай 22 заалтын биелэлтийг 05 дугаар сарын 14-ний өдөр тус системээр тайлагнасан.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 349 | | 25.31.1.3. “Журам батлах тухай” Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-д заасан үнэлгээ хийх аргачлалыг Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-д нийцүүлэн шинэчлэх асуудлыг судалж, санал боловсруулан танилцуулахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүд; | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/82 дугаар “Ажлын хэсэг байгуулах тухай” тушаалаар Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-д нэмэлт, өөрчлөлтийн саналыг Засгийн газрын гишүүдээс авч, нэгтгэн боловсруулж байна. | Тодорхой үр дүнд хүрсэн - 50% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 204 | 350 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 3 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-06-25 Дугаар 2025_3 | 3.17.6.2.. Эрхэлсэн салбар, хариуцсан чиг үүргийн хүрээнд тус чуулганы арга хэмжээнд зохих дэмжлэг үзүүлж, идэвхтэй, оролцоог бүрэн хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд; | Тус чуулганд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас салбар хуралдааныг 5 гишүүнтэй гадны төлөөллийг хамруулан зохион байгуулсан. Дижитал эрин: Хиймэл оюун ухаан ба дэд бүтэц сэдвээр илтгэл тавьж, хэлэлцүүлсэн. | Хэрэгжсэн - 100% | Тийм | Тус чуулган зохион байгуулагдаж дууссан тул хяналтаас хасуулах саналтай байна. |
| 205 | 351 | Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 4 дүгээр хуралдааны тэмдэглэл 2025-07-02 Дугаар 2025_4 | 1.1. Эрхэлсэн чиг үүрэг, харьяа салбарын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа Засгийн газрын агентлаг, төв, нэгж, улсын үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн чиг үүрэг, үйл ажиллагааны үр ашиг, үндэслэл, хэрэгцээ, шаардлагад дүн шинжилгээ хийж, нэгтгэх, нийлүүлэх, татан буулгах замаар өөрчлөн зохион байгуулах, чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах, бүтэц, орон тоог оновчтой тогтоох, төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн холбоодод шилжүүлэн гүйцэтгүүлэх саналыг холбогдох шийдвэрийн төслийн хамт боловсруулж, 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах; | Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн А/223 дугаар тушаалаар яамны зохион байгуулалтын бүтцийн батлагдсан орон тооноос 9 хувь бууруулан боловсруулах, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулсан. Засгийн газрын 2025 оны 07 дугаар тогтоолын дагуу Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/263 дугаар тушаалаар тус яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн албан тушаалын нэр, ангилал, зэрэглэл орон тоог баталсан. Хүний нөөцийн сул орон тоог нөхөх тусгай шалгалтын сонгон шалгаруулалтын зарыг 2025 оны 12 дугаар сарын 15-26-ны өдрүүдэд Төрийн албаны зөвлөлийн шалгалтын "цахим системд" нээлттэй байршуулан, сонгон шалгаруулалтыг 2026 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр явуулж сул орон тоог нөхөн ажиллаж байна.<br>https://se.csc.gov.mn/search?sector_id=02001022 | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 352 | | 1.2.. Засгийн газрын агентлагийн үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг боловсруулахад зохион байгуулалтын бүтцийн нэгж, ажилтны чиг үүрэг, хариуцах ажил нь яамны зохион байгуулалтын бүтцийн нэгж, албан хаагчийн болон тухайн агентлагийн харьяа төв, орон нутгийн байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, компани, гэрээний үндсэн дээр төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын хариуцсан чиг үүрэг, ажилтай давхардахгүй байх чиглэл баримтлах; | 1.Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 07 дугаар тогтоолоор Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны зохион байгуулалтын бүтцийг 5 газар, 5 хэлтэс, орон тооны дээд хязгаарыг 89 байхаар шинэчлэн тогтоосон. Тус яамны зохион байгуулалтын нэгж, орон тооны хязгаарт өөрчлөлт орсонтой холбогдуулан Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/263 дугаар тушаалаар яамны зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын нэрс, ангилал, зэрэглэлийг шинээр баталсан. Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 411, 412, 413 дугаар тогтоолоор албан тушаалын тодорхойлолтыг батлах зөвшөөрөл олгосны дагуу Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/305, 306, 307 дугаар тушаалаар албан тушаалын тодорхойлолтыг баталсан. Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн Б/141 дүгээр тушаалаар яамны үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор албан тушаалын тодорхойлолтын дагуу Төрийн албаны тухай хуульд нийцүүлэн төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангаи албан хаагчдыг үргэлжлүүлэн томилсон.<br>2.Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 10 дугаар 09-ний өдрийн А/134 дүгээр тушаалаар Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тоог, А/137 дугаар тушаалаар Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ-ын зохион байгуулалтын нэгжийн албан тушаалын нэр, орон тоог шинэчлэн тус тус баталж, чиг үүргийн давхардлыг арилгах, албан тушаалтны тоог бууруулах, хариуцсан чиг үүрэг, ажилтай давхардахгүй байх арга хэмжээ авсан.<br><br>Хавсралт : 2 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 353 | | 1.3.. Засгийн газрын агентлагийн бүтцийн нэгжийн оноосон нэр нь яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн нэртэй давхардахгүй байх, хуульд өөрөөр заагаагүй бол дэд, орлогч даргагүй байх, үндсэн чиг үүрэгт хамааралгүй хэлтэс газар дотор байгуулахгүй байх, хэлтэс нь дотроо тасаг, албагүй байхаар тогтоох чиглэл баримтлах; | "Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 07 дугаар тогтоолоор тус яамны зохион байгуулалтын бүтцийг давхардахгүй байх, чиг үүрэгт хамааралгүй хэлтэс газар дотор байгуулахгүй байх, хэлтэс нь дотроо тасаг, албагүй байхаар батлагдсан. Тодруулбал Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах байгууллагуудын нэр, яамны дотоод нэгжийн нэршилтэй давхардаагүй болно.<br>Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 10 дугаар 09-ний өдрийн А/134 дүгээр тушаалаар Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тоог шинэчлэн баталж, чиг үүргийн давхардлыг арилгах, албан тушаалтны тоог бууруулах арга хэмжээ авсан. https://legalinfo.mn/mn/detail?lawId=17432004217932"<br><br>Хавсралт : 2 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 354 | | 1.4.. Засгийн газрын агентлагийн орон тооны дээд хязгаар тогтоох саналыг Монгол Улсын хөгжлийн 2026 оны жилийн төлөвлөгөөнд заасан орон тоо бууруулах чиглэл, төсвийн зардлыг хязгаарлах, хэмнэх зорилгод нийцүүлэн боловсруулах. | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 10 дугаар 09-ний өдрийн А/134 дүгээр тушаалаар Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тоог шинэчлэн баталж, чиг үүргийн давхардлыг арилгах, албан тушаалтны тоог бууруулах арга хэмжээ авсан. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 206 | 355 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 7 дугаар хуралдааны тэмдэглэл<br>2025-07-07<br>Дугаар 2025_07 | 2.2. Хуульд заасан чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлж, Засгийн газрын бодлого, шийдвэрийг зөрчсөн тул Пушаагийн Алтан-Одыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсон тушаалыг 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн дотор хүчингүй болгох арга хэмжээ авахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугарт даалгав.Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын сонгон шалгаруулалт зарлагдаж, томилогдох хүртэл хугацаанд Төрийн албаны хууль тогтоомжид заасны дагуу түүний албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх арга хэмжээ авахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугарт даалгав. | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 7 дугаар хуралдааны 2.2-т тус яамны Төрийн нарийн бичгийн даргын сонгон шалгаруулалт зарлагдаж, томилогдох хүртэл хугацаанд Төрийн албаны хууль тогтоомжид заасны дагуу түүний албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх арга хэмжээ авахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугарт даалгасан. Тус тэмдэглэлийг үндэслэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн Б/26 дугаар тушаалаар Ч.Золбаярыг томилсон. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 207 | 356 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 09 дүгээр хуралдааны тэмдэглэл 2025-07-23 Дугаар 2025_09 | 5.1.3. Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд туссан төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангуулах хүрээнд Монгол Улсын 2026 оны төсвийн төслийг боловсруулахдаа хүний хөгжлийг дэмжих, хүний эрхийг хангах, гэр бүл салалт, гэмт хэргийг бууруулах, хүүхдийн боловсрол, нийтийн эрүүл мэндийг дэмжих, ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад чиглэсэн хөгжлийн төсөл, арга хэмжээг орхигдуулахгүй байхад анхаарч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд; | Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгуулах төслийн саналд хүний хөгжлийг дэмжих, гэмт хэрэг бууруулах, хүүхдийн боловсролын чиглэлээр яамны эрхлэх асуудлын хүрээнд шийдвэрлэх шаардлагатай нийт 19 ажил, арга хэмжээг 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/98 дугаартай албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн. Мөн нэмж тусгуулахаар Эдийн засаг, хөгжлийн яаманд 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 01/916 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br>УИХ-ын 2025 оны 48 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тус яамны хэрэгжүүлэх 11 арга хэмжээ тусгагдсныг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.<br>Цахим хуудаст хандах: https://legalinfo.mn/mn/detail?lawId=17432532573472&showType=1<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Тийм | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай |
| | 357 | | 5.1.4. Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд тусгах Засгийн газраас хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлын талаар Улсын Их Хурлын гишүүдэд танилцуулж, хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүдэд; | Тус яамнаас Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгуулах төслийн санал, тайлбар, шалгуур үзүүлэлтийг эдийн засгийн үр ашиг, хийгмийн ач холбогдлоор ангилан нэгтгэж, Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2025 оны 04 дүгээр сарын 15, 05 дугаар сарын 22-ны өдрийн ээлжит хуралдаан болон УИХ-ын хаврын ээлжит чуулганд хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж ажилласан. Мөн Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төслийг УИХ-ын чуулганаар хэлэлцэхтэй холбогдуулан Эдийн засаг, хөгжлийн яамны төлөвлөгөөнд туссан 2 төсөл, арга хэмжээ болон шинээр нэмж тусгах 4 төсөл, арга хэмжээг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам хариуцан хэрэгжүүлэх зарчмын зөрүүтэй саналын томьёол боловсруулж, Инновац, цахим бодлогын байнгын хорооны даргад хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 358 | | 5.1.5. Төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй, шуурхай үзүүлэх, цахимжуулж ажиллахыг яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт, алдаа, зөрчил гаргасан албан тушаалтанд тухай бүр хариуцлага тооцож ажиллахыг Засгийн газрын гишүүдэд, хяналт тавьж, салбар дундын уялдаа зохицуулалтыг хангаж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогтод. | 1.И-Баримтыг банкны картаар дамжуулан НӨАТ-ын системд автоматаар бүртгэх нөхцөлийг бүрдүүлсэн. 2025 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн байдлаар хэрэглэгчийн систем нийлүүлэгч 8 байгууллагын систем ашиглагч 4147 цэгээс нийт төлбөрийн баримтын 7 орчим хувь нь 3 банкны картаар автоматаар бүртгэгдэх боломжтой болсон байна. 2.Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia)-ийн 5.0 системийг хамгийн сүүлийн үеийн загвар дизайн бүхий хөгжүүлж, 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр ашиглалтад нэвтрүүлсэн. Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-Mongolia.mn)-ээр дамжуулан өргөдөл, гомдол илгээх хөгжүүлэлтийг хийсэн. Тухайн өргөдөл, гомдлыг 11-11 системээр дамжуулан хариуцагч байгууллагад шилжүүлэх бөгөөд шийдвэрлэлтийг мөн И-Монгол системээр дамжуулан буцаан авна. Цаашид DocX системд холбогдсон 17 Erp систем хөгжүүлэгч байгууллагын албан хэрэг хөтлөлтийн системээр дамжуулан иргэнд цахим хэлбэрээр албан бичиг хүргүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд систем хөгжүүлэгч байгууллагуудад өөрсдийн ERP системд хөгжүүлэлт хийн, шаардлагатай холболтуудыг хийхэд хамтран ажиллах талаар 02/2142 дугаартай албан бичгийг хүргүүлсэн. 3.Үндэсний танилт нэвтрэлтийн систем (DAN)-ийн 2.0 хувилбарыг хялбар, тасралтгүй нэвтрэх нөхцөл бүрдүүлэх, Гадаад улсад ажиллаж амьдарч буй иргэдийг таних, баталгаажуулах, Нотариатын итгэмжлэлээр үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэх, Хэрэглэгчээ таних /KYC/ тогтолцоог бий болгох, Байгууллагын нэвтрэлтийг хялбарчлах, Хүүхдийн нэвтрэлтийг оновчтой болгох, Нууц үггүй нэвтрэлт (Fido2 standard), хоёр үе шаттай баталгаажуулалт (2FA), токен болон криптограф аргуудыг нэвтрүүлэх, Нууцлал, мэдээллийн хамгааллын олон улсын стандартад нийцсэн хамгаалалтын протоколууд ашиглах (OAUTH 2.1), Эрх сэргээх/хаах, Хандсан төхөөрөмжийн удирдлага, Хандалт, ашиглалтын лог мэдээлэх зэрэг хөгжүүлэлтийг хийж, 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр ашиглалтад нэвтрүүлсэн. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 208 | 359 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 10 дугаар хуралдааны тэмдэглэл<br>2025-07-30<br>Дугаар 2025_10 | 14.4.. Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт 2023-2025 оны улсын хэлэлцээрийн талаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт 2023-2025 оны улсын хэлэлцээрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, шинээр байгуулах хэлэлцээрийн төслийг боловсруулан 2025 оны 9 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, “Нийгмийн түншлэлийг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2013 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн 370 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, үйл ажиллагаагаа эрчимжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав. | "Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын ажилтан, албан хаагчдын хөдөлмөрлөх, түүнтэй холбогдох эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор Монголын тээвэр, холбоо, газрын тосны ажилтны үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо, тус салбарын төрийн болон төрийн өмчит хуулийн этгээдүүд хамтран 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр “Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарт 2023-2025 онд хэрэгжүүлэх хамтын хэлэлцээр”-ийг байгуулсан. Уг хамтын хэлэлцээрийг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хянан баталгаажуулж, 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдөр бүртгэн хүчин төгөлдөр болсон тул хэлэлцээрийг хэрэгжүүлж ажиллах талаар харьяа болон салбарын байгууллагын удирдлагуудад албан чиглэл өгч ажилласан. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 208 | 360 | | 9.7. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29.1 дэх хэсгийн хэрэгжилтийн талаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулахад цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар зөвлөмж, дүгнэлт гаргуулж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад даалгав. | ЦХХХС-ын 2022 оны А/18 дугаар тушаалаар батлагдсан Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө үйл ажиллагаанд зөвлөмж, дүгнэлт гаргах журмыг шинэчлэн боловсруулж байна. Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө үйл ажиллагаанд зөвлөмж, дүгнэлт гаргуулахтай холбоотой танилцуулгыг Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар 2025 оны 08 дугаар сарын 05-ны өдөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Мөн төрийн байгууллагуудын ашиглаж байгаа цахим систем, мэдээллийн санд дүн шинжилгээ хийж, систем хоорондын залгамж, уялдаа холбоог хангаж давхардлыг арилгах чиглэлээр холбогдох танилцуулгыг бэлтгэн Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 01/1936 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Цаашид төрийн байгууллагууд өөрийн ашиглаж байгаа цахим системийг system.gov.mn цахим системээр бүртгүүлэх, эрхлэх асуудлын хүрээнд бүрдүүлсэн төрөлжсөн мэдээллийн сангийн мета-өгөгдлийг "Төрийн мета-өгөгдлийн нэгдсэн сан"-д бүртгүүлэх, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 заасны дагуу нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө system.gov.mn цахим системээр зөвлөмж, дүгнэлтийг тухай бүр авч уялдаа холбоог хангаж ажиллах юм. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 209 | 361 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 11 дүгээр хуралдааны тэмдэглэл<br>2025-08-06<br>Дугаар 2025_11 | 8.1.2. Бүсийн зөвлөлийн болон Засгийн газрын өргөтгөсөн хуралдааныг бүсийн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн, тухайн бүсээс сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд, орон нутгийн удирдлага, иргэдийн санал, оролцоог хангаж, төсвийн хэмнэлтийн горимоор, урлаг, спортын, шаардлагагүй бусад арга хэмжээгүй зохион байгуулахыг холбогдох Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | Зүүн бүсээс сонгогдсон УИХ-ын гишүүдийн Нэгдсэн ажлын алба, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамтай хамтран ахлах ангийн сурагчдын дунд “Эргэх холбоо cup 2025” харилцаа холбоо, мэдээллийн технологийн тэмцээнийг зохион байгуулсан юм. Дрон жолоодлого, цахим спорт, уран илтгэл гэсэн гурван төрлөөр явагдсан тэмцээнд Сүхбаатар, Хэнтий, Дорнод аймгийн 168 сурагч оролцож, шилдгүүдээ шалгарууллаа. Мөн Чанар хяналтын газар, Сургалт хөгжлийн хэлтсээс аймгийн мэдээлэл технологийн ажилтнууд, төрийн албан хаагчид, “ХУРДАН” клубийн гишүүдэд Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-ийн ашиглалт, “Цахим хөгжлийн багц хууль”, “Хиймэл оюуны хэрэглээ ба эерэг, сөрөг тал”, “Кибер аюулгүй байдал”, “Цахим залилангаас урьдчилан сэргийлэх”, “Цахим донтолт” зэрэг сэдвүүдээр сургалт орж, мэдээлэл өглөө. Түүнчлэн тэмцээний өдрүүдэд Сүхбаатар аймгийн хүн амын төвлөрөл ихтэй хэсгүүдэд хөдөлгөөнт “ХУРДАН” цэгийг байршуулж, иргэдэд төрийн үйлчилгээг шинэлэг хэлбэрээр түргэн шуурхай үзүүлсэн болно. https://www.facebook.com/watch/?v=657021344039220 | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 362 | | 9.7.. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29.1 дэх хэсгийн хэрэгжилтийн талаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулахад цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар зөвлөмж, дүгнэлт гаргуулж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад даалгав. | ЦХХХС-ын 2022 оны А/18 дугаар тушаалаар батлагдсан Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө үйл ажиллагаанд зөвлөмж, дүгнэлт гаргах журмыг шинэчлэн боловсруулж 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/164 дүгээр тушаалаар баталсан. Хууль зүйн улсын бүртгэлийн нэгдсэн санд бүртгүүлэх бичгийг 2025 оны 12 дугаар сарын 16-ны 01/2856 тоот албан бичгийг хууль зүйн яаманд хүргүүлсэн. 2025 оны жилийн эцсийн байдлаар 19 мэдээлэл хариуцагч байгууллагын 40 нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө зөвлөмж, дүгнэлтийг system.gov.mn системээр өгсөн байна.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 363 | | 10.4.1.. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авахыг доор дурдсан албан тушаалтнуудад даалгав:<br>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан нээлттэй мэдээллийг үнэн зөв, иргэдэд ойлгомжтой байдлаар цахим хуудсандаа болон нээлттэй мэдээллийн системд 2025 оны 10 дугаар сарын 01-ний дотор бүрэн байршуулахыг яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан нээлттэй мэдээллийг үнэн зөв, иргэдэд ойлгомжтой байдлаар цахим хуудсандаа болон нээлттэй мэдээллийн системд байршуулсан. Тус яамны нээлттэй мэдээллийн ил тод байдлын 2025 оны 4 дүгээр улирлын үнэлгээ 98%, Засгийн газрын агентлаг-Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 4-р улирлын үнэлгээ хийгдэж байна.<br>https://shilen.gov.mn/index | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 210 | 364 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 15 дугаар хуралдааны тэмдэглэл<br>2025-09-02<br>Дугаар 2025_15 | 10.4.3.. “shilen.gov.mn” цахим хуудсыг хөтлөх үйл ажиллагааг журамлах, үнэлгээний үнэн зөв, бодитой байх шалгуур үзүүлэлтийг сайжруулах, нээлттэй мэдээллийн системийг хөгжүүлж, иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй болгох, мэдээлэл хариуцагч байгууллагуудын алба хаагчдад зориулсан сургалтыг тогтмол зохион байгуулж, үйл ажиллагаагаа холбогдох байгууллагуудтай уялдуулж ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугарт; | Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газраас 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр нээлттэй мэдээллийг shilen.gov.mn-д тайлагнахтай холбоотой сургалтыг төрийн захиргааны төв байгууллагын холбогдох албан хаагчдыг хамруулан зохион байгуулсан. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 365 | | 10.4.4.. Эрхлэх асуудлын хүрээнд харьяа яам, Засгийн газрын агентлаг, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээд буюу мэдээлэл хариуцагчдын хууль биелүүлэх үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээлэл хариуцагч байгууллага байнга ил тод, нээлттэй байлгах 67 төрлийн мэдээллийг нээлттэй байршуулсан эсэх талаарх “Шилэн индекс”-ийн тайланг тус яамны харьяа Засгийн газрын агентлаг-Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар хүлээн авч, үнэлгээ хийж байна. "shilen.gov.mn" системийн 2.0 хувилбарын тусламжтай мэдээлэл хариуцагч байгууллага нээлттэй мэдээллээ оруулах, шинэчлэх, үнэн зөв, бүрэн, бүтэн байдлыг хариуцах боломжийг бүрдүүлсэн. 2025 оны 1 дүгээр улиралд 1135 байгууллага, 2 дугаар улиралд 1621 байгууллага, 3 дугаар улиралд 1879 байгууллага хуулийн хугацаанд тайлан илгээсэн. 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 1135 тайлан илгээж, 1126 байгууллагын үнэлгээ хийсэн. "Шилэн Индекс"-ийн тайлан: Төрийн захиргааны төв байгууллага 92.61% (Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон 11 яам), Төрийн захиргааны байгууллага 79.61% (23 агентлаг), нийслэлийн Засаг даргын Тамгын газар 55.59% (НЗДТГ, 6 ЗДТГ), Нутгийн захиргааны байгууллага 75,84% (14 аймаг), 2 дугаар улирлын байдлаар нийт 1879 тайлан илгээж, 1876 байгууллагын үнэлгээ хийсэн. Төрийн захиргааны төв байгууллага 95.69%, Төрийн захиргааны байгууллага 79.49% (29 агентлаг), Нийслэлийн Засаг Даргын тамгын газар 80.4% (НЗДТГ, 8 ЗДТГ), Нутгийн захиргааны байгууллага 75,84% (19 аймаг), 3 дугаар улирлын байдлаар Төрийн захиргааны төв байгууллага 49.4%, Төрийн захиргааны байгууллага 78.08% (33 агентлаг), Нийслэлийн Засаг Даргын тамгын газар 74.9% (НЗДТГ, 8 ЗДТГ), Нутгийн захиргааны байгууллага 77,09% (21 аймаг) гэсэн үзүүлэлттэй байна. Нээлттэй мэдээллийн нийт 45 төрлийн 970,355 мэдээллийг дор дурдсан чиглэлээр байршуулж, 15,784,843 удаагийн хандалт авсан байна. Хандах эрхийг 4,572 байгууллагын 5,113 албан хаагчдад олгож, Шилэн индексийн тайланг 2025.10.03-ны өдрийн 01/2274 албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. 2025 оны жилийн эцсийн үнэлгээг хийж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 211 | 366 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 16 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-09-10 Дугаар 2025_16 | 28.1.2.. иргэдээс төрийн байгууллагад гаргасан өргөдөл, гомдлын бүртгэл, ангилал, шийдвэрлэлтийг нэгдсэн байдлаар хянах, дүн шинжилгээ хийх, шалтгаан, нөхцөлийг тодруулах, хариу арга хэмжээ авах боломжийг хангасан нэгдсэн мэдээллийн сантай болгох тухай Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдааны 13 дугаар тэмдэглэлээр өгсөн үүргийн хэрэгжилтийг хангаж, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг “И-Монголиа” системээр дамжуулан тухай бүр иргэдэд хүргэх, иргэдээс шийдвэрлэлтийн байдалд үнэлгээ өгөх, төрийн байгууллага хооронд өргөдөл, гомдлыг шилжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, үр дүнг 2025 оны 09 дүгээр сард багтаан танилцуулахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал нарт; | Өргөдөл, гомдлын нэгдсэн мэдээллийн сангаас төрийн байгууллага хооронд өргөдөл, гомдлыг шилжүүлэх болон шийдвэрлэлтийн явцыг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем "И-Монголиа"-ээр дамжуулан тухай бүр иргэдэд хүргэх нөхцөлийг бүрдүүлэх талаар чиглэлийг 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 02/2567 дугаартай албан бичгээр И Монгол академи УТҮГ-т хүргүүлсэн. Улмаар өргөдөл, гомдлын нэгдсэн мэдээллийн санг хөгжүүлэн, Үндэсний дата төвд дэд бүтцийг шийдвэрлэн “MCloud” серверт байршуулж, 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн ашиглалтад оруулаад байна. Тус санд төрийн бүх байгууллагын өргөдөл, гомдлыг нэгтгэх зорилгоор төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системээр дамжуулан мэдээлэл солилцох 5 төрлийн “API” сервисийг хөгжүүлэн гарын авлагыг нээлттэй байршуулж, “EMongolia” ERP; “Able” ERP; Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дотоод удирдлагын ERP системүүдийг холбосон. Өргөдөл, гомдлын нэгдсэн мэдээллийн санг хөгжүүлсэн үр дүнгийн талаарх танилцуулга, мэдээллийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 01/2711 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 2 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 367 | | 28.1.3.. иргэдээс гаргасан өргөдөл, гомдлын бүртгэл, ангилал, шийдвэрлэлтийг нэгдсэн мэдээллийн санд тухай бүр бүртгүүлж байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт. | Өргөдөл, гомдлын нэгдсэн мэдээллийн сангаас төрийн байгууллага хооронд өргөдөл, гомдлыг шилжүүлэх болон шийдвэрлэлтийн явцыг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем "И-Монголиа"-ээр дамжуулан тухай бүр иргэдэд хүргэх нөхцөлийг бүрдүүлэх талаар чиглэлийг 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 02/2567 дугаартай албан бичгээр И Монгол академи УТҮГ-т хүргүүлсэн. Улмаар өргөдөл, гомдлын нэгдсэн мэдээллийн санг хөгжүүлэн, Үндэсний дата төвд дэд бүтцийг шийдвэрлэн “MCloud” серверт байршуулж, 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн ашиглалтад оруулаад байна. Тус санд төрийн бүх байгууллагын өргөдөл, гомдлыг нэгтгэх зорилгоор төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системээр дамжуулан мэдээлэл солилцох 5 төрлийн “API” сервисийг хөгжүүлэн, гарын авлагыг нээлттэй байршуулж, “EMongolia” ERP; “Able” ERP; Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дотоод удирдлагын ERP системүүдийг холбосон. Өргөдөл, гомдлын нэгдсэн мэдээллийн санг хөгжүүлсэн үр дүнгийн талаарх танилцуулга, мэдээллийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 01/2711 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 2 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 368 | | 28.2.1.. 1.Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт дараах арга хэмжээ авахыг даалгав:<br><br>1.1.хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн төслийг боловсруулахдаа тухайн асуудлаар өмнө нь гарсан шийдвэртэй утга агуулгын хувьд давхардуулан гаргахгүй байх, санхүү, төсвийн асуудлыг тусгасан, шалгуур үзүүлэлттэй, хэрэгжихүйц байхад анхаарах;<br><br>1.2.хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг өмнөх тайлант хугацааны биелэлттэй харьцуулж, салбарын хэмжээнд нэгтгэн, хүрсэн үр дүнг товч тодорхой, үнэн, зөв тайлагнах;<br><br>1.3.хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны зохицуулалтад шаардагдах төсөв хөрөнгийг шийдвэрлэх;<br><br>1.4.хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтийг тайлагнахдаа салбар хоорондын уялдаа холбоог сайжруулж, хэрэгжилтийг тогтмол | 1.Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн төслийг тухайн асуудлаар өмнө нь гарсан шийдвэртэй утга агуулгын хувьд давхардуулахгүй, санхүү, төсвийн асуудлыг тусгасан, шалгуур үзүүлэлттэй, хэрэгжихүйц байхад анхаарч боловсруулж байна.<br>2.Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны чиг үүрэгт хамаарах Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний цахим систем www.unelgee.gov.mn-д оруулж тайлагнаж байна. Үүрэг, даалгаврын хэрэгжилтийн явц, үр дүнгийн тайланг улирал тутамд Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлж байна. 2025 оны 1 дүгээр улирлын 246 заалтын биелэлтийг 2025 оны 02 дугаар сарын 03/511 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлж, Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний цахим систем www.unelgee.gov.mn-д оруулсан. Мөн хэрэгжилт удаашралтай, эрчимжүүлэх шаардлагатай 22 заалтын биелэлтийг 05 дугаар сарын 14-ний өдөр тус системээр тайлагнасан. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтийг тайлагнахдаа салбар хоорондын уялдаа холбоог сайжруулан тайлагнаж байна.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 369 | | 28.14.1.3.. шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд цахим хуудсанд байршуулж ажиллаагүй байгууллага, албан тушаалтанд хууль, гэрээнд заасны дагуу хариуцлага тооцож ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт. | Шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд цахим хуудсанд байршуулж байна. Шилэн дансны тухай хууль, шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын хэрэгжилтийг сайжруулах ажлын хүрээнд ТЕЗ-ын харьяа байгууллагуудад 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 01/2676 дугаар албан бичгээр зөвлөмж хүргүүлж ажилласан.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 370 | | 11.1.1. 1.хяналт-шинжилгээний тайлангийн дүнгийн мөрөөр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгов. | Тус яаманд хамаарах Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны эхний хагас жилийн тайланг 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 01/1564, жилийн эцсийн тайланг 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 01/2954 дугаартай бичгээр хүргүүлсэн. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, тус яаманд хамаарах үндсэн арга хэмжээний 2025 оны биелэлтийн тайланг үндэслэн ерөнхий гүйцэтгэл 48.14 хувьтай, өссөн дүнгээр 48.48 хувьтай, шалгуур үзүүлэлтийн хувьд бодлогын үнэлгээ 85.90 хувьтай, Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн 98.4 хувьтай, хөтөлбөрийн үр дүн 99.7 хувьтай тус тус үнэлэгдсэн. Түүнчлэн Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаар өгөгдсөн зөвлөмжийн дагуу яамны гүйцэтгэлийн төлөвлөгөө, 2026, 2027 оны төсвийн төсөлд ЗГҮАХ-г хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлыг тусган санал хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 212 | 371 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 24-ны өдрийн 18 дугаар хуралдааны тэмдэглэл<br>2025-09-24<br>Дугаар 2025_18 | 11.2. . 11.2.“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний эхний хагас жилийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээний дүнгийн талаар Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br>Үүнтэй холбогдуулан “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг төлөвлөсөн зорилтот түвшинд хүргэх, эрчимжүүлэх, нөөцийг оновчтой хуваарилах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд болон аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох төрийн захиргааны байгууллагын дарга нарт даалгав. | Монгол Улсыг хөгжүүлэх 2025 оны төлөвлөгөөний 2 тэргүүлэх чиглэлд нийт 4 зорилго, 13 зорилтыг дэвшүүлэн ажиллаж, биелэлтийг Хяналт хэрэгжүүлэх газарт 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 01/1564 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. 2025 оны эхний хагас жилийн биелэлт дундажаар 43,5 хувийн гүйцэтгэлтэй байсан ба жилийн эцсийн байдлаар 61 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Тийм | Хяналтаас хасуулах саналтай. |
| | 372 | | 11.5.. Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратегийн талаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br>Үүнтэй холбогдуулан Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратегид тусгагдсан зорилт, арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар нарт даалгав. | Их өгөгдөл, хиймэл оюуны өнөөгийн нөхцөл байдал болон дэлхийн цаашдын чиг хандлагын талаар судалж, Монгол Улсын хэмжээнд хиймэл оюуныг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудлын талаар судалж стратегийн төслийг боловсруулахад шаардлагатай суурь судалгааг хийсэн.<br>Дээрх суурь судалгаанд үндэслэн “Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратеги”-ийг төслийг 4 зорилтын хүрээнд 66 арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулан Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанд танилцуулж, 18 дугаар тэмдэглэлийн дагуу уг стратегид тусгагдсан зорилт, арга хэмжээг Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн “Шинжлэх ухаан, технологи, хиймэл оюун” бодлогын чиглэлийн хүрээнд тусгасан. "Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн төсөлд нийт 8 бүлэг асуудлын хүрээнд ТЕЗ-ийн түвшний 9, хөлбөрийн түвшний 21 ажлын үр дүн, арга замыг тодорхойлж хүргүүлсэн ба тус яам хариуцан хэрэгжүүлэх 11, хамтран хэрэгжүүлэх 7 ажил тусч, 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр УИХ-аар батлагдсан.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 373 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 01-ны | 9.1.1.. 9.1.Худалдан авах ажиллагааны төлөвлөлтийг сайжруулж, хууль, журамд нийцүүлэн шуурхай зохион байгуулах төлөвлөгөөний талаар Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:<br>1.шинээр 2026 онд эхлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг төлөвлөгөөний дагуу хууль тогтоомжид заасан хугацаанд авлига, албан тушаалын зөрчлөөс ангид байх зарчмыг баримтлан шуурхай зохион байгуулж ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав. | Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2026 онд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцад хэрэгжүүлэх дараах төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг батлагдсан төлөвлөгөөний дагуу хууль тогтоомжид заасан хугацаанд, ил тод, нээлттэй, шударга зарчмыг баримтлан зохион байгуулж байна. Үүнд:<br>1.УТ2606700065 төслийн кодтой “Үүрэн холбооны сүлжээ, дахин дамжуулах станц (улсын хэмжээнд)”,<br>2.УТ2606700120 төслийн кодтой “Үүрэн холбооны сүлжээ, дахин дамжуулах сүлжээ станц (Ховд аймаг)”,<br>3.УТ2606700121 төслийн кодтой “Өсвөрийн инженерүүдийн инновацын төвийн барилгын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв (Улаанбаатар хот, Баянгол дүүрэг)”,<br>4.УТ2606700119 төслийн кодтой “Төрийн цахим үйлчилгээ, хиймэл оюун, их өгөгдлийн суурь дэд бүтцийн тоног төхөөрөмж (улсын хэмжээнд)” төсөл, арга хэмжээнүүд багтаж байна.<br>Дээрх төслүүдийн худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байдлаар шуурхай хэрэгжүүлж, хяналт тавин ажиллаж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 213 | 374 | өдрийн 19 дүгээр хуралдааны тэмдэглэл<br>2025-10-01<br>Дугаар 2025_19 | 9.4.1.. 1.“Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв”-ийн тоног төхөөрөмж, ашиглалт, үйлчилгээг хариуцаж, хиймэл оюуныг нэвтрүүлэх, зардлыг батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэж Засгийн газрын 2022 оны 187 дугаар тогтоолын 1.4, 1.5 дахь хэсгийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугарт. | Өргөдөл, гомдлын нэгдсэн мэдээллийн сангаас төрийн байгууллага хооронд өргөдөл, гомдлыг шилжүүлэх болон шийдвэрлэлтийн явцыг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем "И-Монголиа"-аар дамжуулан тухай бүр иргэдэд хүргэх нөхцөлийг бүрдүүлэх талаар чиглэлийг 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 02/2567 тоот бичгээр И Монгол академид хүргүүлсэн. Улмаар өргөдөл, гомдлын нэгдсэн мэдээллийн санг хөгжүүлэн, Үндэсний дата төвд дэд бүтцийг шийдвэрлэн “MCloud” серверт байршуулж, 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн ашиглалтад оруулаад байна. Тус санд төрийн бүх байгууллагын өргөдөл, гомдлыг нэгтгэх зорилгоор төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системээр дамжуулан мэдээлэл солилцох 5 төрлийн “API” сервисийг хөгжүүлэн, гарын авлагыг боловсруулж, нээлттэй байршуулж, “EMongolia” ERP; “Able” ERP; Нийслэлийн Засаг даргын тамгын газрын дотоод удирдлагын ERP системүүдийг холбосон.Өргөдөл, гомдлын нэгдсэн мэдээллийн санг хөгжүүлсэн үр дүнгийн талаарх танилцуулга, мэдээллийг боловсруулж, 2025 оны 12 дугаар сарын 01 -ний өдрийн 01/2711 тоот бичгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 2 файл | Тодорхой үр дүнд хүрсэн - 50% | Үгүй | |
| 214 | 375 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 20 дугаар хуралдааны тэмдэглэл<br>2025-10-08<br>Дугаар 2025_20 | 16.4.1.. Үүнтэй холбогдуулан 2025 онд багтаан дараах арга хэмжээг авахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга болон мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад даалгав:<br>1.эрхлэх асуудлын хүрээнд бүрдүүлсэн төрөлжсөн мэдээллийн сангийн мета-өгөгдлийг “Төрийн мета-өгөгдлийн нэгдсэн сан”-д бүртгүүлэх; | “Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах” журамд нийцүүлэн “Төрөлжсөн бүртгэлийн сангийн нэгдсэн (infodata.gov.mn) систем”-ийг хөгжүүлж хэрэглээнд нэвтрүүлсэн. “Төрөлжсөн мэдээллийн сангийн нэгдсэн систем”-д мэдээлэл хариуцагч байгууллагын мэдээллийн сан - 68, статистикийн – 48, хүснэгт - 718, үзүүлэлт – 10528, ангилал, код - 1686 бүртгэгдсэн. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 376 | | 16.4.3.. 2.төрийн байгууллагуудын ашиглаж байгаа цахим систем болон мэдээллийн санг цахим систем (system.gov.mn)-д бүртгүүлэх; | Мэдээллийн системийн бүртгэл, зөвлөмж дүгнэлтийн (system.gov.mn)-д 2025 оны жилийн эцсийн байдлаар нийтийн мэдээлэл хариуцагч 23 байгууллагын 152 систем бүртгүүлсэн байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 377 | | 16.4.3.. 3.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасны дагуу цахим хэлбэрээр үзүүлэх төрийн үйлчилгээг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia.mn)-ээр үзүүлэх. | Мэдээлэл хариуцагч байгууллагуудаас цахим хэлбэрээр үзүүлэх үйлчилгээг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia.mn)-д нэтгэх хүсэлтийг тухай бүр хүлээн авч, Засгийн газрын 2022 оны 196 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-ын дагуу шийдвэрлэж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 215 | 378 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 26 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-11-05 Дугаар 2025_26 | 13.3.1.1.. 1.Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт дараах арга хэмжээг авахыг даалгав: 1.1.Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны “Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай” 01 дүгээр, “Нийгмийн шударга ёсыг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 02 дугаар, “Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах тухай” 03 дугаар, “Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 04 дүгээр албан даалгавраар хугацаатай өгсөн үүргийн хэрэгжилтийг эрчимжүүлэх; | 2025 онд Монгол Улсын Ерөнхий сайдын 01, 02, 03, 04 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллах талаар тус яамнаас харьяа байгууллагуудад 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 02/1714 дугаартай албан бичгээр чиглэл хүргүүлж, биелэлтийг Хэрэг эрхлэх газарт 08 дугаар сарын 11-ний өдрийн 02/1833, 11 дүгээр сарын 03-ны өдрийн 02/2478, 12 дугаар сарын 03-ны өдрийн 03/2736 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Албан даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр төлөвлөгөө баталж, харьяа байгууллагуудад 02/2671, 02/2672 дугаартай албан бичгээр төлөвлөгөөг хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br><br>Хавсралт : 3 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 379 | | 13.3.1.2. 1.2.эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хангалтгүй дүгнэгдсэн заалтын хэрэгжилтийг эрчимжүүлж, хэмжигдэхүйц шалгуур үзүүлэлт бүхий төлөвлөгөө боловсруулах, салбарын хэмжээнд бодит үр дүнг сар бүр нэгтгэн дүгнэж, товч, тодорхой тайлагнах, өмнөх сард тайлагнасан албан даалгаврын хэрэгжилтийг давтан тайлагнахгүй байх. | 2025 онд Монгол Улсын Ерөнхий сайдын 01, 02, 03, 04 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллах талаар тус яамнаас харьяа байгууллагуудад 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 02/1714 дугаартай албан бичгээр чиглэл хүргүүлж, биелэлтийг Хэрэг эрхлэх газарт 08 дугаар сарын 11-ний өдрийн 02/1833, 11 дүгээр сарын 03-ны өдрийн 02/2478, 12 дугаар сарын 03-ны өдрийн 03/2736 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Албан даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр төлөвлөгөө баталж, харьяа байгууллагуудад 02/2671, 02/2672 дугаартай албан бичгээр төлөвлөгөөг хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br><br>Хавсралт : 3 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 380 | | 13.3.3.. 3.“Монгол Улсыг 2025-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” бодлогын баримт бичгийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэнтэй холбогдуулан яамд таван жилийн салбарын хөгжлийн төлөвлөгөөнд тусган бодлогын өөрчлөлтийн талаар олон нийтэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгаа хийх төлөвлөгөө боловсруулж, 2025 оны 11 дүгээр сарын 10-20-ны өдрүүдэд хэрэгжүүлэх, төлөвлөгөөний хэрэгжилтийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлэхийг Засгийн газрын гишүүдэд даалгав; | "Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн төсөлд нийт 8 бүлэг асуудлын хүрээнд ТЕЗ-ийн түвшний 9, хөлбөрийн түвшний 21 ажлын үр дүн, арга замыг тодорхойлж хүргүүлсэн ба тус яам хариуцан хэрэгжүүлэх 11, хамтран хэрэгжүүлэх 7 ажил тусч, 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр УИХ-аар батлагдсан.<br>Мөн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-т “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг боловсруулахдаа олон талын оролцоог хангасан байх ба эцэслэгдсэн төслийг олон нийтээр хэлэлцүүлнэ.” гэж заасны дагуу Эдийн засаг хөгжлийн яамнаас 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдрөөс 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн хооронд Хүний хөгжил, Нийгмийн хөгжил, Эдийн засаг, дэд бүтцийн хөгжил, Байгаль орчин, Засаглал, Бүсийн хөгжил, Үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх гэсэн сэвүүдийн хүрээнд үндэсний үр дүнг тооцох хэлэлцүүлэгт санал боловсруулж, оролцсон ба “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 2026-2030”-д тусгах шинжлэх ухаан, технологийн бүлгийн олон нийтийн хэлэлцүүлгийг 2025 оны 09-р сарын 25-ны өдөр Эдийн засаг, хөгжлийн яамтай хамтран зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт нийт 45 байгууллагын төлөөлөл оролцож, санал, зөвлөмж өгсөн. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 381 | | 13.3.4.. Иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх ажлын хүрээнд яам, Засгийн газрын агентлагууд иргэдийг хүлээн авч уулздаг өдөр, хуваарийг гарган мөрдүүлж, иргэдээс тавьсан өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, үйлчилгээний соёл, чанарыг төлөвшүүлэх арга хэмжээг 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов; | Иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх ажлын хүрээнд яам иргэдийг хүлээн авч уулздаг өдөр, хуваарийг шинэчлэн гарган мөрдүүлж, иргэдээс тавьсан өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэж байна.<br>https://mddic.gov.mn/mn/schedule/<br><br>Хавсралт : 1 зураг | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 382 | | 13.3.7. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад, дотоод томилолт, өндөр өртөгтэй автомашин, тавилга хэрэгсэл, бэлэг дурсгалын зүйлсийг хязгаарлаж, уулзалт, сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж ажиллахыг төрийн байгууллагын удирдлага, албан тушаалтнуудад даалгав; | Байгууллагын хэмжээнд зардлыг оновчтой төлөвлөж, хэрэгцээгүй худалдан авалт, өндөр өртөгтэй эд хөрөнгийн худалдан авалтаас татгалзан гадаад болон дотоод томилолтыг зайлшгүй шаардлагатай тохиолдолд зохион байгуулж байна. Мөн уулзалт, сургалт, хурал зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, төсвийн хэмнэлтийг бодитойгоор хэрэгжүүлэн ажиллаж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| ЗГ-ын албан даалгавар | | | | | | | |
| 216 | 383 | Цахим шилжилтийг эрчимжүүлэх тухай<br>2022-07-04<br>Дугаар 2022_3 | 2. Энэ албан даалгаврын 1-д заасан төлөвлөгөөнд тусгах нийтийн мэдээллийн дэд бүтцэд хамаарах төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөхдөө Цахим хөгжил, харилцаа холбооны яамны санал, зөвлөмжийг заавал авч байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2022 оны А/18 дугаар тушаал “Нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө зөвлөмж, дүгнэлт гаргах журам"-ыг баталсан. Дүгнэлт зөвлөмж гаргуулах тухай 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 01/923 дугаартай албан бичгийг Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны нийт 48 байгууллагад хүргүүлсэн. Зөвлөмж, дүгнэлт гаргах ажлын хэсгийг ЦХИХХС-ын 2025 оны А/55 дугаар тушаалаар шинэчилсэн. Тус яамнаас 2025 оны эхний хагас жилийн байдлаар мэдээлэл хариуцагч байгууллагын 33 системд дүгнэлт зөвлөмж гаргаж өгсөн байна.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 384 | | 6. Цахим шилжилтийг дэмжих, дижитал эдийн засгийг хөгжүүлэх зорилгоор бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа нарт үүрэг болгосугай. | И-Монгол академи улсын төсөвт үйлдвэрийн газрын бүтцэд бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх чиглэлийн сургалт, хөтөлбөрүүдийг зохион байгуулах чиг үүрэгтэй "Цахим ур чадварын газар"-ыг байгуулсан. Тус нэгжээр дамжуулан 2022 оны 03 дугаар сараас 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр хүртэл хугацаанд 126 удаагийн нийт 20.441 иргэн хамрагдсан сургалтыг хийгээд байна. Бүх нийтийн тоон бичиг үсгийн чадавхыг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Цахим хөгжил, харилцаа холбооны, Боловсрол, шинжлэх ухааны, Соёлын болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд нарын хамтарсан тушаалаар 2022 оны 07 дугаар сарын 23-ны өдөр батлуулсан. Цахим ур чадвар дээшлүүлэх 2022-2025 оны сургалтад төрийн албан хаагч 56576, иргэн 26524, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 687, сургагч багш 867, нийт 84643 иргэн хамрагдсан. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 217 | 385 | Цаг үеийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх тухай<br>2022-07-05<br>Дугаар 2022_5 | 1. Цахим шилжилт, төрийн бүтээмж, залуучуудын үзэл бодол, нийгмийн оролцоо, замын тэмдэглэгээ, гэр хорооллын хөгжил, цахим гэмт хэрэг зэрэг цаг үеийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх чиглэлээр дараахь арга хэмжээг 2022 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн дотор авахыг Засгийн газрын дор дурдсан гишүүд, холбогдох албан тушаалтанд тус тус ДААЛГАСУГАЙ:<br>1. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд:<br>1.1. Төрийн байгууллагуудын нэгдсэ цахим шуудангийн системийг ашиглалтад оруулж, төрийн албан хаагчдад нэвтрүүлэх;<br>1.2. Төрийн байгууллагуудын нэгдсэ программ хангамжаар хангах, байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилтийг хянах нэгдсэн систем бий болгох судалгаа хийж, саналаа танилцуулах; | 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 994 домэйн /байгууллагын/ бүхий 61,576 хэрэглэгчийн цахим шуудан үүсгэн ашиглаж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 386 | | 7. Албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах, шаардлагатай бол Ажлын хэсэг байгуулж ажиллах, биелэлтийг Төрийн бүтээмжийн болон Хот хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах, төвлөрлийг сааруулах, авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хороодын хуралдааны тус тус хэлэлцүүлэх арга хэмжээ авахыг Үндэсний хороо (Орлогч дарга Л.Энх-Амгалан, Л.Халтар)-нд даалгасугай. | Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 01 дүгээр зөвлөмжийн 1.3 болон 2.2 дахь заалтад ажилтан, албан хаагчдынхаа дунд "Нэг чиглэлээс нэг автомашинаар" (car pooling, car sharing) буюу машин хуваалцах үйлчилгээг нэвтрүүлж, санаачилгыг өрнүүлэн хэрэгжүүлэх талаар тусгаж, төрийн байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олон нийтийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулсан. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 218 | 387 | Гаалийн байгууллагын үйл ажиллагааны талаар авах арга хэмжээний тухай<br>2022-11-16<br>Дугаар 2022_16 | 1. Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт:<br>1.Гаалийн хяналтын талбай болон албан ажлын өрөөнүүдийг камержуулах арга хэмжээг бүрэн дуусгах;<br>2.Гаалийн байгууллагын үйлчилгээг цахимжуулж, хилийн боомт, гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагаанд хүний оролцоог багасгах, барааг урьдчилан мэдүүлэх үйл ажиллагааг хялбаршуулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авах;<br>3.Гааль, татварын автомат бүрдүүлэлтийн систем бий болгох арга хэмжээг эрчимжүүлэх; | Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон "И-Монгол академи" УТҮГ-ын албан хаагчид 2023 оны 08 дугаар сарын 01-04-ний өдөр хүртэл Дорноговь аймгийн Замын-Үүд суманд албан томилолтоор ажиллаж Хилийн боомт дахь хил хяналтын байгууллагуудын үйл ажиллагааны зураглал хийж, тулгамдаж буй асуудлыг тодорхойлсон. Мөн Засаг даргын Тамгын газарт ажиллан цахим шилжилтийн чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар судалгааг хийж гүйцэтгэсэн. Судалгааны үр дүнд үндэслэн Замын-Үүд сумад цахим шилжилт хийх төслийн баримт бичгийг, төсвийн төсөөллийн хамт боловсруулсан. Хилийн боомтын захиргаанаас 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 23/247 дугаар албан бичгээр "Хилийн боомтын мэдээллийн нэгдсэн систем"-д зөвлөмж, дүгнэлт авах хүсэлтийг тус яаманд ирүүлсний дагуу дүгнэлт, зөвлөмжийг 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 03/2367 дугаар албан бичгээр хариу хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 388 | | 5.5. . Авлигатай тэмцэх "5Ш ажиллагааг эрчимжүүлэх, хэрэгжилт, үр дүнг олон нийтэд тогтмол мэдээлж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж нарт | Засгийн газрын 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуралдааны 23 дугаар тэмдэглэлийн XXII.2.2 дугаарт "Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-д мэдээллийг шууд холбох боломжтой байдлаар өөрийн байгууллагын системийн бэлэн байдлыг хангах", XXII.2.3 дугаарт "Мэдээллийн сан, системийн хэвийн үйл ажиллагаа болон мэдээллийн үнэн зөв, алдаагүй байдлыг бүрэн хариуцах"-ыг даалгасантай холбогдуулан "shilen.gov.mn" системийн 2.0 хувилбарын тусламжтай мэдээлэл хариуцагч байгууллага нээлттэй мэдээллээ оруулах, шинэчлэх, үнэн зөв, бүрэн, бүтэн байдлыг хариуцах боломжийг бүрдүүлсэн. 2025 оны 1 дүгээр улиралд 1135 байгууллага, 2 дугаар улиралд 1621 байгууллага, 3 дугаар улиралд 1879 байгууллага хуулийн хугацаанд тайлан илгээсэн. 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 1135 тайлан илгээж, 1126 байгууллагын үнэлгээ хийсэн. "Шилэн Индекс"-ийн тайлан: Төрийн захиргааны төв байгууллага 92.61% (Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон 11 яам), Төрийн захиргааны байгууллага 79.61% (23 агентлаг), нийслэлийн Засаг даргын Тамгын газар 55.59% (НЗДТГ, 6 ЗДТГ), Нутгийн захиргааны байгууллага 75,84% (14 аймаг), 2 дугаар улирлын байдлаар нийт 1879 тайлан илгээж, 1876 байгууллагын үнэлгээ хийсэн. Төрийн захиргааны төв байгууллага 95.69%, Төрийн захиргааны байгууллага 79.49% (29 агентлаг), Нийслэлийн Засаг Даргын тамгын газар 80.4% (НЗДТГ, 8 ЗДТГ), Нутгийн захиргааны байгууллага 75,84% (19 аймаг), 3 дугаар улирлын байдлаар Төрийн захиргааны төв байгууллага 49.4%, Төрийн захиргааны байгууллага 78.08% (33 агентлаг), Нийслэлийн Засаг Даргын тамгын газар 74.9% (НЗДТГ, 8 ЗДТГ), Нутгийн захиргааны байгууллага 77,09% (21 аймаг) гэсэн үзүүлэлттэй байна. Нээлттэй мэдээллийн нийт 45 төрлийн 970,355 мэдээллийг дор дурдсан чиглэлээр байршуулж, 15,784,843 удаагийн хандалт авсан байна. Хандах эрхийг 4,572 байгууллагын 5,113 албан хаагчдад олгож, Шилэн индексийн тайланг 2025.10.03-ны өдрийн 01/2274 албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. 2025 оны жилийн эцсийн үнэлгээг хийж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 219 | 389 | 2024 оны эхний хагас жилд хэрэгжилтийг эрчимжүүлэх төсөл, арга хэмжээний тухай<br>2024-01-12<br>Дугаар 2024_01 | 6.8.. Хил дамнасан онлайн худалдааны боломжийг бий болгох, олон улсын төлбөр тооцооны нөхцөлийг сайжруулах арга хэмжээг 2024 оны 03 дугаар сарын 01- ний өдрийн дотор авч ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд; | Монгол улсад 2024 оны 12 дугаар сард Apple Pay үйлчилгээг нэвтрүүлэн хэрэглэгчдэд хүргэсэн. 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр Google Pay төлбөрийн системийг нэвтрүүлснээр Android болон Wear OS төхөөрөмж хэрэглэгчид төлбөр тооцоогоо хялбар, түргэн шуурхай гүйцэтгэх боломж бүрдсэн. Google Pay нь төлбөрийн мэдээллийг шифрлэж, биометрийн (хурууны хээ, нүүрний танилт) баталгаажуулалтыг ашиглан хэрэглэгчийн мэдээллийн мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалдаг, дэлхийн 100 гаруй оронд идэвхтэй хэрэглэгддэг төлбөрийн шийдэл юм.<br>Мөн хил дамнасан онлайн худалдааг дэмжих зорилгоор БНХАУ-ын TEMU онлайн худалдааны платформын Монгол Улс дахь төлөөлөгчөөр шуудангийн тусгай зөвшөөрөл эзэмшигч "MN Post" сонгогдон үйл ажиллагаа эхлүүлэн ажиллаж байна. Тус онлайн худалдааны платформын Монгол Улс дахь хүргэлт, тээвэрлэлтийг Монгол шуудан ХК, UBCab Express компани хариуцан ажиллаж байна.<br>https://www.mongolbank.mn/mn/r/11003 | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 390 | | 7.14. . Эрүүл мэндийн салбары цахим шилжилтийг эрчимжүүлэх, систем хооронд мэдээлэл солилцох боломжийг 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн дотор бүрдүүлж ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт; | "Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн чиглэлээр хийсэн ажлын үр дүнг ЗГ-ын 2024.03.26, 07.24-ний өдрийн хуралдаанд танилцуулсан. Эрүүл мэндийн төрөлжсөн мэдээллийн санг үүсгэж, “ХУР”-д 24 шинэ сервисийг нэвтрүүлсэн, 2025.06.24-ний өдрийн байдлаар 443 эмнэлэг холбосон. Иргэнээс зөвшөөрөл авах нөхцөлийг SMS (OTP), хурууны хээ, Push notification, G-Sign хэлбэрээр бүрдүүлсэн. Эмнэлгийн систем хөгжүүлэгч компаниудтай гэрээ байгуулан, VPN, API-г тохируулж, ХУР, Мэдэгдлийн системийн төлбөрийг 2025 оныг дуустал чөлөөлсөн. И-Монгол системд эрүүл мэндийн 25 үйлчилгээг нэвтрүүлэн ба 37 сая мэдэгдлийг хүргэж, 1.4 сая хандалтыг авсан. Цахим эрүүл мэндийн нөхцөл байдлын үнэлгээний судалгааг 325 байгууллагаас авч, үр дүнг нээлттэй байршуулсан. ЭМТХ-ийн 8.4, 8.10 дахь хэсэгт заасан журмыг ЗГ-ын 2024 оны 100 дугаар тогтоол, ЭМС, ЦХИХХС-ын хамтарсан 2025.04.16-ны өдрийн А/130, А/58 тушаалаар батлуулан 2025.05.13-ны өдөр захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн. Эрүүл мэндийн 109 байгууллагын 111 rack, 67 VPS, 153 mail, 137 website, 293 domain-ны үйлчилгээг ҮДТ-өөс үзүүлж байна. “Төрийн бүтээмжийн сэргэлт-Цахим эрүүл мэнд” үндэсний зөвлөлдөх уулзалтыг 2024.04.08,09-нд 150 байгууллагын 380 ажилтанд /digitalhealth.gov.mn/, сургалтыг 2024.04.16-нд анхан шатлалын байгууллагын 200 төлөөлөлд, 2024.05.04-24-нд 21 аймаг, нийслэлд зохион байгуулж эрүүл мэндийн ажилтнуудыг хамруулсан. Монгол Улсын “Цахим эрүүл мэнд”-ийн цогц арга хэмжээний төлөвлөгөө (2025-2028)-г хэлэлцэх уулзалт, хэлэлцүүлгийг НҮБ-ын Хүүхдийн Сангийн дэмжлэгтэйгээр 2025.04.10, 11-ний өдрүүдэд 20 байгууллагын 52 албан хаагчийн дунд зохион байгуулсан. “Эрүүл мэндийн салбарын дижитал шилжилтийн цогц арга хэмжээний төлөвлөгөө”-г ЭМС, ЦХИХХС-ын хамтарсан 2025.05.24-ний өдрийн А/201, А/81 тушаалаар баталсан. Хэлэлцүүлэг, уулзалтын тайланг оролцогч 20 байгууллагад 2025.06.05-ны өдрийн 02/1348, ЗГЭХГ-т 2025.05.20-ны өдрийн 01/1195 албан бичгээр хүргүүлж, ИЦББХ-ны 2025.05.28-ны өдрийн хурлаар танилцуулсан<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 391 | | 1.6. Их өгөгдөл, хиймэл оюунд суурилсан цахим шилжилтийн реформыг хэрэгжүүлэхийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал нарт; | Тус яамнаас НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр “Их өгөгдөл, хиймэл оюуны стратеги” анхдугаар чуулганыг Төрийн ордны Их танхимд зохион байгуулсан. Уг анхдугаар чуулганд төрийн байгууллага, бусад улсаас Монгол улсад суугаа элчин сайд, олон улсын байгууллага, аймаг орон нутгийн болон салбарын харьяа байгууллага, их дээд сургууль, мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгчид, арилжааны банк, финтекийн холбооны нийт 1077 төлөөлөл оролцож, их өгөгдөл, хиймэл оюуны өнөөгийн нөхцөл байдал, бэлэн байдлын үнэлгээ, мөн хувийн хэвшлийн бүтээгдэхүүн үйлчилгээ болон хиймэл оюуны стратегийн төслийг оролцогчдод танилцуулан, хэлэлцүүлэг өрнүүлсэн.<br>Их өгөгдөл хиймэл оюуны стратегийн талаар Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 18 дугаар хуралдаанд танилцуулж, уг стратегид тусгагдсан зорилт, арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төсөлд тусгасан.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 392 | | 2.1.14.. Үндэсний хиймэл дагуулын төсөл - Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү нарт.(2 .Дараах бүтэ байгууллалтын төслүүдийг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж эхлүүлэхийг дараах Засгийн газрын гишүүд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар нарт:) | Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 34 дүгээр захирамжаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар ахлуулсан “Монгол Улсын харилцаа холбооны үндэсний хиймэл дагуулын төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Бүгд Найрамдах Франц Улсын талтай хэлэлцээ хийх, ээлийн ерөнхий нөхцөлийн талаарх олон улсын гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах” ажлын хэсэг байгуулагдсан. Бүгд найрамдах Франц Улсын Талес Алениа Спейс компани ЦХИХХЯ хооронд байгуулах “Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуулын техникийн нөхцөлийг тодорхойлох, гэрээний төсөл боловсруулах” арилжааны гэрээний нөхцөлийг сайжруулах, гэрээний үнийн дүнг буулгах, гэрээний нөхцөлийг сайжруулах чиглэлээр Талес Алениа Спейс компанитай хамтран ажиллаж байна. Францын Сангийн яамтай хийсэн хэлэлцээрийн дүнд Талес Алейна Спейс компаниас ирүүлсэн төслийн санхүүжилтийн саналын арилжааны зээлээр санхүүжүүлэх хэсгийг Засгийн газрын нэн хөнгөлөлттэй зээлд хамруулах тохиролцоонд хүрээд байна. /нууцын зэрэглэлтэй/ | Тодорхой үр дүнд хүрсэн - 50% | Үгүй | |
| 393 | | 4.5.. Хөрөнгө оруулагчдад зориулсан мэдээллийн нэгдсэн системийг төрийн үйлчилгээний нэгдсэн платформ “и-Монголиа”-д холбож, хөрөнгө оруулагчдад зориулсан нээлттэй мэдээллийн санг англи болон түгээмэл хэрэглэдэг бусад гадаад хэл дээр бэлдэж байршуулах. | Хөрөнгө оруулагчдад зориулсан мэдээллийн нэгдсэн системийг Төрийн үйлчилгээний нэгдсэн платформ “и-Монголиа”-д холбох, хөрөнгө оруулагчдад зориулсан нээлттэй мэдээллийн санг англи болон түгээмэл хэрэглэдэг бусад гадаад хэл дээр бэлдэхээр судалж байна. Монгол Улсын Шадар сайдын Ажлын албатай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. | Зохион байгуулалтаас - 0% | Үгүй | |
| 394 | Засгийн газрын 2024-2028 оны | 22.1. 22.1.Төрийн байгууллагуудын цахим хуудсыг нэг загвар бүхий нэгдсэн удирдлагатай болгон хөгжүүлж, төрийн үйлчилгээний нэгдсэн платформ “и-Монголиа”-тай холбох; | Засгийн газрын нэгдсэн веб gov.mn цахим хуудсыг Е-Монголиа төрийн үйлчилгээний цахим платформд үндэслэн хөгжүүлж эхэлсэн. “Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас gov.mn сургалтын хөтөлбөр”-ийн дагуу төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн Засаг даргын Тамгын газрын нэгдсэн цахим хуудасны үйл ажиллагааг хариуцан ажилладаг албан хаагч нарт танхимаар болон цахим хэлбэрээр 53 удаагийн сургалтыг зохион байгуулж, Төсвийн байгууллагын 25% буюу 1416 байгууллагад хандах эрхийг олгосон. Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас (www.gov.mn)-ыг Төрийн үйлчилгээний нэгдсэн платформ "eMongolia"-той уялдуулан хөгжүүлсэн. https://e-mongolia.mn/org | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 220 | 395 | Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан 2024 онд багтаан хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухай 2024-09-18 Дугаар 2024_01_1 | 22.5. 22.5. Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуулын газрын станц байгуулах бэлтгэл хангах, хиймэл дагуул үйлдвэрлэх, нийлүүлэх гэрээ байгуулах ажлыг эхлүүлэх; | “Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуул” төслийн газрын станцын 5 байршилд буюу Улаанбаатар хотын Наран станц, Даланзадгад, Дархан, Чойбалсан, Баян-Өлгий аймгуудын сонгосон байршлуудад (МХС ХХК-ийн салбарууд) Мэдээлэл Холбооны Сүлжээ ХХК, Бүгд Найрамдах Франц Улсын Талес Алениа Спэйс компани, Харилцаа холбооны зохицуулах хорооны инженерүүдтэй хамтран 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс 11 дүгээр сарын 21-ний өдрийн хооронд хийж гүйцэтгэсэн. Дархан-Уул аймгийн газрын станц байгуулах байршилд харилцан нөлөөлөл илэрсэн. Тиймээс дахин өөр цэг сонгон, хэмжилт хийхээр төлөвлөгөө гаргасан.“Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуул” төслийн газрын станцын 5 байршилд буюу Улаанбаатар хотын Наран станц, Даланзадгад, Дархан, Чойбалсан, Баян-Өлгий аймгуудын сонгосон байршлуудад (МХС ХХК-ийн салбарууд) байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх ажлыг "Дойтын булаг" ХХК нь 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрөөс 12 дугаар сарын 20-ний өдрийн хооронд хийж гүйцэтгэн, дүгнэлтийг ирүүлсэн. Уг дүгнэлтээр тус цэгүүдэд байгаль орчны нөлөөлөл байхгүй гэж гарсан.Монгол Улсын Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Бүгд Найрамдах Франц Улсын Талес Алениа Спейс компанитай 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдөр байгуулагдсан “Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуулын техникийн нөхцөлийг тодорхойлох, гэрээний төсөл боловсруулах” санамж бичгийн хүрээнд боловсруулагдсан Монгол Улсын Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам болон Бүгд Найрамдах Франц Улсын Талес Алениа Спэйс компани хооронд байгуулагдах “Харилцаа холбооны модуль, антен, гэтвей станц, сүлжээний удирдлагын газрын сегмент нийлүүлэх” гэрээний төсөл (38 нүүр), “Хиймэл дагуул, хиймэл дагуулын удирдлага хяналтын газрын сегмент нийлүүлэх” гэрээний төслийг 2024 оны 12 дугаар сарын 10-нд англи хэлнээс монгол хэлнээ хөрвүүлэн дуусаж, хянан баталгаажуулахаар хүргүүлж, ажлыг эхлүүлсэн. | Тодорхой үр дүнд хүрсэн - 50% | Үгүй | |
| | 396 | | 22.6 . 22.6. Энэ албан даалгаврын 2.1.14-т заасан төслийг хэрэгжүүлэх хүрээнд хиймэл оюун ухааны чиглэлээр эрх зүйн орчныг бүрдүүлэх, дрон сургалт хөгжүүлэлтийн бүс байгуулах. | Тус яамнаас НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр “Их өгөгдөл, хиймэл оюуны стратеги” анхдугаар чуулганы Төрийн ордны Их танхимд зохион байгуулсан. Уг анхдугаар чуулганд төрийн байгууллага, бусад улсаас Монгол улсад суугаа элчин сайд, олон улсын байгууллага, аймаг орон нутгийн болон салбарын харьяа байгууллага, их дээд сургууль, мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгчид, арилжааны банк, финтекийн холбооны нийт 1077 төлөөлөл оролцож, их өгөгдөл, хиймэл оюуны өнөөгийн нөхцөл байдал, бэлэн байдлын үнэлгээ, мөн хувийн хэвшлийн бүтээгдэхүүн үйлчилгээ болон хиймэл оюуны стратегийн төслийг оролцогчдод танилцуулан, хэлэлцүүлэг өрнүүлсэн. Их өгөгдөл хиймэл, оюуны стратегийн талаар Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 18 дугаар хуралдаанд танилцуулж, уг стратегид тусгагдсан зорилт, арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төсөлд тусгасан.<br>Тус яамны сайдын 2025 оны А/48 дугаар тушаалаар “Дроны туршилтын бүс байгуулах техник, эдийн засгийн судалгаа хийх, холбогдох хууль тогтоомжийн дагуу туршилтын бүс байгуулах” үүрэг бүхий ажлын хэсгийг шинэчлэн байгуулж, эхний хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр цахимаар зохион байгуулсан. Уг хурлаар туршилтын бүс байгуулахтай холбоотой ажлын явцыг танилцуулж, цаашид хийх ажлын талаар санал солилцсон. Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ-ын санхүүжилтээр хийгдэхээр тусгагдсан “Дроны туршилтын бүсийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах” нээлттэй тендер зарласан боловч төсвийн тодотголоор төсөв танагдсантай холбоотой уг ажил санхүүжилтгүй болж зогссон. Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газраас дахин ирүүлсэн байршлуудад 2025 оны 8 дугаар сарын 18-19-ний өдрүүдэд ХХЗХ-оор дахин хэмжилт хийлгүүлж, дүгнэлт гаргуулсан.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжүүлэх зардал, санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 397 | | 1.1.2. 1.1.2.“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор хиймэл оюун ухаан (А1), өндөр технологийн шилжилт, ногоон хөгжлийн шилжилт, хөдөлмөрийн зах зээл, хүний нөөцийн ур чадварын шилжилт хийх стратеги төлөвлөгөө боловсруулж, танилцуулахыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөрт, тус чиглэлээр эрхлэх салбарын хүрээний стратеги төлөвлөгөө боловсруулж, танилцуулахыг Засгийн газрын гишүүдэд; | Ерөнхий сайдын 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 02 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд хиймэл оюун ухаан, өндөр технологийн шилжилт, ногоон хөгжлийн шилжилт, хөдөлмөрийн зах зээл, хүний нөөцийн ур чадварын шилжилт хийх чиглэлээр гаргах стратеги төлөвлөгөөний судалгааг холбогдох газрын мэргэжилтнүүдтэй хамтран боловсруулж байна. Тус чиглэлээр Эдийн засаг, хөгжлийн яамны хариуцсан мэргэжилтэнтэй холбогдож шаардлагатай материал илгээсэн. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/05 дугаар тушаалаар сайдын эрхлэх асуудлын хүрээний 2024-2028 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 398 | | 1.1.3. 1.1.3.төрийн захиргааны бүх шатны байгууллага, төрийн албан хаагч бүр үйл ажиллагааны гүйцэтгэлийг “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 9 зорилгоор улирал тутам тайлагнаж хэвшүүлэхийг Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү нарт; | Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас 2025 оны 01/103 дугаар албан бичгээр "Олон улсын үнэлгээний цогц систем"-ийг Дэлхийн банкны "Ухаалаг засаг 2" төслийн хүрээнд хэрэгжүүлэх саналаа ирүүлсэн. Саналыг "Ухаалаг засаг 2" төслийн худалдан авалтын төлөвлөгөөнд тусгасан бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас "Олон улсын үнэлгээний цогц систем"-ийн ажлын даалгаврыг боловсруулан Дэлхийн Банкаар хянуулан ажиллаж байна. | Тодорхой үр дүнд хүрсэн - 50% | Үгүй | |
| | 399 | | 1.1.4. 1.1.4.төрийн үйлчилгээний нэгдсэн платформ “и-Монголиа”-д суурилсан Засгийн газрын нэгдсэн цахим хуудсыг ашиглалтад оруулж, төрийн байгууллага, албан хаагч хооронд мэдээлэл солилцох, харилцах үйл ажиллагаанд нэгдсэн систем ашиглах нөхцөлийг бүрдүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Учрал, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү нарт; | Засгийн газрын нэгдсэн веб gov.mn цахим хуудсыг Е-Монголиа төрийн үйлчилгээний цахим платформд үндэслэн хөгжүүлж эхэлсэн. “Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас gov.mn сургалтын хөтөлбөр”-ийг боловсруулан, төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн Засаг даргын Тамгын газрын нэгдсэн цахим хуудасны үйл ажиллагааг хариуцан ажилладаг албан хаагч нарт танхимаар болон цахим хэлбэрээр 53 удаагийн сургалтыг хийж Төсвийн байгууллагын 25% буюу 1416 байгууллагад хандах эрхийг олгосон. МУ-ын Ерөнхий сайдын 2024 оны нэгдүгээр, 2025 оны хоёрдугаар албан даалгаварыг хүрээнд өгсөн төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас (www.gov.mn)-ыг төрийн үйлчилгээний нэгдсэн платформ "eMongolia", нээлттэй мэдээллийн shilen.gov.mn -тэй уялдуулах хөгжүүлэлт хийгдэж Засгийн газрын нэгдсэн веб gov.mn цахим хуудсыг Е-Монголиа төрийн үйлчилгээний цахим платформд үндэслэн хөгжүүлж ашиглалтад оруулж. “Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас gov.mn сургалтын хөтөлбөр”-ийг боловсруулан төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн Засаг даргын Тамгын газрын нэгдсэн цахим хуудасны үйл ажиллагааг хариуцан ажилладаг албан хаагч нарт танхимаар болон цахим хэлбэрээр 53 удаагийн сургалтыг зохион байгуулж 1416 байгууллагад хандах эрх олгосон. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 221 | 400 | ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ТУХАЙ 2025-03-06 Дугаар 2025_02 | 2.15. 2.15.Улаанбаатар хотын инженерийн дэд бүтцийг шинээр байгуулах болон өргөтгөн шинэчлэх замаар хүчин чадлыг нэмэгдүүлэхийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү нарт; | Хийгдээгүй. | Зохион байгуулалтаас - 0% | Үгүй | |
| | 401 | | 2.22. 2.22.Хүннү хот дахь чөлөөт бүсийг тулгуурлан дата төв болон хүлэмжийн хийг бууруулах, сэргээгдэх эрчим хүчний хосолсон загвар аж ахуйг хөгжүүлэх төслийг эхлүүлэхийг Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга Р.Эрдэнэбүрэн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү нарт; | Хүннү хот дахь чөлөөт бүсийг тулгуурлан цахиурын хөндий байгуулах ТЭЗҮ боловсруулах ажлыг Монгол улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний хөрөнгө оруулалтын төсөлд тусгуулахаар саналаа Сангийн яаманд хүргүүлсэн. | Тодорхой үр дүнд хүрсэн - 50% | Үгүй | |
| | 402 | | 4.20.2. 4.20.2.Мэдээллийн аюулгүй байдлыг хангасны үндсэн дээр кирилл болон үндэсний бичгийн албан ёсны хөрвүүлэгчийг төрийн байгууллагууд ашиглах боломжийг судалж, танилцуулах; | Тус яамны 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд “Кирилл болон үндэсний бичгийн хооронд харилцан хөрвүүлэг хийх, зөв бичих дүрмийн алдаа хянах программ нэвтрүүлэх”-ээр туссан. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2025.04.17-ны өдрийн ХЭГ/1043 дугаар "Хуулийн хэрэгжилтийг хангах тухай" албан бичгийн хавсралтаар Тагнуулын ерөнхий газрын 2025.04.01-ны өдрийн ТЕГ01/128 дугаар "Мэдээлэл хүргүүлэх тухай" албан бичгийг ирүүлсэн бөгөөд уг албан бичигт Хэлний бодлогын үндэсний зөвлөлөөс баталгаажуулсан "Дуаллайн" ХХК-ийн "Алдаа шалгагч, бичиг хөрвүүлэгч" программыг Засгийн газрын 2023 оны 224 дүгээр тогтоолоор баталсан "Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журам"-д заасан аюулгүй байдлын шаардлагыг хангахгүй, тус системийг төрийн үйл ажиллагаанд нэвтрүүлэн ашиглахад аюулгүй байдлын хувьд эрсдэлтэй тухай ирүүлсэн. "Дуаллайн" ХХК-ийн хөгжүүлсэн тус системд Тагнуулын ерөнхий газраас эрсдэлгүй тухай зөвлөмж ирүүлсэн тохиолдолд ЦХИХХЯ хэрэглээнд нэвтрүүлэхээр хүлээгдэж байна. | Тодорхой үр дүнд хүрсэн - 50% | Үгүй | |
| | 403 | | 4.20.3. 4.20.3.олон улсын байгууллагатай хамтран Монгол Улсын кибер аюулгүй байдлын өнөөгийн түвшнийг тодорхойлж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж гаргах; | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА)-тай хамтран хэрэгжүүлж буй кибер аюулгүй байдлын хүний нөөцийг хөгжүүлэх техникийн хамтын ажиллагааны төслийн хүрээнд Английн Оксфордын их сургуулийн Кибер аюулгүй байдлын чадавхын төвтэй хамтран Монгол Улсын кибер аюулгүй байдлын өнөөгийн түвшинг үнэлэх, зорилтот түвшинг тодорхойлох судалгааг 2024 оны 10 дугаар сарын 02-04-ний өдрүүдэд зохион байгуулсан. Кибер аюулгүй байдлын чадавхын төвийн судлаачид кибер аюулгүй байдлын чадавхыг а) кибер аюулгүй байдлын бодлого ба стратеги, б) кибер аюулгүй байдлын соёл ба нийгэм, в) кибер аюулгүй байдлын мэдлэг ур чадварыг хөгжүүлэх, г) хууль эрх зүйн орчин, д) стандарт ба технологи гэсэн сэдвийн хүрээнд зөвлөлдөх уулзалтыг удирдан явуулсан бөгөөд төрийн болон хувийн хэвшлийн 80 гаруй байгууллагын 110 орчим ажилтан, албан хаагч оролцсон. Судалгааны тайланг 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдөр нээлттэйгээр танилцуулж, судалгааны англи, Монгол хэл дээрх тайланг байгууллагын цахим хуудсанд байршуулсан. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 404 | | 4.20.4. 4.20.4.Засгийн газрын нэгдсэн вэб хуудсыг Е-Монголиа төрийн үйлчилгээний цахим платформд үндэслэн хөгжүүлж, ашиглалтад оруулах. | Засгийн газрын нэгдсэн веб gov.mn цахим хуудсыг Е-Монголиа төрийн үйлчилгээний цахим платформд үндэслэн хөгжүүлж ашиглалтад оруулж. “Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас gov.mn сургалтын хөтөлбөр”-ийг боловсруулан төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн Засаг даргын Тамгын газрын нэгдсэн цахим хуудасны үйл ажиллагааг хариуцан ажилладаг албан хаагч нарт танхимаар болон цахим хэлбэрээр 53 удаагийн сургалтыг зохион байгуулж 1416 байгууллагад хандах эрх олгосон. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 405 | | 1.1.. Шинжлэх ухааны судалгаа, нотолгоонд суурилсан шийдвэр гаргаж, ард иргэдээ сонсон, итгэл, хүлээлт, шаардлагад нь нийцэж ажиллах; | 1.2026 оны улсын төсвийн хүрээнд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам нь Монгол Улсын дижитал шилжилтийг гүнзгийрүүлж, харилцаа холбоо болон дата дэд бүтэц өргөтгөл, хиймэл оюунд түшиглэсэн эдийн засгийн суурь дэд бүтцийг бүрдүүлэх зорилт тавин ажиллаж байна. Төсвийн хэлэлцүүлгийг 2025 оны 08 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулж, олон нийтээс санал авч, танхимын хэлэлцүүлэг зохион байгууллаа. Мөн Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (e-Mongolia.mn)-д 2025 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн байдлаар 2026 оны төсвийн төсөлд 160,000 гаруй санал өгсөн байна. 2.Засгийн газрын бүрэн эрхийн хүрээнд хамаарах нийтийн ашиг сонирхлыг хөндсөн дараах асуудлаар гаргасан иргэн, хуулийн этгээдийн саналыг Монгол Улсын 18 насанд хүрсэн 50 мянган иргэн дэмжсэн бол хуралдаанаар хэлэлцүүлнэ.” гэж Засгийн газрын хуралдааны журамд өөрчлөлт орсны дагуу “Иргэдийн санал, санаачилгыг хүлээн авах Засгийн газрын цахим систем (d-gov.mn)"-ийг хөгжүүлж, 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр ашиглалтад оруулсан. https://www.d-gov.mn/ | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 406 | | 1.2.. Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангах, салбарын удирдлагын манлайллыг мэргэжлийн түвшинд хариуцлагатай хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж ажиллах; | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан ёс зүйн нийтлэг хэм хэмжээг албан хаагчийн үйл ажиллагаанд сахин мөрдүүлэхэд удирдлагаар хангаж ажиллаж байна. Тус яамны цахим хуудас болон цахим мэдээллийн самбарт төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, зарчим, гомдол мэдээлэл хүлээн авах эх сурвалж зэрэг мэдээллийг тогтмол байршуулж, мэдээлж байна. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги шинэчлэн баталсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 411, 412, 413 дугаар тогтоолоор албан тушаалын тодорхойлолтыг батлах зөвшөөрөл олгосны дагуу Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/305, 306, 307 дугаар тушаалаар албан тушаалын тодорхойлолтыг баталсан. Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн Б/141 дүгээр тушаалаар яамны үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор албан тушаалын тодорхойлолтын дагуу Төрийн албаны тухай хуульд нийцүүлэн төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангах албан хаагчдыг үргэлжлүүлэн томилсон. 2025 онд төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээлэл ирээгүй болно.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 407 | | 1.3.. Яам, харьяа байгууллага, салбарын хэмжээнд сахилга, хариуцлагыг өндөржүүлж, бүх шатанд төсвийн хэмнэлтийн горимыг сахин, үр ашиггүй зардлыг танах, төрийн байгууллагын бүтэц, чиг үүргийн давхардлыг арилгаж, орон тоог үе шаттай цөөлөх; | 1.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцад 118.4 тэрбум төгрөг анх батлагдаж, тодотголоор 81.9 тэрбум төгрөг болж буурсан. Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалт, Төрийн хэмнэлтийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, чиглэлийн дагуу төсвийг үр ашигтай удирдаж, төсвийн сахилга хариуцлага нэмэгдүүлж ажилласан. 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар нийт 41.8 тэрбум төгрөгийг гүйцэтгэлтэй тодотгосон нийт төсвөөс 40 гаруй хувийг зарцуулаагүй, хэмнэлттэй ажилласан. Мөн 2025 онд 8.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 11.8 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй, орлогын төлөвлөгөөг 38 хувиар давуулан биелүүлж, Улсын төсөвт төвлөрүүлээд байна. 2.Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги шинэчлэн баталсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 411, 412, 413 дугаар тогтоолоор албан тушаалын тодорхойлолтыг батлах зөвшөөрөл олгосны дагуу Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/305, 306, 307 дугаар тушаалаар албан тушаалын тодорхойлолтыг баталсан. Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн Б/141 дүгээр тушаалаар яамны үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор албан тушаалын тодорхойлолтын дагуу Төрийн албаны тухай хуульд нийцүүлэн албан хаагчдыг үргэлжлүүлэн томилсон. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 408 | | 1.4.. Салбарын хэмжээнд ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх төлөвлөгөө гарган, цахим шилжилтийг эрчимжүүлэх, салбарын онцлогт нийцсэн инновац, шинэ технологийг их өгөгдлийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн, шийдвэр гаргалтад хиймэл оюун ухаан, ашиглах; | Цахим хөгжил, инновац, харилцаа сайд 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр “Эрчимжүүлэх шаардлагатай төлөвлөгөө”-г баталж, хэрэгжилтийг хангаж ажиллах талаар харьяа байгууллагуудад 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 02/2671, 02/2672 дугаартай албан бичгээр чиглэл хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 3 файл | Тодорхой үр дүнд хүрсэн - 50% | Үгүй | |
| 409 | | 1.5.. Улс төрөөс ангид, чадахуйн зарчимд суурилсан, хүртээмжтэй, шуурхай, хариуцлагатай төрийн албыг бэхжүүлж, хүнд суртал, шат дамжлагыг эрс бууруулах бодитой ажлыг зохион байгуулан, тодорхой ахиц гаргаж, үр дүнг тайлагнах; | Төрийн байгууллагын мэдээллийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох, төрийн үйлчилгээг цахимжуулах, цахим шилжилтийг бүх шатны төрийн байгууллагад хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах, үйлчилгээний чанар, хүртээмжийг хэмжих, ил тод тайлагнах арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн А/227 дугаар тушаалаар байгуулж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Төрийн цахим үйлчилгээг нэвтрүүлсэн олон улсын туршлага, стандарт, журмын судалгааг хийж, төрийн цахим үйлчилгээний стандарт журмын төслийг боловсруулсан. Төрийн байгууллагуудын ашиглаж байгаа цахим систем, мэдээллийн санд дүн шинжилгээ хийж, систем хоорондын залгамж, уялдаа холбоог хангаж давхардлыг арилгах чиглэлээр холбогдох танилцуулгыг Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар 08 дугаар сарын 25-ны өдрийн 01/1936 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн. 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанд хэлэлцүүлж, 20 дугаар хуралдааны тэмдэглэлээр баталгаажсан. Цаашид төрийн байгууллагууд өөрийн ашиглаж байгаа цахим системийг system.gov.mn цахим системээр бүртгүүлэх, эрхлэх асуудлын хүрээнд бүрдүүлсэн төрөлжсөн мэдээллийн сангийн мета-өгөгдлийг "Төрийн мета-өгөгдлийн нэгдсэн сан"-д бүртгүүлэх, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө system.gov.mn цахим системээр зөвлөмж, дүгнэлтийг тухай бүр авч уялдаа холбоог хангаж ажиллах юм.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 410 | | 1.6.. Эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх бодитой арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | 1.Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба нь иргэн, хуулийн этгээдэд чиглэсэн кибер халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйлчилгээг Цахим аюулгүй байдлын мэдээлэл удирдлагын төв ГҮТББ-аар гүйцэтгүүлж байна. 2024–2025 онд үндэсний хэмжээний кибер халдлагад хариу арга хэмжээ авах, долоо хоног бүр Монгол Улсын интернэт орчны аюул занал, эрсдэлийн талаарх мэдээллийг гаргаж, олон нийтэд түгээх урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж байна. 2.Төрийн цахим үйлчилгээг хувийн хэвшлийн дэд бүтцээр хүргэх чиглэлд: -Төрийн банк ХК-тай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд тус байгууллагын 120 киоск төхөөрөмжөөр дамжуулан төрийн 12 байгууллагын 66 лавлагаа, тодорхойлолтыг хүргэж байна. -Гео инженер сүрвэй ХХК, Хаан банк ХХК, Капитрон банк ХХК-ийн өөрсдийн төхөөрөмжөөр төрийн цахим үйлчилгээг хүргэх тохирсон системийн хөгжүүлэлтийг хамтран гүйцэтгэсэн. -Ай Си Ти ХК-тай хамтран харилцаа холбоо, мэдээллийн технологийн өсвөрийн, ахмадын, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн "ХУРДАН" клубийн цахим системийг нэвтрүүлж, нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажиллаж байна. -Төрийн үйлчилгээний "ХУР" , "ДАН" , "E-mongolia", "Тоон гарын үсэг", " И-баримт" , Иргэд олон нийттэй харилцах "11-11 төв" зэрэг системийн программ хангамжийг үндэсний компаниуд гүйцэтгэж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 411 | | 1.7.. Салбарын хэмжээнд нэн тулгамдсан, шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай асуудлыг Засгийн газрын 100 хоногийн төлөвлөгөөнд тусгуулан, шуурхай шийдвэрлэх; | Тус яамны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын 100 хоногт багтаан хэрэгжүүлэх 18 төсөл, арга хэмжээний саналыг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 01/1542 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, тайлагнасан.<br><br>Хавсралт : 2 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 412 | | 1.8.. Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаанд оролцох журмыг чанд мөрдөж, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгүүдтэй нягт уялдаатай ажиллах, хүндэтгэлтэй хандах. | Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаанд оролцох журмыг чанд мөрдөж, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгүүдээс ирүүлсэн санал, албан бичгийн дагуу харилцан уялдаатай ажиллаж байна. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд 2025 оны УИХ-ын чуулганы намрын ээлжит чуулган (9 дүгээр сард 7, 10 дугаар сард 5, 11 дүгээр сард 12, 12 дугаар сард 2 удаа)-д бүрэн оролцож, журмыг сахин мөрдөн ажиллаж байна. https://www.parliament.mn/nc/635/?page=2 | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 222 | 413 | Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай<br>2025-06-18<br>Дугаар 2025_01 | 2.1.. Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал болон бусад хууль тогтоомжийг чанд<br>мөрдөж, зөрчсөн үйлдэл гаргахгүй байх; | Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал болон бусад хууль тогтоомжийг чанд мөрдөж, зөрчсөн үйлдэл гаргаагүй болно. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 414 | | 2.2.. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу нууцад хамааруулах шаардлагагүй мэдээллийг зохих журмын дагуу ил болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/310 дугаар тушаалаар Ажлын хэсэг байгуулагдан "Сансрын холбооны болон тандан судалгааны үндэсний хиймэл дагуул хөөргөх техник эдийн засгийн үндэслэл баримт бичиг"-ийг "Нууцын зэрэглэл"-ээс гаргах зөвлөмж гаргасан. Тус яамнаас нууцаас гаргах чиглэл авахаар Тагнуулын ерөнхий газарт 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн Н/55 дугаартай албан бичиг хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 415 | | 2.3.. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах үүргийн биелэлтэд харьяа байгууллага, хуулийн этгээдийн хэмжээнд тогтмол хяналт тавьж, зөрчсөн этгээдэд хариуцлага тооцох; | Засгийн газрын 39 агентлаг, 21 аймгийн Засаг даргын Тамгын газар зэрэг нийт 60 байгууллагад албан бичиг хүргүүлснээс 15 аймгийн Засаг даргын Тамгын газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар хариу албан бичиг ирүүлсэн. Тухайлбал, Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газар нь нээлттэй мэдээллийн систем (Shilen.gov.mn)-д мэдээлэл тогтмол байршуулаагүй, хангалтгүй үнэлгээтэй 10 сум 1 тосгон, сумдын соёлын төв, сургууль, цэцэрлэгийн нийт 80 гаруй удирдах албан хаагчдад хуулийн хэрэгжилт хангагдаагүй талаар дүгнэлт, зөвлөмж хүргүүлсэн. 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 4,579 байгууллага бүртгэл үүсгэснээс 2025 оны 1 дүгээр улиралд 1135 байгууллага, 2 дугаар улиралд 1621 байгууллага, 3 дугаар улиралд 1879 байгууллага хуулийн хугацаанд тайлан илгээсэн. 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 1135 тайлан илгээж, 1126 байгууллагын үнэлгээ хийсэн. "Шилэн Индекс"-ийн тайлан: Төрийн захиргааны төв байгууллага 92.61% (Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон 11 яам), Төрийн захиргааны байгууллага 79.61% (23 агентлаг), нийслэлийн Засаг даргын Тамгын газар 55.59% (НЗДТГ, 6 ЗДТГ), Нутгийн захиргааны байгууллага 75,84% (14 аймаг), 2-р улирлын байдлаар нийт 1879 тайлан илгээж, 1876 байгууллагын үнэлгээ хийсэн. Төрийн захиргааны төв байгууллага 95.69%, Төрийн захиргааны байгууллага 79.49% (29 агентлаг), Нийслэлийн Засаг Даргын тамгын газар 80.4% (НЗДТГ, 8 ЗДТГ), Нутгийн захиргааны байгууллага 75,84% (19 аймаг), 3-р улирлын байдлаар Төрийн захиргааны төв байгууллага 49.4%, Төрийн захиргааны байгууллага 78.08% (33 агентлаг), Нийслэлийн Засаг даргын Тамгын газар 74.9% (НЗДТГ, 8 ЗДТГ), Нутгийн захиргааны байгууллага 77,09% (21 аймаг) гэсэн үзүүлэлттэй байна. Нээлттэй мэдээллийн нийт 45 төрлийн 970,355 мэдээллийг дор дурдсан чиглэлээр байршуулж, 15,784,843 удаагийн хандалт авсан. Хандах эрхийг 4,572 байгууллагын 5,113 албан хаагчдад олгож, Шилэн индексийн тайланг 2025.10.03-ны өдрийн 01/2274 албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн. 2025 оны жилийн эцсийн үнэлгээ хийж байна | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 416 | | 2.4.. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллаж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, хүнд суртал, шударга бус байдалтай тууштай тэмцэх, таслан зогсоох, албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглахгүй байх, төрийн байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг идэвхжүүлэх; | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль батлагдсантай холбогдуулан тус яамны дэргэдэх Төрийн албан хаагчийн Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/126 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан бөгөөд уг хорооны гишүүн Э.Насанбат, Г.Батбилэг нар ажлаас чөлөөлөгдсөнтэй холбогдуулан Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын 2.8-д заасны дагуу дэд хорооны 2 гишүүнийг нөхөн сонгох арга хэмжээг 2025 оны 03 сард зохион байгуулж, нөхөн томилогдсон гишүүдийг Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/77 дугаар тушаалаар баталгаажуулсан. Тус яамны Ёс зүйн дэд хороо нь 6 гишүүнтэй ажиллаж байгаа бөгөөд 2 гишүүнийг Монгол Улсын Ёс зүйн хороо, Удирдлагын академиас хамтран зохион байгуулсан Ёс зүйн сургагч багш бэлтгэх сургалтад хамруулж, эрх аваад байна. Ес зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан. Тус яам Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, И Монгол академи УТҮГ, Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ, Үндэсний дата төв УТҮГ-ын дэргэдэх Ёс зүйн дэд хороотой хамтран албан хаагчдыг идэвхжүүлэх өдөрлөг зохион байгуулсан.<br><br>Хавсралт : 2 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 417 | | 2.5.. Төрийн албан хаагчийг хууль бусаар томилж, чөлөөлөх, аливаа хэлбэрээр дарамт, шахалт үзүүлэхгүй байх; | Тус яамны удирдлагаас төрийн албан хаагчийг хууль бусаар чөлөөлөх, томилох, аливаа хэлбэрийн дарамт шахалт үзүүлэхгүй байх, урьдчилан сэргийлэх талд анхааран ажиллаж байна. Өгөгдсөн үүрэг даалгаврын хугацаанд төрийн албан хаагчийг хууль бусаар томилж, чөлөөлөх болон аливаа хэлбэрээр дарамт шахалт үзүүлээгүй болно. Мөн үүнтэй холбоотой албан хаагчдаас өргөдөл, гомдол бүртгэгдээгүй. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 418 | | 2.6.. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилолтыг хязгаарлаж, тансаглалыг таслан зогсоох талаар харьяа байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг өгч, үр дүнг тооцож ажиллах. | 1.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцад 118.4 тэрбум төгрөг анх батлагдаж, тодотголоор 81.9 тэрбум төгрөг болж буурсан. Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалт, Төрийн хэмнэлтийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, чиглэлийн дагуу төсвийг үр ашигтай удирдаж, төсвийн сахилга хариуцлага нэмэгдүүлж ажилласан. 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар нийт 41.8 тэрбум төгрөгийг гүйцэтгэлтэй тодотгосон нийт төсвөөс 40 гаруй хувийг зарцуулаагүй, хэмнэлттэй ажилласан. Мөн 2025 онд 8.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 11.8 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй, орлогын төлөвлөгөөг 38 хувиар давуулан биелүүлж, Улсын төсөвт төвлөрүүлээд байна. 2.Тус яам нь зөвхөн олон улсын байгууллагын санхүүжилттэй болон зайлшгүй шаардлагатай тохиолдолд гадаад томилолт хийх зохицуулалт үйлчилж байгаа бөгөөд томилолтын үр өгөөжийг тооцон ажиллаж байна. 2025 онд 51 арга хэмжээнд 63 /давхардсан тоогоор/ албан хаагч зохион байгуулагч талын зардлаар оролцсон. Албан уулзалт, хурал, сургалтыг аль болох цахим хэлбэрт шилжүүлж, холбоотой зардлыг бууруулсан. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 419 | | 3.2.. Ерөнхий сайдын өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг хангаж, үр дүнг тухай бүр тайлагнах, биелүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцох; | Ерөнхий сайдын өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг хангаж, үр дүнг тухай бүр тайлагнах, биелүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцох талаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн ХЭГ/2450 дугаартай албан бичгийг нийт албан хаагчдад танилцуулж, дээд шатны байгууллага, албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврыг заасан хугацаанд тухай бүр тайлагнан ажиллаж байна. Өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй албан тушаалтан байхгүй болно. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 420 | | 3.3.. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн, танилцуулсан, эрхлэх ажлын хүрээнд хамаарах асуудлыг бүрэн хариуцаж, гарсан шийдвэр, үр дүнгийн талаар олон нийтэд үнэн зөв, бодитой мэдээлэл өгч байх. | Тус яамны эрхлэх асуудлын хүрээнд 2025 оны 3 дугаар улиралд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, танилцуулах асуудлын жагсаалтыг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 01/1550, 4 дүгээр улиралд танилцуулах жагсаалтыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. 1.“Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн ажиллах журам”, “Виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд үзүүлэх татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх журам”-ыг Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. 2.“Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратеги”-ийн төсөл болон судалгаа, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанд танилцуулсан. 3.Төрийн байгууллагуудын ашиглаж байгаа цахим систем, мэдээллийн санд дүн шинжилгээ хийж, систем хоорондын залгамж, уялдаа холбоог ханган давхардлыг арилгах чиглэлээр холбогдох танилцуулгыг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанд хэлэлцүүлж, 20 дугаар хуралдааны тэмдэглэлээр баталгаажсан. Мөн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн, танилцуулсан, эрхлэх асуудлын хүрээний ажилтай хамааралтай олон нийтэд тухай бүр зэрэг мэдээ мэдээллийг бэлтгэн түгээж байна. Тус яамны эрхлэх асуудалтай хамааралтайгаар буруу ташаа ойлголт бүхий мэдээ мэдээлэл гараагүй болно.<br><br>Хавсралт : 2 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 421 | | 4.. Энэ албан даалгаврын хэрэгжилт, үр дүнгийн талаарх мэдээллийг сар бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлж байхыг Засгийн газрын гишүүдэд, биелэлтэд нь хяналт тавьж, явц, үр дүнг нэгтгэн Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогтод тус тус үүрэг болгосугай. | Албан даалгаврын хэрэгжилт, үр дүнгийн талаарх мэдээллийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2025 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн дугаартай 03/1833 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. 9 дүгээр сарын тайланг 2025.09.17-ны өдөр Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим системээр 81 хувиар үнэлгээ хийж тайлагнасан болно. Хэрэг эрхлэх газарт 2025 оны 02/1833, 02/2478, 03/2736 дугаартай албан бичгээр сар бүр биелэлтийг хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 4 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 223 | 422 | Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах тухай албан даалгавар 2025-07-08 Дугаар 2025_03 | 1.1. Улс төрөөс ангид, чадахуйн зарчимд суурилсан хүртээмжтэй, шуурхай, хариуцлагатай төрийн үйлчилгээг хүргэх, хүнд суртал, шат дамжлагыг бууруулах үр дүнтэй ажлыг зохион байгуулан, ажлын бүтээмжийг нэмэгдүүлж, цахим шилжилтийг эрчимжүүлэх | Төрийн байгууллагын мэдээллийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох, төрийн үйлчилгээг цахимжуулах, цахим шилжилтийг бүх шатны төрийн байгууллагад хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах, үйлчилгээний чанар, хүртээмжийг хэмжих, ил тод тайлагнах арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн А/227 дугаар тушаалаар байгуулж, хэрэгжилтийг хангаан ажиллаж байна. Төрийн цахим үйлчилгээг нэвтрүүлсэн олон улсын туршлага, стандарт, журмын судалгааг хийж, төрийн цахим үйлчилгээний стандарт журмын төслийг боловсруулсан. Төрийн байгууллагуудын ашиглаж байгаа цахим систем, мэдээллийн санд дүн шинжилгээ хийж, систем хоорондын залгамж, уялдаа холбоог хангаан давхардлыг арилгах чиглэлээр холбогдох танилцуулгыг Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар 08 дугаар сарын 25-ны өдрийн 01/1936 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн. 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанд хэлэлцүүлсэн. Цаашид төрийн байгууллагууд өөрийн ашиглаж байгаа цахим системийг system.gov.mn цахим системээр бүртгүүлэх, эрхлэх асуудлын хүрээнд бүрдүүлсэн төрөлжсөн мэдээллийн сангийн мета-өгөгдлийг "Төрийн мета-өгөгдлийн нэгдсэн сан"-д бүртгүүлэх, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө system.gov.mn цахим системээр зөвлөмж, дүгнэлтийг тухай бүр авч уялдаа холбоог хангаан ажиллах юм.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 423 | | 1.2.. төрийн албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, удирдах албан тушаалтны тоог бууруулах арга хэмжээ авч, байгууллагын орон тоог нэмэгдүүлэхтэй холбоотой аливаа шийдвэр гаргахгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоо болон сул орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүй байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад; | 1.Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 07 дугаар тогтоолоор Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны зохион байгуулалтын бүтцийг 5 газар, 5 хэлтэс, орон тооны дээд хязгаарыг 89 байхаар шинэчлэн тогтоосон. Тус яамны зохион байгуулалтын нэгж, орон тооны хязгаарт өөрчлөлт орсонтой холбогдуулан Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/263 дугаар тушаалаар яамны зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын нэрс, ангилал, зэрэглэлийг шинээр баталсан. Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 411, 412, 413 дугаар тогтоолоор албан тушаалын тодорхойлолтыг батлах зөвшөөрөл олгосны дагуу Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/305, 306, 307 дугаар тушаалаар албан тушаалын тодорхойлолтыг баталсан. Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн Б/141 дүгээр тушаалаар яамны үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор албан тушаалын тодорхойлолтын дагуу Төрийн албаны тухай хуульд нийцүүлэн төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангаан албан хаагчдыг үргэлжлүүлэн томилсон. 2.Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 10 дугаар 09-ний өдрийн А/134 дүгээр тушаалаар Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тоог, А/137 дугаар тушаалаар Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ-ын зохион байгуулалтын нэгжийн албан тушаалын нэр, орон тоог шинэчлэн тус тус баталж, чиг үүргийн давхардлыг арилгах, албан тушаалтны тоог бууруулах арга хэмжээ авсан. https://mddic.gov.mn/mn/human-resource-management/<br><br>Хавсралт : 2 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 424 | | 1.3.. иргэддээ чин шударгаар үйлчилдэг, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлэх зорилгод нийцүүлэн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг чанд мөрдүүлэх, хуулийг сурталчлан таниулах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг төрийн бүх шатны удирдлагад; | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэн яамны 2025 оны төсөвт Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг тусган батлаад байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг нийт албан хаагчид үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байгаа бөгөөд ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй болно. Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, И Монгол академи УТҮГ, Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ, Үндэсний дата төв УТҮГ-ын дэргэдэх Ёс зүйн дэд хороотой хамтран албан хаагчдыг идэвхжүүлэх өдөрлөг зохион байгуулсан.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 425 | | 1.4.. төрийн байгууллагын ёс зүйн дэд хороог 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор гүйцээн байгуулж ажиллуулахыг бүх шатны төрийн байгууллагын удирдлагад; | Тус яамны дэргэдэх Төрийн албан хаагчийн Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/126 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан бөгөөд уг хорооны гишүүн Э.Насанбат, Г.Батбилэг нар ажлаас чөлөөлөгдсөнтэй холбогдуулан Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын 2.8-д заасны дагуу дэд хорооны 2 гишүүнийг нөхөн сонгох арга хэмжээг 2025 оны 03 сард зохион байгуулж, нөхөн томилогдсон гишүүдийг Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/77 дугаар тушаалаар баталгаажуулсан. Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, И Монгол академи УТҮГ, Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ, Үндэсний дата төв УТҮГ-ын дэргэдэх Ёс зүйн дэд хороо үйл ажиллагаа явуулж байна.<br><br>Хавсралт : 2 файл | Хэрэгжсэн - 100% | Тийм | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай |
| 426 | | 1.5.. төрийн байгууллагуудын ашиглаж байгаа цахим систем, мэдээллийн санд дүн шинжилгээ хийж, систем хоорондын залгамж, уялдаа холбоог хангаж, давхардлыг арилгах, төрөөс иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлж буй цахим үйлчилгээний хүрээг нэмэгдүүлэх асуудлыг судалж, санал боловсруулан 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугарт; | Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2025 оны 92 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хүрээнд төрийн үйлчилгээг цахимд шилжүүлэх ажлын хэрэгжилт, өнөөгийн нөхцөл байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал хүргүүлсэн. Төрийн байгууллагуудад ашиглагдаж байгаа программ хангамж, мэдээллийн системүүдийн бүртгэлийн формыг боловсруулсан. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/18 дугаар тушаалаар баталсан Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө үйл ажиллагаанд зөвлөмж, дүгнэлт гаргах журмыг шинэчлэн боловсруулж байна. Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө үйл ажиллагаанд зөвлөмж, дүгнэлт гаргуулахтай холбоотой танилцуулгыг Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанд танилцуулж, 20 дугаар хуралдааны тэмдэглэлээр холбогдох шийдвэр гарсан. Төрийн байгууллагууд өөрийн ашиглаж байгаа цахим системийг system.gov.mn цахим системээр бүртгүүлэх, эрхлэх асуудлын хүрээнд бүрдүүлсэн төрөлжсөн мэдээллийн сангийн мета-өгөгдлийг "Төрийн мета-өгөгдлийн нэгдсэн сан"-д бүртгүүлэх, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө system.gov.mn цахим системээр зөвлөмж, дүгнэлтийг тухай бүр авч уялдаа холбоог хангаж ажиллах юм. Үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх хүрээнд “Мэдээллийн системийн бүртгэл, зөвлөмж, дүгнэлтийн (system.gov.mn) систем”-ийн ашиглалтыг сайжруулж, бүртгэл хөтлөх үйл ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулах талаар 2025 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 02/2585 албан бичгийг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газарт, өмчийн бүртгэлийн мэдээллийн системтэй өгөгдөл солилцуулах талаар 11 дүгээр сарын 14-ний өдрийн 02/2572 албан бичгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт, өөрийн байгууллагын хэмжээнд ашиглаж буй төрлийн мэдээллийн систем, программ хангамжийн бүртгэлийг системд бүрэн үүсгэж, дуусгах чиглэлийг 11 дүгээр сарын 14-ний өдрийн 02/2571 албан бичгээр харьяа байгууллагад хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 3 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 427 | | 1.7.. Төрийн албаны тухай хуульд зааснаас бусад үндэслэлээр төрийн албан хаагчдыг төрийн албанаас чөлөөлөхгүй, халахгүй, хуулиар чиг үүрэгт нь өөрчлөлт ороогүй тохиолдолд төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулахгүй байх, төрийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц өөрчлөгдсөн боловч албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг нь хэвээр хадгалагдан үлдсэн төрийн жинхэнэ албан хаагчдыг чөлөөлөх, халах, албан тушаал бууруулах, шилжүүлэх шийдвэр гаргахгүй байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт; | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 07 дугаар тогтоолоор Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны зохион байгуулалтын бүтцийг 5 газар, 5 хэлтэс, орон тооны дээд хязгаарыг 89 байхаар шинэчлэн тогтоосон. Тус яамны зохион байгуулалтын нэгж, орон тооны хязгаарт өөрчлөлт орсонтой холбогдуулан Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/263 дугаар тушаалаар яамны зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын нэрс, ангилал, зэрэглэлийг шинээр баталсан. Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 411, 412, 413 дугаар тогтоолоор албан тушаалын тодорхойлолтыг батлах зөвшөөрөл олгосны дагуу Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/305, 306, 307 дугаар тушаалаар албан тушаалын тодорхойлолтыг баталсан. Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн Б/141 дүгээр тушаалаар яамны үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор албан тушаалын тодорхойлолтын дагуу Төрийн албаны тухай хуульд нийцүүлэн төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг ханган албан хаагчдыг үргэлжлүүлэн томилсон.<br><br>Хавсралт : 2 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 428 | | 1.8.. ажлын байрны нээлттэй мэдээлэлд үндэслэн төрийн албан хаагчдыг хувийн хэвшилд шилжүүлэн ажиллуулах санал боловсруулж, цалин хөлс, нийгмийн баталгааны талаарх мэдээллийг төрийн албан хаагчдад хүргэх уулзалт, арга хэмжээг Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим болон холбогдох бусад байгууллагатай хамтран зохион байгуулахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 07 дугаар тогтоолоор Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны зохион байгуулалтын бүтцийг 5 газар, 5 хэлтэс, орон тооны дээд хязгаарыг 89 байхаар шинэчлэн тогтоосон. Тус яамны зохион байгуулалтын нэгж, орон тооны хязгаарт өөрчлөлт орсонтой холбогдуулан Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/263 дугаар тушаалаар яамны зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын нэрс, ангилал, зэрэглэлийг шинээр баталсан. Шинээр баталсан албан тушаалын дагуу Төрийн захиргааны удирдах 9, гүйцэтгэх 65, нийт 74 албан тушаалын тодорхойлолтыг шинээр болон шинэчлэн боловсруулж Төрийн албаны зөвлөлд батлах зөвшөөрөл олгохыг хүссэн 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 02/2225 дугаартай албан бичиг хүргүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим хамтран 2025 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулсан “Төрөөс хувийн хэвшилд шилжин ажиллахыг дэмжих” өдөрлөгт тус яамнаас нийт албан хаагчид болон түүний харьяа байгууллагын албан хаагчдад мэдээлэл хүргэж, оролцлоо.<br><br>Хавсралт : 4 зураг | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 224 | 429 | ЗАСГИЙН ГАЗРААС ШУУРХАЙ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2025-07-25 Дугаар 2025_04 | 2.6.. гадаадын хөрөнгө оруулагч, гадаад худалдаа эрхлэгчдэд зориулсан “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийн үйлчилгээг И-Монгол платформын И-Бизнес хэсэгт 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор нэгтгэх; | Уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх ажлын дэд хэсгийн хурлыг 2025 оны 08 дугаар сарын 14-ний өдөр И-бизнес платформд гадаад худалдааны цахим нэг цонх, хөрөнгө оруулагчийн бүртгэл, зөвшөөрөл болон бизнес эрхлэхтэй холбоотой төрийн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагуудаас iFrame холболт болон систем хөгжүүлэлт хийх эхний 8 байгууллагатай үйлчилгээний хөгжүүлэлтэд шаардлагатай баримт бичиг, сервисийн шаардлагуудын талаар уулзалт зохион байгуулсан. Гадаадын иргэн F-регистрийн дугаараар e-business системд нэвтрэн хуулийн этгээдийн нэр баталгаажуулах хүсэлтийг илгээх болон бусад лавлагаа, үйлчилгээг авах боломжтой болсон. Мөн хөрөнгө оруулагчийн тодорхойлолтыг e-business платформд нэгтгэх техникийн ажил хийгдсэн бөгөөд үйлчилгээг цахимд нээлттэй болгож, олон нийтэд сурталчлах ажлыг эхлүүлсэн. Гадаадын хөрөнгө оруулагчдад зориулсан төрийн үйлчилгээний жагсаалтыг гарган e-business платформд нэгтгэхээр ажиллаж байна. Түүнчлэн “Гадаад худалдааны платформ”-ын агуулга, шаардлагатай хөгжүүлэлт, талуудын хамтын ажиллагаа болон тавигдах шаардлагуудыг тодорхойлсон. И-Монгол академи УТҮГ нь процессын шинжилгээ хийж байна. | Тодорхой үр дүнд хүрсэн - 50% | Үгүй | |
| | 430 | | 2.7.. төрийн бүтээмжийг нэмэгдүүлж, цахим шилжилтийг эрчимжүүлэх зорилгоор “Цахимаар түрүүнд” ("Digital first") бодлогын төслийг боловсруулан батлуулж, төрийн байгууллагуудын цахим шилжилтийг уялдуулах ажлыг 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор эхлүүлэх; | “Цахимаар түрүүнд (Digital First) бодлого”-ын төсөл болон бусад холбогдох баримт бичгийн төслийг боловсруулан Засгийн газрын гишүүдээс 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 01/2082 дугаартай албан бичгээр санал авч, Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэн “Цахимаар түрүүнд (Digital First) бодлогын зөвлөмж”-ийг баталсан. Тус зөвлөмжийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах Ажлын хэсгийг Ерөнхий сайдын дэргэд байгуулахаар, 3.2-д заасны дагуу Бодлогын зөвлөмжийг хэрэгжүүлэх нэгдсэн төлөвлөгөөний төслийг боловсруулахаар ажиллаж байна.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Тийм | Бодлогын зөвлөмжийг батлуулсан тул хяналтаас хасуулах саналтай |
| | 431 | | 18.1.. нийгэм, эдийн засгийн салбарт харилцаа холбоо, мэдээллийн технологи, инновацын дэвшилтэт шийдлийг нэвтрүүлэх, инновац, хиймэл оюуныг хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд болон гарааны компанид дэмжлэг үзүүлэх, олон улсын зах зээлд гарч, өрсөлдөх боломжийг бүрдүүлэх арга хэмжээний саналыг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэх; | Нийгэм, эдийн засгийн салбарт харилцаа холбоо, мэдээллийн технологи, инновацын дэвшилтэт шийдлийг нэвтрүүлэх, инновац, хиймэл оюуныг хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд болон гарааны компанид дэмжлэг үзүүлэх, олон улсын зах зээлд гарч, өрсөлдөх боломжийг бүрдүүлэх арга хэмжээний санал боловсруулан Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлэхээр ажиллаж байна. Мөн тус саналын арга хэмжээний хүрээнд Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанаар "Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль"-ийн 11 дүгээр зүйлийн 11.7 дахь хэсэг, 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт “Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн ажиллах журам”, “Виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх журам”-ыг тус тус батлуулсан. Өөрөөр хэлбэл харилцаа холбоо, мэдээллийн технологи, инновацын дэвшилтэт шийдлийг нэвтрүүлэх, инновац, хиймэл оюуныг хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд болон гарааны компанид дэмжлэг үзүүлэх, олон улсын зах зээлд гарч, өрсөлдөх боломжийг бүрдүүлэх чиглэлээр холбогдох журмуудыг Засгийн газрын хуралдаанаар баталсан.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Тийм | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 432 | | 18.2.. төрийн байгууллагын мэдээллийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох, төрийн үйлчилгээг цахимжуулах, цахим шилжилтийг бүх шатны төрийн байгууллагад хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах, үйлчилгээний чанар, хүртээмжийг хэмжих, ил тод тайлагнах арга хэмжээний талаар 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэх; | Төрийн байгууллагын мэдээллийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох, төрийн үйлчилгээг цахимжуулах, цахим шилжилтийг бүх шатны төрийн байгууллагад хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах, үйлчилгээний чанар, хүртээмжийг хэмжих, ил тод тайлагнах арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн А/227 дугаар тушаалаар байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төрийн цахим үйлчилгээг нэвтрүүлсэн олон улсын туршлага, стандарт, журмын судалгааг хийж, төрийн цахим үйлчилгээний стандарт журмын төслийг боловсруулсан. Төрийн байгууллагуудын ашиглаж байгаа цахим систем, мэдээллийн санд дүн шинжилгээ хийж, систем хоорондын залгамж, уялдаа холбоог хангаж давхардлыг арилгах чиглэлээр холбогдох танилцуулгыг Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар 08 дугаар сарын 25-ны өдрийн 01/1936 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн. 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанд хэлэлцүүлж 2025.10.08-ны өдрийн 20 дугаар хуралдааны тэмдэглэл гарав. Цаашид төрийн байгууллагууд өөрийн ашиглаж байгаа цахим системийг system.gov.mn цахим системээр бүртгүүлэх, эрхлэх асуудлын хүрээнд бүрдүүлсэн төрөлжсөн мэдээллийн сангийн мета-өгөгдлийг "Төрийн мета-өгөгдлийн нэгдсэн сан"-д бүртгүүлэх, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө system.gov.mn цахим системээр зөвлөмж, дүгнэлтийг тухай бүр авч уялдаа холбоог хангаж ажиллах юм.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 433 | | 18.3.. төрийн цахим үйлчилгээний стандарт, журмыг боловсронгуй болгох талаарх саналыг 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэх; | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/133 дугаар тушаалаар үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхтэй холбоотой үүсэх асуудлыг зохицуулах, холбогдох журмын төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсэг "Мэдээлэл хариуцагчийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх журам"-ыг боловсруулан батлуулахаар "Үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын тогтоолын төсөл, журам, танилцуулгад санал авах 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 01/2562 дугаартай албан бичгийг Засгийн газрын гишүүдэд хүргүүлсэн. Цахим хөгжил, инновац, харилцаа сайдын 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр баталсан “Эрчимжүүлэх шаардлагатай төлөвлөгөө”-ний дагуу Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар бэлтгэж байна.<br><br>Хавсралт : 3 файл | Тодорхой үр дүнд хүрсэн - 50% | Үгүй | |
| | 434 | | 18.4.. гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэнийг танин баталгаажуулах хялбар нэвтрэлтийн боломжийг бүрдүүлсэн найдвартай баталгаажуулалт бүхий “Үндэсний танилт нэвтрэлтийн Дан 2.0 систем”-ийг 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор нэвтрүүлэх; | Үндэсний танилт нэвтрэлтийн систем (DAN)-ийн 2.0 хувилбарыг ДАН системд ухаалаг гар утсаар хялбар, тасралтгүй нэвтрэх нөхцөл бүрдүүлэх, гадаад улсад ажиллаж амьдарч буй иргэдийг таних, баталгаажуулах, нотариатын итгэмжлэлээр үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэх, хэрэглэгчээ таних /KYC/ тогтолцоог бий болгох, байгууллагын нэвтрэлтийг хялбарчлах, хүүхдийн нэвтрэлтийг оновчтой болгох, iOS, Android, Huawei платформд зориулсан хэрэглэгч төвтэй интерфейс бүхий аппликейшн бүтээх ажлын мобайл хувилбар 70%, портал хувилбар 60%, нууц үггүй нэвтрэлт (Fido2 standard), хоёр үе шаттай баталгаажуулалт (2FA), токен болон криптограф аргуудыг нэвтрүүлэх, нууцлал, мэдээллийн хамгааллын олон улсын стандартад нийцсэн хамгаалалтын протоколууд ашиглах (OAUTH 2.1), эрх сэргээх/хаах, хандсан төхөөрөмжийн удирдлага, хандалт, ашиглалтын лог мэдээлэх ажил болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын үүлэн тоон гарын үсгийн “GSIGN” аппликейшнтэй нэгтгэх, аппликейшн ашиглан цахим баримт бичигт гарын үсэг зурах баталгаажуулах боломжийг олгох, үйлчилгээнүүдтэй хялбар, автоматаар холбогдох боломж бүрдүүлэх, Төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системийн баталгаажилтын суваг болгох ажил тус тус хийгдсэн. 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр системийн сайжруулсан хувилбарыг олон нийтэд танилцуулж нэвтрүүлсэн. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 435 | | 18.5.. хиймэл оюунд суурилсан виртуал оператор бүхий Төрийн үйлчилгээний нэгдсэн систем И-Монгол 5.0 шинэчлэгдсэн хувилбарыг 2025 оны 09 дүгээр 20-ны өдрийн дотор ашиглалтад оруулах; | Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia)-ийн 5.0 хувилбарын хөгжүүлэлтийн хүрээнд Хиймэл оюунд суурилсан ухаалаг автомат хариулагчтай харилцах, Төрийн үйлчилгээний хөтчөөр дамжуулан үйлчилгээгээ хялбар олох, хэтэвчээр дамжуулан төрийн үйлчилгээний төлбөр тооцоог төлөх, хэрэглэгч өөрийн тээврийн хэрэгслийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцах, Судалгаанд оролцох, Төрийн байгууллагаас хэлэлцүүлж буй хэлэлцүүлэгт санал өгөх зэрэг боломжуудыг бүрдүүлсэн, мөн төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудастай холбож төрийн байгууллагаас ил тод нээлттэй байршуулахаар туссан 68 төрлийн мэдээллийг нэг дороос авах, хэл ярианы бэрхшээлтэй иргэдэд системийг ашиглах зөвлөгөөгөөр хангаж, хамгийн сүүлийн үеийн загвар дизайн бүхий системийг хөгжүүлж, 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр ашиглалтад нэвтрүүлсэн.<br>https://www.youtube.com/watch?v=HMKdiSKTL2U | Хэрэгжсэн - 100% | Тийм | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай |
| | 436 | | 18.6.. төрийн байгууллагын албан бичгийг иргэд цахимаар, эсхүл цаасаар хүлээн авах боломж, сонголтыг бий болгох; | Төрийн үйлчилгээний нэгдсэн И-Монгол системээр дамжуулан өргөдөл, гомдол илгээх хөгжүүлэлтийг хийсэн. Тухайн өргөдөл, гомдлыг 11-11 системээр дамжуулан хариуцагч байгууллагад шилжүүлэх бөгөөд шийдвэрлэлтийг И-Монгол системээр дамжуулан буцаан хүлээн авна. Цаашид DocX системд холбогдсон 17 Егр систем хөгжүүлэгч байгууллагын албан хэрэг хөтлөлтийн системээр дамжуулан үндэсний цахим шуудангийн хаягаар дамжин цаасаар албан бичиг хүргүүлэхээр хөгжүүлэлтийг хийсэн бөгөөд ингэснээр 2858 байгууллагаар дамжуулан иргэнд цахим хэлбэрээр албан бичиг хүргэх боломжтой болсон. | Хэрэгжсэн - 100% | Тийм | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай |
| | 437 | | 18.7.. их өгөгдөл, хиймэл оюун ухааны үндэсний стратеги боловсруулж, хэрэгжүүлэх аргачлалын талаар 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэх; | “Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратеги”-ийн төсөл болон судалгаа, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хамт 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 01/2103 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 18 дугаар хуралдаанд танилцуулж, уг стратегид тусгагдсан зорилт, арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төсөлд тусгасан.<br><br>Хавсралт : 1 файл | Хэрэгжсэн - 100% | Тийм | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай. |
| | 438 | | 18.8.. бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх зорилгоор хуулийн этгээд байгуулах, бүртгүүлэх бүхий л үйл ажиллагааг төрийн үйлчилгээний нэгдсэн систем “E-Bussiness”-т, тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зөвшөөрлийн цахим систем “license.mn”-д тус тус нэгтгэх ажлыг зохион байгуулах. | Бизнес эрхлэгчдэд зориулсан e-business.mn цахим систем нь хуулийн этгээд үүсгэн байгуулахаас эхлээд бүх төрлийн үйлчилгээг цахимжуулж, олон төрлийн зөвшөөрөл хүсэх, сунгах, байгууллагын лавлагааг нэг дороос авах боломжийг бүрдүүлэх зорилготой систем бөгөөд одоогийн байдлаар иргэн, аж ахуйн нэгж байгууллагад төрийн 88 байгууллагын 953 үйлчилгээг цахимаар хүргэн ажиллаж байна. 1.Зөвшөөрлийн нэгдсэн систем license.mn-тэй хамтран зөвшөөрлийн нэгдсэн санд байгаа зөвшөөрлийн төлөвийн мэдээллийг e-mongolia мобайл аппликейшний “Төрд байгаа мэдээлэл” цэсэд харуулахаар хөгжүүлэлтийг хийсэн. 2.Мөн license.mn системийг e-business.mn системд нэгтгэн Зөвшөөрлийн цахим систем цонхонд харуулах хөгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. 3. Зөвшөөрлийн тухай хуульд заасан 254 тусгай зөвшөөрлөөс e-business платформд 44 цахимжиж, 134 линкээр холбогдож, 76 цахим хэлбэрт шилжээгүй, харин 124 энгийн зөвшөөрлөөс 23 цахимжиж, 43 линкээр холбогдож, 58 цахим хэлбэрт шилжээгүй байна.4. E-Business.mn платформын хэрэглээг нэмэгдүүлэхээр ухаалаг утасны хувилбарт хөгжүүлэлт хийн ажиллаж байгаа бөгөөд 2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр дуусгахаар хөгжүүлэлтийн төлөвлөгөө гарсан.<br><br>Хавсралт : 1 файл | Тодорхой үр дүнд хүрсэн - 50% | Үгүй | |
| | 439 | | 21.. Энэ албан даалгаврын хавсралтад заасан хууль тогтоомжийн төслүүдийг боловсруулж, 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг холбогдох Засгийн газрын гишүүдэд үүрэг болгов. | Тус албан даалгаврын хавсралтад тус яамнаас хариуцан боловсруулах хууль тогтоомжийн төсөл тусгагдаагүй болно. | Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй | Тийм | Тус яамнаас хариуцан боловсруулах хууль тогтоомжийн төсөл тусгагдаагүй тул хяналтаас хасуулах саналтай. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 225 | 440 | Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай 2025-12-10 Дугаар 2025_05 | 1.1.. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэлтэй уялдуулж төсвийг хуваарилан зарцуулахдаа үр ашиггүй, тэвчиж болох зардлыг танах, хэмнэлтийн горимыг чанд мөрдөн ажиллах талаар харьяа байгууллагын удирдлагад үүрэг, чиглэл өгч, үр дүнг тооцож ажиллах; | Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэлтэй уялдуулан төсвийг хуваарилан зарцуулахдаа үр ашиггүй, тэвчиж болох зардлыг танах, хэмнэлтийн горимыг чанд мөрдөн ажиллах чиглэлийг харьяа байгууллагын удирдлагуудад өгч, зардлын гүйцэтгэлд тогтмол хяналт тавин, хэрэгжилтийн үр дүнг тооцож ажиллаж байна. | Ахиц гарсан - 50% | Үгүй | |
| | 441 | | 1.2.. төрийн байгууллагын үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн бүх төрлийн тэтгэвэр, тэтгэмж, хүүхдийн мөнгөн тэтгэмж, хүүгийн төлбөр, эмнэлэг, сургууль, цэцэрлэг, онцгой байдлын байгууллагын шаардлагатай урсгал зардлыг тэргүүн ээлжид, бусад зардлыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон эрэмбийн дагуу санхүүжүүлэх; | Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” албан даалгаврын хүрээнд хурал, семинар, сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж, дотоод болон гадаад томилолт, тээвэр, шатахуун, зочин төлөөлөгч хүлээн авахтай холбоотой зардлыг хэмнэн ажилласан. Мөн байгууллагын дотоод журмаар олгодог нэг удаагийн тэтгэмж, урамшууллыг түр хугацаагаар зогсоож, тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж, бичиг хэргийн зүйлсийн худалдан авалт хийгээгүй бөгөөд гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх мэргэжлийн болон зөвлөх үйлчилгээний гэрээг шинээр байгуулаагүй. Түүнчлэн төрийн байгууллагын хэрэгжүүлдэг хөтөлбөр, арга хэмжээний зарим зардлын санхүүжилтийг дараагийн төсвийн жилд шилжүүлэн тооцож, төсвийн хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэн ажилласан. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 442 | | 1.3.. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг чанд мөрдөж, төсвийн хөрөнгөөр шинэ жил, байгууллагын болон салбарын ой тэмдэглэх зэрэг олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахгүй, бэлэг дурсгалын зүйл бэлтгэхгүй байх; | Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган төсвийн хөрөнгөөр шинэ жил, байгууллагын болон салбарын ой тэмдэглэх зэрэг олон нийтийн арга хэмжээ зохион байгуулаагүй, бэлэг дурсгалын зүйл бэлтгээгүй бөгөөд төсвийн сахилга бат, хэмнэлтийн горимыг чанд мөрдөн ажиллаж байна. | Ахиц гарсан - 50% | Үгүй | |
| | 443 | | 1.4.. тэвчиж болох дараах арга хэмжээ, зардлын санхүүжилтийг 2025 он дуустал хугацаанд зогсоож, зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааг хэмнэлттэй, үр ашигтай байдлаар зохион байгуулах: | Тэвчиж болох арга хэмжээний хүрээнд хурал, семинар, сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж, дотоод болон гадаад томилолт, тээвэр, шатахуун, зочин төлөөлөгч хүлээн авахтай холбоотой зардлыг хэмнэсэн. Мөн байгууллагын дотоод журмаар олгодог нэг удаагийн тэтгэмж, урамшууллыг түр хугацаагаар зогсоож, тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж, бичиг хэргийн зүйлсийн худалдан авалт хийгээгүй байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 444 | | 1.4.1.. хурал, семинар, сургалтыг цахимаар зохион байгуулж, дотоод, гадаад томилолт, тээвэр шатахуун, зочин, төлөөлөгч хүлээн авах зардлыг хэмнэх; | Хурал, семинар, сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж, дотоод болон гадаад томилолт, тээвэр, шатахуун, зочин төлөөлөгч хүлээн авахтай холбоотой зардлыг хэмнэн ажиллаж байна. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 445 | | 1.4.2.. байгууллагын дотоод журмаар олгодог нэг удаагийн тэтгэмж, урамшууллыг түр зогсоох; | Байгууллагын дотоод журмаар олгодог нэг удаагийн тэтгэмж, урамшууллыг тогтоол гарснаас хойш олгоогүй болно. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| | 446 | | 1.4.3.. тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж, бичиг хэргийн зүйлс худалдан авахгүй байх; | Тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж, бичиг хэргийн зүйлсийн худалдан авалт хийгээгүй. | Хэрэгжсэн - 100% | Үгүй | |
| 226 | 447 | Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай 2025-12-10 Дугаар 2025_05 | 1.4.5.. төрийн байгууллагын хэрэгжүүлдэг хөтөлбөр, арга хэмжээний зардлын санхүүжилтийг дараагийн төсвийн жилд шилжүүлэх. | Төрийн байгууллагын хэрэгжүүлдэг хөтөлбөр, арга хэмжээний зарим зардлын санхүүжилтийг дараагийн төсвийн жилд шилжүүлэн тооцож ажилласан. | Ахиц гарсан - 50% | Үгүй | |
| Нийт үнэлгээний дундаж хувь | | | | | | | 87% |